

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
УЛС ТӨР СУДЛАЛЫН ТЭНХИМ – АРДЧИЛАЛ СУДЛАЛЫН ТӨВ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ
ПОЛИТОЛОГИ
№ XXI

МУИС-ийн ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР

2023 он

ПОЛИТОЛОГИ ХХІ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№21 (579)
ХХІ

ISSN 2227-6904

Key title: Политологи

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч: проф. Ж.Төртогтох, МУИС, Улс төр судлалын тэнхим
Орлогч эрхлэгч: проф. С.Мөнхбат, МУИС, Улс төр судлалын тэнхим
Нарийн бичиг: Д.Уртнасан, МУИС, Улс төр судлалын тэнхим
Сэтгүүлийн туслах ажилтан: Г.Баярчимэг, МУИС, Улс төр судлалын тэнхим

Гишүүд:

проф. С.Базарпүрэв - МУИС, Улс төр судлалын тэнхим
проф. Н.Бурмаа - МУИС, Нийтийн удирдлагын тэнхим
др. Д.Ундрах - МУИС, Улс төр судлалын тэнхим
др. Б.Эрдэнэдалай - МУИС, Улс төр судлалын тэнхим
др. Г.Туяагэрэл - МУИС, Улс төр судлалын тэнхим
др. Я.Төгөлдөр - ШУТИС, Нийгмийн ухааны тэнхим
др. Н.Мягмарцоож - МУБИС
др. О.Хатанболд - ШУА, ФХ, Улс төр, эрх зүйн салбар
др. Б.Одгэрэл - Отгонтэнгэр Их Сургууль
др. М.Мөнхзул - ХААИС
др. Ж.Жаргал - Удирдлагын Академи

Хаяг:

Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө, МУИС-ийн хичээлийн II байр
Шинжлэх Ухааны сургууль, Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв

Утас: 976 - 75754400 (2317)

POLITOLOGY XXI SCIENTIFIC JOURNAL

№21 (579)
XXI

ISSN 2227-6904

Key title: Politology

EDITORIAL BOARD

Editor-in-Chief:	Prof. Turtogtokh Janar, National University of Mongolia
Co-editor	Prof. Munkhbat Sonomdarjaa, National University of Mongolia
Secretary:	Urtnasan Dagiidamba, National University of Mongolia
Assistant:	Bayarchimeg Ganbaatar, National University of Mongolia
Board members:	Prof. Bazarpurev Sambuu, National University of Mongolia
	Prof. Burmaa Natsag, National University of Mongolia
	Dr. Undrakh Davaadorj, National University of Mongolia
	Dr. Erdenedalai Bat-Ulzii, National University of Mongolia
	Dr. Tuyagerel Ganbat, National University of Mongolia
	Dr. Tuguldur Yanjiv, Mongolian University of Science and Technology
	Dr. Myagmartsooj Natsag, Mongolian State University of Education
	Dr. Khatanbold Oidov, Mongolian Academy of Sciences
	Dr. Odgerel Batsaikhan, Olgontenger University
	Dr. Munkhzul Myagmarsuren, Mongolian University of Life Science
	Dr. Jargal Jambal, National Academy of Governance

Address:

Department of Political Science & Center for Democracy Studies, School of Arts and Sciences, National University of Mongolia, Zaluuchuud avenue, Ulaanbaatar, Mongolia,

Phone: 976 – 75754400 (2317)

ПОЛИТОЛОГИ ХХ
Эрдэм шинжилгээний бичиг
№21 (579)

АГУУЛГА

Өмнөх үг

АРДЧИЛАЛ, ИРГЭНИЙ НИЙГЭМ

“Төлөөллийн засаг, төлөөллийн ардчиллын үзэл санаа ба Монголын ардчилал: төрийн ба улс төрийн институцууд төлөөллийн ардчилалд хэрхэн нөлөөлж байна вэ?”

Ж.Төртогтох, С.Мөнхбат, Б.Эрдэнэдалай, Г.Туяагэрэл9

Монгол дахь ардчилал ба түүний чанар

Д.Ганбат30

Монголын ардчиллыг Засгийн газар ба намуудын харилцааны динамик өөрчлөлтөөр хэмжих нь

Павел Маскаринеч38

Монголын иргэний нийгмийн хөгжлийн сорилт бэрхшээл, боломж нөхцөл

Д.Мягмарсүрэн, Я.Төгөлдөр48

Иргэний нийгмийн байгууллагын ардчиллын бэхжилтэд үзүүлэх нөлөөлөл, чиг хандлага

Б.Одгэрэл, О.Мөнхжаргал60

Өмнөд Солонгосын иргэний нийгэм: глобалчлалын эсрэг үзэгдэл, популизм, дижитал хувьсгал

Хьюн Чин Лим, Сук Ки Кон70

Ардчиллын талаарх Монголын залуучуудын хандлага

Николас Назке, Г.Золзаяа, Г.Жаргалмаа81

УЛС ТӨРИЙН СОЁЛ

Орчин үеийн Монголчуудын улс төрийн мэдлэг, уламжлал, соёл, үнэт зүйлсэд гарч буй өөрчлөлт

О.Хатанболд, Д.Уртнасан93

Залуу үеийнхний улс төрийн соёлын өөрчлөлт нь ардчилалд итгэх итгэлийг багасгаж , технократ аль нэг хувилбарыг илүүд үзэхээ болиход хүргэж байна уу

Сааша Ханниг Нүнец115

Монголчуудын улс төрийн соёлд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс

Ж.Төртогтох, Д.Хулан125

ТӨР, ТӨРИЙН ИНСТИТУТ

Монгол улсын засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тогтвортой байдлын асуудал <i>Д.Түмэнжаргал, Г.Туяагэрэл</i>	137
--	-----

“Неопатримониал” онолын ойлголтыг тайлбарлах нь <i>Б.Эрдэнэдалай, Г.Мөнхтуяа</i>	145
---	-----

Монгол дахь парламентын хяналтын асуудал <i>Х.Батхүү, С.Базарпүрэв</i>	153
---	-----

СОНГУУЛЬ, УЛС ТӨРИЙН НАМ

Монгол Улс дахь сонгуулийн зарим тоон өгөгдлийн ил тод, нээлттэй байдал <i>Д.Ундрах, Б.Эрдэнэдалай</i>	163
---	-----

Онлайн ардчиллын бэхжилт ба Монголын улс төрийн намын гишүүнчлэлд тулгарч буй сорилтууд <i>С.Мөнхбат, Н.Батсүмбэрэл</i>	172
--	-----

Ардчиллын хөгжилд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг <i>Б.Баярбаатар, Д.Бумдарь</i>	180
--	-----

Сонгуулийн эрх зүйн антропологи <i>С.Номынбаясгалан</i>	193
--	-----

Зохиогчдын тухай товч	207
-----------------------------	-----

POLITOLOGY XXI
Scientific journal
№21 (579)

CONTENTS

Foreword

DEMOCRACY AND CIVIL SOCIETY

The Representative Democracy in Mongolia: How Do State and Political Institutions Affect Representative Democracy?

Turtogtokh J., Munkhbat S., Erdenedalai B., Tuyagerel G.9

Democracy in Mongolia and Its Quality

Ganbat D.30

Dynamics and Changes of the Executive-Parties Dimension of the Mongolian Democracy and Its Effect on Democratic Performance

Pavel Maškarinec38

Civil Society Development in Mongolia: Challenges and Opportunities

Myagmarsuren D., Tuguldur Ya.48

The Effect of Civil Society Organizations on Democratic Strengthening and Their Participation in it

Odgerel B., Munkhjargal O.60

Drifting Civil Society in South Korea: De-globalization, Populism, and Digital Revolution

Hyun-Chin Lim, Suk-Ki Kong70

Mongolian Youth's Attitudes Towards Democracy and Government

Nicholas Natzke, Zolzaya G., Jargalmaa G.81

POLITICAL CULTURE

Transformative Power of Politics - its Traditions, Cultures and Values: The Context of Modern Mongolia

Khatanbold O., Urtnasan D.93

Changes in political culture among younger generations trigger loss in trust in democracy and preference for technocratic alternatives

Sascha Hannig Núñez115

Social and economic factors of political culture of mongolians

Turtogtokh J., Khulan D.125

STATE AND INSTITUTIONS

The stability of Mongolian government

<i>Tumenjargal D., Tuyagerel G.</i>	137
Interpreting the Concept of Neopatrimonial <i>Erdenedalai B., Munkhtuya G.</i>	145
Parliamentary oversight issues in Mongolia <i>Batkhuu G., Bazarpurev S.</i>	153
ELECTION AND POLITICAL PARTIES	
Transparency and Openness of some Election Numeric data of Mongolia <i>Undrakh D., Erdenedalai B.</i>	163
Strengthening of Online Democracy and the challenges for Political party membership of Mongolia <i>Munkhbat S., Batsumberel N.</i>	172
The Role of Political Parties in Making Democracy <i>Bayarbaatar B., Bumdari D.</i>	180
Anthropology of electoral law <i>Nomynbayasgalan S.</i>	193
List of Contributors	207

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн тусгай дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж байна.

Улс төрийн үзэгдэл, үйл явц, харилцааны мөн чанар, шалтгааныг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлэлт дүгнэлтийг өгөх учир холбогдол бүхий улс төрийн мэдлэгийг бий болгоход улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг их юм. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны арга хэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна. Улс төрийн мэдлэгийн даяарших үйл явц нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэсээр байх болно.

Монголд улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төвөөс Шинжлэх Ухаан Технологийн Үндэсний Зөвлөл, МУБИС, ШУТИС, ШУА-ийн Философийн Хүрээлэнгийн Улс төр судлалын сектор, Отгонтэнгэр Их Сургууль зэрэг төрийн болон эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран 2022 оны 10-р сард зохион байгуулсан “Is Mongolia an Oasis of Democracy?: A Comparative Perspective” сэдэвт олон улсын хурлын агуулга, үр дүнд холбогдуулан гаргаж буй энэхүү тусгай дугаар болно.

Сэтгүүлийн энэхүү тусгай дугаарт ардчилал, иргэний нийгэм, улс төрийн соёл, төр, төрийн институт, сонгууль, улс төрийн нам зэрэг улс төрийн шинжлэх ухааны хэд хэдэн чухал дэд хэсгүүдийн хүрээнд нийт 29 эрдэмтэн судлаачдын дангаар болон хамтран бичсэн 17 өгүүлэл нийтлэгдэж байна.

Энэхүү дугаарт нийтлэгдсэн өгүүлэл тус бүр нь тухайн зохиогчийн үзэл санаа, байр суурь, судалгааны өгөгдөхүүнд тулгуурлаж байгаа бөгөөд МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв, Политологи сэтгүүлийн редакцын байр суурь биш болохыг анхаарч хүлээн авна уу. Цаашид тус сэтгүүл МУИС-ийн эрдэм шинжилгээний бусад сэтгүүлүүдийн нэгэн адил цахим системд орж байгаатай холбогдуулан редакцийн зөвлөл, нийтлэлийн бодлого зэрэгт зохих өөрчлөлт тусгагдан орж буй болно. Уншигч та сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ Улс төр судлалын тэнхимийн хаягаар ирүүлбэл бид гүнээ талархах болно.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

**“ТӨЛӨӨЛЛИЙН ЗАСАГ, ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛЛЫН ҮЗЭЛ САНАА БА
МОНГОЛЫН АРДЧИЛАЛ: ТӨРИЙН БА УЛС ТӨРИЙН ИНСТИТУЦУУД
ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛАЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БАЙНА ВЭ?”**

Ж.Төртогтох

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор
Ардчилал судлалын төвийн захирал

С.Мөнхбат

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн профессор

Б.Эрдэнэдалай

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Г.Туяагэрэл

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

Хураангуй:

Төлөөллийн ардчиллыг ажиллуулах гол механизм, институт нь ардчиллын чанарыг танин мэдэх түлхүүр нь болдог. Эрх зүйт төр, хуульт ёс, иргэдийн тэгш, хүртээмжтэй оролцоо зэрэг ардчиллын чанарыг танин мэдэхэд дөхөм болох үзүүлэлтүүд улс орон бүрт харилцан адилгүй байна. Тиймээс тус өгүүлэлд төлөөллийн ардчиллын бэхжилтэд төрийн болон улс төрийн институцуудын үүрэг, нөлөө, иргэдийн дээрх институцуудад итгэх итгэл, ардчилсан тогтолцоонд хэрхэн өөрчлөгдөж байгааг нөгөө талаас дээрх институцууд ардчиллыг өөрсдийн хэв маягт нийцүүлэн хувирган өөрчилж байгаа эсэх улмаар ардчилалд хандах иргэдийн хандлага, түүнд нөлөөлсөн нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлсийг судлан гаргасан.

Төлөөллийн ардчиллын бэхжилтэд төрийн институци, улс төрийн институци, оролцогч бусад талуудын нөлөөг судлахдаа хүчин зүйлийн болон хамаарлын шинжилгээг хийж, ардчиллын бэхжилтэд тулгарч буй асуудлыг дүгнэсэн. Бид судалгаандаа улс төрийн чанарын судалгааны арга зүй болох экспертийн судалгааг гол арга болгон нийт 8 эксперттэй ганцаарчилсан ярилцлага хийж, өндөр түвшний 90 экспертээс 2022 оны 6-р сарын 20-оос 8-р сарын 20 хүртэлх хугацаанд нийт 110 асуулт бүхий асуулгыг бичгээр авч, үр дүнг боловсруулан судалгааны дүгнэлтэд нэгтгэсэн болно.

Түлхүүр үг: Төлөөллийн засаг, төрийн институци, улс төрийн институци ардчиллын бэхжилт

Удиртгал:

Калифорнийн Их Сургуулийн профессор Стивен Фиш “Монгол Улс ардчиллын урьдач нөхцөлүүдийн аль нь ч байгаагүй хэрнээ ардчилсан шилжилтийг амжилттай хийж чадсан нь гарцаагүй чухал баримт мөн” гэсэн байдаг. Ардчилал, сонгуульд

дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс (IDEA) 2005 онд хийсэн “Монгол Улсын ардчиллын төлөв байдал” хэмээх судалгаандаа “Монгол Улсын ардчиллын бэхжилтийн үйл явцыг ажиглан харахад сорилт, боломжууд бий болж байгаа хэдий ч ардчилсан шилжилт хийснээс хойш Үндсэн хууль баталж, хүчтэй өрсөлдөөн бүхий улс төрийн намын тогтолцоо байгуулж, иргэний нийгмийн амьд тогтолцоог бий болгож, чөлөөт зах зээлийн шинэчлэлийг хийсэн” хэмээн цохон тэмдэглэсэн байдаг.

Монгол Улс ардчилалд шилжээд 33 жил болж байна. Энэ хугацаанд хүний эрх, эрх чөлөөний үзэл баримтлалд тулгуурласан ардчилсан Үндсэн хуультай болж эрх зүйт төр иргэний нийгмийн зүг шийдвэртэй алхам хийв (Ш.Содном, 2009). УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн ИТХ-ын нийт 24 удаагийн ардчилсан сонгуулийг зохион байгуулж иргэнийхээ улс төрийн эрх, эрх чөлөөг бодитой эдлүүлэх улс төр, эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. Олон намын систем тогтож, олон ургальч үзэл дэлгэрэв. Иргэдээс улс төр, улс төрийн систем, дэглэмд хандах хандлага, чиг баримжаа өөрчлөгдөж Монголын иргэд сонгогчдын үйл байдал, улс төрийн соёлд гүн гүнзгий өөрчлөлт гарсан. Ийнхүү Монголд ардчилал, ардчилах үйл явц эргэлт буцалтгүй болж түүний хөгжил, төлөвшлийн асуудлаар нухацтай хэлэлцэн шинжлэх нийгэм, улс төрийн бодит нөхцөл бүрдээд байна.

Төлөөллийн ардчиллын талаарх онолын үзэл баримтлал

Жон Стюарт Милл “Төлөөллийн Засаг” хэмээх сонгодог бүтээлдээ Төлөөллийн засаг нь олон түмэн хариуцдаггүй удирдлага ба цөөнхийн өөрийгөө бодохуйн хоорондох хамгийн хаахгүй ний эргэцүүлэн бодох чадваргүй засаглал, цөөн хүмүүсийн хувийн эрх ашгийн хоорондох хамгийн ухаалаг тохиролцоо гэж авч үзсэн. Тэрээр уг бүтээлдээ үнэн ба худал ардчилал нь бүхнийг төлөөлж байна уу эсвэл зөвхөн олонхийн төлөөллийн тусгал болж байна уу гэдэг асуудлыг гаргаж тавьсан билээ (John Stuart Mill, *Considerations on Representative Government*, Published 1991 by Prometheus Books, NY, p. 144).

Цицерон Төрийн дээд эрх мэдэл ард түмний гарт байсан цагт л эрх чөлөө бодитой орших бөгөөд тэнд эрх чөлөөнөөс илүү тааламжтай ямар ч зүйл үгүй. Хэрэв тэгш эрх үгүй бол тэнд ямар ч эрх чөлөө байхгүй хэмээн тодорхойлсон (Ардчиллын мөн чанар ба үнэт зүйл Ханс Кельзен УБ 2015, 22) нь өдгөө ч Монголын ардчиллыг эргэцүүлэн авч үзэхэд утга учиртай хэвээр байна. Даль орчин үеийн ардчилалд зайлшгүй байх улс төрийн институтуудыг авч үзэхдээ тэдгээрийн хэрэгцээ шаардлагын асуудлыг ч үндэслэлтэй авч үзсэн нь бий (Robert A. Dahl, *On Democracy*, Yale University Press, p.76, 82). Милл "Янз бүрийн оронд өөр өөр үзэл бодол давамгайлж байгаа тул зарим газар цөөнх болсон үзэл бодол бусад газарт олонх байдаг" гэж тэмдэглэсэн" (Mill, 148).

Төлөөллийн ардчиллын үзэл санаа аливаа улсын нийгмийн байгуулал, улс төрийн дэглэм, соёл зэргээс хамааран харилцан адилгүй хэрэгжиж ирсэн нь ардчиллыг төлөөлөн илэрхийлэх, ажиллах, хэрэгжүүлэх институтуудээс хамааралтай байжээ. Тэдгээр институтыг төслийн судалгааны баг олон талт байдлаар авч үзсэн боловч энэ удаагийн илтгэлээр зөвхөн төрийн ба улс төрийн институц гэсэн 2 үндсэн хэсэгт авч үзлээ.

Нэгэн улсад иргэдийн хамгийн их итгэл хүлээлгэдэг улс төрийн институц нөгөө нэгэн улсад эсрэгээрээ байх явдал өнөө цагт тийм ч хачирхалтай үзэгдэл биш болсон байна. Үүнд улс төрийн дэглэмийн мөн чанар үндсэн суурь нөхцөл болдог нь ч дамжиггүй. Тиймээс Бийтам идеал ардчиллын үндсэн зорилгыг улс төр ба иргэний эрх чөлөө, ард нийтийн сувернитет, улс төрийн тэгш байдал, сайн засаглал буюу түүний нээлттэй шинж, хуульт ёс хэмээн авч үзсэн (David Beetham, *"Towards a Universal*

Framework for Democracy Assessment," Democratization 11 (April 2004): 1-17). Ардчилал хэрэгжих, оршин тогтнох, үр дүнтэй ажиллах чухал хөрс суурь мөн тэдгээртэй холбоотой. Тиймээс бид ардчиллын мөн чанар, ялангуяа төлөөллийн ардчилал, төлөөллийн засгийн үзэл санаа Монголын ардчилалд хэрхэн холбогдож ирсэн бэ гэдгийг тоон болон чанарын судалгаанд тулгуурлан тоймлон гаргахыг зорьсон юм.

“Ардчиллын тухай” хэмээх бүтээлдээ Бернард Крик "иргэд юунаас ч хараат бус байх эрх чөлөөг эрхэмлэдэг боловч, өөрсдийнх нь эрх мэдлийг хязгаарласан төлөөллийн хурал бүхий улсуудын холбоог хэдийнээ бий болгосон" гэжээ (Бернард Крик, Ардчиллын тухай, 2002, 127). Төлөөлөл нь ардчилсан нийгэмд иргэдийн зохион байгуулах гол зарчим байсаар ирсэн. Иргэдийн улс төрд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх, тэдний ашиг сонирхлыг төлөөлөх хоорондын тэнцвэрт байдлыг хангахад төлөөллийн ардчиллын мөн чанар оршдог. Тийм байж чадвал ард түмэн хүлээн зөвшөөрдөг.



Ардчиллын хэрэгжилт, бэхжилтийг олон талаас нь судлан авч үзэх болсон ардчиллын орчин үеийн судалгааны арга зүйд ч энэхүү харилцан адилгүй байдлыг олон үзүүлэлтээр дэлгэрэнгүй авч үзэх болсон. Учир нь ардчиллын олон талт байдал улс орон бүрт өөр өөрөөр ажиглагддаг тул тэдгээр улсууд дахь эрх зүйн зохицуулалтаас илүү бодит улс төрийн ажиглалт, дүгнэлт, үнэлгээг чухалчлан үзэж байна. Экспертийн судалгааны арга зүй нь Coppedge, Michael, John Gerring, Steven Fish, Jan Teorell (2011) нарын судалгааны өгүүлэлд дэлгэрэнгүй тодорхойлогдсон байна.

Төлөөллийн ардчиллын бэхжилтэд төрийн институцийн нөлөө

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээр ардчилсан Үндсэн хуультай болж улмаар түүнд нийцсэн эрх зүйн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэн эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу төрийн институцууд бүрэлдэн төлөвшиж улс төрийн тогтолцоо бүхэлдээ ардчилсан шинж төрхийг олсон байна. Хэдийгээр Монгол Улс ардчиллыг амжилттай бэхжүүлж байгаа хэдий ч улс төрийн системийн тогтворгүй байдал, эрх мэдлийн институцуудын харилцан тэнцвэртэй байх механизм алдагдан, нийгэмд тэгш бус байдал үүсэн, авлигын үр нөлөөгөөр бий болсон орлогын тэгш бус байдал, ялагч бүхнийг эзэмшдэг улс төрийн сонгуулийн тогтолцооны сөрөг үр дагавар, улс төрийн намын дотоод институтжилт алдагдсан гэх мэт олон сорилтууд тулгарсаар байна. Гэхдээ ардчиллын бэхжилтэд учирч болох хамгийн том сорилт бол иргэдийн ардчиллын талаарх ойлголт төсөөлөл, ардчилалд итгэх итгэл алдрах тухай асуудал юм. Нөгөө талаас ардчиллын бэхжилтэд учирч буй сорилт гэдэг нь Үндсэн хуулиараа баталгаажуулсан төрийн институцуудын төлөвшил, цаашдын чиг хандлага, улс төрийн намын тогтолцоо болоод иргэний нийгмийн хөгжлийн зүй тогтолд учирч буй сорилт гэсэн үг юм.


Судалгааны дүнгээс харахад ардчиллын өнөөгийн төлөв байдалд сэтгэл ханамж дундуур байгаа нь тогтолцооны хувьд бүрэн ардчилалтай биш гэж үзэж байгаатай нь холбоотой юм. Мөн дээрх судалгаанд ардчилсан засаглалын төлөв байдал нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд гарч байгаа өөрчлөлт хоорондын нийцлийн талаарх үр дүнг харахад 2006-2020 онуудад аажмаар буурч олон түмний ардчиллаас хүлээж байсан үр дүн нийгэмд бий болоогүйг харуулж байна.

Зураг 1. Ардчилсан тогтолцооны талаарх үнэлгээ



(Эх сурвалж: “Азийн барометр” судалгаа. УТБА. 2006, 2020 он)


Зураг 2. Ардчилсан засаглалын нийцэл ба ардчиллын бэхжилт



(Эх сурвалж: “Азийн барометр” судалгаа.
УТБА. 2006, 2020 он)

2006-2020 онуудад хийгдсэн “Азийн барометр судалгаа”-ны үр дүнгээс харахад иргэд ардчиллыг нийгэмд тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх арга зам гэж үзэн ардчилсан хөгжлийн үр дүнд эдийн засгийн өсөлт бий болно гэсэн хүлээлттэй байсан нь харагдаж байна.


Зураг 3. Ардчиллын талаарх ойлголт



(Эх сурвалж: “Азийн барометр” судалгаа. УТБА. 2006, 2020 он)

Ардчиллын бэхжилтийг хангахад учирч буй сорилт, бэрхшээлүүд нь түүнээс татгалзах үндэслэл болохгүй гэдгийг судалгааны доорх үр дүн харуулж байна. Өөрөөр хэлбэл, ардчилалд тодорхой хэмжээний сөрөг асуудал байгаа хэдий ч энэ нь ардчилсан сонгууль, төлөөллийн ардчиллын илэрхийлэл болох парламентын тогтолцооноос татгалзах, нэг нам дангаар засаглах, хүчтэй удирдагчийг хүсэмжлэх хандлага олон нийтийн санаа бодолд давамгайлахгүй байгаа нь харагдаж байгаа юм.

Зураг 4. Ардчиллын цаашдын хөгжлийн талаарх хандлага



(Эх сурвалж: “Азийн барометр-2020” судалгаа. УТБА. 2006, 2020 он)


Ардчиллын талаарх олон түмний төсөөлөл, ардчиллын хөгжлөөс хүлээх үр дүн нь ардчиллын бэхжилтийг хангахад чиглэсэн төрийн болоод улс төрийн институцууд, иргэний нийгмийн хөгжил, ардчиллын бэхжилтийг хангахад чиглэсэн улс төрийн соёл оролцооны төлөвшилтэй шууд холбоотой байдаг. Иймд төлөөлийн ардчиллын бэхжилтийг хангахад төрийн болон улс төрийн институцуудтай холбоотой доорх хүчин зүйлүүдийг судлах шаардлагатай юм.

1. Төлөөлийн ардчиллын бэхжилтэд нөлөөлөх гол хүчин зүйл болох төрийн институцид итгэл олон түмний итгэл.
2. Бодлого боловсруулж, асуудал шийдвэрлэхэд төрийн болон улс төрийн институцийн үүрэг.
3. Төрийн болон улс төрийн институцүүдийн чадамж.

Төлөөлийн ардчиллын онолын үүднээс авч үзвэл, хууль тогтоох институц болох Улсын Их Хурал нь үндэсний нийтлэг арх ашгийг илэрхийлэн хамгаалж байдгаараа бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны байх шинжээ бүрдүүлж байдаг. Монгол

Улс парламентын тогтолцоонд шилжээд 30 жил болсон хэдий ч хууль тогтоох институцийн ард түмнийг төлөөлөх чиг үүрэг багасах, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэхэд чиглэсэн үндсэн үүрэг нь бүдгэрэх, улмаар институцид итгэх олон түмний итгэл буурах байдал сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна.


Зураг 5. Институцид итгэх итгэл



(Эх сурвалж: “Улс төрийн барометр-2010-2020” судалгаа. Сант Марал сан)

Энэ нь тухайн институцууд тогтолцооны төлөвшил, үйл ажиллагааны харилцан үйлчлэл нь төлөөллийн ардчиллыг бэхжүүлэхэд сорилт болсоор байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, төрийн институцуудын үйл ажиллагааны уялдаа сул, улс төрийн намуудын төлөвшил сул, сонгуулийн тогтолцоо боловсронгуй бус байгаатай холбож ойлгож болохоор байна. Мөн УИХ-ын дотооддоо болон Засгийн газарт тавих хяналт улам бүр суларч, засаглалын институцуудын хараат бус бие даан ажиллах зарчим алдагдсаар байгаатай холбоотой юм.


Зураг 6. Асуудал шийдвэрлэхэд төрийн, улс төрийн институт ба иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо



(Эх сурвалж: “Улс төрийн барометр-2010-2020” судалгаа. Сант Марал сан)


Улс төрийн шийдвэр боловсруулах үйл явцад төрийн институт болон улс төрийн нам, иргэний нийгмийн оролцоог авч үзэхэд гүйцэтгэх засаглалын институцийн оролцоо бусад институцуудаас давамгайлж байгаа нь ажиглагдсан хэдий ч аажмаар буурч байгаа нь бас харагдаж байна. Мөн Засгийн газрын үйл ажиллагааны талаарх үнэлгээнээс харахад “бүрэн нийцэж байна” гэсэн хариултын хувь “огт нийцэхгүй байна”, “бараг нийцдэггүй” гэсэн сонголтуудаас бага хувийг эзэлж байна. Энэ нь манай улсын хувьд 1992 оны ардчилсан Үндсэн Хууль батлагдсанаас хойшхи Засгийн газрын бүрэн эрхийн хугацааг авч үзэхэд хоёрхон Засгийн газар бүрэн эрхийн хугацаагаа дуусгаж, бусад нь бүгд хугацаанаас өмнө огцорч гүйцэтгэх засаглалын институцийн тогтвортой байдал алдагдсантай холбоотой юм. Мөн хууль тогтоох институт болон, гүйцэтгэх институцийн бүрэлдэхүүнийг хольж улмаар улс төрийн болон төрийн үйл ажиллагааг нэг чиглэлд явуулах болж эрх баригч улс төрийн хүчин сонгуулийн хуулийг өөрт ашигтай байдлаар өөрчлөн сонгуулийн тогтолцооны сөрөг талыг улам бүр нэмэгдүүлэн, төрийн институцуудын тогтвортой ажиллах үндсийг алдагдуулсантай холбоотой юм.

Зураг 7. Засгийн газрын үйл ажиллагааны талаарх үнэлгээ




(Эх сурвалж: “Улс төрийн барометр-2010-2020” судалгаа. Сант Марал сан)

“Азийн барометр судалгаа”-ны үр дүнг харахад улс төрийн системд ард түмний зүгээс ирж байгаа шаардлагад төрийн институцууд төдийлөн мэдрэмжтэй бус ханддаг байна. Сонгогчийн хувьд нам, нэр дэвшигчийн талаар бодит сонголт хийх боломжтой болж байгаа хэдий ч нөгөө талаар нийт ард түмний төлөөллийн институц болох УИХ-ын зүгээс Засгийн газарт тавих хяналт аажмаар буурч байгаа төлөв харагдаж байна.




Төрийн институцийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлохдоо институцийн хариуцлага, институцийн нэр хүнд, ардчиллыг бэхжүүлэхэд хүлээсэн үүрэг гэсэн үндсэн 3 хүчин зүйлийг авч үзсэн.

Зураг 13. Төрийн институцийн нэр хүнд



(Эх сурвалж: Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Зураг 14. Засгийн газар болон Ерөнхийлөгчийн хариуцлага, ардчиллын бэхжилтэд үзүүлсэн нөлөө



(Эх сурвалж: Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Төрийн институцийн хөгжил ба төрийн институцийн нэр хүндийн хамаарал нь 0.323*, төрийн институцийн хөгжил ба ардчиллыг бэхжүүлэхэд хүлээсэн үүргийн хамаарал нь 0.370*, төрийн институцийн хөгжил ба төрийн институцийн хариуцлагын хамаарал нь 0.767* нэгж байна. Эндээс авч үзвэл Төрийн институцийн хөгжил нь төрийн институцийн хариуцлагаас хамгийн их буюу 0.767 нэгжээр, төрийн институцийн нэр хүнд(х11)ээс хамгийн бага буюу 0.323 нэгжээр эерэг хамаарч байна. Өөрөөр хэлбэл, төрийн институцийн хөгжилд хамгийн их ахиц бий болгохын тулд институцийн хариуцлагад илүү их анхаарах шаардлагатай буюу төрийн институцийн хариуцлагыг нэг нэгжээр нэмэгдүүлэхэд төрийн институцийн хөгжилд 0.767 нэгжийн эерэг өөрчлөлт бий болох боломжтой болохыг дээрх хамаарлын шинжилгээ харуулж байна. Улс төрийн институцийн хөгжил ба улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын хамаарал нь 0.468*, улс төрийн институцийн хөгжил ба улс төрийн намын гишүүнчлэл, хүний нөөцийн асуудлын хамаарал нь 0.384*, улс төрийн хөгжил ба улс төрийн намын санхүүжилтийн хамаарал нь 0.563* байна. Эндээс авч үзвэл улс төрийн институцийн хөгжил нь улс төрийн намын санхүүжилтаас хамгийн их буюу 0.563 нэгжээр, улс төрийн намын гишүүнчлэл, хүний нөөцийн асуудлаас хамгийн бага буюу 0.384


нэгжээр эерэг хамаарч байна.

Төлөөллийн ардчилал төрийн институцүүдийн хууль боловсруулах, бодлого төлөвлөх шийдвэр гаргах үйл явцад иргэдийн төлөөллийг хангаж чадаж байгаа эсэхээр хэмжигдэнэ. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцооноос 0.175*, залуучуудын оролцооноос 0.138*, ахмадуудын оролцооноос 0.204*, эмэгтэйчүүдийн оролцооноос 0.164*, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн оролцооноос 0.167*, үндэсний цөөнхийн оролцооноос 0.175*, малчдын оролцооноос 0.199*, алслагдсан орон нутагт оршин суугчдын оролцооноос 0.180* нэгжээр тус тус хамаарч байна. Эндээс авч үзвэл, иргэдийн оролцоо нь ахмадуудаас хамгийн их буюу 0.204 нэгжээр, залуучууд /18-35/ үеийнхнээс хамгийн бага буюу 0.138 нэгжээр эерэг хамаарч байна.

Иргэний нийгмийн байгууллагуудын хөгжилд боловсролын төлөөх төрийн бус байгууллагууд 0.176* нэгжээр, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллагууд 0.187* нэгжээр, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагууд 0.175* нэгжээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагууд 0.182* нэгжээр, малчдын эрх ашгийг хамгаалах байгууллагууд 0.174* нэгжээр, нийгмийн бусад хөдөлгөөнүүд 0.156* нэгжээр, цахим хөдөлгөөн, сошиал санаачилга арга хэмжээнүүд 0.202* нэгжээр, шашны байгууллага, холбоод 0.177* нэгжээр тус тус нөлөөлсөн байна. Эндээс иргэний нийгмийн байгууллагуудын хөгжилд цахимаар явагддаг сошиал хөдөлгөөн, санаачилга, арга хэмжээнүүд хамгийн их буюу 0.202 нэгжээр, нийгмийн хөдөлгөөнүүд бусад хөдөлгөөнүүдээс хамгийн бага буюу 0.156 нэгжээр эерэг хамаарч байгаа нь харагдаж байна.

Ардчиллын бэхжилтэд иргэдийн улс төрийн соёл төлөвшил хэрхэн нөлөөлж байгааг судлахад улс төрийн ардчилсан соёлын хөгжилд иргэдийн улс төрийн оролцоо 0.205* нэгжээр, иргэдийн төр засгийг хүндэтгэх байдал 0.158* нэгжээр, иргэдийн улс төрийн боловсрол 0.140* нэгжээр, иргэдийн төр засгийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх байдал 0.157* нэгжээр, улс төрийн систем, үйл явцын талаарх мэдлэг 0.187* нэгжээр, төр түүний институцид итгэх итгэл 0.157* нэгжээр, улс төрийн институцийн талаарх үнэлэмж 0.150* нэгжээр, төр засгийн талаарх төрийн институцийн талаарх үнэлэмж 0.171* нэгжээр тус тус нөлөөлж байна.

Зураг 15. Ардчиллын бэхжилтэд нөлөөлсөн хүчин зүйлүүдийн хамаарлын шинжилгээ



(Эх сурвалж: Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Эндээс улс төрийн соёл төлөвшил нь иргэдийн улс төрийн оролцооноос хамгийн их буюу 0.205 нэгжээр, иргэдийн улс төрийн боловсролоос хамгийн бага буюу 0.140 нэгжээр эерэг хамаарч байна.

Дээрх хүчин зүйлүүдийг ардчиллын хөгжилд хэрхэн нөлөөлснийг судлаж үзэхэд төрийн институцийн хөгжил 0.255* нэгжээр, улс төрийн институцийн хөгжил 0.175* нэгжээр, иргэдийн оролцоо 0.021* нэгжээр, иргэний нийгмийн хөгжил 0.149* нэгжээр, улс төрийн соёлын төлөвшил 0.166* нэгжээр тус тус нөлөөлсөн байна. Эндээс харвал, ардчиллын хөгжил нь төрийн институцийн хөгжлөөс хамгийн их буюу 0.255 нэгжээр, иргэдийн оролцооноос хамгийн бага буюу 0.021 нэгжээр эерэг хамаарч байна

Төлөөллийн ардчиллын бэхжилтэд улс төрийн институцийн нөлөө


Дэлхий дахинд ардчиллын олон хэв загвар бүрэлдэн хөгжиж буй хэдий ч төлөөллийн ардчилал, түүний ололт амжилт, уналтын олон шалтгааныг улс төрийн намтай холбон тайлбарлаж ирсэн. Улс төрийн нам нь иргэд төрөө эмхлэн байгуулах оролцооны суваг, бүгд найрамдах засаглалын үндсэн “хэрэгсэл” болон хөгжихдөө сонгуульт ардчилал буюу төлөөллийн ардчиллын үндсэн институт болон төлөвшжээ. Энэ агуулга, ач холбогдлоор нь намыг төлөөллийн ардчиллын үндсэн, гол элемент гэж үзэхийн сацуу улс төрийн ач холбогдолоор нь төрөөс илүү үнэлж, цэгнэх нь бий.

Төлөөлөл нь ардчилсан нийгэмд иргэдийн зохион байгуулах гол зарчим байсаар ирсэн. Иргэдийн улс төрд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх, тэдний ашиг сонирхлыг төлөөлөх хоорондын тэнцвэрт байдлыг хангахад төлөөллийн ардчиллын мөн чанар оршдог. Тийм байж чадвал ард түмэн хүлээн зөвшөөрдөг. Төлөөллийн ардчиллыг хөгжүүлэхэд нам дараах хэдэн чухал үүргийг гүйцэтгэдэг гэж үзэж болно.

Нэг. Нам бол ардчиллын үндсэн институт мөн. А.Линкольны хэлснээр “Ардчилал бол ард түмний төлөө, ард түмний оролцоотой, ард түмний өөрсдийнх нь байгуулсан засаг” гэж үзэх юм бол тэрхүү оролцооны үндсэн суваг нь улс төрийн нам юм. Тиймээс орчин үед намгүйгээр ардчиллыг төсөөлөх аргагүй, ардчилалгүйгээр намыг хөгжүүлэх боломжгүй. Намууд ардчиллыг бүтээдэг (Ж.Тертогтох, 2014) бол ардчилал намыг төлөвшүүлж, хөгжүүлдэг. Төлөөллийн ардчиллын суурь зарчмуудыг хэрэгжүүлэхэд намын үүрэг роль улам бүр нэмэгдэж байгааг судлаачид онцолж байна (Gunther R L. J., 2009).

Нөгөө талаар иргэний улс төрийн эрх, эрх чөлөөг дээдэлж, хангахад улс төрийн намын үүрэг улам өсөн нэмэгдэж байна. Нам нийгмийг гэгээрүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарах болсон. Үүний үр дүнд иргэдийн ухамсартай оролцоо өсөн нэмэгдэж, улс төрийн эрхээ эдлэх, эрх зөрчигдөхөөс сэргийлэх, тэгш эрхийг хангах зэрэг өргөн боломжийг нээсэн нь төлөөллийн ардчиллын чанарт шууд нөлөөлдөг болсон. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Фрийдом Хаусын судалгаагаар Монгол Улсад иргэний улс төрийн эрх, эрх чөлөөний зэрэглэлийн дундаж (1.0-2.5 оноо эрх чөлөөт, 3.0-5.0 оноо хагас эрх чөлөөт, 5.5-7.0 оноо эрх чөлөөгүй) 2012 оны байдлаар 2.0 оноогоор “чөлөөт” гэсэн ангилалд багтсан бол 2018 оны байдлаар мөн л 2.0 оноогоор “чөлөөт” (<https://freedomhouse.org/sites/default/files/>, 2020) гэсэн ангилалдаа хэвээрээ байна. Олон улсын байгууллагын судалгаагаар улс төрийн эрх, эрх чөлөөгөөрөө “чөлөөт” гэсэн ангилалд багтаж буй хэдий ч түүний хэрэгжилтийг бодитойгоор үнэлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм. Монголд хийгдсэн зарим судалгааны дүнгээс харахад өнөөгийн улс төрийн тогтолцоо, иргэний улс төрийн эрх, эрх чөлөөний хэрэгжилт нийгэм, эдийн засгийн нөхцөл, орлогын ялгаатай байдлаас үүдсэн сорилтууд байсаар байгааг тэмдэглэж байна.

Зураг 9. Өнөөгийн ардчилал болон улс төрийн тогтолцоо сэтгэлд нийцэх байдал



(Эх сурвалж: “Улс төрийн барометр. 2010-2022” судалгаа. Сант Марал сан)

Хоёр. Нам бол улс төрд төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх үндсэн механизм. Орчин үеийн агуулгаараа нам болон сонгууль нэг цаг хугацаанд үүсэн, хөгжиж ирсэн. Нам үүссэн цагаасаа л төлөөллийн байгууллага байсан төдийгүй өдгөө ч энэ чанараа гээгээгүй. Нам нь төлөөллийн хоёрдмол шинжийг өөртөө агуулж байдаг онцлогтой институт. Нам дотооддоо намын лидерээс эхлэн намын дээд, дунд, доод шатанд гишүүд, дэмжигчдээс сонгогдсон сонгуульт албан тушаалтнуудаар цөмөө бүрдүүлдэг бол, гадна талдаа иргэд сонгогчдын дэмжлэгээр төрийн төлөөллийн байгууллагад сонгогдсон гишүүдээрээ дамжуулан өөрийн бодлогоо нийгэмд хэрэгжүүлдэг. Эндээс нам бол нийгмийн төлөөллийг хэрэгжүүлдэг улс төрийн үндсэн институт мөн.

Харин намууд төлөөллийг хэрэгжүүлэх онцлог, арга хэлбэрээрээ өөр хоорондоо ялгаатай. Энэхүү ялгаатай байдлыг эш үндэс болгон судлаачид элит нам, олон түмний нам, боловсон хүчний нам, өргөн хүрээний нам, картель нам гэх зэргээр хэв маягчилж ангилдаг. Орчин үед ардчиллын ололт амжилт, түүний чанар, бэхжилтийн үр дүнд намын хөгжилд таатай боломжуудыг нээсэн явдал нь намын шинэ хэв маягууд бий болох бодит нөхцөлийг бүрдүүлсэн. Нөгөө талаар намын хөгжлийн үйл явц эрчимжих, шинэ ойлголт, хандлагуудаар баяжиж буй явдал нь төлөөллийн ардчилал түүний хамрах хүрээ тэлж байгаа үйл явц гэж ойлгож болно.

Гурав. Нам бол улс төрийн коммуникацийг хөгжүүлэгч институт юм. Орчин үеийн төлөөллийн ардчилалд улс төрийн намын хөгжил онцгой байр суурь эзэлж байна. Ардчиллын чанар, иргэдийн оролцооны олон талт хэлбэрүүд бий болж байгаатай уялдуулан улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд зарчмын томоохон шинэчлэл явагдаж байна. Үүний нэг тод илрэл бол “дигитал нам” (Gerbaudo, The Digital Party: Political Organization and Online Democracy, 2019, p. 4) юм. Уламжлалт


хандлагаас дижитал намын үүрэг орчин үеийн улс төр, сонгуульд оролцож саналаа өгөхөөс хөндийрсөн, ардчиллын үнэ цэнийг төдийлөн ойлгохгүй байгаа сонгогчдод хүрэх, намын үйл ажиллагааг идэвхтэй явуулах боломжийг олгож болохоор болсон байна.

Төлөөллийн ардчиллын бэхжилт ба Монголын улс төрийн намууд

1992 оны Үндсэн хуулиар парламентын засаглалыг сонгож, олон намын системийг төлөвшүүлэх ардчилсан шилжилтийн үйл явц Монгол Улсад төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх хөрс суурийг тавьсан. Төлөөллийн ардчиллыг бэхжүүлэхэд улс төрийн намууд маш чухал үүрэг гүйцэтгэж ирсэн, цаашдаа ч намуудын үүрэг, хариуцлага улам бүр өсөх хандлагатай байна. Сүүлийн жилүүдэд төлөөллийн ардчиллын мөн чанар алдагдлаа, сонгуульд дарангуйллын шинжүүд илрэх боллоо, нэг намын олон жилийн засаглал олон ургальч үзэл, улс төрийн тавцан дахь намуудын өрсөлдөөний гарааны тэгш нөхцөл, боломжийг улам бүр хумьж байна гэх зэрэг өргөн хүрээний шүүмжлэл иргэд, иргэний нийгмийн байгууллага, намуудыг зүгээс байнга гарах боллоо. Иймд төлөөллийн ардчиллын өнөөгийн байдал, түүнд намуудын гүйцэтгэж буй үүрэг, хариуцлагыг улам нарийвчлан авч үзэх шаардлага бодитойгоор тулгарч байна.

Үүний тулд төлөөллийн ардчиллын хөгжил, бэхжилтийн өнөөгийн дүр зургийг тодруулах хэрэгтэй. Удирдлагын Академиас хийсэн судалгаанд (Г.Чулуунбаатар Ш. 2021) төлөөллийн ардчилал гэх ойлголтын шинж чанарыг илэрхийлэх үндсэн гурван зарчим болох “иргэний эрх чөлөө”, “иргэний хяналт”, “иргэний тэгш эрх” гэсэн гурван багц дэд үзүүлэлтийг сонгож судалсан байна. Судалгааны дүнгээс нэгд, иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналттай байх тухай ойлголт Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжинд тусгагдсан, хоёрт, ардчилсан засаглалын онолын концепцийн ойлголт судлагдсан хэдий ч нийтийн хүртээл болоогүй, гуравт, Монгол Улсын төрийн байгуулал дахь төрийн институцийн үйл ажиллагааны чиг үүрэг, харилцан хамаарлын хүрээнд онолын зөрүүтэй ойлголт хуульчлагдсан, дөрөвт, төрийн байгууллын институцийн үйл ажиллагааны зарчим хэт тунхаглалын чанартай бөгөөд иргэний “эрх чөлөө, иргэний тэгш эрх, иргэний хяналт”-тай байх зарчимд чиглэгдээгүй байна гэсэн зарчмын шинжтэй дүгнэлтийг хийсэн байна. (Г.Чулуунбаатар Ш. , 2021) Төрийн институцийг ингэж үнэлж дүгнэсэн байгаа бол иргэдийн улс төрийн эвлэлдэн нэгдэх эрхийн нэг хэлбэр болсон улс төрийн намуудын төлөөлөх чадварыг иргэд хэрхэн үнэлж дүгнэснийг дараах судалгаанаас харъя.

Зураг 10. Таны бодлоор манай өнөөгийн сонгогчид улс төрийн бодлогод хэр зэрэг нөлөө үзүүлж чадах вэ?




(Эх сурвалж: “Улс төрийн барометр. 2010-2020” судалгаа. Сант Марал сан)

Дээрх судалгааны дүнгээс харахад манай улс төрийн намууд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө, тэдний санаа бодлыг илэрхийлэх, хэрэгцээ шаардлагад нийцсэн бодлого, үйл ажиллагаа явуулж буй эсэх тал дээр маш хангалтгүй үнэлгээ, үнэлэмжийг авсан байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогсодын 50 ба түүнээс дээш хувь нь намыг сөргөөр үнэлсэн байгаа нь цаашид намууд төлөөллийн үүрэг, хариуцлагаа дээшлүүлэх, парламент дахь бодлого, үйл ажиллагаандаа дүгнэлт хийх цаг ирсэн гэж үзэхэд хүргэж байна. Төр нь ч төрийн эрхийг барьж буй болон бодлого шийдвэрт оролцож буй намууд, бодлогын гадна байгаа намууд ч ялгаагүй Монголын ардчилал өдий хүртэл “амь бөхтэй” явж ирсэний баталгаа болж буй төлөөллийн ардчиллыг сонголтоосоо урхахгүйгээр түүнд учирч буй сорилтуудыг даван туулах замаар улам бэхжүүлэх, чанаржуулахад цаашид анхаарах цаг болсоныг илтгэж байна.

Дэлхий дахинд ардчиллын хувь заяа ээдрээтэй, эргэлт буцалттай, далайн давлагаа мэт түрэлт, таталттай явж ирсэн. Тэр дундаа Ази тив дэх ардчилал маш эмзэг. Ази тивийн ардчиллын баян бүрд гэж нэрлэгдэж буй Монгол Улсын ардчилал түүнийг хадгалж, хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж буй төлөөллийн ардчилал, парламентын засаглалаа бэхжүүлэхэд бид чухам юу хийж чадах вэ?.

Юуны урьд улс төрийн намын төлөвшилт, хөгжилд онцгой анхаарах явдал чухал юм. Улс төрийн намуудын нэр хүнд жилээс жилд буурсаар байна. 2012 он буюу одоогоос 10 жилийн өмнө намуудыг үнэлэх иргэдийн үнэлэмж 45% орчим (судалгаа, 2012) байсан бол арван жилийн дараа буюу 2022 оны байдлаар хамгийн итгэл алдарсан инсититуцийн хоёрдугаарт эрэмблэгдсэн байна.

Зураг 11. Улс төрийн намд итгэдэг байдал



(Эх сурвалж: “Улс төрийн барометр. 2010-2020” судалгаа. Сант Марал сан)

Монголын улс төрийн намыг үнэлэх үнэлэмж ийнхүү буурахад юу нөлөөлөв. Хоёр суурь хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж болно. Үүнд:

1. Намын төлөөлөх чадвар түүний институцжилт. Монголын улс төрийн намуудад үзэл баримтлал, үнэт зүйлс, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны институцжилт маш сул явж ирсэн. Институцжилтийг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл явц удаашралтай байна. 1990 онд батлагдсан улс төрийн намын тухай хуульд 2007 онд “косметик” шинжтэй өөрчлөлт орсоноос өөрөөр ахиц дэвшил гараагүй байна. Улс төрийн намууд үзэл баримтлал, үнэт зүйлсээ намын их, бага хурал зөвлөгөөнүүдээрээ нийтэд зарлан тунхагладаг боловч түүнийгээ амьдралд хэрэгжүүлэх, нийгмийн амьдралд бодит байдал болгоход чиглэсэн үйл ажиллагааг явуулдаггүй “тунхаглал”-ын хэлбэрээр нь хадгалсаар өнөөг хүрсэн. Үндсэндээ намын бодлогыг тухайн намын үзэл баримтлал, үнэт зүйлсийг эрхэмлэж ойлгосон гишүүд, дэмжигчдийн оролцоог хангах байдлаар биш намын удирдлагад байгаа цөөхөн манлайлагчдын дүрээр бүтээдэг, тэр нь ихэнхдээ улс төр-бизнесийн төлөөллийн зарчмаар ажиллаж ирсэн учраас нэг талаас бодлогын шийдвэрийг төвлөрүүлэх, нөгөө талаас дургүйцсэн гишүүд, сонгогчдын дунд үзэл санааны “гацаанд” орсон. Энэ байдал нь намын дээд хэсгийг гишүүд, дэмжигчид, нийгмээс тасарч хөндийрөх нөхцөл рүү түлхсэн. Де Факто судалгааны институтээс 2020 онд хийсэн Улс төрийн намын дотоод ардчиллын индекс судалгааны дүнгээс үзэхэд “Улс төрийн намуудын авсан онооны хооронд зөрөө их гараагүй, дотоод ардчиллын түвшин тун ойролцоо буюу хангалтгүй түвшинд байна. Улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийг тодорхойлох судалгаанд хамрагдсан намуудыг авсан оноогоор дүгнэж болох ч оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдал гэсэн дөрвөн үзүүлэлт тус бүр дээр харилцан адилгүй, өөрчлөлттэй байна. Энэ нь улс төрийн намуудын сонгуульд нэр дэвшигчдээ тодруулах үйл явц, өрсөлдөөн, гишүүдийн оролцоо, ил тод байдал зэрэгтэй шууд хамааралтай байна” (Э.Гэрэлт-Од, 2020) гэж дүгнэжээ. Энэ нь намуудын бүтэц, зохион байгуулалтын институцжилт сул байгааг харуулж буй үзүүлэлт.

Ийнхүү намыг дотоод ардчилалгүй болгож, шийдвэрийг цөөнх “шилэн цонх”-ны цаана гаргах механизмыг бүрдүүлсэн нь нам институцийн соёлоор ажиллах биш улс төр бизнесийн зарчмаар ажиллаж ардчиллыг унагаж олигархийг төрүүлэх таатай хөрсийг бүрдүүлжээ. Олигархиудын үндсэн сонирхол нь “клиентелист нам” (Klima, 2017)-ыг зохион байгуулахад чиглэж бодит үр дүнд хүрсэн гэж үзэж болно.

Клиентелист¹ намын шинжийг Чехийн судлаач М.Клима доороос хувьчлагдсан нам, дээрээс колоничлогдсон нам гэсэн нэр томъёогоор илэрхийлж гаргасан байдаг. “Доороос хувьчлах нь орон нутаг, муж улмаар бүс нутгийн засаг захиргааг эзлэн авах зорилгоор хөлсний намын гишүүдийг олноор худалдан авдаг. Голлох үүргийг орон нутгийн баячууд эсвэл загалмайлсан эцгүүд гүйцэтгэнэ. Дээрээс колоничлох дээд төвшний далд бизнесийн субъектүүд хэрэгжүүлдэг” гэж дүгнэсэн. Судлаач М. Клима бидэнтэй нэг цаг хугацаанд ардчилалд шилжсэн Зүүн Европын орнуудад намын хөгжлийн энэхүү өвөрмөц гажуудал түгээмэл байгааг онцолсон.

Дээрх дүгнэлтээр авч үзвэл, Монголын улс төрийн намууд доороос хувьчлагдаж, дээрээс колоничлогдсон дүр төрхтэй байна. Үүний гол шалтгаан нь намууд орон нутгийн засаг захиргааны нэгжид бүтэцтэй байх хуулийн зохицуулалт, сонгуулийн тогтолцоо түүнийг дагасан намын дунд анхан шатны нэгжид эрх мэдлээ тогтоох гэсэн улс төрчдийн өрсөлдөөн. Төлөөллийн дээд байгууллага УИХ-д сонгогдсон гишүүд өөрийн сонгогдсон сонгуулийн тойрогт “хөлтэй” байхын тулд нийслэл, орон нутаг дахь намын дунд, анхан шатны байгууллагын “колоничлох” үйл ажиллагаанд зайлшгүй татагдан ордог. Тиймгүй бол дараагийн сонгуульд ялалт байгуулах ямар ч боломжгүй болно. Нөгөө талаар намын дунд, анхан шатны байгууллагын удирдлага орон нутаг сонгуульд ялж өөрийн эрх мэдлийг тогтоохын тулд УИХ-д сонгогдсон гишүүдийнхээ ивээлийг хүртэх, хариуд нь тэдэнд “аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ” гэдэг зарчмаар үйлчилдэг тогтолцоог бүрдүүлсэн.

Өөр нэг жишээ татъя. Аливаа намын их, бага хурлыг зохион байгуулах, төлөөлөгчдийг сонгох, оролцуулах үйл явц мөн тухайн нутаг, тойргоос сонгогдсон УИХ, Засгийн газрын гишүүдийн бүрэн “ивээл” дор өрнөдөг. Сум, дүүрэг, хорооноос хэнийг төлөөлөгч болгох талд орон нутагт намыг колоничилсон дээд төвшний улс төрчдөөс ивээл хүртсэн дунд шатны дарга ажиллаж дунд доот шатанд намын гишүүдийг өөртөө татан ажиллаж намыг доороос нь хувьчлах ажлыг амжилттай гүйцэтгэж ажилладаг. Гишүүдэд мөнгө тараах, элдэв ажил алба амлах, биенесийн үйл ажиллагааг нь дэмжих зэрэг олон хөшүүргийг ашигладаг.

2. Улс төр, бизнесийн заагийг тогтоож, харилцан хамаарлыг хязгаарлах хууль эрх зүйн орчинг бүрдүүлж чадаагүй явдал Монголын төлөөллийн ардчилалд учирч буй том сорилт болсон хэвээр байна. Хамгийн эхэнд онцгой анхаарал хандуулах асуудал бол нам, сонгуулийн санхүүжилтийн орчинг боловсронгуй болгох явдал юм. Үүнийг бататгах үүднээс судалгааны доорх дүнг танилцуулья. Үнэлгээг 1-7 оноогоор (1 хамгийн сайн, 7 хамгийн муу үнэлгээг илтгэнэ) үнэлж дүгнэхэд экспертүүд нам болон сонгуулийн санхүүжилтийн өнөөгийн байдалд хангалтгүй үнэлгээг өгсөн байна.

¹ Клиентелизм- олон хүнийг хамарсан найз нөхөд, хамаатан садангийн онцгой харилцаа холбоо бөгөөд голдуу тодорхой зорилгод чиглэсэн байх ба нийгэм, эдийн засаг, улс төрийн эрх мэдлийн хувьд дээгүүр зиндааны нэг болон хэд хэдэн этгээд (патрон, ивээн тэтгэгч) нь доогуур зиндааны нөгөөдөө (клиент, дэмжигч, үйлчлэгч) өөрийн нэр нөлөө, боломж бололцоог ашиглан хангамж, хамгаалалт үзүүлж байхад клиент нь мөн хариуд нь ивээн тэтгэгчдээ үйлчлэх, үйлчилгээ үзүүлэх зэргээр дэмжлэг тусалцаа үзүүлдэг харилцааг хэлнэ.

Зураг 12. Улс төрийн санхүүжилтийн үнэлгээ



(Эх сурвалж: “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Улс төрийн нам, сонгуулийн санхүүжилтийн өнөөгийн зохицуулалтыг сайжруулахгүйгээр бид төлөөллийн ардчиллын бодит хэрэгжилтийг хангах боломжгүй гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Судалгаанд оролцсон експертүүд улс төрийн санхүүжилтийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй болгох, ингэхдээ сонгуулийн бус үеийн улс төрийн намын санхүүгийн мэдээллийг нийтэд нь ил болгохыг улс төрийн санхүүжилтийн орчны эрх зүйн зохицуулалтад тусгах хэрэгтэй байна гэж дүгнэжээ. Нам, сонгуулийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтын тунгалаг орчин бүрдүүлэх нэн ялангуяа олон улсад хэрэгжиж буй төрөөс санхүүжүүлэх механизмыг бий болгож улс төр, бизнесийн хамааралт байдлыг багасгаж чадвал нийгмийн олон талт төлөөллийг намд, цаашлаад төрд бий болгох бололцоо нээгдэнэ. Ингэж чадвал Монгол дахь төлөөллийн ардчиллын дархлаа сайжирч, бэхжинэ.

Keywords: Representative government, state and political institution, democracy strengthening

Abstract:

The key mechanisms and institutions to operate democracy are the keys to recognizing the quality of democracy. Each country has a variety of indicators that will help recognize the quality of democracy, such as ethics, law, equal and accessible participation of citizens. In studying the impact of the State Institution, the political institution, and other stakeholders involved in the strengthening of democracy, he analyzed factors and dependency tests and analyzed the challenges facing the strengthening of democracy.

Дүгнэлт

Дэлхий дахины улс төрийн намуудад гарч буй өөрчлөлт, хөгжлийн шинэ чиг хандлага Монголын улс төрийн намуудад хэрхэн нөлөөлж, тэр чиг хандлага руу хөгжих нөхцөл бүрдэж буй эсэх нь өнөөдөр чухал асуудал болоод байна. Мэдээллийн технологийн хөгжил, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ололт амжилт бүр улс төрийн намын бодлого,

үйл ажиллагаа, зохион байгуулалтад эерэг, сөргөөр нөлөөлж ирсэн байдаг. Сүүлийн жилүүдийн байдлаас дүгнэхэд Монголын намууд мэдээллийн технологийн хөгжлийн давуу талыг ашиглах чиглэлд ихээхэн хүч, нөөцийг дайчлах болсон. Сонгуулийн кампанит ажлын зардлын 50-иас доошгүй хувийг үүнд зарцуулж байна гэсэн судалгаа бий. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулах, сайт болон мэдээллийн технологийн компаниуд, ассосиаци, мэргэжлийн байгууллага, судлаачдын татан оролцуулах хандлага эрс нэмэгдсэн.

Фэйсбүүк, твиттер, инстаграмм болон бусад сошиал талбарыг ашиглах, эдгээрт олон дагагчтай инфлүүсэрүүдийг хөлслөх, олон нийтэд танигдсан, нэр нөлөө хүмүүсээр пост, жиргээг хийлгэх зэргээр намууд гудамжны улс төрөөс дэлгэцийн улс төр рүү шилжих шилжилтийг хийж буй дүр зураг ажиглагдаж байна. Зарим тохиолдолд сошиалын мэдээ мэдээлэл, ирж буй даралт, шахалтаас үүдэн Засгийн газар бодлого шийдвэрээ өөрчлөх тохиолдолд ч гарч байна.

Манай намууд мэдээлэл, технологийн ололтыг ийнхүү ашиглах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд их ач холбогдол өгөх үйл явц үндсэндээ сүүлийн гурван сонгуулиас эрс идэвхжсэн билээ. Телевиз, радио, сайт болон бусад мэдээллийн сувгуудийн тоо ч үүнийг дагаад маш их нэмэгдсэн. Энэ нь нэг талдаа иргэд мэдээллийг олон талт эх үүсвэрээс олж авах, хэвлэлийн эрх эрх чөлөөг бий болгох сайн талтай ч нөгөө талдаа хэвлэлээр улс төрчид, улс төрийн намыг “агнах” (төлбөрт захиалгат нэвтрүүлэг, жиргээ, пост, нийтлэл, ярилцлага гэх мэт) шинэ ажлыг бий болгож нийгэмд манипуляцийг бодитой хэрэгжүүлэх хөрсийг бүрдүүлсэн байна. Энэ бол сөрөг тал нь юм.

Гэвч монголын намуудын дижитал шинжийг олж байгаа дүрх төрх нь дэлхий намын хөгжлийн чиг хандлагад нийцэж буй мэт боловч бодит байдалд хатуу гишүүнчлэл, засаг захиргааны нэгжид суурилсан данхар бүтэц, иргэд сонгогчид нийгэмд биш гишүүддээ үйлчилдэг хуучинсаг үйл ажиллагааны арга барил зонхилсон хэвээр байна. Энэ байдлыг шинэчилж дижитал нам, цахим нам болохын тулд бодлого, эрх зүйн орчноо өөрчилж нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн лидерүүдийг төрүүлэх замаар цомхон чадварлаг, хурдан хугацаанд маневрлах чадвартай бүтэц, зохион байгуулалтыг бий болгон ажиллах цаг нэгэнт ирсэн байна. Хатуу гишүүнчлэлийн асуудлыг эргэн харж орчин үеийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэхгүйгээр бид төлөөллийн ардчиллыг намаар дамжуулж бодитой төлөвшүүлэх бололцоо хумигдсаар байх болно.

Өнөөдрийн байдлаар авч үзэхэд, Монголын улс төрийн намууд дижитал, цахим намын тодорхой шинжийг өөртөө бий болгосон гэхдээ уламжлалт бүтэц, хүний нөөцийг бодлогоо үргэлжлүүлсэн намын хөгжлийн гибрид хэв шинжтэй гэж дүгнэж болохоор байна. Энэхүү гибрид шинж төрх нь намуудын төлөөллийн ардчиллыг хөгжүүлэх, төлөөлөх чадварыг нэмэгдүүлэхэд нэг их эерэг нөлөө үзүүлэхгүй байх дүр зураг ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, Монголын намуудын үндсэн шинж бол төрийн албан тушаалыг хуваарилах (албан тушаалын буюу боловсон хүчний нам), түүнд нам доторх бүлэглүүд өөрсдийн хүнээ томилуулахын төлөө ажилладаг улс төрийн институт болон хувирсан байна.

Ном зүй

1. Held, D. (2006). Models of democracy. Cambridge and Malden: Polity
2. John Stuart Mill. (1991). Considerations on Representative Government. Prometheus Books, NY
3. Robert A. Dahl. (1956). A Preface to democratic theory. Chicago: University of Chicago Press
4. Robert A. Dahl (1971). Polyarchy: Participation and opposition. New Haven: Yale University Press

МОНГОЛ ДАХЬ АРДЧИЛАЛ БА ТҮҮНИЙ ЧАНАР

Д.Ганбат

Улс төрийн Боловсролын Академийн
Удирдах Зөвлөлийн дарга**Товч агуулга:**

Ардчиллын чанарын хувьд гурав дахь давалгааны ардчилсан улс өнөөдөр ч янз бүрийн асуудалтай тулгарсаар байгаа ба зарим нь улс төрийн хөгжлийн зогсонги байдлаас гарахын тулд “хадуурах” явдал түгээмэл болжээ. Ардчиллын амлалт ба бодит байдлын хоорондын ялгаа улам нэмэгдсэн, ардчилсан замаар сонгогдсон төрийн түшмэд авлигад автсан, өрсөлдөх чадваргүй, төр засаг нь иргэдийн дуу хоолойг үл тоодог, сонгогчдын итгэл даах чадвар сул гм шинэ ардчилсан улсуудыг тодорхойлох төсөөлөл нэгэнт бий болжээ.

Учир иймд, ардчиллын чанарыг цогцоор нь сайжруулахгүй бол ардчилал хүлээн зөвшөөрөгдөхүйц, хууль ёсны (legitimacy) болох боломжгүй гэдгийг гурав дахь давалгааны ардчилсан улсын жишээ харуулж, энэ нь Азийн шинэ ардчиллын хувьд бүр ч илүү чухал болно. Олон түмний ой санамжинд амь бөхтэй оршсоор байгаа өмнөх тоталитар, авторитар системийн үлдэгдэлтэй өрсөлдөхийн зэрэгцээ өнөөдөр “үр ашигтай” гэсэн имиж төлөвшүүлж буй авторитар, хагас авторитар хөршүүдийн (Хятад, Сингапур) жишээтэй давхар өрсөлдөх хэрэгтэй болсон. Энэ утгаараа, Зүүн Азийн хөгжингүй ардчилсан (Япон зэрэг) улсын бодит байдал, шинж чанар, ардчиллын хөгжил нь шинэ ардчилсан улсуудад улам чухал болж ирнэ.

Төсөөлж байсан ардчиллын чанар амьдралд биеллээ олохгүй бол ардчилал алсдаа ард түмний зүрх сэтгэлийг эзэмдэж чадахгүй болно. Өөрөөр хэлбэл, ардчиллын легитим шинж ба ардчиллын чанар хоорондоо цогц хамааралтай юм¹. Сайн засаглалын шинж болох улс төрийн эрх чөлөөт байдал, тэгш эрх, эрх зүйт ёс, хариуцлага, тайлагнал, ил тод байдал зэрэг нь ардчилсан дэглэмийн бодит илэрхийлэл болсноор олон нийтийн оролцоо, дэмжлэг нэмэгдэж өмнөх дэглэмийн ул мөр арилах болно. Нөгөө талаас, муу засаглалын шинж тэмдэг болох эцэс төгсгөлгүй авлига, сонгуулийн луйвар, сунжирсан хуурмаг амлалт зэрэг нь ардчиллын институтэд итгэх иргэдийн итгэлийг хэврэг болгоно.

Түлхүүр үг: Ардчиллын чанар, ардчиллын легитим шинж, ардчиллын үнэт зүйлс

А. Ардчиллын легитим шинж

- Taagepera R (2003) Arend Lijphart's Dimensions of Democracy: Logical Connections and Institutional Design. Arend Lijphart's Dimensions of Democracy: Logical Connections and Institutional Design. *Political Studies* 51(1): 1–19.

МОНГОЛЫН ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН СОРИЛТ БЭРХШЭЭЛ, БОЛОМЖ НӨХЦӨЛ

Д.Мягмарсүрэн

ШУТИС, Хүний нөөцийн захирал, доктор, дэд профессор

Я.Төгөлдөр

ШУТИС, БУХС, Нийгмийн ухааны салбарын эрхлэгч, дэд профессор

Түлхүүр үг: Төрийн бус байгууллага, улс төрийн хөдөлгөөн, институционал өөрчлөлт, посткоммунист нийгэм, эрх зүйн институтичлал, иргэний оролцоо.

Хураангуй:

Энэхүү илтгэлээр өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Монгол дахь иргэний нийгмийн хөгжил төлөвшлийн үе шатыг үечлэн тоймлон тодорхойлоход чиглэв. Ардчилсан шинэчлэл, зах зээлийн харилцааны хосолмол шилжилт хийсэн хагас жарны хугацаанд посткоммунист монголын нийгэм, соёлын өвөрмөц орчинд иргэний нийгэм бүрэлдэхэд ямар сорилт бэрхшээлийг туулж байгааг авч үзлээ. Ардчилсан улс төрийн шинэтгэл, зах зээлийн эдийн засаг, эрх зүйн салбарын шинэтгэл, уул уурхай, олборлох салбарын гэнэтийн өсөлт ба бууралт, монголын уламжлалт ахуй соёл, мэдээллийн технологийн дэвшил, даяаршил зэрэг гадаад, дотоод хүчин зүйлс Монгол төрхөт иргэн хөгжихөд ямар бололцоо нөхцөл олгож буйг авч үзсэн болно.

Иргэний нийгмийн тухай үндсэн ойлголт, үзэл санаа

Иргэний нийгэм /Social society/ хэмээх нэр томъёог Английн философич А.Фергюсон 1767 онд “*An Essay on the History of Civil Society*” бүтээлдээ хэрэглэж эхэлснээр нийгмийн ухаанд эргэлтэд анх орсон ажээ. Улмаар иргэний нийгмийн үзэл санааг Ж.Локк, Ш.Л.Монтескье, С.Пуфендорф, И.Кант, Ф.Гегель зэрэг өрнөдийн сэтгэгчид боловсруулсан.

Төрийн бүтцээс иргэний нийгмийн ялгарах тал бол иргэний нийгэм нь эрх чөлөөтэй, тэгш эрхтэй хамтран хоршигчдын өрсөлдөөнт, эв нэгдэлт харилцаа нь төр лугаа адил босоо, угсраа биш, харин эсрэгээрээ хэвтээ, зэрэгцээ хэлхээ холбоонд суурилдагт оршино¹. Эдүгээ энэ ойлголтыг тодорхойлсон олон янзын онолын баримтлалууд бий бөгөөд иргэний нийгмийн тухай тэдгээр тодорхойлолтод ерөнхий төстэй талууд байх боловч төгс нарийн нэгдсэн ойлголцолд хүрсэн нь бага юм. Тухайлбал, зарим тодорхойлолт нь иргэний нийгмийн тодорхой хэсэг шинж чанарыг онцлоод бусдыг орхигдуулдаг бол зарим нь төрийн эрх мэдэл, улс төр, иргэний хүний эрх чөлөөний тал дээр илүүтэй анхааран тодорхойлж, үлдсэн хэсэг нь нийгмийн хөрөнгө, нэгдэл нягтрал болоод эдийн засгийн үүрэг функцийн асуудалд илүү ач холбогдол өгдөг байх жишээтэй. Эдгээр үзэл хандлага нь бие биенээ нөхдөг ба онол, зарчим гэхээс илүү бодлогын хэрэгжилт, онцолж буй зүйл, тайлбарлалын асуудал дээр ялгаатай төдий юм².

¹ Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. Уб., 2014. Х-6

² Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. Уб., 2014. Х-40-41

Улс төрийн философич Эрнест Геллнер иргэний нийгмийг төр, зах зээлийн хооронд оршин нийгмийн хүрээ, төр хийгээд зах зээлийн аль алиныг хангалттай хянаж чадах бамбай бүс, тиймээс аль нэгнийг хүчирхэг, хэт давуу болохоос сэргийлж байдаг гэж үзжээ³.

Нийгмийн тогтолцооны тоглогчдыг эрдэмтэн судлаачид янз бүрээр ангилан хуваасан нь бий. Тэдгээр институциудын харилцаа, түвшинг авч үзсэн үзэл баримтлал, онолуудад иргэний нийгмийн эзлэх байр суурийг тодотгосон үзэл санаа цөөнгүй. Тухайлбал, Ж.Рокамора зэрэг судлаачид өөр хоорондоо харилцан хамаарал бүхий 4 түвшинд нийгмийн институцийг ангилсан байна.

- Төр
- Улс төрийн нийгэм
- Иргэний нийгэм
- Олон улсын тоглогчид гэж хуваасан байна.⁴

Дээрх болон бусад онол, үзэл баримтлалууд дахь нийтлэг санаа нь иргэний нийгэм харьцангуй бие даасан бөгөөд нийгмийн бусад тоглогчидтой харилцан үйлчилж байдаг аливаа ардчилсан тогтолцоон дахь чухал тоглогч байдаг.

Иргэний нийгмийн талаарх орчин үеийн онол, үзэл баримтлалыг үндсэн дөрвөн загварт хувааж үзэх хандлага нийтлэг байна. Үүнд:

1. Коммунитариан загвар буюу иргэдийг нийгэмшүүлэх, эв нэгдлийг бэхжүүлэх зэргээр нийгмийн капиталыг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн сайн дурын нийгэмлэг холбоодын чиг үүргийг авч үздэг. Гол төлөөлөгч А.Макинтайр, М.Уолцер, Амитай Этциони, Р.Патнам, Ж.Коулман
2. Иргэдийн улс төрийн оролцооны загварыг чухалчлан хөнддөг “Ардчилсан загвар” нь төрөөс бие дааж зохион байгуулалтад орж, иргэдийн улс төрийн эрх, иргэний үндсэн эрхийг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулдагаараа онцлог
3. Либерал хувилбар. Төрийн оролцоогүй төвлөрсөн улс төрийн эрх мэдлээс заан чиглүүлдэггүй бие даасан байгууллагуудын хэлбэрээр орших нь иргэний нийгмийн суурь үндэс болох тухай санааг германы социологич Р.Дарендорф дэвшүүлжээ. Түүний бодлоор улс төрийн ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засаг, иргэний нийгэм гэсэн гурван тулгуур дээр эрх чөлөө оршдог⁵ ажээ.
4. Юрген Хабермасын дискурс-онолын хандлага. Иргэний нийгэм нь аяндаа бий болсон нийгэмлэг, байгууллага, хөдөлгөөнүүдээс бүрэлдэх бөгөөд чухамхүү янз бүрийн түвшний олон ургальч хэлэлцүүлэг, мэдээлэл харилцааны үр дүнд улс төрийн үйл явц, хууль эрхийн төгөлдөржилт, эрүүл иргэний нийгэм төлөвшин хөгждөг болохыг задлан шинжилсэн.

Онолын шинжтэй олон ойлголт, тодорхойлолтыг нэгтгэн, эмпирик түвшинд судалгаа хийх зорилгоор нилээн оновчтой тодорхойлолт гаргах оролдлогыг CIVICUS буюу Иргэний оролцоог дэмжих дэлхийн холбоо хийсэн байдаг. “Иргэний нийгэм бол гэр бүл, төр, зах зээл зэргээс гадуур оршдог иргэдийн эвсэлдэн нэгдэж, нийтлэг эрх ашгийнхаа төлөө үйл ажиллагаа явуулдаг талбар” гэсэн тодорхойлолтыг олон улсын байгууллага иргэний нийгмийн индекс боловсруулахдаа баримталдаг. Энэхүү өгүүлэл нь уг тодорхойлолтын хүрээнд Монголын иргэний нийгэм, түүний хөгжил төлөвшлийг үечлэн хувааж, тулгарч буй, сорилт бэрхшээлийг задлан шинжлэх юм.

³ Ernest Gellner, Conditions of Liberty: Civil Society and Its Rivals. Penguin Books, 1996. p-34

⁴ Emma Porio Civil Society and Democratization in Asia: Prospects and Challenges in the New Millennium New challenges for development and modernization: ..., 2002 https://www.academia.edu/1000929/Civil_Society_and_Democratization_in_Asia_Prospects_and_Challenges_in_the_New_Millennium

⁵ Ralf Dahrendorf Reflections on the revolution in Europe: in a letter intended to have been sent to a gentleman in Warsaw, 1990. 154p

Орчин үед иргэний нийгмийн талаарх тоон мэдээлэл, мэдээллийн хүртээмж сайжирч байгаа тул түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд улам бүр нэмэгдэж байна. Тухайбал, улс орнуудын иргэний нийгмийн талаарх тоон өгөгдөлд тулгуурлан үр дүнгээ нийтэлдэг судалгааны дараах гол тайлангуудыг дурдаж болно. Үүнд:

1. The Global Civil Society Index developed by the Coparative Nonprofit Sector Project at Johns Hopkins University (<http://www.jhu.edu>), 40 гаруй орны ашгийн бус байгууллагын хамрах хүрээ, эдийн засгийн хувь нэмэр зэрэгт шинжилгээ хийдэг.
2. The Civil Society Strength Index developed on the basis of the CIVICUS Civil Society Index data, (www.civicus.org), 50 гаруй орны иргэний нийгмийн байдлыг үнэлгээний оролцооны арга болон холимог олон аргуудыг ашигладаг.
3. LSE's Global Civil Society Index, which measures the extent to which a country's civil society participates in global civil society, (<http://www.lse.ac.uk/Depts/global/researchgcs.pub.htm>), Лондонгийн Эдийн засгийн сургуулиас хэвлэдэг, жил бүрийн дэлхийн иргэний нийгэмд тулгарч буй сорилтуудын талаар нийтэлдэг.
4. USAID's NGO Sustainability Index for post-Communist Europe and Eurasia, a (http://www.usaid.gov/locations/europe_eurasia/dem_gov/ngoindex/), 1998 оноос хойш жил бүр тухайн бүс нутаг дахь ТББ-ын салбарын тогтвортой байдалд үнэлгээ хийдэг.
5. ARVIN Tool (<http://lnweb18.worldbank.org/ESSD/>) Дэлхий банкны боловсруулсан, Иргэний оролцоог хангах таатай орчныг үнэлэх зорилготой судалгаа.
6. World Value Survey (<http://www.worldvaluessurvey.org/>) Pippa Norris' Social Capital Index, олон улсын олон нийтийн санал бодлыг тандсан иргэний оролцооны талаарх асуултууд багтаасан томоохон судалгаа. Уг судалгааны мэдээлэл нь иргэний нийгэм, нийгмийн капиталын талаарх олон тооны үндэстэн дамнасан индексүүдийн үндэс суурь болдог.

Гэхдээ эдгээр судалгаанууд мэдээлэл цуглуулах түүврийн эх олонлог, эх сурвалжийн найдвартай байдал, үзэл баримтлал ба үзүүлэлтийн хоорондын ялгаатай талуудтай тул улс орнуудыг аль нэг судалгааны индексийн үзүүлэлтээр туйлын эрэмбээр авч үзэх нь учир дутагдалтай болохыг дурдах нь зүйтэй юм.

Иргэний нийгмийг хэмжих үзүүлэлтүүд, индексүүд нь судалгааны шинэ салбар хэвээр байна. Цаашид судлаачдын үзэж байгаагаар иргэний нийгмийн талаарх судалгааны чиглэл нь түүний хөгжил, өөрчлөлтөд чиглэсэн дараах чиглэлд хандаж буйг тэмдэглэсэн байна⁶.

- *Нэгд*, одоо байгаа индексүүд нь ЭЗХАХБ-ын төлөөллөөс бүрдсэн 50 улс орнуудаас хүрээгээ тэлж, дэлхийн улс орнуудыг төлөөлөх илүү том өгөгдлийг хамарсан байх нь чухал хэвээр байна.

- *Хоёрт*, иргэний нийгмийн талаарх соёлын хэмжүүр юм. Соёлын хэмжүүр нь үзэл баримтлалын хувьд ч эмпирикийн хувьд ч хөгжөөгүй хэвээр байна. Энэ үзүүлэлтээр иргэний нийгэм нь хэрхэн итгэл үнэмшил, үнэт зүйлс, ашиг сонирхлынхоо хувьд ялгаатай байдаг вэ? гэсэн асуултад хариу өгөхөд чухал юм.

- *Гуравт*, иргэний нийгмийн индексийг боловсруулагчид нь үндсэн онолын үзэл баримтлалд илүү анхаарал хандуулахыг чухалчилж байна. Иргэний нийгмийн тухай янз бүрийн ойлголтууд нь яагаад өөр өөр үзэгдэл, хэв шинжтэй болохыг авч үзэж, холбогдох салбаруудын уялдуулан тайлбарлах хэрэгтэйг онцолж байна.

Иргэний нийгмийн талаарх судалгааны ирээдүй нь тухайн улсын ардчиллын чанарт нөлөөлөх байр суурь, онцлогийг тодорхойлох судалгаа давамгайлах хандлага ажиглагдаж, дэлхийн улс орнуудын судлаачдын хамтын оролцоо чухлыг онцолж

⁶ V. Finn Heinrich. Civil society Indicators and Indexes. Transparency International, Melville, 2010. 379 p

байгаа нь монгол судлаачдын хувьд ч хамааралтай болохыг дээрх судалгааны дүгнэлтүүд харуулж байна.

Монголын иргэний нийгмийн хөгжлийн үе шат

Монгол дахь иргэний нийгмийн хөгжил, төлөвшлийн тухай гадаад, дотоодын судлаачдын цөөнгүй судалгаа шинжилгээний өгүүлэл, нийтлэл буй бөгөөд иргэний нийгмийн хөгжлийг янз бүрийн шалгуур нөхцөлөөр хуваан үечилсэн байна. Тухайлбал, философич Д.Чулуунжав, Д.Дашпүрэв, Г.Чулуунбаатар зэрэг судлаачид өөрсдийн саналаа дэвшүүлсэн нь бий.

Энэхүү илтгэлд ардчилсан хөгжлийн 30 жилийн хугацаан дахь Монголын иргэний нийгмийн хөгжлийг үечлэх тухайд зохиогчид дараах саналыг дэвшүүлж байна. Энэхүү үе шатыг ангилан зааглахдаа шинэ тутам бүрэлдэн төлөвшиж буй иргэний нийгэмд хууль, эрх зүйн институцилал, ардчилсан шилжилтийн үе дэх улс төрийн соёлын өөрчлөлт, улс төрийн тогтолцоо ялангуяа сонгууль, улс төрийн намуудын төлөвшилд гарч буй чиг хандлага, иргэдийн улс төрийн оролцооны арга барил, иргэний нийгэм дэх эдийн засгийн хөшүүрэг зэрэг гарч буй өөрчлөлт зэрэг хүчин зүйлийг баримжаалан хуваасан болно.

Монголын иргэний нийгмийн хөгжлийн үечлэх гол шалгуур, тэдгээрийн онцлог ялгааг хүснэгтээр үзүүлбэл:

Хөгжлийн үечлэл /оноор/	Үйл ажиллагааны хэлбэр	Үйл ажиллагааны гол чиглэл	Оролцооны хэлбэр	Хууль эрх зүйн орчин	Санхүү эдийн засгийн хөшүүрэг
1989-1992	Улс төрийн ардчилсан хөдөлгөөн	Улс төрийн реформ, эрх чөлөө, ардчилал, либерал үзэл баримтлал	Жагсаал цуглаан өлсгөлөн, чөлөөт хэвлэл	Шилжилтийн үеийн хууль эрх зүйн орчин зохицуулалт	ОУ-ын байгууллага, иргэдийн идэвхи хандив
1992-1997	Олон нийтийн байгууллага, хөдөлгөөн	Хүний эрх, шашны эрх чөлөө	Жагсаал цуглаан өлсгөлөн, Хувийн мэдээллийн хэрэгслүүд	Үндсэн хууль, ТББ-ийн тухай хууль, жагсаал цуглааны хууль, өмч хувьчлах шийдвэр	ОУБ, төрийн санхүүжилт, гадаадын шашны байгууллагууд
1998-2006	ТББ, ОНБ, Иргэний хөдөлгөөнүүд,	Нийгмийн халамж үйлчилгээ, төрийн оролцоог хумих	Хэвлэл мэдээлэл, радикал жагсаал цуглаан	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, төр иргэний түншлэлийн хөтөлбөр	ОУБ, ЗГ, хувийн хэвшил
2007-2012	Байгаль орчны	Хэвлэл мэдээллийн	Радикал, оролцооны	Иргэний танхим, орон	ОУБ, ҮД корпорациуд,

	хөдөлгөөнүүд, олон нийтийн хамарсан үймээн	эрх чөлөө, Баялгийн хуваарилалтад тавих хяналт, төсөвт иргэдийн оролцоо	хэлбэрүүд, жагсаал цуглаан, интернет талбар	нутгийн хөгжлийн сан, Газар өмчлэх тухай хууль, төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаарх бодлого	гадаад ил далд, санхүүжилт, нам, хувийн хэвшил
2013-2019	Улс төржсөн захиалгат хөдөлгөөн, хэт үндсэрхэг хөдөлгөөн, цөөнхийн эрх, жендерийн эрх тэгш байдал	Ил тод нээлттэй байдал, хэвлэлийн эрх чөлөө, нийгмийн эгэх хариуцлага, амьдрах орчин нөхцөл, иргэдийн сайн дурын үйл ажиллагаа	Нийгмийн сүлжээний хөдөлгөөн, радикал хөдөлгөөн, захиалгат жагсаал, орон нутгийн гэрээ	Шилэн данс, Зөвлөлдөх санал асуулгын хууль	ОУБ, Улс төр-бизнесийн бүлэглэл, улс төрийн нам, улс төрчид,
2020 оноос хойш	Залуучуудын санаачилгат хөдөлгөөн, нийгмийн сүлжээний санаачлагууд	Засгийн бодлого, нийгмийн сайн дурын үйл ажиллагаа, бүх нийтийн санал асуулга	Нийгмийн сүлжээ, тайван жагсаал цуглаан	Үндсэн хуулийн өөрчлөлт, нам, иргэний байгууллагын шинэ хуулийн санаачилга	Улс төрийн нам, гадаадын сонирхогч талууд

Дээрх шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах 6 үе шатад хувааж үзлээ.

1. Улс төр-иргэний хөдөлгөөн бүрэлдэх үе шат (1989-1992)

Энэ үе шатын онцлог нь анхны ардчилсан улс төрийн өөрчлөлтийг санаачлан, гардан хэрэгжүүлэгч бүлгэм, клубууд байгуулагдаж, улмаар улс төрийн нам болон өргөжив. Чөлөөт хэвлэл, улс төрийн шинэ тутам хөдөлгөөнүүд олон улсын доноруудын дэмжлэгтэйгээр хөл дээрээ тэнцэж эхэлсэн юм. Иргэний нийгмийн чухал хөшүүрэг болох хувийн өмчийг бий болгох зорилгоор хувьчлалыг эхлүүлэв.

2. Иргэний эрүүл нийгэм бүрдүүлэх хүчин чармайлт (1992-1997)

Ардчилсан шинэ Үндсэн хуулинд иргэний нийгэм байгуулах явдлыг Монголчуудын эрхэм зорилго болгон дэвшүүлэв. Иргэний нийгмийн байгууллагын хууль эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж, олон улсын донор байгууллагуудын дэмжлэгтэй төдийгүй дотоодын иргэний нийгмийн байгууллагууд улс төрийн төдийгүй ардчиллын суурь зарчим болох хүний эрх, эрх чөлөө, иргэдийн оролцоог хамгаалах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллаж, шашны сүм хийд, чөлөөт хэвлэл мэдээллийн байгууллагууд цэцэглэн хөгжив.

3. Иргэний нийгмийн улс төржсөн идэвхжилтийн үе (1998-2006)

Улс төрийн засаглалын түвшинд савалгаа доргио ихтэй он жилүүд байсан бөгөөд төрийн бодлого, үйл ажиллагааны алдаа дутагдал, засгийн газрын тогтворгүй байдал болон улс төрчдийн авилга хээл хахууль, хүнд суртлын улмаас улс төрийн хөдөлгөөнүүд, жирийн иргэдийн эсэргүүцэл тэмцэл ихээр гарав. Нөгөө талаас иргэний нийгэм, тэр дундаа чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТББ-уудын үйл ажиллагааны цар хүрээ улам тэлж, Монголын нийгэмд эзлэх байр суурь нь өргөжин тэлсэн байна. Төрийн оролцоог хязгаарлах, хувийн өмчийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн либерал хандлагатай томоохон алхмууд хийгдсэн гэж дүгнэж болно.

4. Иргэний нийгэм дэх төрийн оролцооны өсөлтийн үе (2007-2012)

Уул уурхайн салбарын тэлэлттэй холбоотойгоор иргэний нийгмийн төлөвшилд шинэ сорилт тулгарах болсон бөгөөд байгал орчин, уламжлалт аж ахуйг хадгалах, хамгаалах зорилго санаархал бүхий иргэний нийгмийн байгууллагууд олноор байгуулагдаж, зарим нь радикал үйлдлүүд иргэний нийгэмд итгэх олон нийтийн байр суурийг эргэлзээнд оруулав. Байгалийн баялгийн орлогоос үүдэн төрийн эрх мэдэл аяндаа данхайж, улс төрийн намуудын бэлэн мөнгө, халамж амласан сонгуулийн өрсөлдөөн нь овоо торниод байсан иргэний нийгэмт хөгжлийг сульдаахад хүргэв.

5. Улс төржсөн ба дайжсан иргэний нийгмийн хуваагдал (2013-2019)

Баялгийн хараалын улмаас данхайж эхэлсэн төрийн оролцоог хязгаарлах, төсвийн хуваарилалтыг ил тод болгох, түүнд иргэдийг оролцоог хангах оролдлогууд хийгдэх болсон ч төрийн яам, агентлаг, албан хаагчийн тоо, авилгын хэмжээ буурсангүй. Иргэдийн улс төрийн сонгуулийн идэвхи буурч, улс төрөөс дайжин залхах үзэгдлийг сааруулах зорилгоор “зөвлөлдөх ардчилал”, иргэний танхим зэрэг ардчиллын механизмуудыг нэвтрүүлэхийг хичээв. Хэвлэл мэдээллийн салбарт нийгмийн сүлжээний эзлэх байр суурь эрс өссөн цаг үе байлаа.

6. Үндсэн хуулийн өөрчлөлтийн дараах иргэний нийгэм (2020 оноос хойш)

Монгол Улсын Үндсэн Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар зөвлөлдөх санал асуулгын бэлтгэл ажлыг 2017 оноос эхэлж, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн 306 мянга гаруй, улс төрийн намууд, эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн 600 мянга гаруй санал авч, хэлэлцсэний эцэст 2019 онд нэмэлт өөрчлөлтийг баталсан. Ардчилсан шилжилт гацаанд орж, иргэний нийгмийн улс төрийн дайжилт явагдаж буй үед оролцооны шинэ механизмыг туршиж, иргэдийн идэвхи оролцоог сэргээсэн цаашид ч Монголын ардын эрхэт засгийг бэхжүүлэх томоохон алхам болсон уг үйл явдал болон судлаачдын Монголын иргэний нийгмийн хөгжлийг өөдрөгөөр харах эрэлхийлэл ба эрмэлзлээс үүдэн Үндсэн хуулийн өөрчлөлтөөр зааглан нэгэн үе шат болгон хуваахаар зориглов. Хэдийгээр шинэ үе шат маш богино хугацааг туулж буй ч иргэний нийгэмд шинэлэг гэмээр цөөнгүй үзэгдэл гарсныг дурьдах нь зүйтэй.

- Залуучуудын улс төрийн идэвх оролцооны өсөлт

Сүүлийн жилүүдэд Монголын залуучууд ялангуяа “Z generation” гэж нэрлэдэг 1995 оноос хойшхи залуучуудын улс төрийн идэвхи, оролцоо нэмэгдэж байгаа нь иргэний нийгмийн ирээдүйд бага боловч найдлага төрүүлж байна. Ард иргэдийн улс төрийн сонгуулийн идэвхи оролцоо сонгуулиас сонгуульд буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч залуучуудын идэвхи харьцангуй нэмэгдэж байгааг тоо статистик харуулж байна. Тухайлбал, 2020 оны УИХ-ын сонгуулиар 18-25 насны залуучуудын 63% нь санал өгч өмнөх жилүүдэд байгаагүй өндөр ирцтэй оролцсон бол мөн оны 10 сард болсон ИТХ-ын сонгуульд дээрх насны залуучуудын ойролцоогоор 37.4% нь санал өгсөн байна. Энэ нь өмнөх ИТХ-ын сонгуулийн ирцээс 4.8%-аар өссөн үзүүлэлт юм⁷.

⁷ С.Болдсайхан. Улс төрийн оролцоо гэж юу вэ, бид ямар түвшинд байна вэ? <https://ikon.mn/opinion/249k> Нийтлэсэн 2021 оны 2 сарын 2.

Монголын улс төрд сүүлийн 10 гаруй жилд захиалгат буюу аль нэг нам хүчний даалгавраар, төлбөрийн нөхцөлтэйгөөр жагсаал цуглаан өрнөх нь хэвийн үзэгдэл болсон нь нууц биш. Харин 2021 оны 1-р сард ковидын хөл хорионы хатуу арга хэмжээнээс болж иргэн хүн хохирч буй мэдээнд дургүйцсэн залуучууд Сүхбаатарын талбайд гарч ирж жагссанаар Засгийн газар огцорсон, 2022 оны 4-р сард үнийг өсөлт, эрх баригчдын бодлогыг эсэргүүцсэн залуучууд суулт зарлаж, эрх баригчдад шаардлага хүргүүлснээр Засгийн газрын тэргүүн биечлэн гарч ирж тайлбар хийсэн нь Монголын улс төрд шинэлэг үзэгдэл болсон гэж хэлж болно. Хэдийгээр эдгээр жагсаал цуглааныг захиалгаар өдүүлсэн, эрх барих хүчин улс төрийн акци зохион байгуулсан гэх хардалт сэжиг байсан ч уг үйл явдалд оролцсон олон залуучууд чин сэтгэлээсээ оролцож, дуу хоолойгоо илэрхийлсэн органик хөдөлгөөн байсан гэж судлаачийн хувьд үзэж байна.

- Улс төрийн нам, иргэний нийгмийн эрх зүйн орчин дахь өөрчлөлт

Олон жил яригдсан улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл УИХ-аар идэвхтэй хэлэлцэгдэж эхлэв. Уг хууль батлагдвал Монголын улс төрийн ардчилсан тогтолцоонд томоохон дэвшил болох бөгөөд дамаа иргэний нийгмийн төлөвшилд ч чухал нөлөө үзүүлэх юм.

Тэрчлэн 2021 онд “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” хууль батлагдаж, “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл”-ийг УИХ-д өргөн барьсан явдал иргэний нийгмийн эрх зүйн орчинд томоохон өөрчлөлтийг авчирсан үйл явдал гэж тооцож байна.

2019 онд батлагдсан Татварын багц хуулийн шинэчлэлээр ТББ, ашгийн бус хуулийн этгээд ААН үйл ажиллагаа эрхлэх боломжийг нээж, үйл ажиллагаанаас олсон орлогыг нийтэд тустай үйлсэд зарцуулах бололцоог нээв. 1997 онд батлагдсан ТББ-ын тухай хууль болон эрх зүйн зохицуулалтыг цаг үеийн шалтгаанаар шинэчлэх, нарийвчлах шаардлага тулгарч, Холбоо, сангийн эрх зүйн байдлын хуулийн төслийг санаачилж өдгөө нийгмийн хэлэлцүүлэг идэвхтэй өрнөж байна.

- Нийгмийн сүлжээ, иргэний сэтгүүлзүйд суурилсан иргэний нийгэм

Иргэний нийгэм хэмээхийг өөрсдийнхөө төлөө өөрөө зохион байгуулалтад орж өөрсдийн эрх ашгийг хамгаалж, аяндаа цэгцэрдэг нийгмийн институци гэж үзвэл сүүлийн жилүүдэд нийгмийн сүлжээ буюу мэдээлэл технологийг ашиглан Монголын иргэний нийгэм дан ганц улс төрийн сэдэв гэлтгүй нийгмийн сайн сайхан байдалд чиглэсэн тал бүрийн асуудлаар шүүмжлэл хэлэлцүүлэг өрнүүлж, бодит ажил хэрэг болгох үйл явж өргөн хүрээнд явагдаж байна.

Хот суурин газар иргэдийн хувьд ИТХ, иргэний танхим, төрийн захиргааны байгууллагын хөшүүн хойрго байдлыг алгасан өдөр тутам гарч буй иргэний ая тухтай амьдрах орчин, аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой асуудлыг нийгмийн сүлжээг ашиглан шуурхай шийдвэрлэдэг суваг үндсэндээ бүрэлдэн тогтжээ. Нийгмийн сүлжээг ашиглан нийгмийн хэв журам, хууль дүрмийг зөрчсөн үйлдлийг буруутгах, арга хэмжээ авахыг шаардах, нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулсан хүмүүсийг урамшуулан дэмжих зэрэг байдлаар нийгмийн аяндаа цэгцрэх байдалд шууд нөлөө үзүүлэх болжээ. Улмаар улс төрчид, төрийн захиргааны байгууллагын хүнд суртал, авилгын асуудлаар газар дээр нь шууд сурвалжлан мэдээлж, иргэдийн анхаарлыг хандуулдаг “лайвчин” гэх бараг мэргэжил үүсчээ.

Нийгмийн сүлжээ, чөлөөт хэвлэл мэдээллийг дан ганц иргэний нийгэм үр дүнтэй ашиглаж байгаа гэж хэлэх нь өрөөсгөл юм. Зарим нөхцөлд төр засгийн байгууллага ч улс төр-бизнесийн бүлэглэл, хувь улс төрчдийн авилгажсан үйлдлийг зогсоох, шахалтад оруулахад иргэний сэтгүүл зүйг гаргууд ашиглаж болдгийг ЖДҮ, “Хөгжлийн банкны хэрэг”-ээс харж болно. (Эргэн сануулахад, ЖДҮ болон Хөгжлийн банкнаас эрх мэдлээ ашиглан их хэмжээний зээл авсан ч эргэн төлөхгүй байсан олон

томчуудыг хэвлэл болон цахим сүлжээний дайралтаар шахамдуулан богино хугацаанд төлүүлэх акцийг зохион байгуулсан билээ.)

Монголын иргэний нийгэмд сүүлийн жилүүдэд тулгарч буй сорилт бэрхшээл ба боломж


Ардчилсан шилжилтийн 30 гаруй жилийн хугацаанд Монгол дахь иргэний нийгмийн хөгжил олон сорилт бэрхшээлийг туулж өдгөө монголын нийгэм, улс төр, ахуй соёлын онцлогт тохирсон байдлаар өөрийн гэсэн өвөрмөц төрхийг олж, хөгжин төлөвшиж байна. Тэртээ 1992 онд Монголчууд ардчилсан Үндсэн хуулиндээ тавьсан “Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх” зорилго хэр биелэн хэрэгжсэнийг энэхүү богино өгүүлэлд цөөн үгээр илэрхийлэх боломжгүй билээ. Тэгэхийг ч зорьсонгүй. Харин эрхэм зорилгоо болгон тодорхойлсон иргэний нийгмийг цогцлоох үйл явцад тулгарч буй өнөө цагийн сорилт бэрхшээл хийгээд боломж нөөц юу байгааг ажиглалт, шинжилгээндээ үндэслэн зохиогчид дор тоочихыг хичээв.

Монголын иргэний нийгэмд тулгарч буй сорилт бэрхшээл

Дэлхийн иргэний нийгмийн байгууллагын холбооноос гаргасан 2021 оны тайлангаар Монголын иргэний нийгэм 2018 оны “хязгаарлагдмал” (obstructed) төлөвтэй харьцуулахад “хагас нээлттэй” (partowed)-д төлөв рүү ахьсан байна (CIVICUS, 2021)⁸. Ийнхүү шат ахихад “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” хууль батлагдсан хийгээд Монголын хэвлэлийн эрх чөлөөт байдал голлон нөлөөлжээ.

- Иргэний нийгмийн байгууллагуудад санхүүжилтийн тогтвортой механизм дутмаг. 2021 оны эхний байдлаар Монголд ТББ-ын тоо 23 мянга гаруй ТББ бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрийн тал хүрэхгүй хувь нь үйл ажиллагаа явуулдаг аж.⁹

Бүртгэлтэй ТББ-ын тоо¹⁰



1997 онд ТББ-ын тухай батлагдсанаас хойшхи хугацаанд тэдгээрийн санхүүжилтийн ердөө 2 хүрэхгүй хувийг төрийн санхүүжилт бүрдүүлж иржээ.

⁸ Mongolia press release Mongolia is the only country upgraded in 2021 civic rights rankings, <https://findings2021.monitor.civics.org/country-ratings/mongolia.html> 8 December, 2021.

⁹ Төрийн бус байгууллагууд: Бүртгэл ба тайлан. <http://eagle.mn/r/83496> 2021-02-16

¹⁰ Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа (дэлгэрэнгүй тайлан). Иргэний нийгмийн консерциум. УБ., 2020. Х-12.

Хөгжингүй орнуудад төрийн санхүүжилт 48 хувьтай байхад, бусад оронд 22% хувь болж байна. ТББ-уудын 80 гаруй хувь нь гадны эх үүсвэрээр санхүүждэг бөгөөд үлдсэн хэсгийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхой бус байдаг тул нийгмийн ашиг сонирхлыг илэрхийлэх бус, ашгийн байгууллага болж хувирсан гэх шүүмжлэлийг дагуулсаар байна¹¹.

- Унаган байгаль, язгуур аж ахуйгаа хадгалах эрмэлзэлтэй малчид болон уул уурхайн хайгуул, олборлолттой холбоотой зөрчил хурцдах, гадаад дотоод сонирхогч талуудын оролцоогоор үндэсний эрх ашигт хохиролтой алхам руу түлхэх явдал нэг бус ажиглагдаж байна. Эрдэнэбүрэний УЦС байгуулах талбай, Дорнод дахь уран хайгуул, олборлолтын эсрэг орон нутгийн иргэдийн радикал үйлдэл. ТББ, иргэний дуу хоолой, ОУБ-ын нэрээр Монголын дотоод хэрэгт хошуу дүрэх явдал нэг бус гарч байна. Тухайлбал, “Хил хязгааргүй гол мөрөн” нэртэй ОУБ нэртэй хэдий ч хөрш залгаа орны халхавч байгууллагууд болон гадны тусгай байгууллагын санхүүжсэн гэж шүүхээс ял авсан "Монгол хүн Монгол хүндээ тусалъя" ТББ-ын тэргүүн Ч.Мөнхбаяр нарын үйл ажиллагааг үүнд дурьдаж болно.

- Нийгмийн сүлжээг ашиглан гадаад дотоод өдөөлт, турхиралтын улмаас нийгэм талцан хуваагдах эрсдэл учирч байна. Тухайлбал, Украйны дайнтай холбоотойгоор цахим талбарт тодорхой улс орны захиалгаар тролл бүлэг хуурамч мэдээллийг цацаж, тархи угаах оролдлого хийж байгаа нь нууц биш. Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш тун саяхан твиттер жиргээндээ: "Уур бухимдал, үзэн ядалтад суурилсан бизнес загвартай нийгмийн цахим сүлжээний талбарууд нь аливаа нийгэмд асар их хор хохирол учруулах боллоо. Үзэн ядсан үг хэллэг, худал мэдээлэл гаарлаа. Бидний өгөгдөл мэдээллийг зан үйлд нөлөөлөх зорилгоор зарж борлуулах болов. Үүнийг засах хууль, эрх зүйн шинэчлэл хэрэгтэй."¹² хэмээн халаглажээ. Цахим орчин дахь эзэнгүй, худал, төөрөлдүүлсэн мэдээллийг цэгцлэх зорилгоор парламентад нэг бус удаа хуулийн төсөл санаачилсан ч хүний эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлахад хүргэнэ гэсэн олон нийтийн эсэргүүцлээс үүдэн өнөөг хүртэл батлагдаагүй юм.

- Хуучин социалист тогтолцооны үед байгуулагдсан олон нийтийн байгууллагууд шинэ нийгмийн нөхцөл шаардлагад тохирсон хэлбэрээр шинэчлэгдэн өөрчлөгдөж чадахгүй байна. Үйлдвэрчний эвлэл, Залуучуудын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, Ахмадын холбоо зэрэг коммунист нам төрийн үзэл суртлын гол талбар болж ирсэн байгууллагууд орчин цагийн нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хэв загвараар бус хуучин буурин дээрээс хоцрогдсон арга барилаараа үйл ажиллагаа явуулж ирлээ. Эдгээр байгууллагууд иргэний нийгмийн төлөвшилд ноцтой хохирол учруулаагүй нь үнэн хэдий ч иргэний нийгмийн байгууллагын орчин үеийн хэрэгцээнд зохицон нийцэж чадахгүй, олон нийтийн шүүмжлэлийн бай болсоор байна.

Монголын иргэний нийгмийн хөгжилд гарч буй боломж нөхцөл

- Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулах бодлогын хүрээнд хуулийн этгээдийн бүртгэл, мэдээлэл цахим талбарт нээлттэй болсон төдийгүй бүртгэл, тайлагнал цахим хэлбэрт шилжсэн явдал нь иргэний байгууллагуудын үйл ажиллагааг маш хөнгөвчилж, амар хялбар болгосон. Мөн ТББ-иуд холбогдох хуулиар аж ахуйн эрхлэх боломж олгосон нь тэдгээрийн үйл ажиллагаандаа шаардлагатай санхүүжилтийг бүрдүүлэхэд чухал гарц гаргалгаа болж байна.

¹¹ Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж. КАС, МУИС, 2020. Х-223.

¹² António Guterres @antonioguterres. 3:00am · 26 Sep 2022 · TweetDeck

- Нийгмийн хөгжил өөрчлөлттэй уялдан иргэний нийгмийн харилцаа ч нарийн төвөгтэй болж байна. Шинэ тутам бүрэлдэж буй харилцааг зохицуулах, эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлага ч тулгарах болов. 1997 оноос хойш иргэний нийгмийн байгууллагын харилцааг зохицуулж ирсэн гол эрхзүйн акт болох ТББ-ын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, холбоо, сангийн харилцааг тусдаа хуулиар зохицуулах санал, санаачилгад холбогдох талууд идэвхтэй оролцож байна. Мөн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, Шүтэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хууль тогтоох байгууллагын хэлэлцүүлэгт орсон. Эдгээр хууль нь ойрын жилүүдэд иргэний нийгмийн шинэ тутам харилцааг хөгжүүлэх эрх зүйн суурь нөхцөл боломжийг олгоно хэмээн найдаж байна.

- Social enterprise буюу бизнес, эдийн засгийн хувьд ашигтай хэрнээ давхар нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг бизнесийн загварууд Монголд хөгжиж байна. Монголын уламжлалт буюу нүүдлийн мал аж ахуйд суурилсан бизнес, мэдээлэл технологи, финтех технологийн богино хугацаанд эзэмшсэн туршлагад тулгуурлан монголын залуучууд гарааны компаниуд олноор байгуулагдаж, дотоодын төдийгүй олон улсын зах зээлд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлж амжилт олж байгаа нь цөөнгүй байна. Үүнд МАА-н түүхий эдэд суурилсан органик бүтээгдэхүүнээс (гоо сайхны бүтээгдэхүүн, хүнс, бөс бараа, загварын хувцас) аваад бичил санхүү, ажил хэргийн үйлчилгээний платформыг (санхүү зээлийн цахим апплейкшн, утасны дуудлагын үйлчилгээ, МТ-ийн аутсорсинг) гадны улс оронд нийлүүлж байгаа компаний жишээг дурьдаж болно. Үүнд шинэ тутам уг харилцаанд төрийн зүгээс бодлого, эрх зүйн зохицуулалт хийх шаардлага тавьж буйгаас өөр санхүү, менежментийн хүсэлт шаардлага бага бөгөөд цаашдаа Монголын иргэний нийгэм бэхжихэд маш том нөлөө үзүүлэх чиглэл гэж харж байна.

- Уламжлалт, институтсан иргэний нийгмийн байгууллагуудаас гадна өдгөө нийгмийн цахим сүлжээ, тоон технологит суурилсан албан бус иргэний нийгэм (зарим ном зохиолд үүнийг “шинэ” иргэний нийгэм хэмээн нэрийдэж байна)¹³ эрчимтэй хөгжиж байна. Институтжлагдаагүй иргэний нийгмийн идэвхтнүүд цахим орон зайг ашиглан нийгэмд тулгамдсан асуудалд идэвхтэй оролцож, иргэний нийгмийн өөрөө зохион байгуулагдан цэгцрэх үйлсэд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ төр засгийн бодлого, үйл ажиллагааг шүүмжлэх, хяналт тавих зэргээр зарим талаар Монголын улс төрд дутагдаж буй сөрөг хүчний үүргийг дангаараа шахуу гүйцэтгэж байгаа гэж хэлж болно. 2021 оны байдлаар Монголчуудын 80 гаруй хувь нь өндөр хурдны интернет холбогдсон бөгөөд нийт хүн амын 78.7% буюу 2.6 сая иргэн сошиал медиа буюу цахим мэдээллийн сүлжээг идэвхтэй ашиглаж байгаа гэсэн статистик байна¹⁴.

Дүгнэлт

Орчин үед иргэний нийгмийн талаарх тоон мэдээлэл, мэдээллийн хүртээмж сайжирч байгаа тул түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд улам бүр нэмэгджээ. Гэхдээ иргэний нийгмийн талаарх онолын суурь үзэл баримтлалаас хазайхгүйгээр түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох нь чухал болохыг судлаачид дүгнэсэн байна. Тэрдундаа ардчиллын онол болон нийгэм, улс төрийн соёлын онол талаас авч үзэх нь зайлшгүй гэдгийг дурдаж байна.

Монгол дахь иргэний нийгмийн судалгаа шинжилгээ 1990-ээд оны дундаас эхэлжээ. Тэдгээр нь иргэний нийгмийг онол, философи, эрх зүйн үүднээс голчлон задлан шинжилсэн байна. Мөн иргэний нийгмийн тухай хөндсөн ном бүтээлд иргэний

¹³ Civil Society in Central and Eastern Europe: Challenges and Opportunities. Edited by Peter Vondor, Nicole Traxler, Reinhard Millner, and Michael Meyer. ERSTE Foundation, 2017.

¹⁴ Монголын харилцаа холбооны салбарын онцлох 5 үзүүлэлт. <https://posted.mn/c/levelup-communication-data> 5/25/2021

нийгмийн хөгжлийг үечлэн хувааж судалсан нь тун маруухан аж. Иймд Монгол дахь иргэний нийгмийн хөгжлийг хууль эрх зүйн шинэчлэл, ардчилсан шилжилтийн үе дэх улс төрийн соёлын өөрчлөлт, улс төрийн тогтолцоо ялангуяа сонгууль, улс төрийн намуудын төлөвшилд гарч буй чиг хандлага, иргэдийн улс төрийн оролцооны арга барил, иргэний нийгэм дэх эдийн засгийн хөшүүрэг зэрэг хүчин зүйлсэд үндэслэн дараах үе шатад хуваав.

- 1989-1992. Улс төр-иргэний хөдөлгөөн бүрэлдэх үе шат
- 1992-1997. Иргэний эрүүл нийгэм бүрдүүлэх хүчин чармайлт
- 1998-2006. Иргэний нийгмийн улс төржсөн идэвхжилт
- 2007-2012. Иргэний нийгэм дэх төрийн оролцоо өссөн нь
- 2013-2019. Улс төржсөн ба дайжсан иргэний нийгмийн хуваагдал
- 2020 оноос хойш. Үндсэн хуулийн өөрчлөлтийн дараах иргэний нийгэм.

Ардчилсан шилжилтийн 30 гаруй жилийн хугацаанд Монгол дахь иргэний нийгмийн хөгжил олон сорилт бэрхшээлийг туулж өдгөө монголын нийгэм, улс төр, ахуй соёлын онцлогт тусгасан өвөрмөц төрхийг олж, хөгжин төлөвшиж байна. 1992 онд ардчилсан Үндсэн хуулиндаа эрхэм зорилго болгон дэвшүүлсэн “иргэний нийгмийг цогцлоох” үйл явцад тулгарч буй өнөө цагийн сорилт бэрхшээл хийгээд боломж нөөцийг товч дурьдвал:

Сорилт бэрхшээлийн тухайд:

- Иргэний нийгмийн байгууллагуудад санхүүжилтийн тогтвортой механизм дутмаг. 1997 онд ТББ-ын тухай хууль батлагдсанаас хойшхи хугацаанд тэдгээрийн санхүүжилтийн ердөө 2 хүрэхгүй хувийг төрийн санхүүжилт бүрдүүлж иржээ. Хөгжингүй орнуудад төрийн санхүүжилт 48 хувьтай байхад, бусад оронд 22% хувь болж байна.

- Нийгэм-эдийн засгийн хэвшил, соёл ахуйн эрс өөрчлөлтөөс шалтгаалан иргэний нийгэм болон ашгийн төлөө байгууллагуудын хооронд зөрчил сөргөлдөөн гарч байна. Тухайлбал, унаган байгаль, язгуур аж ахуйгаа хадгалах эрмэлзэлтэй малчид болон уул уурхайн хайгуул, олборлолттой холбоотой зөрчил хурцдах, гадаад дотоод сонирхогч талуудын оролцоогоор үндэсний эрх ашигт хохиролтой алхам руу түлхэх явдал нэг бус ажиглагдаж байна.

- Нийгмийн сүлжээг ашиглан гадаад дотоод өдөөлт, турхиралтын улмаас нийгэм талцан хуваагдах үзэгдлүүд олширч байна.

- Хуучин социалист тогтолцооны үед байгуулагдсан олон нийтийн байгууллагууд шинэ нийгмийн нөхцөл шаардлагад тохирсон хэлбэрээр шинэчлэгдэн өөрчлөгдөж чадахгүй байна. Үйлдвэрчний эвлэл, Залуучуудын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, Ахмадын холбоо зэрэг коммунист нам төрийн үзэл суртлын гол талбар болж ирсэн байгууллагууд орчин цагийн нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хэв загвараар бус хуучин буурин дээрээ хоцрогдсон арга барилаар үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Боломж нөхцөлийн тухайд:

- Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулах бодлогын хүрээнд төрийн бүртгэл, тайлагнал цахим хэлбэрт шилжсэн явдал нь иргэний байгууллагуудын үйл ажиллагааг хөнгөвчилж, амар хялбар болгосон.

- Нийгмийн хөгжил өөрчлөлттэй уялдан иргэний нийгмийн шинэ тутам харилцааг зохицуулах, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр цөөнгүй алхам хийгдэв. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хууль тогтоох байгууллагын хэлэлцүүлэгт орсон.

- “Social enterprise” буюу бизнес, эдийн засгийн хувьд ашигтай хэрнээ давхар нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг бизнесийн загвар Монголд хөгжиж байна. Монголын уламжлалт буюу нүүдлийн мал аж ахуйд суурилсан

бизнес, мэдээлэл технологи, финтех технологийн богино хугацаанд эзэмшсэн туршлагад тулгуурлан монголын залуучууд гарааны компаниуд олноор байгуулагдаж, дотоодын төдийгүй олон улсын зах зээлд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлж амжилт олж байгаа нь цөөнгүй байна.

- Уламжлалт, институцсан иргэний нийгмийн байгууллагуудаас гадна өдгөө нийгмийн цахим сүлжээ, тоон технологид суурилсан албан бус иргэний нийгэм эрчимтэй хөгжиж байна. Институцлагдаагүй иргэний нийгмийн идэвхтнүүд цахим орон зайг ашиглан нийгэмд тулгамдсан асуудалд идэвхтэй оролцож, иргэний нийгмийн өөрөө зохион байгуулагдан цэгцрэх үйлсэд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ төр засгийн бодлого, үйл ажиллагааг шүүмжлэх, хяналт тавих зэргээр зарим талаар Монголын улс төрд дутагдаж буй сөрөг хүчний үүргийг гүйцэтгэж байгаа гэж хэлж болно.

Abstract:

This article aims to describe and define the developmental phases of Mongolia's civil society during the last 30 years periodically. This study examined the challenges the civil society has encountered and overcome in the unique social and cultural context of post-communist Mongolia during those 30 years of parallel transition to democratization and market economy. It investigated what opportunities and situations for creating citizens with Mongol identity have been produced by the external factors such as democratic reform, market economy, legal changes, sudden boom and decline of mining sector, and traditional life and culture.

Keywords: Non-governmental organizations, political movement, institutional reform, post-communist society, legal institutionalization, civic participation

**ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН АРДЧИЛЛЫН БЭХЖИЛТЭД
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ЧИГ ХАНДЛАГА**

Б.Одгэрэл

Отгонтэнгэр их сургууль,
Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал

О.Мөнхжаргал

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн багш

Хураангуй:

Энэхүү өгүүлэл нь “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт судалгааны хүрээнд хийгдэж буй иргэний нийгмийн байгууллагын ардчиллын хөгжилд оруулж буй үр нөлөөг тодруулах судалгааны зарим үр дүнг танилцуулна. Монгол дахь иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшил, хөгжлийн үйл явцыг тодорхойлох, монгол дахь төлөөллийн ардчиллын бэхжилтэд иргэний нийгэм түүн дотор иргэний нийгмийн байгууллагын оролцоог илрүүлэх, ардчиллын шилжилт ба бэхжилтийн үеийн иргэний нийгмийн байгууллагын нөлөөллийг үнэлэх, ардчиллын цаашдын хөгжилд оруулах хувь нэмрийг тодотгохыг энэ өгүүлэлд чухалчлав. Мөн иргэний нийгмийн хөгжилд эерэг ба сөрөг хэлбэрээр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг өндөр түвшний экспертүүдийн судалгаанд үндэслэн тодорхойлохыг зорьсон.

Түлхүүр үг: Иргэний нийгэм, төрийн хяналт, ардчиллын бэхжилт, төр иргэний түншлэл, хүчин зүйлсийн судалгаа

1990-ээд оны ардчилсан шилжилтэд иргэний нийгмийн гүйцэтгэсэн үүргийг судлаачид олон хэлбэрээр тайлбарлаж, дүгнэлт санал дэвшүүлсэн байдаг. Зарим шинжээчид коммунизмын уналт хийгээд ардчиллын давллагаанд нөлөөлсөн гол хүчин зүйл бол иргэний нийгэм хэмээн үздэг боловч нөгөөтээгүүр уг шилжилтээс хойших постсоциалист орнууд дахь иргэний нийгмийн хөгжил нь уналтад орсон хэмээн дүгнэдэг¹. Ихэнх улс төрийн онолч, судлаачид иргэний нийгэм бол ардчиллын зайлшгүй урьдач нөхцөл, либерал ардчиллын бат бөх, тогтвортой байдал нь эрүүл нийгмийн идэвхтэй оролцооноос хамаарна гэсэн НеоТоквиллч үзэл санаатай санал нэгддэг. Манай зарим судлаачдын хувьд Монгол улс XX-р зуны эхнээс өөрийн орны онцлогтоо тохирсон үндэсний ардчилсан загварыг хэрэгжүүлж эхэлсэн² гэдэг ч нийтлэг үзлээр бол 1990-ээд оны эхээр явагдсан ардчилсан хөдөлгөөн хийгээд либерал, төлөөллийн ардчиллын зарчим бүхий 1992 оны шинэ Үндсэн хуулийг баталснаас хойш авч үздэг.

Ардчиллын эхэн үеийн зорилт нь либерал ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, институциудыг бий болгох, бэхжүүлэх, зүй зохистой ажиллуулах явдал байсны хувьд иргэний нийгмийн төлөвшил ч уг агуулгын хүрээнд явагдаж байв³.

¹ How to Study Civil Society: The State of the Art and What to Do Next. Jan Kubik, 2003. Oxford

² Г.Чулуунбаатар, Ш. (2021). *Монголын ардчилал: Төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж*. Улаанбаатар: KAS.

³ Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт. 2019.

Тиймдээ ч иргэний нийгмийн сэдвээр нэг талаас философи, улс төрийн шинжлэх ухааны онолын түвшинд авч үзсэн академик шинжтэй бүтээлүүд нөгөө талаас мэдээллийн сан бүрдүүлэх, иргэний нийгмийн хөгжил дэх зарим тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавьсан бодлогын шинжтэй судалгаанууд ихээр хийгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд хийгдэж буй судалгаа, боловсруулалтын ажлуудаас авч үзвэл иргэний нийгэм гэдгийг манайд “иргэд үзэл бодол, нийтлэг ашиг сонирхлоороо нэгдэн улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутаг болон үндэсний хэмжээнд оролцдог албан ба албан бус бүлэг, төрийн бус байгууллага болон хувь хүмүүсийн төрөл бүрийн нийгэмлэг” хэмээн тодорхойлж хэвшсэн байна (Г.Чулуунбаатар нар, 2020).

Судлаач Д.Мягмарсүрэн (2019) ардчилсан шилжилтээс хойших монголын иргэний нийгмийн хөгжлийг хууль эрх зүйн институтчилэл, улс төрийн соёл болон тогтолцоонд гарсан өөрчлөлт, иргэдийн улс төрийн оролцооны арга барил, иргэний нийгэм дэх эдийн засгийн хөшүүрэг зэрэг хүчин зүйлст тулгуурлан 1989 оноос өнөөг хүртэлх цаг хугацааг 6 үе шатанд хуваасан⁴ нь иргэний нийгмийн төлөвшил, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийн динамикийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой судалгаа болжээ.

Түүнчлэн 2005 онд Ардчиллын төлөөх олон улсын иргэний нийгмийн чуулганы нарийн бичгийн дарга нарын газар, Иргэдийн оролцоог дэмжих дэлхийн холбооноос (CIVICUS) монгол дахь иргэний нийгмийн индексийг боловсруулах ажлын хүрээнд монголын иргэний нийгмийг *бүтэц, орчин, үнэт зүйлс, үр нөлөө* гэсэн 4 гол хэмжигдэхүүн, 25 дэд хэмжигдэхүүн, 78 үзүүлэлт бүхий индексээр задлан шинжилсэн⁵ нь хожмын судалгаануудад түгээмэл ашиглагдаж байна. Хэдий тийм боловч иргэний нийгмийн индексийг боловсруулагчдын чухалчилсан үндсэн онолын үзэл баримтлалыг анхаарч байх шаардлагатай байдаг.

Ардчилал үндсэндээ иргэний нийгмийн хүчирхэг институци (чөлөөт хэвлэл гэх мэт) болон ТББ-уудын олон талт байдлыг (сүүлийн жилүүдэд олон оронд ийм нөлөө үзүүлсэн байгаль орчны бүлгүүд, корпорацын хяналтын бүлгүүд гэх мэт) шаарддаг. Бернард ба Хелмих нар (1998) иргэний нийгмийн олон нийтийн ашиг сонирхолд болон өөртөө туслах бүлгүүдийг төрийн бус байгууллага, ашгийн бус холбоод, асуудалд чиглэсэн албан бус байгууллагууд зэрэг институцийн олон хэлбэрээр байж болохыг жишээгээр дурджээ. Мөн тэд ТББ-ыг төрөөс хараат бус, цаашдын хөгжлийн зорилтод хүрэхийн тулд олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн, ашгийн бус, гишүүн бус зуучлагч байгууллага гэж тодорхойлсон байдаг (Бернард ба Хелмих, 1998).

Ардчилсан засаглалыг бэхжүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэхэд иргэдийн болон иргэний нийгмийн оролцоо чухал шаардлагатай болсноор иргэний нийгмийг идэвхжүүлэх, чадавхжуулах асуудал чухлаар тавигдах болж тус асуудалд анхаарсан судалгаанууд ихээр хийгдэж ирсэн. Тэдгээр нь ерөнхийдөө иргэний нийгмийн оролцоог сайжруулахад нэгдүгээрт, эрх ашиг нь хөндөгдөж буй иргэд, сонирхогч талуудын бодлогын үйл явцад оролцох эрхийг хангах, хоёрдугаарт, бодлогын яриа хэлэлцээр, түншлэлийн үр нөлөө бүхий механизмыг бий болгох, бэхжүүлэхийг чухалчлах болов.

ИНБ, ТББ гэх мэт нэр томьёо нь эцэслэгдсэн томьёоллоор бус хувьсах шинж чанартай хэвээр байгаагаас үүдэн тэдгээрийн хэрэглээ нь нөхцөл байдал бүрд байнга

⁴ Д.Мягмарсүрэн, 2019. Конрад Аденаурын сан, Монгол дахь ардчилал хөгжил, бэхжилт, сорилт. УБ.2019

⁵ Монголын иргэний нийгмийн өнөөгийн байдал - 2004/2005. Иргэний нийгмийн индексийг боловсруулахуй. УБ., 2006.

шинэчлэгдэж байна.⁶

Иргэний нийгмийн байгууллага, иргэний нийгэм, ардчилал хоорондын харилцааг ихэвчлэн дараах байдлаар төсөөлдөг. ИНБ нь иргэний нийгмийн нэг хэсэг боловч үйл ажиллагаагаар дамжуулан үүнийг бэхжүүлж, улмаар ардчиллын үйл явцыг дэмждэг. Ийм үндэслэлийн үүднээс "ардчилал", "иргэний нийгэм"-ийн зорилго, хөгжлийг дэмжихэд ИНБ-уудын гүйцэтгэх үүргийг тодорхойлдог. Алексис де Токвилл, Сэмюэл Хантингтон, Роберт Путнам болон бусад судлаачдын модернизаци, улс төрийн хөгжлийн судалгаа ч үүнд чиглэсэн байдаг. Либерал ардчилсан онолоор хариуцлагатай төрийг чөлөөт, шударга сонгууль явуулахын зэрэгцээ иргэний нийгэм нь иргэний болон улс төрийн эрх, эвлэлдэн нэгдэх бие даасан байдлыг бий болгосноор бүрдүүлэн төлөвшүүлэх ёстой. Тиймээс төрийн эрх мэдлийг хэтрүүлэхээс хамгаалж, төрийн эрх мэдлийг хууль дээдлэх зарчимд тулгуурлан хууль ёсны болгоход хүчирхэг, олон талт иргэний нийгэм зайлшгүй шаардлагатай (Даймонд, 1994).

Иргэний нийгэм ардчиллын үйл явцын үе шатуудад өөр өөр үүрэг гүйцэтгэдэг гэж судлаач Даймонд үзжээ. *Ардчилсан шилжилтийн үед* иргэний нийгэм улс төрийн өөрчлөлтийн төлөөх шахалтыг дайчлах гол үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг. Оюутнууд, эмэгтэйчүүдийн бүлгүүд, тариаланчдын байгууллага, ТББ, үйлдвэрчний эвлэл, шашны бүлгүүд, мэргэжлийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, судалгааны төвүүд, хүний эрхийн байгууллагууд зэрэг зохион байгуулалттай нийгмийн бүлгүүд нь ардчилсан өөрчлөлтийн чухал эх үүсвэр болдог бол иргэний нийгэм нь *ардчиллын бэхжилтийн үед* төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах явдлыг шалгах, дарангуйлагч засгийн газрууд эрх мэдлээ сэргээхээс урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавихад гол үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг. Тиймээс ардчиллыг бэхжүүлж, хадгалахад эрч хүчтэй иргэний нийгэм чухал гэдгийг судлаачид тодотгодог.⁷

Ардчиллын бэхжилтэд иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагуудын үр нөлөө өндөр байхыг либераль үзэл санааны үүднээс чухалчлах боловч эсрэгээрээ иргэний нийгмийн төлөвшил, иргэний нийгмийн байгууллагын чадавх, иргэдийн оролцооны асуудал нь засаглалын болон эрх зүйн тогтолцоо, хүний хөгжлийн үзүүлэлтүүд, шударга ёсны үнэлэмжтэй хамааралтай байгааг латин америк болон пост социалист улс орнуудын ардчилсан шилжилтийн дараах нөхцөл байдалд судалгаа хийсэн судлаачид дурдаж байна.⁸ Иргэний нийгмийн байгууллагуудад ч хөгжиж байгаа эдийн засгийн хувьд дорой байгаа ардчилсан шилжсэн улс орнуудад донороос хамаарах хамаарал нэмэгдэж, төр засагт үйлчлэх шинжтэй байгааг мөн тэмдэглэж байна.⁹

Төрийн бус байгууллага, ардчиллын тухай ном зохиолд иргэний нийгэм, ардчилсан хөгжлийг бэхжүүлэхэд ИНБ-уудын гүйцэтгэх үүргийг дэмжсэн гурван гол үндэслэл байна.

1. Юуны өмнө, ИНБ-ууд бие даасан оролцогчид байдгаараа засаглалын институцийн олон ургалч байдлыг хангаж байдаг.
2. ИНБ-ууд ихэвчлэн санхүүгийн чадваргүй, эрх ашиг нь хамгаалагдах шаардлагатай бүлгүүдээс бүрддэг анхан шатны байгууллагуудтай хамтран ажилладаг ба үүнтэй холбоотойгоор иргэдийн оролцоог нэмэгдүүлэх (нийгэм, газарзүйн хувьд) мөн гүнзгийрүүлэх (хувь хүний болон зохион байгуулалтын чадавхын хувьд) боломжтой (Silliman and Noble, 1998: 306). Судлаач Фишер энэ төрлийн "доороос дээш чиглэсэн

⁶ Jonas J. Schoenefeld Interest Groups, NGOs or Civil Society Organisations? The Framing of Non-State Actors in the EU

⁷ Claire Mercer NGOs, civil society and democratization: a critical review of the literature

⁸ Vladimíra Dvořáková Civil Society in Latin America and Eastern Europe: Reinvention or Imposition? 2008

⁹ Мөн тэнд

ардчилал" нь олон тохиолдолд маш амжилттай байсан тул эцэст нь "дээрээс доош чиглэсэн улс төрийн өөрчлөлт"-д хүргэж болзошгүй гэж үздэг (1998: 126).

3. ИНБ-ууд төрийн эрх мэдлийн төвлөрсөн болон орон нутгийн хэмжээнд бие даасан байдлыг нь сорьж, өөрчлөлт хийхийг шахаж, ялгаатай бодлого боловсруулан санал болгох замаар шалгадаг гэжээ.

ИНБ-ууд засаглалын институцийн талбарыг олон талт болгож, иргэний нийгмийг өргөжүүлэн бэхжүүлж, улс төрийн хүрээнд илүү ардчилсан оролцогчдыг авчирдаг учраас ардчиллыг дэмждэг нь гарцаагүй. Гэвч иргэний нийгмийн байгууллагын салбар байж л ийм үр дүнд хүрнэ гэж үзэх нь хэтэрхий ерөнхий юм. Ийм байр суурь нь ихэвчлэн ИНБ-уудыг иргэний нийгэмтэй (мөн эсрэгээр) хооронд нь хольж хутгах явдалд хүргэдэг тул олон тооны ИНБ-уудыг иргэний нийгмийн гол хэмжүүр болгоход хүргэж байгаа нь өрөөсгөл юм. Ийм байр суурь нь ер бусын зүйл биш (Фукуяма, 2001) бөгөөд хэд хэдэн шалтгааны улмаас асуудалтай байдаг. Нэгдүгээрт, ИНБ-ууд хөгжиж буй орнуудад иргэний нийгмийн биелэл болж хувирах ёстой байсан шалтгаануудын нэг хэсэг нь ИНБ өөрчлөгдөж буй хөгжилтэй холбоотой гэдгийг хүлээн зөвшөөрөх байдалтай холбогдож байна. ИНБ-уудын мөн чанар нь ардчилсан шинж чанартай. Хоёрдугаарт, ИНБ-уудыг иргэний нийгэмтэй холих нь ойлголтын хувьд тодорхойгүй байдал үүсгэж байдаг ба ИНБ-ын ангилалд хамаарах байгууллагуудын хүрээ нь зохиогч, байгууллага, орон нутгийн хувьд ялгаатай байдаг тул "иргэний нийгэм" гэдэг нь өөрөө ойлголтын хувьд тодорхойгүй байдаг. Гуравдугаарт, ИНБ болон ТББ-уудыг төрийн өмнө харуулын үүрэг гүйцэтгэх, эсвэл тодорхой бүлгийн эрх ашгийг төлөөлөх зэрэг иргэний нийгмийн тодорхой шинж чанаруудыг эзэмшдэг гэж үздэг.

Монгол Улсад Төрийн бус байгууллагын тухай хууль 1997 онд батлагдсанаас хойш иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, хүний эрхийг хангахад ИНБ, ТББ-ууд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Хууль батлагдсанаас хойш үйл ажиллагаа явуулах ТББ-уудын тоо өсөж, зохион байгуулалт, үйл ажиллагаа, салбар чиглэл, нийслэл, аймаг бүрд хүрч ажилладаг иргэний нийгэм төлөвшин хөгжиж байна.¹⁰ Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 24,276 бүртгэлтэй ТББ байгаагаас үйл ажиллагаа явуулж байгаа нь 10,806 байна¹¹. 2013 оноос бүртгэлтэй ТББ болон үйл ажиллагаа эрхлээгүй ТББ-ын тоо хурдтай нэмэгдэх болсон байна. Нийт бүртгэлтэй ААНБ-ын дунд эзэлж буй ТББ-ын хувь хэмжээ 1998 онд 5.7% байснаа 2020 онд 9.7% болж бараг 2 дахин нэмэгдсэн байна. Орон нутаг болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичиг, эрх зүйн актад оруулж батлуулсан нэмэлт өөрчлөлтийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл байгаль орчны чиглэлээр 85¹² бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан нь хамгийн их байна.

“Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт судалгааны багаас хийсэн өндөр түвшний экспертүүдээс авсан судалгааны үр дүнд боловсруулалт хийж үзэхэд ардчиллын хөгжилд төрийн институцийн хөгжил 0.255* нэгжээр, улс төрийн институцийн хөгжил 0.175* нэгжээр, иргэдийн оролцоо 0.021* нэгжээр, иргэний нийгмийн хөгжил 0.149* нэгжээр, улс төрийн соёлын төлөвшил 0.166* нэгжээр тус тус нөлөөлсөн байна. Үүнээс үзвэл ардчиллын хөгжил нь төрийн институцийн хөгжлөөс хамгийн их буюу 0.255 нэгжээр, иргэдийн оролцооноос

¹⁰ Монголын иргэний нийгмийн консорциум. ИРГЭНИЙ ОРОН ЗАЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА. УБ. 2021

¹¹ Үндэсний статистикийн хороо, Бизнес регистрийн сан, 2020

¹² Монголын иргэний нийгмийн консорциум. ИРГЭНИЙ ОРОН ЗАЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА. УБ. 2021

хамгийн бага буюу 0.021 нэгжээр эерэг хамааралтай байна¹³. Ардчиллын хөгжилд иргэдийн оролцоо хамгийн бага хамааралтай гарсан нь анхаарал татаж байна. Экспертүүдээс Монголын ардчиллын хөгжилд саад болж буй хүчин зүйлсийг нэрлэнэ үү гэсэн нээлттэй асуулгад хамгийн их давтагдаж байгаа хариултуудыг авч үзвэл

1. Ардчиллын талаарх зөв үзэл төлөвшиж чадаагүй, үзэл санаа үнэт зүйлсийг цэгцтэй ойлголт мэдлэг бүрдээгүй
 2. Эрх мэдлийн зөрчил, клиенталист улс төрчид, хуйвалдааны улс төр цэцэглэсэн
 3. Өндөр түвшний авлига, албан тушаалын гэмт хэрэг болон шударга бус байдал даамжирсан
 4. Улс төрийн намуудын төлөвшөөгүй байдал, намуудын хагарал
 5. Эдийн засгийн сул дорой байдал, амьжиргааны түвшний доройтол
 6. Хуучин нийгмийн тогтолцооны суурь, хандлага
 7. Иргэдийн улс төрийн боловсрол муу
- зэрэг хариултуудыг хамгийн олон давтамжтайгаар нэрлэсэн байна.

аливаа эвсэл холбоод, хөдөлгөөн зэргийг зохион байгуулж, улмаар тэрхүү төлөөлөгчдийн сонгосон хэсэг нь тэдний нэрийн өмнөөс ашиг сонирхлоо төр засагт уламжлах, хамгаалах, итгүүлэн үнэмшүүлэх зэрэг үйл ажиллагааг үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу эрхлэн явуулах шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна. Иргэдийн улс төрийг сонирхох байдлыг оршин суугаа газартай харьцуулахад тодорхой ялгаа ажиглагдахгүй байгаа нь нийгэмд энэ ойлголт байр суурь хот, хөдөөгүй нэгэн хэвийн байгаа авч, газар нутгийн байршлын ялгаа нөлөөлөхгүйгээр тэдний улс төрийн амьдралын идэвх, сонирхлоос гадна оролцооны түвшин олон шатны, тодорхой үйл ажиллагаанд хэрхэн хангагдаж байгааг дараах зүйлсээр тодорхойлохыг оролдлоо.


Улс төрийн мэдлэг, улс төрийн боловсрол иргэдийн улс төрийн үйл байдалд хэрхэн нөлөөлж буйг судлах явцад улс төрийн ухамсрын асуудал хөндөгддөг. “Улс төрийн ухамсар бол тухайн хүний улс төрийн сэтгэлгээ юм. Энэхүү сэтгэлийн байдал нь улс төрийн талаарх хувийн байр суурь, улс төрийн тогтолцоо, түүхэн дэх байр суурь, үйл ажиллагаа явуулж буй улс төрийн бодит байдалд нөлөөлөхийн тулд хийх боломжтой гэж үздэг үйлдлүүд дээр суурилдаг. Улс төрийн ухамсар нь улс төрийн өвөрмөц байдал, улс төрийн оролцоо, улс төрийн соёл, ард түмэн, төрийн хоорондын нийгмийн гэрээний үзэл санаатай нягт холбоотой байдаг.”¹⁰ Өөрөөр хэлбэл өөрсдийн жинхэнэ улс төрийн үүрэг, жинхэнэ мөн чанараа олсон гэдгийг илтгэх үзүүлэлт болж, энэ нь олон нийт, бие хүмүүсийн иргэнлэг байдалд шууд нөлөө үзүүлдэг байна. Улс төрийн ухамсар төлөвшин тогтоход тухайн бие хүний төрж, өссөн орчин гэр бүл, найз нөхдийн хүрээлэл, сургууль, хамт олон, үе тэнгийнхний нөлөөлөл, улс төрийн институт, төрийн байгууллагын бодлого, шийдвэрүүд, улс төрчдийн үйл байдал, улс төрийн үйл явц, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зэрэг олон хүчин зүйлс нөлөөлөлдөг. Энэ бүхэн эргээд улс төрийн тогтолцооны мөн чанарын талаарх өргөн тархсан итгэл үнэмшил, мэдрэмж, үнэлэмжийг бий болгож, иргэн, төрийн харилцааны холбоос болдог байна.

Бидний цахимаар хийсэн олон нийтийн санаа бодлын тандан судалгаанд оролцсон нийт оролцогчдын улс төрийн мэдлэгтээ сэтгэл хангалуун байгаа эсэх талаар 1-10 баллаар үнэлсэн үнэлгээнд 69.2% нь таваас дээш үнэлгээ өгсөн бол өндөр түвшний экспертийн санаа бодлын судалгаагаар ардчилалд саад болж буй хүчин зүйлсийг тодорхойлсон ойлголтуудын хамгийн их давтамжтай хариултыг агуулгаар нь багцлан ангилахад 28.3% иргэдийн улс төрийн мэдлэг боловсрол сул, улс төрийн ташаа ойлголттой байдаг, улс төрийн оролцоо бага гэсэн үзүүлэлт хамгийн өндөр дүнтэй байна. Олон нийт өөрсдийн улс төрийн мэдлэгийг дунджаас дээш хэмээн үнэлж байгаа бол экспертүүд сонгогчдын үйл байдалд дүн шинжилгээ хийж олон нийтийн улс төрийн оролцоо хангалтгүй эсвэл улс төрийн бодит нөхцөлийг ухамсарласан сонголтыг хийж чадахгүй байгаа нь ардчиллыг гажуудуулах, сулруулах хүчин зүйл болж байна гэдэг байр суурийг илэрхийлж байна. Харин олон нийтийн улс төрийн мэдлэг олж авах сувгийн хувьд олон нийтийн мэдээллийн хэрэгслээс 46.7%, цахим орчноос 34.7%, сургууль, сургалтын үйл ажиллагаанаас 5.3%, гэр бүл ойр дотнынхоосоо 6.7%, найз нөхөд, хамт олноосоо 4%, ном, бүтээлээс 1.3% гэж хариулсан байна. Интернэтийн хэрэглээ хурдацтай нэмэгдсэн нь улс төрийн үйл явцад социал сүлжээний үүргийг нэмэгдүүлж, улс төрийн институт, улс төрчдийн олон нийтийн сэтгэл хөдлөлийг улс төрийн зорилгоор ашигладаг, олон нийтийн сэтгэлзүйг хянах, удирдах, ашиг сонирхлоо хэрэгжүүлэх нарийн боловсруулсан компанит ажлыг зохион байгуулдаг олон төрлийн арга технологиуд хөгжих байна. Үүний үр дүнд улс төрийн институтууд хүртэл цахим хэлбэрт шилжих, олон нийт улс төрийн оролцоог цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, сэтгэгдэл үлдээх зэргээр тодорхойлох болов.

¹⁰ https://link.springer.com/referenceworkentry/10.1007/978-94-007-0753-5_2193

Түүнчлэн энэ сэдвийн хүрээнд авч үзэх ёстой нэг чухал асуудал бол улс төрийн сонирхолгүй, улс төрийн үйл хэрэгт ямар нэгэн байдлаар татагдан орохоос татгалзах хандлагатай бүлэг, бие хүний талаарх ойлголт, төсөөлөл юм. Үүнд хүмүүсийн хүүхэд нас болон өсвөр насны үеийн ойр дотнынхон, эцэг эхийн нөлөөлөл их байдаг. Эцэг эх, ойр дотнынх нь улс төрийн сонирхолгүй байвал тэд ихэвчлэн улс төрийн сонирхолгүй болж төлөвшдөг байна. Тиймээс сонгуульд очиж саналаа өгөхийн оронд дуртай телевизийн нэвтрүүлгээ үзэх, өөрийн сонирхсон зүйлсээ хийхийг илүүд үздэг. Судалгаанаас харахад судалгаанд оролцогчдын улс төр сонирхдоггүй хэсэг нь нэлээд өндөр хувийг тогтмол эзэлж байгаа бөгөөд 2010 онд 38.4% байсан бол 2019 онд 45.6% болж өсжээ. Нөгөөтэйгөөр, сонгуульд санаа өгсөн ч тэдний санал төрийн бодлогод нөлөөлөхгүй гэсэн итгэл үнэмшилтэй байдагтай холбоотойгоор улс төрийн сонгуулийн идэвх сулардаг.

Зураг 1. Сонгогчдын улс төрийн бодлогод нөлөөлөх нөлөө



Эх сурвалж: “Сант Марал” Сан Улс төрийн барометр

Олон нийтийн санаа бодлын тандалт судалгаанаас үзэхэд сонгогчдын улс төрийн бодлогод огт нөлөөлдөггүй гэсэн үзүүлэлт тогтмол нэмэгдэж 2021 оны байдлаар 25.5% хүрсэн байгаа бөгөөд бага зэрэг нөлөөлдөг гэсэн үзүүлэлтийг сөрөг үнэлгээ гэж авч үзвэл судалгаанд оролцогчдын 69.1% нь сонгууль өгсөн ч тэр цаашдын төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөх нөлөө сул гэж үздэг гэсэн хандлага харагдаж байна. Мөн сонгогчдын улс төрийн бодлогод нөлөөлдөг нөлөө огт байхгүй гэж үзэх хандлага 11 жилийн өмнөхтэй харьцуулахад 14.7 нэгжээр, бага зэрэг л нөлөөлдөг гэсэн хандлага 11 нэгжээр нэмэгдсэн нь олон нийт сонгуульд саналаа өгөх нь үр ашиггүй, цагаа дэмий үрсэн зүйл гэж үздэгийн илрэл гэлтэй.

Улс төрөөс залхах хандлага нь иргэд төрийн болон улс төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй болж итгэх итгэл нь буурснаас сонгуульд саналаа өгөх нь цагаа үрсэн дэмий хэрэг гэж үзэж сонгуульд оролцохоос татгалзаж байгаагаар илэрдэг. Манай улсын хувьд улс төрийн институтүүдээс итгэл үзүүлэлтээр хамгийн бага хувийг эзэлж байгаа нь улс төрийн намууд байна. Энэ нь улс төрийн сонгуульд мөрийн хөтөлбөрөө танилцуулах гол оролцогч нь болох улс төрийн нам байдаг учраас улс төрийн намд дургүйцсэн иргэд сонгуульд оролцохоос татгалзах хандлага буюу “abstention” их байх магадлалтай.

Монголчуудын улс төрийн үнэт зүйлс, түүний уламжлалт болон модерн шинжийн тухайд

Эрдэмтэн Х.Нямбуу “Уламжлал гэдэг нь өргөн утгаараа нийгмийн туршлага үзэл санааг үеэс үед дамжуулах нийгмийн харилцааны онцгой хэлбэр”¹¹ хэмээн тодорхойлсон бол эрдэмтэн Ц.Ганболд “Уламжлал бол юуны өмнө хэм хэмжээ, арга жаяг, туршлага өөрөө хараахан биш харин тэдгээр арга маяг хэм хэмжээ туршлага нь тодорхой цаг хугацаа, орон зайд тодорхой хэмжээгээр дахин сэргээгдэх замаар харьцангуй давтагдаж буй хэрэг, өөрөөр хэлбэл уламжлал гэдэг нь нийгмийн харилцааны элемент, үйл ажиллагааны нэг тал, философийн утгаараа хөгжлийн залгамжлагдах түгээмэл хууль нийгэмд өвөрмөц байдлаар илэрч буй хэрэг”¹² хэмээжээ. Уламжлал судлалын судалгааны чиглэлүүдээс харахад нийгэм, улс төрийн сэтгэлгээтэй холбоотойгоор Өрнөдийн судлаачдын хувьд нийгмийн харилцааны гол субъект болдог бие хүний сэтгэлзүй, аж амьдралд уламжлалын нөлөөтэй байдал, нийгмийн ухамсрын түвшин, удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөө, хэл соёл, шашин, зан заншлын дамжих үйл явц талаас нь түлхүү судалдаг бол Дорнын улс орнууд тэр дундаа Монгол Улсын хувьд уламжлалт зан заншил, сурган хүмүүжүүлэх ухаан, түүх, уран зохиол, ёс заншил, угсаатан зүй, нийгэм улс төрийн сэтгэлгээ, төрт ёс, эрх зүйн уламжлал зэрэг талаас судлагдаж байна.

Монголчуудын улс төрийн уламжлалд өнөөг хүртэл хадгалагдан ирсэн зарим ойлголтыг судлаачдын байр сууриар тодорхойлбол:

- “Монголын төр хэзээнээс нааш төр улсынхаа тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдал, үндэснийхээ эрх ашиг, нэр төрийг хамгаалж ирсэн.”¹³

- “Хүннүгийн үеийн зонхилогчдын зөвлөлөөс Чингисийн үеийн их хуралдай, Богд хаант Монгол Улсын дээд доод хурлаас одоогийн УИХ хүртэлх хуралдайн ёс уламжлагдан ирсэн гэж үзэх үзэх үндэслэлтэй.”¹⁴

- “Нүүдлийн соёл иргэншилтэй, түүнээс улбаалсан эрх чөлөөг эрхэмлэдэг Монголчуудын хувьд нэгдэн нягтрах шалтгаан нь удирдагчийн онцгой авьяас чадвар болох харизм, түүнд суурилан төвлөрсөн нэгдмэл хүчтэй удирдлага болж таарч байна.”¹⁵

- “Дээд тэнгэр, эх нутаг, уул ус, гал голомт, өвөг дээдсээ шүтэн бишрэхээр дамжин төрөө дээдлэх уламжлалт үзэлд нэвт шингэсэн байдаг. Төрд захирагдах дотоод итгэл үнэмшил, монголчуудын улс төрийн соёлын нэг онцлог болохын сацуу ёс суртахуун, зан заншил нүүдэлчдийн хамтаар аж төрөх өвөрмөц, байдлаас үүдэн ахан дүүс, төрөл садан, нутаг усныхаа төдийгүй нийгмийн хэмжээнд хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулахад үлэмж үүрэгтэй байжээ”¹⁶

- “Монгол үндэстэн түүхийн олон зууныг өртөөлөн түүчээлж ирэхдээ төрийг албадлагын хэрэгсэл гэхээсээ илүү авран хамгаалах, өршөөн тэтгэх хүч хэмээн үзэж, төрийг хүчтэй хийгээд төвлөрсөн нэгдмэл цул байх ёстой хэмээ эрхэмлэн дээдэлж байв.”¹⁷

- “Өвөр зуураа эв эвдрэлцвэл төр улс бууран доройтож, хөндлөнгийн хүний идэш болно гэдгийг Чингис хааны үр хүүхдүүд, хамтран зүтгэгч болон удам судар нэгт ахан

¹¹ Ц.Ганболд. Монголын улс төрийн уламжлал, шинэчлэл, тэмдэглэл. УБ., 2020. 54 дэх тал

¹² Ц.Ганболд. Монголын улс төрийн уламжлал, шинэчлэл, тэмдэглэл. УБ., 2020. 54 дэх тал

¹³ Д.Содномгомбо. Монголын уламжлалт төрт ёс, түүний шинэчлэлийн зарим асуудалд. УБ., 2020. 149 дэх тал

¹⁴ Мөн тэнд

¹⁵ Д.Сүхболд. Засаглалын хэлбэр Монголчуудын уламжлалт засаг төрийн тогтолцоо, соёл иргэншил, легитимчлэлтэй уялдах тухай. Политологи №19. УБ., 2021. 61 дэх тал

¹⁶ Шинжлэх ухааны академи, Улс төр, эрхзүйн салбар. Монгол дахь улс төрийн соёл: Уламжлал, орчин үе. УБ., 2020. 77 дахь тал

¹⁷ Мөн тэнд

дүүс, олон түмэн иргэддээ захин гэрээсэлсэн юм. Тиймээс ч эв нэгдлээ хичээн эрхэмлэх үзэл Монгол төрийн бодлогод ч зон олны ухаан бодол, хүмүүжилд ч нэн чухал тулгуур зарчим болсоор ирсэн билээ”¹⁸

- Бидний өвөг дээдсийн “төрийн сүлд өршөө”, “төр төмбөгөр, ёс ёмбогор” хэмээн төрийг дээдлэх үзэл, үнэт зүйл чиг баримжаа нь өнөөг хүртэл уламжлагдан иржээ.”¹⁹ Төрийг дээдлэх үзлийн мөн чанар нь “Манай ухаант ард түмэн энд ганц нэг эрхэм чанар, төрийн албадлагын механизм зэргийг ойлгож хэлээгүй. “төрийн оюуныг буюу оюун сэтгэхүйг дээдлэх зарчмыг хэлж байгаа мэт.”²⁰ Өөрөөр хэлбэл хэн нэг баатар жанжин, төрийн эрхийг барьж буй бүлэг, албадлагын хэрэгслийн дээдлэн шүтнэ гэсэн үг биш харин оюун санааг дээдэлнэ гэсэн санаа буй.

- “Монголчуудын сэтгэлгээнд хариуцлагын мэдрэмж тун бага байр суурь эзэлдэг уламжлалтай төдийгүй ялангуяа Манжийн ноёрхолд орж байсан халх монголчууд ёс журмыг баримтлахгүй, төрт ёс, хууль, цааз, зовох сэтгэлгээг авлига хээл хахуулаар сольж байсан түүхтэй.”²¹

Эрдэмтдийн тэмдэглэсэн эдгээр монголчуудын улс төрийн уламжлалын талаарх үзэл санаа нь бидний өнгөрсөн түүхийн явцад туулж ирсэн замнал, улс төр, нийгмийн нөхцөл байдлаас улбаатай. Бидний явуулсан өндөр түвшний экспертийн судалгаанд бидэнд өвлөгдөн ирсэн хамгийн чухал улс төрийн уламжлалыг дурдахдаа:

Зураг 2. Улс төрийн уламжлалын тухай экспертийн дүгнэлт



Ийнхүү өндөр түвшний экспертийн судалгаанд бидэнд өвлөгдөн ирсэн хамгийн чухал улс төрийн уламжлалыг тодорхойлсон ойлголтуудын хамгийн их давтамжтай хариултыг агуулгаар нь багцлан дээрх чиглэлд ангилснаас 28,5% ардчилал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, 25% төрийг дээдлэх үзэл, 10,7% харьцангуй тайван замаар асуудалд хандаж, зөвшилцөлд хүрэх, 10,7% төрийн болон улс төрийн институц,

¹⁸ Ж.Бор, Д.Баатар. Монголын улс төр. УБ., 2015, 28 дахь тал

¹⁹ Шинжлэх ухааны академи, Улс төр, эрхзүйн салбар. Монгол дахь улс төрийн соёл: Уламжлал, орчин үе. УБ., 2020. 77 дахь тал

²⁰ Ч.Ган-Өлзий. Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлт хөгжил. УБ., 2014. Тод бичиг ХХК, 51 дэх тал

²¹ Ч.Ган-Өлзий. Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлт хөгжил. УБ., 2014. Тод бичиг ХХК, 164 дэх тал

түүнд хандах хандлага зэргийг өндөр үзүүлэлттэй нэрлэжээ. Монголчуудын улс төрийн уламжлалд төр, улсын бүрэн бүтэн байдал, төрийг дээдлэх үзэл санаа илүүтэйгээр хадгалагдан ирсэн байдаг нь эртнээс төр ард түмнээ амар энх амьдруулахын тулд дотоод хямрал, харийн түрэмгийллийг няцаах гол хүч, хууль сахиулж, ёс журмыг сүсэглүүлэх их хүч болж дээд тэнгэрээс заяасан хүчирхэг хаан эзнээр удирдуулдаг гэсэн ойлголттой холбоотой. Өөрөөр хэлбэл “Шүтэн бишрэхүйн үнэт зүйлс ба төрийн үнэт зүйлс хоёр хэзээ ч эсрэгцэж байгаагүй түүхтэй”²²

Харьцангуй тайван замаар асуудалд хандаж, зөвшилцөлд хүрдэг гэсэн үзэл санааны тухайд “Монголчууд аливаа зүйлд огцом түргэн хандахаасаа илүү яаралгүй алгуур бодож хандах сэтгэлзүй давамгайлсан байдал ажиглагддаг. Энэ чанараасаа болоод хуучнаасаа салж аливаа шинэ зүйлд дасах үйл явц харьцангуй өвөрмөц онцлогтой тал бий. Зах зээлд шилжих үйл явц нийгмийн өөрчлөлтийн хувьд монгол хүний язгуурын сэтгэл зүйтэй нь харьцуулж үзвээс их л тулгуур тавигдсан асуудал гэдгийг хэн бүхэн мэднэ. Гэвч монголчууд аливаа зүйлийг эрс эсэргүүцэхээсээ түрүүнд алив шинэчлэлт өөрчлөлт огцом эсвэл удаан ч байсан тэр бүхнийг аль болох эерэг талаас нь ханддаг нэг талаар тэвчээртэй улс, үндэстэн гэж үзэх үндэслэл бас байдаг.”²³ гэсэн дүгнэлттэй ижил агуулгатай байна.

Нөгөөтээгүүр, төрөө дээдлэх үзэл бидэнд уламжлагдан ирсэн суурь улс төрийн үнэт зүйл мөн боловч сүүлийн үеийн олон нийтийн санаа бодлын судалгаанд төр, засагт сэтгэл дундуур байх, үл итгэх хандлага их байгаа нь чухам хэдий үеэс энэхүү зөрчилтэй нөхцөл бүрэлдсэн эсэхэд анхаарал татаж байна.

МУИС, Японы “АСАХИ” сонины газартай хамтран 1992 оны 10 сард “Монголын ард олны санаа бодлын өнөөгийн дүр төрх” сэдэвт судалгааг хийсэн бөгөөд дараах асуудлыг тодруулах зорилготой байжээ.

1. Монголд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлийн үйл явц, тухайн үеийн бодит байдалд өгөх ард олны үнэлэлт дүгнэлт
2. Улс үндэсний ирээдүй, хөгжлийн чиг хандлага, түүний тулгуур үндэс, учир шалтгааны тухай төсөөлөл
3. Монгол хүний хэрэгцээ, сонирхлын бүтэц, өөрчлөлт, амьдрах ухааны төлөв хандлага
4. Гадаад харилцааг ойлгох байдал

Тус судалгааны зарим дүнгээс үзвэл цаашдын амьдралд хамгийн түгшүүр үүсгэж буй хүчин зүйлсийн тухайд хамгийн өндөр үзүүлэлт нь хүний мөс чанарын өөрчлөлт 32.4%, үнийн өсөлт, мөнгөний ханшны бууралт 20.1%, гэмт хэрэг, нийгмийн журмын гажуудал 14.3% нь хариулсан байна. Хамгийн хүнд хэцүү үед засаг төрд 34.2%, улс орны дотоод нөөц, бололцоонд 23.9%, олон түмний хүчин зүйлд 15.8% нь найдвар тавьж буйгаа илэрхийлжээ. Монгол Улсын улс төрийн байдлыг маш сайн болон хангалттай гэж 30.5%, хангалтгүй болон маш хангалтгүй гэж 64.8% нь үзсэн бол 1990 оноос ардчиллын талаарх явуулсан бодлогыг их дэмжиж байгаа 25.2%, бага зэрэг 44.5%, нэг их дэмжихгүй болон огт дэмжихгүй гэж 31.8% нь хариулжээ. Түүнчлэн ардчилах үйл явцын үр дүнд улс төрийн бодлогод санал бодол нь тусаж байгаа эсэхэд маш хангалттай болон нэлээд тусаж байгаа гэж 39.1%, бага зэрэг тусаж байгаа гэж 45.8%, огт тусахгүй байна гэж 9.5 хувь нь тус тус үзэж байжээ.

Дээрх хариултаас харвал 1990 оны ардчилах үйл явцыг эхэн үедээ нийгмийн дэг журам, хүний мөс чанарыг алдагдуулах эрсдэлтэй улс төрийн үзэгдэл гэж болгоомжилж ийм хэцүү цаг үед төр засагт итгэл тавьж, бодлого шийдвэрүүдэд нь

²² Ч.Ган-Өлзий. Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлт хөгжил. УБ., 2014. Тод бичиг ХХК, 50 дахь тал

²³ В.Отгоннасан. Монголын нийгэм ба олон нийтийн санаа бодол. УБ., 2021. 139 дэх тал


олон нийтийн санаа бодол тусдаг гэсэн байр суурьтай байжээ. Энэ нь өмнөх социалист тогтолцооны ул мөр бөгөөд аажимдаа энэ байр суурь өөрчлөгдөж эхэлсэн байна.

“Засгийн газарт итгэх олон түмний итгэлийн бууралтыг харуулж байвал улс төрийн системд асуудал үүсэж байгааг илтгэсэн түгшүүрийн дохио гэж тайлбарлах явдал элбэг байдаг байна. Удаан хугацаанд оршин тогтож буй дэглэмтэй харьцуулахад ардчиллыг шинээр тогтоосон улс орнууд илүү эмзэг байдаг учраас итгэл буурах, үл итгэх байдал өсөх нь бүр ч их аюултай.”²⁴ Хувь хүмүүсийн улс төрийн системээ үнэлэх үнэлэмж нь улс төрийн институтуудад итгэх итгэл, түүнээс үүдэн гарах улс төрийн үйл байдлаар илэрч байдаг.

“Хүмүүс эдийн засгийн нөхцөл байдлын талаар илүү эерэг төсөөлөлтэй байвал тэд улс төрд итгэх магадлал нь илүү байдаг.”²⁵ Учир нь хувь хүмүүс эдийн засгийн өнөөгийн байдал, өмнөх байдал, өнөөгийн байдал болон өмнөх байдлын хоорондын өөрчлөлт, ирээдүйн талаар төсөөлөл зэргээр улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн байдлыг дүгнэдэг. Монгол улсын хувьд ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орж эхэлснээр улс төр бизнесийн явцуу бүлэглэлд эрх мэдлийн далд төвлөрөл бий болох үйл явц өрнөснөөр хувь хүмүүсийн улс төрийн үнэлэмж өөрчлөгдөж, улс төрийн итгэл буурч эхэлсэн. Энэ нь эдийн засгийн рационал байдал чухал бөгөөд эдийн засаг сайн байх нь эрх баригчдад илүү дэмжлэг үзүүлдэг.

Улс төр-эдийн засгаас үүдэлтэй авлигын нөлөөлөл: “Засгийн газар эдийн засгийн нэлээд хэсгийг хянадаг бөгөөд тэгэх ч ёстой гэж иргэд үздэг учраас үндэсний эдийн засгийн нөхцөл байдлыг улс төрийн итгэлтэй холбож үзэх нь ойлгомжтой. Гэхдээ төр нь эдийн засгийн өсөлтийн үр шимийг хуваарилахдаа авлигад автсан бол эдийн засгийн өсөлт нь үл итгэх байдлыг нэмэгдүүлж болдог”²⁶

Зураг 3. Төрд итгэх иргэдийн илтгэл
(Төр засаг иргэдийн төлөө зөв зүйтэй зүйл хийж байна гэдэгт итгэж байгаа эсэх)



Эх сурвалж: “Сант Марал” Сан Улс төрийн барометр


²⁴ Улс Төрийн Боловсролын Академи . Зүүн Азийн Барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ., 2005. 122 дахь тал

²⁵ Мөн тэнд. 126 дахь тал

²⁶ Улс Төрийн Боловсролын Академи. Зүүн Азийн Барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ., 2005

“Авлигын тухайд сүр дуулиан ихтэй цөөн улс төрчдийг шалгасан гэх мэдээллүүд гардаг боловч, улс төрийн шинжтэй шоунаас хэтэрч авлигыг бүх төвшинд бууруулах бодит үр дүнгээ өгөхгүй байгаа учраас авлигын үзүүлэлтүүд олигтой багасахгүй байна. Харин ч нийгмийг айдас хүйдэст автуулах, хаглан бутаргах, зарим сөрөг үр дагавартай болж байгааг ирэгд анхааруулж байгаа билээ”²⁷ Улс төрийн итгэлцэлд үзүүлэх эдийн засгийн нөлөө, улс төрийн нөлөө, улс төр-эдийн засгаас үүдэлтэй авлигын нөлөө хувь хүний үнэлэмж дэх улс төрийн итгэлд ийнхүү нөлөөлөх нь улс төрийн институтэд итгэх итгэлийн үзүүлэлтээр тод ажиглагдах боломжтой.

Зураг 4. Улс төрийн тусгай итгэлийн харьцуулал
(Улс төрийн тогтолцооны байгууллагад итгэдэг эсэх /итгэдэггүй)



Эх сурвалж: “Сант Марал” Сан Улс төрийн барометр*

Улс төрийн байгууллагуудад итгэх итгэлийн үзүүлэлт жил ирэх тусам буурч байгаа бөгөөд иргэдийн итгэлийг хамгийн бага төрүүлдэг байгууллагаар УИХ, хуулийн байгууллагууд, улс төрийн намууд байна. УИХ- д итгэдэггүй гэсэн үзүүлэлт 2010 онд 44,6% байсан бол 2019 онд 62,6% болж 18 нэгжээр, хуулийн байгууллагуудад итгэдэггүй гэсэн үзүүлэлт 2010 онд 54,8% байсан бол 2019 онд 55,7% болж 0,9 нэгжээр, улс төрийн намуудад итгэдэггүй гэсэн үзүүлэлт 2010 онд 58,5% байсан бол 2019 онд 73,7% болж 15,2 нэгжээр тус тус нэмэгдсэн байна. Харин тухайн институтэд итгэх итгэл 2021 онд тодорхой түвшинд нэмэгдсэн нь Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн төрийн бодлого, шийдвэрүүдтэй холбоотой байх магадлалтай. Тухайлбал, зээлийн хүүг хойшлуулах, мөнгөн тусламж үзүүлэх, ахуйн хэрэглээний зардлыг үнийг тэглэсэн зэрэг нь гол нөлөө үзүүлсэн болов уу хэмээн таамаглаж байна.

Монголын ардчиллын хөгжилд саад болж буй хүчин зүйлстэй дүйцүүлэн үзэх боломжтой гэж үзэж байна. “2016 оны шинжээчдийн үнэлгээгээр монголын ардчиллын

²⁷О. Хатанболд. Ардчиллыг ойлгохуй ба судлахуй Монгол орны Жишээн дээр. УБ., 2017. "Соёмбо принтинг" ХХК. 129 дэх тал

* Улс төрийн тогтолцооны байгууллагад итгэх олон нийтийн санаа бодлын итгэдэггүй гэсэн үзүүлэлтийг бараг итгэдэггүй болон итгэдэггүй гэсэн хувийн нийлбэрээр тооцсон болно.

хөгжилд саад бэрхшээл учруулж буй хамгийн гол хүчин зүйлсийг шинжээчид эрх мэдлийн төлөөх тэмцэл 81,3%, авлига, хээл хахууль 75%, шударга бус байдал 65,6%, улс төрийн намуудын төлөвшил 46,9%, улс төрчдийн хувийн ашгаа илүүд үздэг байдал 37,6%, боловсрол нэмгэн байдал 34,4%, нийгмийн эмх замбараагүй байдал 18,8%, төрийн албаны хүнд суртал, төрийн дарамт 15,6%, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа 12,5% гэсэн шатлалаар 17 бэрхшээлийг дурдсан байна.”²⁸

Зураг 5. Ардчилалд саад болж буй хүчин зүйлс
/Өндөр түвшний экспертийн санаа бодлын судалгаа/



Өндөр түвшний экспертийн судалгаанд ардчилалд саад болж буй хүчин зүйлсийг тодорхойлсон ойлголтуудын хамгийн их давтамжтай хариултыг агуулгаар нь багцлан дээрх чиглэлд ангилснаас 28.3% иргэдийн улс төрийн мэдлэг боловсрол сул, улс төрийн ташаа ойлголттой байдаг, Улс төрийн оролцоо бага, 16.6% авлига, улс төрийн санхүүжилтийн асуудал, 10.5% улс төрийн тогтолцоо, төрийн эрх мэдлийн хуваарилалтын алдаа, 8.3% улс төрийн намын төлөвшил гэсэн агуулга өндөр үзүүлэлттэй байгаа нь 2016 онд хийгдсэн шинжээчдийн үнэлгээтэй ижил байгааг илэрхийлж байна.

Мөн дараагийн анхаарал татаж буй сэдэв бол засаглал дэмжих олон нитийн хандлага бөгөөд “Парламент, сонгуулийг үгүй хийх дарангуйлагчийг гаргаж ирэх ардчилсан бус хувилбарыг дэмжиж байгаа нь оршин буй улс төрийн институт итгэх итгэл доогуур байгаатай холбоотой байж болох юм”²⁹

Зураг 6. Монгол дахь засаглалын хэлбэрийн дэмжлэг
(Монголд ямар засаглал илүү тохирох вэ?)

²⁸ Мөн тэнд. 130 дахь тал

²⁹ Улс Төрийн Боловсролын Академи. Зүүн Азийн Барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ., 2005. 127 дахь тал



Эх сурвалж: “Сант Марал” Сан Улс төрийн барометр

Судалгаанаас үзэхэд одоо байгаа засаглалын хэлбэрээ дэмжих хандлага тогтмол буурч харин улс төрийн намуудын нөлөөллийг хязгаарласан ерөнхийлөгчийн засаглалыг дэмжих хандлага тогтмол нэмэгджээ. Энэ нь нөгөө талаараа улс төрийн институтүүдээс иргэдийн итгэх итгэл хамгийн бага нь улс төрийн нам байгаатай холбоотой байх талтай. Учир нь төрийн бодлого мөн чанарынхаа хувьд зөв зохистой байхын тулд оролцож буй субъектүүдийн тэгш оролцоо чухал хэдий ч ардчилал бэхжиж амжаагүй байгаа манайх шиг улсын хувьд улс төр эдийн засгийн явцуу бүлэг үүсэж, корпорацийн сонирхлоо хамгаалан тодорхой хүрээнд төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд үлэмж нөлөө үзүүлдэг.

Судалгааны дүнгүүдээс харахад улс төрийн итгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг харгалзан үзэх онол, практикийн ач холбогдолтой. Улс төрийн итгэлд нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх олон судалгааны ажил байдаг бөгөөд улс төр судлаач Ричард Роуз Монгол улсыг оролцуулаад Зүүн Азийн бүс нутагт ардчиллын хөгжлийн талаарх харьцуулсан судалгааг хийсэн нь бүс нутгийн хийгээд улс орны онцлогийг тусгасан тул илүү нийцтэй байна. Улс төрийн итгэлд үзүүлж буй женерик нөлөөнд:

- Нийгмийн бүтцийн таван сонгодог ялгаа \нас хүйс, боловсрол, шашин шүтлэг, гэр бүлийн байдал\.

- Эдийн засгийн нөхцөл: эдийн засгийн нөхцөл байдлын талаар илүү эерэг төсөөлөлтэй байвал тэд улс төрд итгэх магадлал өндөр гэхдээ төр нь эдийн засгийн өсөлтийн үр шимийг хуваарилахдаа авлигад авсан бол эдийн засгийн өсөлт нь үл итгэх итгэлийг нэмэгдүүлж болдог.

- Улс төрийн үнэлэмж: шинээр ардчилал тогтсон улсуудын иргэд ардчилсан болон ардчилсан бус дэглэмүүдийн аль алинд амьдарч үзсэн учир улс төрийн өрсөлдөөний тулгуур хэлбэр нь дэглэмүүдийн хоорондын өрсөлдөөн болдог.

Улс төрийн итгэлд үзүүлж буй тухайлсан нөлөөнд:

- Азийн уламжлалт үнэт зүйлс \гэр бүлийг дээдлэх, ахмадыг болон зэрэг дэв бүхий бүлгийн тэргүүнийг хүндэтгэх, бүлгийн хэм хэмжээг хувийн сонирхлоос дээгүүр тавих\

- Пост коммунист үнэлэмж \материалаас шинж чанартай эдийн засгийн бодлого болон нам төвт үзэл\

- Улс орны онцлог өөрийн улс төрийн соёл

Тус хандлагаар улс төрийн итгэл буурах женерик нөлөө болох социал болон эдийн засгийн хүчин зүйл, тухайлсан нөхцөл болсон улс орны өөрийн онцлог улс төрийн соёлын тухай өмнө нь нэлээдгүй дурдсан тул бусад агуулгын хүрээнд товч дурдъя.


Шинээр ардчилал тогтоод удаагүй байгаа улсын хувьд иргэдийн улс төрийн үнэлэмж ардчилсан болон ардчилсан бус дэглэмүүдийн хоорондын өрсөлдөөн, харьцуулал байнга явагдаж байдаг. Өндөр түвшний экспертийн судалгаанд Монголын ардчиллыг 1-7 оноогоор гурван түвшинд үнэлэхэд Монгол Улсын хэмжээнд 3.7558, оршин суугаа газарт 3.6163, ажилладаг байгууллага, салбарт 4.0930 гэж үнэлсэн бол судалгааны дүнг бататгах олон нийтийн санаа бодлын туршилт судалгаанд оролцсон нийт оролцогчдын 56.2% Монгол улсын хэмжээнд ардчиллын хөгжил дунд, 51.2% оршин суугаа газарт дунд, 48.7% ажилладаг байгуулга, салбарт дунд гэсэн үнэлгээ өгч байгаа нь судалгааны дүнгүүд таарч байгааг илэрхийлж байна. Мөн социализмын талаарх байр суурийг тодруулах экспертийн асуултын хэсэгт 1-7 оноогоор дүгнэхэд илүү сайхан амьдарч байсан 2.4878, зарим талаараа сайхан амьдрах нөхцөл бүрдсэн байсан 3.5714, олон талаараа сайхан амьдрах боломжгүй байсан 2.4268, ардчилаас мэдээж муу байсан 4.6463, мэдэхгүй 2.1379 гэсэн үнэлгээ өгсөн нь ардчиллын хөгжил дундаж гэж үзэж байгаа боловч социализмаас илүү гэсэн хандлагатай хэсэг давамгайлж байна.

Монголчуудын улс төрийн үйл байдалд гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн тухайд үнэнийг тогтоохдоо зөвхөн удирдлагын систем, институтийн бүтцийг судлах нь хангалтгүй бөгөөд үндсэн хуулийн заалт, төрийн бодлого шийдвэр, сонгуулийн үр дүн, нийгмийн гишүүд сонгуульд оролцож байгааг хэр зэрэг ухамсарлаж буйг түшиглэн үнэн, бодит нөхцөлийг судалж тогтоосноор цаашдын улс орон, нийгмийн хөгжлийг тодорхойлох үндэс суурь болж өгдөг. “Иргэдийн байнгын үр нөлөө бүхий оролцоогүйгээр ардчилал оршин тогтнох боломжгүй юм. Зөвхөн төлөөллийн ардчиллаар хязгаарлах юм бол удирдлагын элит бүлэг буй болох, төр иргэдээс хол хөндий болох, зэрэг улс төрийн талын хор уршгаас гадна төрийн бодлого ард түмний ашиг сонирхлоос хөндийрөх, хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байх зэрэг сөрөг талтай.”³⁰

Зураг 7. Улс төрийн амьдралд оролцох боломжийн талаарх бодомжууд, иргэдийн санал бодол, 2019 он

³⁰ Ш.Батсүх, Ц.Дэлгэржаргал. Орон нутаг дахь иргэдийн оролцоо. In Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь. УБ., 2019. "Мөнхийн үсэг" ХХК, 198 дахь тал



Эх сурвалж: “Ардчиллын талаарх ОНСБ,” 2019³¹

Олон нийтийн санаа бодлын уг судалгааны дүнд “Улс төр жирийн иргэдэд улам хаалттай зүйл болж хувирах бүрийдээ дээдсийн давхарга олон түмнээс тасран нарийсах төлөвт орох юм. Ингэх тусам хүн амын хамгийн чинээлэг өчүүхэн хэсэг болон улс төрийн элитүүдийн хэлхээ улам бүр нягтрах, улс төрийн өв залгамж ихээхэн нийтлэг зүйл болж ирэх учиртай. Олон түмэн улс төрийн үйл хэрэгт боломж нээлттэй хэвээр үлдэх ч, үнэн хэрэгтээ нийгмийн хамгийн чухал шийдвэрүүдийг гаргахад тэдний бодит нөлөө хумигдах эрсдэлтэй.”³² гэжээ. Учир нь иргэдийн оролцоо тэр дундаа улс төрийн оролцоо эрх зүй, нийгмийн орчинд хязгаарлагдаагүй боловч иргэд улс төрийн оролцооны ач холбогдлыг ухамсарлахгүй байх, өөрсдийн үзэл бодол, нөлөө бодит байдал дээр бодлого шийдвэрт тусдаггүй гэж итгэх, улс төрийн талаар нийгмийн сөрөг үнэлгээ зэрэг хүчин зүйлсээс болж улс төрөөс хүнийсэх хандлага улам нэмэгдэж байна.

Улс төрийн оролцооны судалгаанд залуучуудын улс төрийн оролцооны байдал судлаачдын анхаарлыг татдаг чухал сэдвийн нэг байдаг. Учир нь олон нийтийн санаа бодлын цуврал судалгаа болон сонгуулийн идэвх оролцооны тайлан мэдээнд залуучуудын оролцооны түвшин бага үзүүлэлттэй байдагтай холбоотой юм. 1990-ээд оны дунд үеийн Нийслэлийн залуучуудын нийгмийн дүр төрх³³ судалгааны дүгнэлт хэсэгт тухайн үеийн залуучуудын нийгмийн дүр төрхийг тодорхойлсон нь 1/өмнөх нийгмийн дүр төрхийг мөн давхар илэрхийлсэн, 2/ ардчилалд шилжсэнээр тулгарсан асуудал болон шинэ боломжуудыг тодруулсан, 3/ одоогийн монголчуудын аливаа нийгэм, улс төрийн талаарх үнэлэмж, үйл байдалд эдийн засгийн хүчин үйлс /ахуйн хэрэгцээнээс улбаатай/ илүүтэй нөлөөлөх шалтгаан зэргийг илэрхийлж байна. “Залуучуудын амьдралд бие даан хөл тавих үе нь улс орны шилжилтийн ээдрээтэй үетэй давхацсан, ахуйн болон сэтгэлгээний шинжтэй элдэв бэрхшээл тэдний амьдралд илүү тохиолдсон нь итгэл үнэмшил, чиг зорилгын төлөвшил нь хоёрдмол шинжтэй, энэ нь үнэт зүйлсийн хүрээнд гэхээсээ ахуйн түвшинд прагматик чиглэл рүү түлхүү хандсан, үйл ажиллагааны хүрээнд үндсэн сонирхлоос гадна нийгэм, улс төр, ахуйн шинжтэй элдэв сонирхол, хэрэгцээ зэрэгцэн үүсэж түүний улмаас тодорхой үйл

³¹ Г.Түмэннаст. Нийгмийн социал хүрээний өөрчлөлт, асуудал. In Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2019/ (pp. 240-271). УБ., 2019. "Адмон принт" ХХК. 269 дэх тал

³² Мөн тэнд

³³ В.Отгоннасан. Монголын нийгэм ба олон нийтийн санаа бодол. УБ., 2021. 158 дахь тал

ажиллагааных нь үр дүн тарамдуу шинжтэй байгаа”³⁴, түүнчлэн олон улстай харилцах боломж нээгдсэнтэй холбоотойгоор “залуучууд юм үзэж , нүд тайлж” үзэл санаа, үйл хэргийн олон талт байдал бүрэлдсэн байна.

2016 онд Конрад Аденауэр Сан болон Удирдлагын Академийн хамтран хийсэн “Залуучуудын улс төрийн оролцоо”³⁵ гэсэн судалгааг Хөвсгөл, Говь-Алтай, Хэнтий аймгууд болон нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүргүүдийн 18-35 насны 1051 оролцогчдыг хамруулан хийжээ. Судалгааны дүнгээр нийт судалгаанд оролцсон залуучуудын 7,4% улс төрийн үйл явцад байнга оролцдог, 35% зарим үед оролцдог, 57,6% огт оролцдоггүй гэж хариулсан байна. Улс төрийн оролцооны гол хэлбэрүүд нь сонгуульд саналаа өгөх 70,8%, фэйсбүүкээр санал бодлоо илэрхийлэх 40,7%, твиттерээр санал бодлоо илэрхийлэх 10,1%, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан санал бодлоо илэрхийлэх 10,1% гэх мэт байна. Улс төрд оролцохгүй байх шалтгааныг тодруулахад дараах үр дүн гарсан байна. итгэл үзүүлэх нам, улс төрч байхгүй байна гэж 20,9%, сонгуульд санал өгөхөд төвөгтэй байдаг 17,9%, улс төрд итгэдэггүй 13,7%, улс төр сонирхдоггүй 11,5% нь үзэж байгаа нь судалгааны хамгийн өндөр үзүүлэлтүүд байна. Өндөр үзүүлэлтийн тал хувь нь улс төрийн итгэл бага байгаатай холбоотойгоор улс төрийн оролцоо буурдаг болохыг илтгэж байгаа бөгөөд улс төр хэт замбараагүй байна гэж 55,8%, сонгууль дөхөөд шоу хийсэн байдалтай байна гэж 27,1% гэж нийт оролцогчид хариулж байгаа нь мөн тус дүнг баталгаажуулж байна. Харин залуучуудын улс төр сонирхох байдлын хувьд маш их сонирхдог 6,3%, ер нь сонирхдог 18,7%, хааяа сонирхдог 29,5%, нэг их сонирхдоггүй 33,2%, огт сонирхдоггүй 12,3% нь тус тус хариулжээ.

Нийгэм, улс төрийн аливаа үзэгдэл, үйл явц огтоос сэтгэлд нийцэхгүй болж, төрийн бодлого шийдвэр, улс төрийн нам, улс төрчдийн үйл байдлын талаар хэвлэл мэдээллийн шүүмж хүчтэй өрнөх болж энэ нь эргээд улс төрчид, улс төрийн нам, УИХ, Засгийн газрын гишүүд, төрийн албан тушаалтнууд тэрхүү нөхцөлд нэр төрөө бодох, олон нийтэд таалагдах, дахин сонгогдох зэрэг ашиг сонирхлын үүднээс бодлого, шийдвэр илүүтэй гаргаж байна.

Монгол Улсын хувьд засаглалын легитим шинж нь засаглалын байгууламж, түүний үйл ажиллагаа нь иргэдийн үнэт зүйлстэй нийцэж байгаа байдлаас гадна иргэд ахуй амьдралд нь нөлөөлөх эдийн засгийн үр ашгийг илүүтэйгээр харгалзаж байгаа байдал судалгааны дүнгүүдээс харагдаж байна. Улс орны эдийн засаг тогтворгүй, иргэдийн аж амьдрал таруу, инфляц, ядуурлын түвшин, орлогын зөрүү зэрэг нийгэм, эдийн засгийн сөрөг үзэгдлүүд нь иргэдийн улс төр, төр засагтаа үнэлэлт өгөх хамгийн гол хэмжүүр болж байгаа бөгөөд энэ нь ардчилал бэхжиж байгаа улс орнуудад нийтлэг ажиглагддаг болохыг судлаачид олонтоо тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл тухайн дэглэмийн үед аж амьдрал сайн болсон гэж ард түмэн мэдрэх тусам дэглэмийн хүлээн зөвшөөрөгдөх байдал нэмэгддэг. Нөгөөтэйгөөр улс орны хөгжлийг эдийн засгийн өсөлтөөр хэмжих үзэл санааны тогтох нэг нөхцөл нь Нийслэл залуучуудын дүр төрхийн судалгааны дүнд дурдагдсан “Залуучуудын амьдралд бие даан хөл тавих үе нь улс орны шилжилтийн ээдрээтэй үетэй давхацсан, ахуйн болон сэтгэлгээний шинжтэй элдэв бэрхшээл тэдний амьдралд илүү тохиолдсон”³⁶ гэсэн санаатай холбогдож болох юм.

Иргэд болон улс орны нийгэм- эдийн засаг, улс төр соёлын хүрээний олон чухал асуудлуудад улс төрийн нэг нам, эдийн засгийн явцуу бүлгүүдийн ашиг сонирхолд нийцсэн бодлого шийдвэр гаргах, хээл хахууль, авлигын хэрэгт холбогдох, иргэдийн

³⁴ Мөн тэнд

³⁵ Удирдлагын Академи. Залуучуудын улс төрийн оролцоо /18-35 нас/. 2016. Retrieved from http://ivote.mn/files/kas_45694-1522-18-30.pdf

³⁶ В.Отгоннасан. Монголын нийгэм ба олон нийтийн санаа бодол. УБ., 2021. 158 дахь тал

олон эрхүүдийг зөрчих зэрэг нөхцөлүүдийг бүрдүүлсэн тогтолцоотой төр шударга бус байдал, авлигыг дэмжих, улс төр, эдийн засаг, нийгмийн суурийг нь хууль, эрхзүйн хүрээндээ бүрдүүлэх нь иргэдийн шударга ёс, тэгш байдал, ардчилсан тогтолцоондоо итгэх итгэлийг улам бүр бууруулдаг. Монгол улсын байгалийн баялаг эдийн засгийн эргэлтэд орсонтой холбоотойгоор сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд улс төрч, төрийн өндөр албан тушаалтнуудын авлига, хээл хахуул, оффшор дансны хэргүүд, гадаад дахь өндөр зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, ашигт малтмалын ордуудыг тойрсон маргаантай асуудлууд нь нийт улс төрийн хүрээнийхний нэр хүндийг унагаасан. Төрийн бодлого мөн чанарынхаа хувьд зөв зохистой байхын тулд оролцож буй субъектүүдийн тэгш оролцоо чухал хэдий ч ардчилал бэхжиж амжаагүй байгаа манайх шиг улсын хувьд улс төр эдийн засгийн явцуу бүлэг үүсэж, корпорацын сонирхлоо хамгаалан тодорхой хүрээнд төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд үлэмж нөлөө үзүүлдэг. Энэ үзэгдлийг Чехийн улс төр судлаач Михал Клима клиентелизм гэж тодорхойлсон байна. Төрийн хууль тогтоох байгууллага нь иргэд төлөвлөлөөрөө дамжуулж байгуулдаг төлөөллийн байгууллага бөгөөд энэхүү үйл явц нь улс төрийн намаар дамжин хэрэгждэг. Өөрөөр хэлбэл улс төрийн нам нь төр болон иргэний нийгмийг холбогч гүүр байх учиртай.

Харин намууд олгархи бүлгийн гарт орж клиентелист болох үед төрөөс гарах хууль тогтоомж, бодлого цөм тухайн бүлгийн эрх ашгийг хамгаалсан байдаг. Ийнхүү улс төрийн намууд клиентелист болж ирэхийн цагт олгархи бүлэглэлийн эрх ашгийг хамгаалахын тулд төрийн эрх мэдлийг авах гэж улайран сонгуулийн хэтийдсэн амлалт өгч сонгуульд оролцдог. Гэвч амлалтдаа хүрч чадаагүй учир иргэдийн үл итгэх байдал улам нэмэгддэг.

Цахим мэдээллийн сүлжээний хэрэглээ Монгол улсад өндөрсөж, түүнийг улс төр, бизнес, нийгмийн бүхий л хүрээнд хамгийн өргөн үзэл бодлоо илэрхийлэх индэр болгон ашиглаж байна. Мэдээлэл хүртэх, түгээх суваг ийнхүү тэлсэн ч мэдээллийн урсгал, тэр дундаа нийгэм, улс төрийн талаарх мэдээлэл сөрөг хандлагаар тархаж улс төрч бол муу, улс төр бол бохир гэсэн олон нийтийн хандлагыг нэмэгдүүлсээр байна. Энэ нь нийгмийн стрессийн түвшнийг нэмэгдүүлээд зогсохгүй улс төрч, төрийн өндөр албан тушаалтны олон нийтэд таалагдах гэсэн аливаа улс төрийн акцын шалтгаан болж байна. Тэдний хувьд олон нийтэд таалагдаж байж дараагийн сонгуульд ялалт байгуулах тул богино хугацаат хүчин зүйлсээр улс төр хийх нь ихсэж байгаа нь сүүлийн жилүүдийн Монголын улс төрийн амьдралд ажиглагдсан улс төрийн үйл явцуудаас харагдаж байна. Ийм байдал удаан хугацаагаар тогтоход ард иргэд улам бүр улс төрчдийн хэлсэн үг бүрд эргэлзэж, хийсэн үйлдэл бүрийг буруутгах хандлага нэмэгддэг байна. Учир нь нийгмийн сэтгэлзүйд хэт туйлширсан хандлага тогтоосон, популист улс төрчид гарч ирснээр нийгэм, улс төрийн хүрээнд түр хугацааны тааламжтай уур амьсгалыг бүрдүүлэх боловч ингэж бүрдүүлсэн улс төрийн имиж удаан тогтож чаддаггүй.

Улс төрийн туйлширсан байдал нь сонгогчид, өрсөлдөгч хоёр талууд өөрсдийгөө илүү давуу гэж үзэх, хуваагдмал байдлыг дэврэгдэг улс төрийн манлайлал зэргээс үүдэлтэй. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь хүртэл хоёр талд хуваагдан нэр дэвшигчдийг дэмжих хандлагатай байдаг. Эдгээр мэдээллийн хэрэгслүүд нь дэмжигч улс төрийн лидерийн үйл ажиллагааг олон нийтэд эергээр түгээхээс гадна эсрэг талын нэр дэвшигчийн мэдээллийг байнга хуурамч мэдээлэл болгон цацах нь хямралыг гүнзгийрүүлдэг. Туйлшрал гүнзгийрвэл сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн нийгмийн бослого хөдөлгөөн өрнөж, эмх замбараагүй байдал газар авдаг.

Ардчиллын соёл нь олон аргаар ардчиллыг дэмжин хөгжүүлдэг зүйл юм. Тухайлбал, урлаг бол орчин цагийн хүндрэл, бэрхшээл, дургүйцэл бухимдлыг тусган харуулах, аливаа нийгмийг төлөөлөх үүднээсээ ардчилсан үзэл санаа, практикийг

түгээн дэлгэрүүлэх нэг чухал хэрэгсэл юм. Мөн аливаа орны түүх, түүний институтүүдийн онцгой ардчилсан, нийтийг хамарсан талуудыг ёслон тэмдэглэх бүх нийтийн баяр ёслолын аргыг ч ашиглаж болно. Хамгийн гол нь, улс төрийн боловсролыг өргөн хүрээнд олгоход, нэн ялангуяа олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, төр засгийн бодлогод шүүмжлэлтэй хандах, нийгмийн гишүүд бие биетэйгээ харилцах сувгаар хангахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх нь тодорхой.ⁱ Ардчилсан институци хямралыг даван гарч чадах үгүй нь зарим нэгэн хүчин зүйлсээс үүдэлтэй. Угтаа улс төрийн манлайлагчид, эгэл жирийн иргэд нь ардчилсан үзэл санаа, үнэт зүйл, дэг журамд хүчирхэг дэмжлэг үзүүлж байдаг орнуудад тогтвортой ардчилал тогтох боломж нэмэгдэж байдагт оршино. Тэрхүү дэмжлэг нь ардчилсан санаа бодол, ардчиллыг тууштай баримтлах явдал нь тухайн орны соёлд үндэслэсэн, тодорхой хэмжээгээр үе дамжиж байдаг ба тэр тохиолдолд хамгийн найдвартай зүйл болдог. Өөрөөр хэлбэл, энэ орон ардчилсан улс төрийн соёлтой байна гэсэн үг.

Үнэндээ ардчилсан улс төрийн соёл нь ардчилал болон улс төрийн тэгш эрх нь хүслэн болсон зорилго гэдэгт итгэх иргэдийн итгэл төлөвшихөд тусалдаг. Энэхүү хүслэнт зорилго нь зэвсэгт хүчин ба цагдаад тавих хяналт, сонгогдсон манлайлагчдын гарт бүхэлдээ байх ёстой. Аливаа сонгогдсон төлөөлөгчид нь үр нөлөө бүхий оролцоотой, засгийн үйл ажиллагаандаа хяналт тавьдаг байх, чөлөөтэй шударга, байнга явагдах сонгууль нь сонгох тэгш эрхтэй оролцоог чухалчилдаг. Нэг үгээр засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь үр нөлөөтэй оролцоо, мэдээлэлд үндэслэгдсэн мэдлэг чадвартай байх нь зүйн. Аливаа алтернатив эх булгаас мэдээлэл авах боломж нь засгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үр нөлөөтэй оролцоог бий болгож улмаар мэдээлэлд үндэслэгдсэн мэдлэг чадвартай байхыг өнөөгийн цаг үе биднээс шаардаж байна. Мэдээлэлжсэн мэдлэг чадвартай байх, иргэний нийгэмд хамрагдсан байдал зэрэг нь төр засагтаа хяналт тавьж, иргэд улс нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцдог байх хэмээх ардчиллын суурь институцийгⁱⁱ ямар ч нөхцөл байдалд хамгаалах ёстой. Иргэдийн хооронд үүссэн улс төрийн санал зөрөлдөөн болон ялгаанд тэвчээртэй харилцахыг шаарддаг, оршин байх эрхийн амин чухал сүнс учир жижиг хамтын нийгэмлэгийг биш, харин улс орныг удирдахад зайлшгүй хэрэгтэй байсан учраас л үүссэн гэж болно.

Энэ бүхнийг хураангуйлан дүгнэвэл, өнөөгийн ардчилал нь иргэд, улс төрчдийн нягт хамтын ажиллагааг өрнүүлж, харилцан бие даасан, хараат бус байдлыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтойн дээр тэдний хооронд үүссэн аливаа хил заагийг багасгаснаар чанарын хувьд ахиц гарч болно. Нэг талаас, сонгогдсон улс төрчдийн зүгээс аливаа асуудлаар улс төрийн шийдвэр гаргахдаа өөрсдийн эрх мэдлээр давамгайлах явдлыг бууруулж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд иргэдтэй харилцан зөвшилцөж, тэдний санаа бодлыг сонсох, үзэл бодлоо хуваалцах замаар шийдвэрлэх шаардлагатайг илэрхийлж буй явдал юм.

Улс төрийн соёл нь үр ашиг, толерант чанар, итгэлцэл зэрэг үнэлэмж болон олон төрлийн хандлага, байр суурь, итгэл үнэмшилтэй холбоотой. Эдгээр нь нийлбэрээрээ тухайн иргэний улс төрийн амьдрал, иргэний нийгэм дэх оролцоо, үзэл бодолд нөлөөлнө. Үүний дотроос бусдаасаа хамгийн суурь утгыг илэрхийлдэг нь ардчиллын талаарх хандлага, байр суурь юм гэж үздэг. Өөрөөр хэлбэл, ардчилал нь бусад алтернатив хувилбараас илүү дээр гэж үзэх итгэл үнэмшил тулгуур, суурь нь болно.

Иргэдийг улс төрийн үйл явцад оролцоходоо юуны өмнө өөрсдийн шийдвэр гаргах эрх мэдлийг бүрэн ухаарч ойлгосон, бодит төлөвшилтэй болгох. Чингэснээр иргэд өөрсдийн гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээх, бодитоор оролцох замаар ардчиллыг идэвхжүүлж, улмаар төлөөллийн тогтолцоог ард иргэддээ ойртуулж, тэдний үг хэлэх, дуу хоолойгоо илэрхийлэх, улс төрийн шийдвэр гаргах үйл явцаас хүнийсэж,

хөндийрөх байдлыг саармагжуулна. Энэ бол иргэдийн зүгээс улс төрчдийг үл тоомсорлох, улс төрөөс хөндийрөх байдлыг бууруулах субстантив ач холбогдолтойгоос инструментал ач холбогдолтой болгож байна.

Abstract:

The important indicators in determining the problems of the political scope and its reality are citizens' attitudes towards the political process, social and political psychological phenomena, and political behavior based on political awareness, traditions, values, and cultures. The article compares Mongolians understanding of political knowledge and citizenship, how they realize and implement the rights and duties granted by the democratic constitution, the different interests of social groups, and the public and experts' opinion on political knowledge. By comparing the past and the present, how the ideas and thoughts passed down to the establishment of the political values of Mongolians have changed and adapted to the modern democratic system. It was clarified by the attitude of citizens towards the state, government and social system, and the social, economic and political factors that influenced it. In order to find out whether the changes in the political behavior of Mongolians have an effect on the establishment of democratic values and the strengthening of the democratic system, a factor analysis was performed and the problem was analyzed.

Key words: Political culture, democracy, political behavior, democratic values, democratic system

Ном зүй:

1. Archie Brown. Jack Gray. Political Culture and Political Change in Communist States. New York: Holmes & Meier, 1977.
2. Almond A. Gabriel., Powell G. Bingham, Jr. Comparative Politics: System, Process, and Policy. Second Edition, Little, Brown and Company. Boston. 1978.
3. Alekseevna, M. (2013). Political traditions: The concept and structure. Modern Research of social(4), 366-380.
4. Archie Brown. Jack Gray. Political Culture and Political Change in Communist States. New York: Holmes & Meier, 1977.
5. Ирхин Ю.В, Зотов В.Д, Зотова Л.В. Политология. Учебник., Москва., 2002.
6. М. Klima., Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу. УБ., 2017. "Сэлэнгэпресс" ХХК.
7. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. ННФ. УБ., 2006
8. Ш.Батсүх, Ц.Дэлгэржаргал. Орон нутаг дахь иргэдийн оролцоо. In Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь. УБ., 2019 "Мөнхийн үсэг" ХХК.
9. Ж.Бор, Д.Баатар. Монголын улс төр. УБ., 2015.
10. Д.Бумдарь. Ардчиллын хөгжил, бэхжилтийн тулгамдсан асуудал, сорилтууд. In Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт \1990-2019\ (pp. 9-41). УБ., 2019. "Адмон принт" ХХК
11. Ц.Ганболд. Монголын улс төрийн уламжлал, шинэчлэл, тэмдэглэл. УБ., 2020.
12. Ч.Ган-Өлзий. Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлт хөгжил. УБ., 2014. Тод бичиг ХХК.
13. МУИС. Монгол Улсын түүх. Ред. Болдбаатар Ж. УБ., 1999.
14. В.Отгоннасан. Монголын нийгэм ба олон нийтийн санаа бодол. УБ., 2021.

15. Д.Содномгомбо. Улс төрийн мэдлэгт. УБ., 2020.
16. Д. Содномгомбо. Монголын уламжлалт төрт ёс, түүний шинэчлэлийн зарим асуудалд. УБ., 2020.
17. Д.Сүхболд. Засаглалын хэлбэр Монголчуудын уламжлалт засаг төрийн тогтолцоо, соёл иргэншил, легитимчлэлтэй уялдах тухай. Политологи №19. УБ., 2021.
18. Г.Түмэннаст. Нийгмийн социал хүрээний өөрчлөлт, асуудал. In Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2019/ (pp. 240-271). УБ., 2019. "Адмон принт" ХХК.
19. А.Цанжид. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2001
20. О.Хатанболд. Ардчиллыг ойлгохуй ба судлахуй Монгол орны Жишээн дээр. УБ., 2017. "Соёмбо принтинг" ХХК.
21. Хатанболд О., & Энхболд, Д. (2021). Монголын өнөөгийн улс төрийн соёлын ойлголт, төлөв байдал, чиг хандлага. Политологи №19 (558),
22. Б.Хишигням. 90 оноос хойшхи нийгмийн зарим үзэгдэлд хийсэн сэтгэлзүйн шинжилгээний үр дүн. In Монгол дахь эрдчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2019/ (pp. 297-299). УБ., 2019. "Адмон принт" ХХК.
23. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. Үндэсний өвөрмөц соёлын орчин дахь ардчиллын зарчмын үйлчлэл. Эрдэм шинжилгээний грант төслийн тайлан. УБ., 2008.
24. Шинжлэх Ухааны Академи, Улс төр, эрхзүйн салбар. Монгол дахь улс төрийн соёл: Уламжлал, орчин үе. УБ., 2020.
25. Сант Марал Сан. Улс төрийн барометр №8-№18. УБ., 2010-2021 Retrieved from <https://mn.santmaral.org/publications>

CHANGES IN POLITICAL CULTURE AMONG YOUNGER GENERATIONS TRIGGER LOSS IN TRUST IN DEMOCRACY AND PREFERENCE FOR TECHNOCRATIC ALTERNATIVES

By Sascha Hannig Núñez

Associated Researcher, Instituto Desafíos de la Democracia (IDD) Chile.
Assistant, Institute for Global Governance Research, Hitotsubashi University

Abstract:

Democratic values are on the crossroads, facing threats such as polarization, economic uncertainty, social unrest, disinformation or the challenge of raising authoritarian and illiberal regimes. When understanding changes and proposing measures to strengthen political culture, younger generations should come to the center of the debate, as this cohort will be the one to consolidate said trends for better or worse. The youngest voting generation (centennials) will be among the most affected by the long-term the effects of the pandemic; the scaling geopolitical tensions and the overall decrease in democracy across the world that high-impact studies have warned about. This piece will address one of the key characteristics that this generation exhibits when analyzing their political values: the support for technocracy and even census voting. The World Values Survey (WVS)'s last edition measures citizens decision-making preferences, which was crossed with 38 "Free" countries in the Freedom in the World report 2021. Partial results show that "expert decision making" over "politicians" is stronger in people under 29 years old in developed countries, when compared to the average population. In the case of recently-established democracies, the difference between generations was mixed. Several interpretations can be withdrawn from these results, and the recommendations towards strengthening political culture should not ignore this reality and rather address it to consolidate democracy instead of leaving room for authoritarian technocratic narratives to penetrate across the youth¹.

Keywords: Youth, Democracy, Political Culture, Technocracy, Decision Making

Introduction.

Although performance results of democracies around the world are mixed depending on each country's context, research on measurable freedom and institutional defense of basic civil rights, has shown losses for more than a decade. These reports include international indexes such as the Freedom in the World², The Economist³ or several Pew Research Centre reports⁴.

¹ This issue revisits results obtained from an analysis on the 2021 Freedom in the World report and the latest data from the World Values Survey. These data were first released on the Hitotsubashi University *Institute for Global Governance Research, Issue Briefing, N°10* on September 2022, under the title: "Are disengaged centennials endangering democracy? A technocratic future for decision-making might be brewing within consolidated democracies".

²Freedom House (2021) "Democracy Under Siege", available at: <https://freedomhouse.org/report/freedom-world/2021/democracy-under-siege>

³ The Economist (2021), "Democracy has a very bad year", available at: <https://www.economist.com/graphic-detail/2021/02/02/global-democracy-has-a-very-bad-year>

⁴ Pew Research Center. (2017). Globally, broad support for representative and direct democracy. Washington, DC: available at: <http://www.pewglobal.org/2017/10/16/globally-broadsupport-for-representative-and-direct-democracy/>

Recently established democracies, especially those institutionalized after the Cold War, are on the spotlight as they exhibit more fragility to change and a different approach to democratic values⁵. As societies around the world face upcoming challenges such as polarization, economic uncertainty, social unrest, disinformation or raising authoritarian and illiberal regimes, it is necessary to create responses that aim at strengthening political culture. In that context, younger age-cohort will have a larger responsibility on the consequences of these phenomena, as they are the most affected by the crises that will determine their future opportunities or the hindering factor for their development in society⁶. Even though millennials (ages 27-41 according to Pew Research⁷) are often the focus of research, new available sources enable a deeper understanding around the *sub-29 generation*, mostly composed by centennials, who have experienced different challenges compared to their predecessors.

To provide some highlights on this uncertain scenario, this piece reviews recent research based on data from the World Values Surveys (from here on WVS)⁸ and from international indexes such as Freedom House (specifically 38 countries that were tagged as “free” on that year) and available data from polls and surveys, to present an introductory dimension of this discussion. It is important to note that, even though the researched group is the most interconnected and affected by similar globalized challenges, world views and values differ considerable depending on the country’s democratic performance and demographics⁹.

Социалист тогтолцооны он жилүүдэд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн гол суурь нь үйлдвэрлэл байсан бөгөөд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 25%, худалдаа 26%, мал аж ахуй, хөдөө аж ахуй 25 хувийг тус тус бүрдүүлж байсан нь одоогийнхоор солонгорсон эдийн засаг, бүх нийтээр ажил эрхлэлттэй байсан байна. Үүнийг судлаач Никсон шилжилтээс өмнөх Монгол Улс нэг хүнд ногдох ДНБ-ий утгаар харьцангуй ядуу орон байсан хэдий ч бүрэн хийгээд тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн бодлого, суурь хэрэгцээний хангамж, эрүүл мэнд, боловсролыг багтаасан нийгмийн үйлчилгээний өргөн цар хүрээтэй систем оршин байсан нь өрнөдийн стандартаар тэгш бус байдал харьцангуй доогуур байсан гэж үзсэн байна. Харин ардчилсан шилжилт хийснээр өөрсдөө эдийн засгийн асуудлаа шийдвэрлэх, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаа өөрчлөн шинэчлэх асуудал үүссэн нь монголчуудын дунд өнөөг хүртэл яригддаг тухайн үеийн ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн гуайн нэрээр алдаршсан 20 дугаар тогтоол юм. Энэхүү тогтоолын үр дүнд нийгмийн амьдралыг бүхэлдээ өөрчлөгдөж, барааны үнэ хоёр дахин нэмэгдсэн, цалин хөлс хоёр дахин нэмэгдсэн, мөнгөний ханш хоёр дахин унах зэрэг үр дагаврууд гарч байжээ. Улмаар Монгол Улсын засгийн газраас 1991 онд Чех, Словак, Румын, Польш улсуудын өмч хувьчлалдаа хэрэглэсэн практик буюу баялагийг хувьд шилжүүлэх аргыг ашиглан өмч хувьчлах тухай хууль батлан, өмч хувьчлах зарчим, арга хэлбэрийг тодорхойлсон нь хөрөнгө оруулалтын эрхийн бичиг /ягаан, ногоон тасалбар/ хэмээх хувьцаагаар улсын өмчийг хувьдаа шилжүүлэн авах эрх зүйн орчин бүрдсэн байдаг. Энэхүү ардчилсан шилжилтийн үйл явц нь эдийн засгийн системийн бүрэн өөрчлөлт гэсэн итгэл үнэмшил байсан бөгөөд зах зээлийн системийн олон хувилбарт туршилтын талбар болгосноор нийгмийн бүтэц, давхраажлын тогтолцоог орвонгоор нь эргүүлж 1994 он гэхэд ажилгүйдэл 8,7%, 1996 онд 20%-д хүрсэн тооцоо байдаг бол ядуурлын шугамнаас доогуур амьдарч байсан хүн ам 1992 онд 16%, 1994 онд 26.5% хүрсэн бол 1996 онд дэлхийн банкны судалгаагаар нийт хүн амын 36% ядуу байгааг тогтоосон байна. Ажилгүйчүүд, албан бус ажиллагсдын тоо нэмэгдэж, мал аж ахуйд олон тооны ажиллах хүч шилжсэн ч хөдөлмөрийн бүтээмж буурч, ядуурлын эгнээ тэлсэн үйл явцыг судлаачид аж үйлдвэргүйжилт хийгээд ХАА-н урвуу хөгжил гэж дүгнэсэн байдаг. Ардчилсан шилжилтэд орсон эхний 10 жилийн туршид эдийн засгийн хүрээнд гарсан энэхүү өөрчлөлт нь 2001 оноос эхлэн харьцангуй тогтвортой шинж чанартай болсон бөгөөд 2004-2008 он гэхэд Монгол Улсын ДНБ жилд дунджаар 9.1% өссөн нь нэг хүнд ногдох ДНБ-ы ангиллаар дундаж орлоготой орнуудын жагсаалт руу шилжиж 2011 он гэхэд улсын эдийн засаг 17.5%-иар өсч, дэлхийн хамгийн өндөр өсөлт бүхий эдийн засагтай орон болсон юм. Эдийн засгийн тогтвортой өсөлт бий болсон гол шалтгаан нь уул уурхай, үйлчилгээний салбарт гадаадын хөрөнгө оруулалт тогтвортой болж ирсэн байна. Гэсэн хэдий ч энэхүү өсөлтийн үр дүн нь иргэдийн амьдралын чанарт нөлөөлөхөөс илүүтэй улс төр болон бизнесийн салбар хоорондын харилцан хамаарлыг хүчтэй болгосон юм. Улс төрийн нам болон мөнгө хоорондын холбоо нь улс төрийн намд мөнгөтэй хүмүүсийг шургалуулж улс төрд орсон баячууд эрх мэдлээ урвуулан ашиглаж уул уурхайн баялагаас ашиг хүртэх, өрмийг нь хамах зарчим үйлчилсээр байна. Үүнийг БНЧУ-ын судлаач Михаил Клима “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал” номондоо клиентелист харилцаа гэсэн томъёоллоор илэрхийлсэн байдаг. Ардчилсан нийгмийг бүрэлдүүлэхэд чухал ач холбогдол бүхий улс төрийн нам гэх институцууд бодлогоор биш популизмаар уралдаж үүний үр дүнд хариуцлагагүй, чадваргүй улс төрчид сонгогдох нь үеэс үе дамжин өвлөгдсөөр ардчиллыг гажуудуулж буй улс төрийн соёл болон төлөвшиж байна. Харин популизм хэмээх ойлголт нь латин үгнээс гарал бүхий ард түмэн /populus/ гэсэн утгыг илэрхийлэхийн зэрэгцээ ард түмэнд

таалагдах гэсэн улс төрчдийн бодит бус амлалт, бодлого мөн тэд ба бид гэсэн хуваагдал хэмээн тодорхойлохыг оролдож байна¹². Тиймд энэхүү үзэгдэл нь тухайн дэглэм гажуудсан тохиолдолд түүн дээр дөрөөлөн гарч ирснээр ард иргэдийн уур бухимдал газар авч, эдийн засгийн тэгш бус байдал үүсч, улс төрийн тогтолцооны ил тод байдал алдагдаж, эргэлзээт байдал бий болсон, боловсрол доройтсон тохиолдолд хүчээ авах нь тун элбэг байдаг бөгөөд хөгжингүй, чинээлэг, боловсролын түвшинтэй улсад биш ардчилал бэхжиж амжаагүй, иргэд нь хангалттай мэдээлэл боловсруулах чадваргүй улсад л хүч түрэн гарч ирдэг юм. Үүний нэгэн адилаар манай улсад уул уурхайн, төрийн засаглалын ялзрал, авлига, баялагийн тэгш бус хуваарилалт гэх мэтчилэн асуудлууд нь улс төрийн ашиг хонжоо олох сэдвүүд болсоор ирсэн. Сонгууль болохоор хамгийн ихээр яригдаж, өнгөрсөн 4 жилд засаг барисан нам, эрх баригчдыг шүүмжлэн бухимдсан ард түмний эсрэг талцуулан тавидаг үзэгдэл сонгуулийн өмнөх уламжлал болсон байх жишээтэй байдаг. Энэ талаар **Яица Моунки** үзэхдээ либерал ардчиллын гажуудсан хэлбэр бол популизм гэсэн байдаг¹³. Манай Улсад популизм үүсэх суурь шалтгаан нь **нэг талаас шилжилтийн үеийн эдийн засаг, нийгмийн хүрээнд гарсан өмч хувьчлалтай холбоотой** бөгөөд тэрхүү нөлөөлөл нь нийгэмд нийгмийн давхраажлын хэт тэгш бус байдлыг бий болгосонтой холбогдож байгаа юм. Хэдийгээр ардчилсан шилжилтийн хоёр дахь арван жилээс эдийн засаг сэргэж эхэлсэн ч дээр гарсан үр дүнгээс үүдэлтэйгээр улс төрчдийн түвшинд авилга газар авч популист улс төрийн орчин нөхцөл үүссэн. Нийгмийг бүрдүүлж буй иргэд олонхийн дийлэнхэд эдийн засаг болон боловсролын хэт зөрүүтэй байдал бий болсноор нийгмийн давхраажил хэт баян, хэт ядуу гэсэн заагралд хуваагдаснаар халамжийг хүсэмжлэх, саналаа худалдах, биелэгдэх боломжгүй амлалтад итгэх улс төрийн орчин нөхцөл энгийн үзэгдэл болсоор байна. Энэ нь манай ардчилал тогтворгүй бөгөөд ардчилсан улс төрийн соёл ямар нэг байдлаар төлөвшөөгүй байгааг илтгэж байна. Тэгвэл өрнөдийн улс төр судлаачид ардчилал тогтвортой байхад /улс төрийн соёл тогтвортой байхад/ нөлөөлдөг гол хүчин зүйлүүдийг эдийн засгийн чадамжтай холбон тайлбарлажээ¹⁴.


1. Ард түмний амьдралын түвшин өндөр байх тусам ардчиллыг нийтээр хүлээн зөвшөөрч, дэмжих хандлага илүү байдаг.
2. Аж амьдралын түвшин нь улс төрийн үзэл баримтлал, итгэл үнэмшилд нөлөөлнө.
3. Хувь хүний боловсрол мэдлэг өндөр байх тусам тэрээр улс төрийн бодлогыг илүү сонирхон түүнд идэвхтэй оролцдог гэсэн хамаарлыг гаргасан нь монголчуудын нийгэм-эдийн засгийн нөхцөл буюу улс төрчид, төрийн байгууллагын авилгад идэгдсэн, баян-ядуугийн хоорондын зөрүүтэй байдал, нийгмийн шударга ёс алдагдсан гээд төр болон иргэдэд аль алинд нь ардчиллыг төлөвшүүлэх соёл дутагдаж байгааг дараах үзүүлэлтүүдээр илэрхийлж байна.

¹² Cas Mudde “The Problem with Populism,”

¹³ Ronald Inglehart and Christian Welzel “Modernization, Cultural Change, and Democracy”


¹⁴ Б.Хатанболд, Ардчиллыг ойлгохуй ба судлахуй.,УБ.,2017

Монгол Улсын авилгын үзүүлэлт, 2000-2020 он




Эх сурвалж: <https://www.transparency.org/en/gcb/asia/asia-2020>
Монгол Улсын авилгын үзүүлэлт хувиар, 2000-2020 он

Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ, 2010-2020 он



Эх сурвалж: <https://tradingeconomics.com/mongolia/gdp-per-capita>
Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ

Монгол Улсын ядуурлын түвшин, 1995-2016 он хувиар



Эх сурвалж: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2800_001V1
Монгол Улсын ядуурлын түвшин хувиар, 1995-2016 он,

Дээрх графикаас дүгнэхэд авилга, орлогын хэт ялгаатай байдал бий болж энэ байдлаасаа гарч чадахгүй нийгмийн нэг хэсэг нь хэт баян нөгөө хэсэг нь хэт ядуу гэсэн ялгарал яван явсаар нийгмийн олонхи нь ардчиллыг ойлгох, түүнд оролцох нь сөрөг хэлбэртэй болсоор иржээ. Энэ нь өнөөгийн ардчилалд сөргөөр нөлөөлөх улс төрийн соёл болон хэлбэржиж байна. Тиймд монголчуудын ардчилал, улс төрийн соёлын төлөвшиж чадахгүй байгаа, нийгэмд улс төрийн ардчилсан соёл нийгэмшиж чадахгүй байгаагийн гол эх сурвалж нь шилжилтийн үеийн эдийн засгаас үүдэлтэй боловсрол, нийгмийн хүрэн дэх ялгаатай байдал нь төр засгийн хүрээнд ч, иргэдийн хүрээнд ч нийтлэгээр ардчиллыг ойлгох, зөв хэрэгжүүлэх, зөв хэрэгжүүлэхийг шаардах улс төрийн соёлын түвшинд хараахан төлөвшүүлж чадахгүй байна.

IV Дүгнэлт

Уг судалгааны ажлын хүрээнд монгол дахь ардчилсан улс төрийн соёлын төлөвшил хэрхэн явагдаж байгаа, түүнд тулгарч буй асуудлууд юу болох талаар дараах дүгнэлтэд хүрлээ.

Нэг: Социализмаас ардчилал руу шилжих үеийн нийгмийн бэлэн биш байдалд засгийн газраас авч хэрэгжүүлсэн өмч хувьчлал, эдийн засгийн эрс шинэчлэл зэрэг нь өмчийн талаарх ойлголтгүй нийгмийг баян ядуугийн хэт туйлд хуваах суурь болсноор нийгмийн бусад салбаруудад ч мөн тэгш бус гарааны эхлэлийг тависнаар өнөөг хүртэл улс төр, эдийн засгийн хэт тэнцвэргүй харилцаа бий болж ардчиллыг гажуудуулж байна. Хэдийгээр бүх зүйл чөлөөтэй шударга, ил тод өрсөлдөөний зарчмаар явах улс төр, эдийн засгийн харилцаа нь ардчиллын мөн чанар боловч өмч хувьчлалын үед мэдээлэлд ойр хэсэг бүлэг нь эрх мэдлээ ашиглан улсын өмчийг хувьдаа авах, жагсаал цуглааны эхэнд явсан хэсэг бүлэг нь өндөр дээд албан тушаалд очих тэгснээрээ нийтийн эрх ашиг бус өөрийн гэр бүл, танил талын эрх ашигт үйлчлэх болсон бөгөөд иргэд ч мөн адил ямар нэгэн аргаар өмчтэй болох, эрх мэдэлд хүрэхийг зорьж ажил хэргээ бүтээхийн тулд танил талаа ашиглан хээл хахууль өгч эхэлсэн нь төрийн өндөр дээд албан тушаалтангууд, төрийн албан хаагчдад гээд төр гэх шийдвэр гаргах институцэд итгэх итгэл үлэмж ихээр алдагдаж эхэлсэн. Өмнөх нийгэмдээ дээд боловсрол эзэмшсэн, эзэмшээгүй байдлаас үл хамааран өөрсдийн хийж чадах зүйлээр хувь нэмрээ оруулан, адил, тэгш зарчмаар хөдөлмөрлөн амьдарч ирсэн иргэд зах зээлийн зарчмаар амьдрах болсон нь гэнэтийн сорилт болохын зэрэгцээ улс төрийн сонгууль хийхдээ рациональ сонголт хийх соёл төлөвшихгүй явсаар сонгогдсон төлөөлөл нь нийтлэг эрх ашгийн төлөө бус амин хувийнхаа эрх ашгийг урьтал болгож улсын эдийн засгийн үр өгөөж нийгмийн чинээлэг бүлэгт урсан орж, ард иргэдийн эдийн засгийн байдал доройтсоор байгаа нь улс төрд үл итгэх хандлага бий болсон байна. Энэ нь ардчилсан улс төрийн соёл төлөвшихгүй, ардчиллын мөн чанарыг алдагдуулсаных юм. Энэхүү байдал нь 32 жилийн туршид үргэлжилснээр ардчилал, гэж юу болох талаар иргэдийн төсөөлөл, үнэт зүйл, итгэл үнэмшил нь Томасс Гоббсын зохиол дээрх Левиафан болон хувирсан байна.

Санал зөвлөмж

Френсис Фукуяма Эдийн засгийн хөгжил нийгмийн шинэ давхаргыг бий болгоно, энэ нь нийгмийн хөгжлийн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөх буюу ардчилал хөгжинө. Ингэснээр хуулийн засаглалыг төр хэрэгжүүлэх боломжтой хэмээн үзсэн байдагчлан монголчуудын хувьд ардчилалд шилжихэд эдийн засгийн сууриа зөв тавих нь боловсрол, эдийн засаг нийгмийн бүхий л салбарт тэгш гарааны хөгжлийн суурийг бий болгон ардчиллыг ойлгодог, улс төрийн мэдлэг, чадавхтай иргэдийг төлөвшүүлэн төр, нийгмийн түвшинд эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс бүхий ардчилсан нийгэм, улс төрийн соёлыг төлөвшүүлэх боломжтой юм. Гэсэн хэдий ч

өнөөдрийн энэхүү байдалд хүргэсэн шалтгаан үр дагаварт өнгөрсөн үеэ буруушаахаас илүүтэй өнөөдрийн ардчилал, улс төрийн соёлыг бэхжүүлэх асуудал нь ардчиллаас ухрах уу, урагшлах уу гэсэн сорилтыг бий болгож байгаа юм.

Abstract: Political culture refers to the level of political culture maturity and the attitudes and behavior of the common people who make up the society. As a society makes a systemic political transition, the political culture also changes and develops depending on the values and ideals of the system that it aims to develop. Although Mongolians are facing 32nd anniversary of the transition to democracy to socialism, it is still in the list of distorted democracy by researchers and international organizations. Thus, it is explored that how the social and economic change in the Mongolian society is influencing the maturity of political culture and democratic system. In the other words, a problem is concluded by performing a correlation analysis between social and economic factors to clarify how the current political development and advancement is influenced by the conventional political culture and thinking, as well as the factors of the transition period.

Key words: Political culture, Social change of Mongolia, Mongolian social transition, Strengthening of Mongolian democracy, Privatization

Ашигласан эх сурвалж

1. Ё.Довчин.Харьцуулсан Улс төр.,УБ.,2010
2. Улс төрийн шинжлэх ухаан.,МУИС.,УБ., 2010
3. Б.Хатанболд,Ардчиллыг ойлгохуй ба судлахуй.,УБ.,2017
4. Михал Клима,Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал.,УБ.,2018
5. Д.Содномномбо,Ч.Найдансүрэн. Улс төрийн соёл түүний Монгол дахь төлөвшлийн асуудал,УБ.,2000
6. Юндэндорж,Өрнө Дорнын мэргидийн нийгэм,улс төрийн сургааль, УБ.,2001
7. Ж.Болдбаатар.,Д.Лүндээжанцан.,Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал.,УБ.,1997
8. А.Жамбал.,Улс төрийн сургаалийн түүх.,УБ.,2001.
9. Д.Загджав.,Монгол дахь иргэдийн улс төрийн оролцоо, өөрчлөлт.,УБ.,2002.
10. Ч.Дашдаваа, Монгол дахь ардчиллын түүхэн уламжлалын асуудалд,УБ.,2005.

Судалгааны бүтээл

1. Конрад Аденаур сан., Монгол дахь ардчилал, хөгжил, бэхжилт, асуудал, сорилт,УБ.,2019
2. Конрад Аденаур сан, Нээлттэй Ардчилал, УБ.,2019
3. Конрад Аденаур сан, Ардчилал, Иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм, Улс төрийн судалгаа,УБ.,2020
4. Улс төрийн боловсролын академи, Шинэ толь сэтгүүл № 23
5. МУИС, Политологи сэтгүүл.,УБ.,2010

Гадаад эх сурвалж

1. Juan J. Linz and Alfred Stepan “Problems of Democratic Transition and Consolidation” <http://cep.unep.org/download/4534594-file.pdf>
2. Stephen Fisher ,”Social Attitudes and Value Change” <http://users.ox.ac.uk/~nuff0084/polsoc/PostmaterialismLecture.pdf>
3. Freedom house report.,2020,2021 , <https://freedomhouse.org/country/mongolia/freedom-world/2021#PR>
4. Transparency international report.,2020 <https://www.transparency.org/en/cpi/2020/index/mng>

5. Journal of democracy <https://journalofdemocracy.org/articles/democracys-future-the-primacy-of-culture/>
6. GDP per capita 2010-2020 <https://tradingeconomics.com/mongolia/gdp-per-capita>

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ**

Д.Түмэнжаргал

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

Г.Туяагэрэл

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

Товч утга:

Монгол улс анхны ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд батлан мөрдөж эхэлсэн, мөн Монгол улс ардчилсан сонгуулиа мөн л 1992 онд явуулсан. Үүнээс хойшхи үеийн Монгол улсын гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага (Засгийн газрын) үйл ажиллагаа, түүн дотроо Засгийн газрын тогтворгүй байдал, Засгийн газрын солигдох болсон шалтгаан, нөхцөл, цаашид анхаарах асуудлыг энэхүү өгүүлэлд авч үзлээ. Мөн түүнчлэн Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн гучин наймдугаар зүйл “Монгол улсын Засгийн газар” гэсэн хэсэгт өмнө нь мөрдөж байсан болон шинэ ямар нэмэлт өөрчлөлтүүд оруулсан талаар харьцуулан харуулахыг хичээлээ.

Түлхүүр үг: Монгол улсын Үндсэн хууль, ардчилал, улс төрийн нам, гүйцэтгэх засаглал, Засгийн газар

Нэг. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны өнөөгийн байдал

Монгол улс ардчиллын замд шилжсэнээс хойшхи хугацаанд үзэл баримтлалын ялгарал, хэт улс төржилт, ардчиллын хөгжилд, ардчиллын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна. Мөн түүнчлэн төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын хүрээнд ардчилсан тогтолцоог бүрдүүлсэн ч хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн зүйл, заалтууд бодит амьдралд хэрэгжүүлсэн туршлагын хооронд зөрүүтэй, зөрчилтэй байдлыг үүсгээд байна. Парламент, Засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг төрийн эрх барих дээд байгууллагуудын хоорондын уялдаа, харилцаанд ойлгомжгүй байдал байна.

Засгийн газрын ажилласан байдал

Монгол улсын Засгийн газрын 1992 оноос хойшхи ажилласан аль нам, эвсэлээс Засгийн газрын тэргүүнүүд сонгогдон ажилласан байдал болон ажилласан хугацаа, солигдолтыг доорх хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт № 1. Нэг сонгуулийн жилд Засгийн газрын солигдсон байдал¹

№	Сонгуулийн жил	Нам, эвсэл	Засгийн газрын тэргүүний нэр	Засгийн газрын тэргүүнээр ажилласан хугацаа
1	1996	МУАН, МСДН, Ардчилсан холбоо эвсэл	М.Энхсайхан	1996.07.19-1998.04.23 1 жил 9 сар
			Ц.Элбэгдорж	1998.04.23-1998.12.09 8 сар
			Ж.Наранцацралт	1998.12.09-1999.07.22 8 сар
			Р.Амаржаргал	1999.07.30-2000-07.26 1 жил
2	2004	Эх орон ардчилал эвсэл	Ц.Элбэгдорж	2004.08.20-2006.01.13 1 жил 5 сар
		МАХН	М.Энхболд	2006.01.26-2007.11.07 1 жил 10 сар
		МАХН	С.Баяр	2007.11.22-2008.09.11 9 сар
3	2008	МАХН	С.Баяр	2008.09.11-2009.10.29 1 жил 11 сар
		МАХН	С.Батболд	2009.10.29-2012.08.10 2 жил 10 сар
4	2012	АН, Шударга ёс эвсэл, ИЗНН	Н.Алтанхуяг	2012.08.10-2014.11.05 2 жил 2 сар
		АН, Шударга ёс эвсэл, ИЗНН	Ч.Сайханбилэг	2014.11.21-2016.07.08 1 жил 7 сар
5	2016	МАН	Ж.Эрдэнэбат	2016.07.08-2017.10.04 1 жил 3 сар
		МАН	У.Хүрэлсүх	2017.09.08
6	2020	МАН	У.Хүрэлсүх	2020.07.01. Үндсэн хуулийн шинэ нэмэлт өөрчлөлт хэрэгжсэнээс хойш 6 сар ажилласан
7	2021	МАН	Л.Оюун-Эрдэнэ	2021.01.27-ноос өнөөг хүртэл ажиллаж байна.

Хүснэгт № 2. Хамгийн тогтвортой ажилласан Засгийн газар²

№	Сонгуулийн жил	Нам, эвсэл	Засгийн газрын тэргүүний нэр	Засгийн газрын тэргүүнээр ажилласан хугацаа
1	1992	МАХН дангаараа	П.Жасрай	1992.07.01-1996.07.19 4 жил
2	2000	МАХН дангаараа	Н.Энхбаяр	2000.07.26-2004.08.20 4 жил 1 сар

¹ Конрад Аденауэрын сан. МУИС.Улс төр судлалын тэнхим. Монгол улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа.(судалгааны үр дүн бодлогын зөвлөмж). 81-р тал. УБ., 2018 он

² Мөн тэнд

Хоёр: Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу Засгийн газартай холбоотой гол чухал нэмэлт өөрчлөлтүүд

Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн гучин наймдугаар зүйлийн 1 дэхь хэсэгт “Монгол улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” хэмээн заасан байдаг.³ Монгол улсын Үндсэн хуулийн 3-р бүлэг “Монгол улсын төрийн байгуулал” бүлгийн 38-р зүйл “Монгол улсын Засгийн газар” хэсэгт 2019 оны 11-р сарын 14-ний өдөр дараахь өөрчлөлтүүдийг оруулсныг хуучин зүйл заалттай харьцуулан харуулъя. Тодруулбал,

1. УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллахыг хязгаарлах

Хуучин заалт: 39.1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ гэж заасан. Шинэ өөрчлөлтөөр 39.1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно хэмээн өөрчилсөн 2019 оны 11-р сарын 14-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр өөрчилсөн. Гэсэн хэдий ч 2022 оны 08-р сарын 25-ны өдөр дахин нэмэлт өөрчлөлт оруулж Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн УИХ-ын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэснийг хүчингүй болгосон.⁴ Энэхүү заалт нь улс төр, эрх зүй судлаачдын анхаарал татаж байна. Учир нь давхар дээлтэй байхыг хориглох байр суурьтай байсан улс төрийн нам төрийн эрхийг дангаар гартаа авсанаар Үндсэн хуульд гар хүрч хүчингүй болгосон нь хачирхалтай.

2. Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх

Хуучин заалт: 33.1.2 Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна гэж заасан. Шинэ нэмэлт өөрчлөлтөөр 39.2. Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна хэмээн өөрчилсөн.

3. Засгийн газрыг эмхлэн байгуулах журам

Хуучин заалт: 39.2. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ гэж заасан. Шинэ нэмэлт өөрчлөлтөөр 39.3. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ гэж заасан. Шинэ нэмэлт өөрчлөлтөөр 39.4. Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө гэж өөрчилсөн.

³ Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992

⁴ Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992

4. Ерөнхий сайдыг огцруулах журам

Хуучин заалт: 43.1. Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно гэж заасан. *Шинэ нэмэлт өөрчлөлтөөр:* 43.1. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно гэж өөрчилсөн.

Хуучин заалт: 43.2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно гэж заасан. *Шинэ нэмэлт өөрчлөлтөөр* 43.2. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

5. Ерөнхий сайд өөрт нь итгэл үзүүлэхийг хүсэх

Хуучин заалт: 44.1. Өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ гэж заасан. *Шинэ нэмэлт өөрчлөлтөөр* 4.1. Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн, арав хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж өөрчилсөн.

Шинээр нэмсэн заалт: 44.2. Улсын Их Хурал тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно гэж шинээр нэмсэн.

Гурав: Монгол улсын загсийн газар солигдсон шалтгаан

Сүүлийн үед Монгол улсад үүсээд байгаа улс төрийн хямралт нөхцөл байдал, төр барьж байгаа МАН-ын дотоод хагарал, тэмцэлдээн нь ардчиллын хөгжилд ноцтой садаа болж, Монголын улс төрийн түүхэнд сөргөөр ул мөрөө үлдээгээд байна. Монгол улс ардчиллын замд шилжсэнээс хойшхи 28 жилийн дотор Ерөнхийлөгч, УИХ-ын сонгууль, Орон нутгийн сонгууль тус бүрдээ 7 удаа явуулсан. 1912 оноос хойш Монгол улсын түүхэнд нийтдээ 32 хүн сайдаар ажилласан байдаг. Үүнээс 1992 онд Шинэ үндсэн хууль батлагдсанаас хойш буюу УИХ-ын 8 удаагийн сонгуулийн явуулахад хугацаанд нийт 14 сайд ажилласан.

Монгол улсын Засгийн газрын ажилласан байдлыг өмнөх жилүүдийн түүхээс харахад нилээдгүй олон солигдож ирсэн байна. УИХ-ын 8 удаагийн сонгуулийн жилд 14 удаа Засгийн газар солигдсон. 1992, 2000 оны УИХ-ын сонгуулийн жилүүдэд гүйцэтгэх засаглал тогтвортой ажилласан. Үүнээс: сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Засгийн газрыг солиогүй тогтвортой барьсан 2 сонгуулийн жил байдаг. Тодруулбал, УИХ-ын 1992 он, 2000 оны сонгуулийн үр дүнд сонгуулиар МАХН (одоогийн МАН) ялалт байгуулж бий болсон П.Жасрай, Н.Энхбаяр нарын тэргүүлсэн Засгийн газрууд бат бөх байж 4 жил тогтвортой ажилласан юм. 1996 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд МҮАН, МСДН, Ардчилсан холбоо эвслийн байгуулсан Засгийн газар тухайн сонгуулийн жилд түүхэндээ хамгийн олон удаа буюу 4 удаа Засгийн газар сольсон нам болсон. Тухайн сонгуулийн жилд М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Ж.Наранцацралт, Р.Амаржаргал нар Засгийн газрын тэргүүнээр ажилласан.

2004 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд МАХН болон Эх орон ардчилал эвслийн аль нь ялалт байгуулаагүй тэнцсэн тул хамтарсан Засгийн газар байгуулж ажилласан боловч мөн л 3 удаа Засгийн газар нь солигдсон. Харин 2008 оны УИХ-ын

сонгуулийн үр дүнд МАН дангаараа олонхийн суудал авч Засгийн газрыг 2 удаа, 2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд АН, Шударга ёс эвсэл, ИЗННам олонхийн суудал авч Засгийн газрыг 2 удаа, 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд МАН олонхийн суудал авч Засгийг газрыг 2 удаа тус тус сольсон байдаг.

Ерөнхий сайдуудын солигдсон шалтгаан⁵



1992 онд ардчилсан сонгууль явуулснаас хойш нийт 14 Ерөнхий сайд ажилласны 4 Ерөнхий сайд нь сайн дураар огцорсон, 4 Ерөнхий сайд нь бүрэн эрхийн хугацаа дууссан, 5 Ерөнхий сайд УИХ-ын гишүүдийн саналаар ажлын хариуцлага алдсан огцорсон гэсэн шалтгаанаар тус тус огцорсон.

1992 оны Үндсэн хуульд 2019 оны 11-р сарын 14-нд нэмэлт өөрчлөлт оруулснаас хойш анх удаа өөрийн хүсэлтээр огцрох хүсэлтээ өгсөн Ерөнхий сайд бол У.Хүрэлсүх юм. 2021 оны 01-р сарын 21-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд байнгын хорооны санал дүгнэлтээр гар өргөн санал хураалт явуулахад гишүүдийн 95.2 хувийн саналаар Монгол Улсын 31 дэх Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг огцрохыг дэмжсэнээр тэрээр өөрийн хүсэлтээр огцорсон. Хамгийн тогтвортой ажиллах байсан, Үндсэн хуулийн хамгаалалттай Засгийн газар ийнхүү хамгийн хурдан буюу зургаан сарын дараа огцорсон. У.Хүрэлсүхийн огцорсон шалтгаан нь нэгд, Үндсэн хуулийн шинэ өөрчлөлттэй холбоотой, хоёрт, шударга ёсыг тогтоож, хариуцлага хүлээдэг дэг жаягийг тогтоох ёстой гэсэн байр суурьтай огцорсон.

2020 оны УИХ-ын сонгуулиар МАН дангаараа төрийн эрхийг гартаа авч Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ үргэлжлүүлэн ажиллаж байна. Хэрвээ 2022 оны сонгуулийн жил болтол Ерөнхий сайдаа МАН солихгүй бол тогтвортой ажилласан Засгийн газар болох хэдий ч Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулж түүний Засгийн газар нь Ерөнхий сайд болон 21 гишүүнтэй, бүтцийн хувьд ерөнхий чиг үүргийн дөрөв, чиглэлийн 12 яамтай үйл ажиллагаа явуулж байна. 2022 оны 08-р сарын 30-ны өдөр Засгийн газрын сайдуудын заримыг сольж өөрчилсөн. Үүнийгээ тайлбарлахдаа шинэ сайд нараа сонгохдоо “шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх амбицтай, гар нийлэх боломжтой хүмүүсээр багаар бүрдүүлсэн гэдгээ тодотгоод шинээр сонгогдсон сайд бүр дээр тодорхой үндэслэл, шаардлагад нийцсэн гэж сонгосон хэмээн тайлбарлаж байсан юм. Харин хамгийн сүүлд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ бүрэн эрхийнхээ хүрээнд сайд нарыг чөлөөлөх, томилох асуудлыг дахин

⁵ Парламентын институтын улс төр, эрх зүйн шинжилгээ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2018 он

оруулж ирсэн. Шинээр бүрдэж буй танхим нь Ерөнхий сайдтай нийлээд 21 сайдтай байхаар санал оруулснаас 10 сайдыг дахин өөрчилж шинээр томилох асуудлыг УИХ-д танилцуулсанаар хүчин төгөлдөр болсон. Тодруулбал,

Үргэлжлүүлэн ажиллаж байгаа сайдууд:

1. Шадар сайд **С.Амарсайхан**,
2. Хууль зүй, дотоод хэргийн сайд **Х.Нямбаатар**,
3. Сангийн сайд **Б.Жавхлан**,
4. Гадаад хэргийн сайд **Б.Батцэцэг**,
5. Батлан хамгаалахын сайд **Г.Сайханбаяр**,
6. Байгаль орчин аялал жуулчлалын сайд **Б.Бат-Эрдэнэ**,
7. Соёлын сайд **Ч.Номин**,
8. Боловсрол, шинжлэх ухааны сайд **Л.Энх-Амгалан**,
9. Барилга, хот байгуулалтын сайд **Л.Мөнхбаатар**
10. Эрүүл мэндийн сайд **С.Энхболд** нарыг үргэлжлүүлэн ажиллуулахаар болсон.

Шинээр томилогдсон сайдууд:

1. ЗГХЭГ-ын дарга бөгөөд сайдаар-**Д.Амарбаясгалан**
2. Эдийн засгийн хөгжлийн сайдаар **Ч.Хүрэлбаатар**
3. УУХҮ-ийн сайдаар – **Ж.Ганбаатар**
4. Эрчим хүчний сайдаар – **Б.Чойжилсүрэн**
5. ХНХ-ын сайдаар – **Д.Сарангэрэл**
6. ЗТХ-ийн сайдаар **Д.Бямбацогт**
7. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаар- **Н.Учрал**
8. ХХААХҮ-ийн сайд - **Х.Болорчулуун**
9. Нийслэлийн асуудал эрхэлсэн сайдаар – **Ж.Сүхбаатар**
10. Спорт, олимпизмын асуудал эрхэлсэн сайдаар –**Б.Бат-Эрдэнэ** нар нь шинээр томилогдсон ажиллахаар болсон байна.

Эдгээр сайдуудыг солих болсон шалтгаан нь:

1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх амбицтай, гар нийлэх боломжтой хүмүүсээр багаар бүрдүүлсэн гэдгээ тодотгоод шинээр сонгогдсон сайд бүр дээр тодорхой үндэслэл, шаардлагад нийцсэн гэж сонгосон.
2. УИХ, Засгийн газар, орон нутгийн уялдаа холбоог сайжруулах, төрийн бүтээмжийг дээшлүүлэх, ажлын гүйцэтгэлийг хурдасгах, Засгийн газраас дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийн хяналт үнэлгээг сайжруулахад бодитой ахиц гарна.

Засгийн газар ингэж тогтворгүй, олон солигдох болсон хэд хэдэн шалтгаан байна. Үүнд:

1. Монгол дахь улс төрийн намуудын үзэл баримтлал, чиг баримжаа тодорхойгүй, намууд төлөвшөөгүй, намын дотоод ардчилал байхгүй, боловсон хүчний бодлого алдагдсан зэргээс үүдэлтэй.
2. Монголын улс төрд эрх мэдлийн хуваарилалтыг тодруулбал, Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын эрх үүргийг тодорхой нарийн чанд зааж өгөөгүйтэй холбоотой.
3. Монголын төрд хариуцлагын хатуу тогтолцоо, эргээд хариуцлага тооцдог механизм сул байгаатай холбоотой.
4. Сонгуулийн тухай хууль болон улс төрийн намуудын тухай хуульд анхнаасаа УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэхдээ өндөр босго, шалгуур үзүүлэлтийг эрх зүйдээ тусгаагүйтэй холбоотой.
5. Засгийн газар олон солигдсоноор ардчиллын мөн чанар алдагдаж, төрийн залгамж чанар, бодлого үйл ажиллагаа алга болж, цашлаад ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг гажуудуулах нөхцлийг бүрдүүлж байна.

6. Монгол улсын Үндсэн хуульд Засгийн газартай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал, Засгийн газрын тэргүүн хариуцлага алдвал бүрэн бүрэлдэхүүнээрээ сайн дураар огцорно. холбоотойгоор хамгийн сүүлийн буюу У.Хүрэлсүхийн Засгийн газар огцорч байсан гэх мэт олон шалтгаанаас үүдэлтэй байна.

Мөн түүнчлэн шат шатны төрийн байгууллагуудын ажил суларч, төрд итгэх иргэдийн итгэл өдрөөс өдөрт суларсаар байна. Тийм учраас Засгийн газрыг тогтвортой ажиллуулах нь хамгийн чухал асуудал юм.

Дүгнэлт, санал

Монгол улс ардчиллын замд шилжсэнээр дэвшилттэй тал байгаа ч Монгол улсад ардчилал төлөвших болоогүй, бүрэн хэрэгжиж чадаагүй байна. Монгол улсын Засгийн газрын танхимын бүрдэл, төвхнөл, огцруулалт, Үндсэн хуулийн цэцийн маргаан нь дээр дурьдсан бэрхшээлтэй байдлыг харуулж байна. Мөн Засгийн газар олон солигдож, төрийн залгамж чанар алдагдаж байгаа нь ардчиллын хөгжилд ноцтой саад учруулж байна. Монгол улсад болсон өмнөх сонгуулиудын жилүүдэд сонгож байгуулсан Засгийн газрын олон удаа тогтворгүй, солигдож ажилласан зэрэг нь ардчиллыг бэхжүүлэх, ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөлөл үзүүлэх үндэс суурийг бий болгож байна.

Монгол улсын Засгийн газар олон солигдсоноор төрийн залгамж чанар, бодлого үйл ажиллагаа алдагдаж, шат шатны төрийн байгууллагуудын ажил суларч, төрд итгэх иргэдийн итгэл өдрөөс өдөрт буурсаар байна. Тийм учраас Засгийн газрыг тогтвортой ажиллуулах нь хамгийн чухал асуудал юм.

1. Монголын улс төрд хариуцлагын тогтолцоог чангатгаж хоорондоо хагаралдах биш Монгол улсын хөгжлийн цаашдлын бодлого боловсруулж Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулах, алсын хараатай, Монгол улсын хөгжил дэвшлийн төлөө ажиллах шаардлагатай байна.

2. Улс төрийн намын төлөвшлийг сайжруулах зайшгүй шаардлага байна. Нэг нам дангаар төрийн эрх барьж байгаа, Засгийн газрыг удирдаж байгаа мөртлөө Засгийн газрын бүтэц, бүррэлдэхүүнийг олон удаа сольж байгаа нь улс төрийн намын төлөвшил сул байгааг харуулж байна. Иймд улс төрийн намуудын төлөвшил, бодлого үйл ажиллагаа, улс төрийн намын дотоод ардчиллыг сайжруулах шаардлагатай байна.

3. Монгол улсын Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой Засгийн газарт нилээдгүй эрх мэдлийг өгсөн. Иймд эрх мэдлийнхээ хүрээнд төрийн үйл ажиллагаа, залгамж чанарыг алдагдуулалгүй ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Key words: Constitution, democracy, party, executive power, government

Abstract: Mongolia adopted its first democratic constitution in 1992, and Mongolia held its first democratic elections in 1992. This article discusses the activities of Mongolia's executive authority (Government) since then, including the causes, conditions, and further consideration of government instability, the replacement of government.

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол улсын Үндсэн хууль. 1992 он
2. Монгол улсын Засгийн газрын тухай хууль. УБ., 1993 он
3. Б.Чимид Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ. 2006 он
4. Очиржав О. Парламентат ёс ба Үндсэн хууль // Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал: товхимол 1, УБ., 1999.
5. Ж.Төртогтох. Парламент судлалын гарын авлага, УБ., 2010
6. Ж.Төртогтох. Үндсэн хуулийн политологийн шинжилгээ, УБ., 2010
7. Монгол улсын Засгийн газрын бүтэцийн тухай хууль. УБ., 2016 он

8. Конрад Аденауэрын сан. МУИС.Улс төр судлалын тэнхим. Монгол улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа.(судалгааны үр дүн бодлогын зөвлөмж). 81-р тал. УБ., 2018 он
9. Парламентын институтын улс төр, эрх зүйн шинжилгээ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2018 он
1. ¹Сонгуулийн Ерөнхий Хороо. УИХ-ын сонгуулийн дүн. УБ., 1992-2020 он
2. Засгийн газрын бүрэлдэхүүний өөрчлөлт (mass.mn)
3. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР (mongolia.gov.mn)
4. http://www.conscourt.gov.mn/?page_id=3260
5. <https://www.legalinfo.mn/law/details/367>
6. Засгийн газрын хуралдаан (mongolia.gov.mn)

“НЕОПАТРИМОНИАЛ” ОНОЛЫН ОЙЛГОЛТЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ**Б.Эрдэнэдалай**МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор**Г.Мөнхтуяа**МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн магистрант**Хураангуй:**

Уламжлалт төрөөс орчин үеийн төр рүү шилжих шилжилт нь нийгэм эдийн засаг болоод улс төрийн хөгжилд чухал нөлөөтэй. Зарим улс орнуудын хувьд энэхүү шилжилтийн үед завсрын шинжтэй төрийг хадгалж үлдсэн байдаг ба үүнийг неопатримониал төр хэмээн нэрлэдэг. Товчхондоо, нийтийн эрх ашгийн төлөө бодлого, шийдвэр гаргахаас илүүтэй хувийн эсвэл бүлгийн ашиг сонирхолд тулгуурлан рациональ бус шийдвэр гаргадаг төрийг ойлгож болно. 1970-аад оноос хойш судалгааны эргэлтэнд орсон уг хандлагын онолын ойлголтын учир шалтгаан, нийгмийн үйл явдлыг хэрхэн тайлбарлаж буйг голлон авч үзсэн болно.

Түлхүүр үг: Неопатримониализм, төр, патримониаль, клиентлизм, патрон, клиент

Удиртгал:

Эртний сэтгэгч Аристотель төрийн гол зорилгыг аз жаргалтай нийгмийг бий болгох хэмээн цохон тэмдэглэж байсан¹ ба орчин үед энэ агуулга өөрчлөгдөөгүй. Хөгжлийн тухай яригдах бүрт төрийн тухай авч үзэх нь зайлшгүй ба 1997 оны Дэлхийн банкнаас гаргасан “Өөрчлөгдөн буй ертөнц дэх төр” хэмээх тайланд төргүйгээр хөгжил дэвшил ирэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Хантингтон “Иргэншил хоорондын мөргөлдөөн хийгээд дэлхийн дэг журамд гарсан өөрчлөлт” бүтээлдээ төр хоорондын ялгаа нь тэдний засаглалын хэлбэр бус засаглалын түвшинээс хамаардаг гэж үзсэн байдаг². Иймд төрийн чадавх, хэв шинж нь өрнөөд буй хөгжлийн асуудлын гол цөм юм. Улс орон бүр нийгэм эдийн засгийн хөгжилд хүрэхийг эрмэлзэн тодорхой арга замыг сонгож, ялгаатай үр дүнг үзүүлсээр байгаа бөгөөд үүний учир шалтгааныг улс төр судлалын үүднээс тайлбарлах олон онол хандлага бий.

Зүүн Азийн орнуудын үсрэнгүй хөгжлийн голлох шалтгаан нь орчин үеийн хүчтэй төр, меритократ төрийн алба бөгөөд оновчтой бодлого шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлж байсанд оршиж байв. Ялангуяа Япон улсад 1950-1990 оны өсөлтийн үед төрийн оновчтой зохицуулалт, чадварлаг төрийн алба нь тогтвортой макро эдийн засгийн бодлого, ажиллах хүчний зохион байгуулалт, технологийн нээлтийг хийж тухайн улсын хөгжлийн суурь үндэс болж байсан. Энэ тухай Чалмерс Жонсоны Японы гайхамшиг гэх судалгааны ажилд тодорхой дурддаг. Харин Африкийн зарим улс оронд функциональ байдлаа алдсан, хэт бүлгийн болон хувийн ашиг сонирхлыг түрүүнд тавьснаар төр системчлэгдсэн авлигалд өртөж, үйлдвэржилт бүтээн байгуулалтаас

¹ Б.Жамбал, *Улс төрийн сэтгэлгээний түүх*

² Samuel P Huntington. (1968). *Political order in Changing Societies*. Yale University.

хөрөнгөжих бус төрд орж хөрөнгө мөнгө олох зорилготой болсон байдаг. Энэхүү неопатримонийн бодит практик нь Африкийн улсуудаар хязгаарлагдахгүй бөгөөд дэлхийн нийтийн үзэгдэл, улс орнуудад тулгарч буй гажуудал юм (Theobad, 1982; Mkandawire, 1998; Erdmann and Angel, 2007). Иймд хөгжингүй орнуудын амжилт ололтыг судлахын зэрэгцээ буурай орнуудын алдаа дутагдлыг мэдэж авах нь орчин үеийн улс төрийн асуудлыг шийдэхэд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

1. Неопатримониализм онолын ойлголт

Хорьдугаар зууны дунд үед судлаачид неопатримониал төрийн бодлого, шийдвэр гаргалтын үр нөлөөний тухай таамаглал дэвшүүлэлгүй хөгжлийн тодорхой үе шатанд орчин үеийн болон уламжлалт төр зэрэгцэн орших нь хэвийн үзэгдэл гэж үздэг байв.³ Энэ үзэл 1970-аад оны эхэн үеэс Африкийн нийгэм яагаад орчин үежиж чадахгүй байгаа, яагаад харизматик удирдагчид амлалтаа биелүүлж чадаагүйг тайлбарлах зорилгоор хэрэглэснээс хойш өөрчлөгдөж эхэлсэн. Неопатримониализм нь М.Веберийн патримониализм гэх нэр томъёоны үргэлжлэл бөгөөд Шмуэль Н.Эйзенштадтын 1973 онд бичсэн “Traditional Patrimonialism and Modern Neopatrimonialism” гэдэг бүтээлээр орчин үеийн шинжлэх ухааны эргэлтэд оруулсан⁴. Неопатримониализмын "нео" нь рациональ-хууль ёсны засаглалыг илэрхийлдэг ба патриомониал хэв шинжтэй хавсардаг. 1980-аад он гэхэд неопатримониализмын үзэл баримтлал илүү танигдаж Африкийн улс орнуудын эдийн засгийн дорой үзүүлэлт, түүний дотоод шалтгаантай хамт тайлбарлагдаж ирсэн. Энэхүү онолын хандлага уламжлалт болон орчин үеийн төрийн нийлмэл байдал нь хөгжлийн доод түвшинд хүргэх төдийгүй олон улсын түншүүд, цаашдын нийгэм улс төрийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлнэ гэж үздэг.⁵

Неопатримониал төрийн үед улс төрийн тогтолцоо нь албан бус харилцаан дээр давамгайлан суурилдаг. Түүнчлэн нийтийн болон хувийн өмчийн асуудалд ялгаа бага гаргадаг нь хууль ёсны засаглал, институцүүдэд сөрөг үр дагавартай. Судлаачдын үзэж байгаагаар, неопатримониал хэв шинжтэй төрд учирдаг асуудал нь дээд түвшний албан тушаалтнууд рент хөөцөлдөх явдал байдаг. Үүний үр дүнд эдийн засаг дахь төрийн оролцоо хэт ихсэх, төр данхайн томорч үр ашиггүй рент гувших монополь үүсэж, зөвхөн эрх баригчдад ашигтай хувьчлал явагдаж, ил тод биш зөрчил ихтэй татвар, хөрөнгө оруулалт, төсвийн зарцуулалтын хуулиуд гарч эдийн засгийн өсөлт саардаг. Неопатримониал хэв шинжтэй төрийн тодорхойлолтыг судлаачид дараах байдлаар тодорхойлжээ.

- Кристофер Клапамын тодорхойлсноор, улс төр болон хууль ёсны шугамаар бий болсон захиргааны системд гаж нөлөөтэй патримониал харилцааны зохион байгуулалтын хэлбэр өргөн цар хүрээтэй тогтсон байдаг⁶.

- Р.Фаттоны үзсэнээр, тухайн улс орны удирдагчид улс төрийн эрх мэдлийг зөвхөн өөрийн тойрон хүрээлэгчиддээ үйлчлэхэд зориулж ашигладаг явдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, “рентийн хойноос хөөцөлдөх үзэл бөгөөд өмчлөх эрхийг дахин хувиарилахдаа гэр бүл, садан төрөл, нутаг усныхан зэрэг явцуу бүлгийн тодорхой ашиг сонирхолд хөтлөгдөн төрийн аппаратыг ашиглах”⁷ явдал юм.

³ Pitcher, Moran, and Johnston 2009 challenge this evolutionist interpretation of Max Weber

⁴ (Ц.Батболд, Улс төрийн социологи, 2018)

⁵ Mkandawire, T. (2015). *Neopatrimonialism and the Political Economy of Economic Performance in Africa: Critical Reflections*. London: The London School of Economics and Political Science.

⁶ Ц.Батболд, 2018. *Улс төрийн социологи*. Улаанбаатар: МУИС пресс

⁷ (Ц.Батболд, Улс төрийн социологи, 2018)

• Г.Эрдманн, Ульф Энгелийн хувьд неопатримонийн тогтолцоо нь "хамтдаа оршдог, хэсэгчлэн сүлжсэн хоёр төрлийн ноёрхол юм. Тухайлбал, уламжлалт болон хууль ёсны бюрократ ноёрхол"-ын холимог шинж чанартай байдаг.

Неопатримониал хэв шинжтэй төрийн үед улс төр, эдийн засгийн институтууд хямралд орж ардчиллын гажуудал, эдийн засгийн доройтол, чадваргүй төрийн алба бэхждэг. Патримониализмын гол шалгуур бол хаан буюу эрх баригчдад үнэнч байх явдал бөгөөд оршин тогтнох үндэс нь фаворитизм (тойрон хүрээлэгчид) болон патернализм (төрөл садан, найз нөхөд, угсаатан, үндэстэн)-д тулгуурладаг. Энэ утгаар энэ хоёр систем хоорондоо зөрчилтэй боловч оршин тогтнох үндэс нь патрон клиентын харилцаа юм.⁸ Өмнө нь дурдсанчлан неопатримониал хэв шинжтэй төрийн үед албан бус харилцаа давамгайлдаг ба энэ нь патрон клиентын харилцаагаар илэрдэг. Иймд патрон клиентын харилцааг дэлгэрэнгүй судлах шаардлага тулгарч байгаа юм.

2. Патрон клиентын харилцаа гэж юу вэ?

Патрон клиентын үүсэл нь Ромын эзэнт гүрний үед харц гаралтай иргэд болон язгууртан хоорондын хамаарлаар тодорхойлогдож байв. Энгийн иргэд газрын эздэд өрийн бичгээр боогдсон байдалтай, харин язгууртнууд өөрийн нэрийн өмнөөс албатдаа хамгаалал үзүүлдэг байв. Тухайн язгууртны нэр хүнд нь цэргийн хүч болон улс төрийн хүчтэй салшгүй холбоотой байсан.

Патрон, клиентын харилцаа нь эдийн засаг болоод нийгмийн асар их хүчтэй ивээн тэтгэгч болон хүч сул клиентүүдийн хооронд үүсдэг харилцаа юм. Энэхүү ойлголт нь олон давтамжтай албан бус, институцлэгдээгүй нөхцөл байдлаар хэмжигдэх ба эрх мэдлийн түвшин ялгаатай хувь хүн болон бүлгийн хооронд явагддаг. Түүнчлэн клиентлизмийн хэв маяг нь улс орон, бүс нутгуудад ялгаатай байдлаар ажиглагддаг хэдий ч нийтлэг гурван хэв шинж байдаг. Үүнд албан бус, хоёрлосон ситемтэй, зөвшилцөлд хүрдэг хэв шинжүүд байдаг.⁹

• **Scott (1972):** Патрон клиентын харилцаа нь аюулгүй байдал, урамшуулал эсвэл хоёуланг нь өгөх чадвартай албан тушаалтан болон түүний хувийн дагалдагчдаас бүрдсэн албан бус кластер юм. Ийм ашиг тусын хариуд ивээн тэтгэгчид үнэнч байж хувийн туслалцаа үзүүлдэг.¹⁰

• **Kaufman (1974):** Тэрээр патрон клиентын харилцааг хувь хүмүүсийн арилжаа солилцоо гэж үзээд нийтлэг гурван хэв шинж байдаг ба үүнд тэгш бус харилцаа (inequality), харилцан солилцоо (reciprocity) нарийн нягт холбоо (particularity) гэж тодорхойлсон. Түүний хэлснээр уг харилцаа нь эрх тэгш биш эрх мэдэлтэй хүмүүсийн харилцаа гэж үзээд тэдгээр оролцогчид нь нуугдмал нарийн нягт уялдаатайгаар нийтийн хууль, хэм хэмжээг чөлөөтэй өөрчилж тогтоодог гэж үзжээ. (Kaufman, 1974 and Scott, 1972)

• **Eisenstadt & Roniger** нар нь Kaufman-тэй ижил үзэл санаатай байсан бөгөөд уг харилцааны ерөнхий хэв шинж, гурван гол ухагдахууныг гаргаж тавьсан байдаг.

Клиентлизмыг тайлбарлах оксфордын толь бичигт клиентлизмын эхэн үеийн тодорхойлолт нь клиентүүд нь эрх мэдэлгүй, тэгш байр суурьгүй оролцогчдын дунд удаан хугацааны туршид санал солилцох байдлаар ивээл үзүүлдэг харилцааг онцолж байв. Улс төрчид өөрсдийн дэмжигчдийнхээ тодорхой хэсгийг сонгуулийн дэмжлэгийн

⁸ (Ц.Батболд, Бюрократ онолын үндэс, 2013)

⁹ "Patron-Client Politics and Governance System in Nepal" Shiva Hari Adhikari, Seoul National University <https://dms.nasc.org.np/sites/default/files/documents/Patron-Client%20Politics%20and%20Governance%20System%20in%20Nepal.pdf>

¹⁰ "Patron-Client Politics and Governance System in Nepal" Shiva Hari Adhikari, Seoul National University [p.9https://dms.nasc.org.np/sites/default/files/documents/Patron-Client%20Politics%20and%20Governance%20System%20in%20Nepal.pdf](https://dms.nasc.org.np/sites/default/files/documents/Patron-Client%20Politics%20and%20Governance%20System%20in%20Nepal.pdf)

хариуд улсын мөнгө, нөөцөөр шагнадаг. Нэгдүгээрт, үйлчлүүлэгчид зөвхөн санал өгөх биш улс төрчдөд санхүүгийн хандив, мөнгөн бус эх үүсвэр санал болгодог. Хоёрдугаарт, улс төрчдөд санхүүгийн хандив мөнгөн бус эх үүсвэр санал болгодог. Гуравдугаарт, ашигтай байхын тулд саналаа зарж байгаа нь эсрэг тохиолдолд клиент биш авлига гэж тодорхойлох боломжтой.¹¹

Патронеиж нь оксфордын толь бичигт латин хэлний “patronus” буюу хамгаалагч гэх утгатай үгнээс гаралтай ба дундад зууны үеийн сүмд энэ нь “сүм хийдийн түшмэдийг томилох эрхтэй хүн” гэсэн утгатай байсан. Дээрх ойлголтыг улс төрийн ивээн тэтгэх ойлголтын хувьд сайн хослуулсан байдаг.

Патрон клиентын 3 үндсэн хэв шинж:


1. Зохион байгуулалттай (organizational);
2. Солилцооны дүрэм журамтай (regulation of exchange);
3. Нийгмийн зүтгэлтнүүдийн нөөц урсгалтай (flow of resources between social actors);

Патрон клиентын 9 суурь хэв шинж:

1. particularistic - нарийн нягт уялдаа холбоотой;
2. exchange of resource - харилцан солилцооны нөөцтэй;
3. package deal – харилцан ашигтай наймаалцал;
4. conditional relation - болзолт харилцаа;
5. solidarity - эв нэгдэлтэй;
6. contractual/not legal хуулийн дагуу биш;
7. voluntarily relation - сайн дурын харилцаа;
8. vertical network - босоо чиглэлтэй харилцаа;
9. inequality - тэгш бус харилцаа;

Патрон клиентын хоорондын холбоог хоёр байдлаар үзүүлсэн. (Scott 1972) Эхний холбоос нь патроноос шууд хамааралтай клиентүүд байгаа бол хоёр дахь нь босоо чиглэлтэйгээр патроноос шууд хамааралтай клиентүүд дахин доод түвшний клиентүүдтэй болох юм.

Зураг 1. “Патрон клиентын холбоо”



Патрон, клиентын харилцааны нийгэмд үүсгэх асуудал их бөгөөд үүнд хүчирхэг патроны систем нь улс төрийн шийдвэр гаргалтыг илүү клиентлист, төрийн албаны тогтолцоог илүү патримониал, засаглалыг анархи хариуцлагагүй болгодог байна. Патрон клиентын харилцаанд оролцогчид засаглалыг сул дорой болгож, төрийн албаны үйлчилгээний шударга байдлыг алдагдуулдаг. Эрх мэдэл нь тодорхой хэсэг бүлэг элитийг төвлөрүүлж өөрсдийн ашиг сонирхлын төлөө албан бус үйл ажиллагаа явуулдаг. Патрон болон клиентүүд өөр хоорондоо чухал үүрэг хүлээсэн байдаг. Патрон болон түүний даган хүрээлэгчид, иргэдийн төлөөлөгчид, бизнес эрхлэгчид, нийтийн байгууллага эсвэл дэмжигчид хоорондын хууль бус амлалт/үүрэг нь

¹¹ Oxford. (2009). *Concise dictionary of politics dictionary*. NewYork: SPI publisher.

материаллаг давуу талуудыг тэдэнд бий болгож байдаг. Тэнцвэргүй хүчийг хэрэглэж, патрон нь дүрэм журам алдагдуулан тойрон хүрээлэгчи

дээ ажлын байр, хөрөнгө мөнгөөр тэтгэж, өөрийн хамааралд байх үл хөдлөх хөрөнгийг хуваарилдаг ба тэдний дэмжлэг болон хамтралын төлөө хариу үзүүлдэг.

Клинтелизм нь ямар нэгэн төрлийн нөөцийг харилцан ашигтай хэлбэрээр хоорондоо арилжаалж буй ивээгч, үйлчлүүлэгч хоорондын онцгой солилцоог хэлдэг. Уг солилцоонд оролцогчид статусын хувьд тэгш бус хэдий ч хоёул үр ашиг хүртэхээр байдаг. Ивээгч буюу газрын эзэд эсвэл нутгийн эрх мэдэлтнүүд солилцоонд илүү хүчирхэг оролцогчид болдог ба тэд газар гэх мэт нөөцийг онцгой эрхтэйгээр ашиглаж байхад тэдний үйлчлүүлэгчид болох энгийн ядуу тариачид, шилжин ирэгсэд, бусад эмзэг бүлгийнхэнд хаалттай байдаг. Ивээгчид нь тэдгээр нөөцүүдээс үйлчлүүлэгчиддээ шууд ашигтай байхаар сонгон хуваарилж хариуд нь тэдний тусламж, дэмжлэг эсвэл үнэнч байдлыг хүсдэг. Ийм солилцоонууд нь эцэстээ үйлчлүүлэгчийг ивээгчээс хамааралтай болгож, уламжлалт нийгмүүдэд түгээмэл байсан үнэнч зан, ач тус санах, үүрэг хариуцлага хүлээх мэдрэмжээр удирддаг нийгмийн харилцааг бэхжүүлдэг.

3. Неопатримонал хэв шинж ардчиллын түвшин, улс төрийн дэглэмд хэрхэн нөлөөлдөг вэ?


Неопатримониал орнуудад сонгууль байдаг боловч голчлон хэлбэр төдий байдаг. Тухайлбал, эрх баригчдад санал худалдан авах ажиллагаа нь сонгуулийн ялалтыг баталгаажуулах хэрэгсэл болсон. Үүнтэй адил улс төрийн эрх, иргэний эрх чөлөөг зөвхөн эрх баригчдын үйл хэрэгт туслах түвшинд л өгдөг (Bratton & van de Walle 1997: 61). Үүний үр дүнд бүх эрдэмтэн судлаачдын ардчиллын үндэс гэж үздэг түгээмэл эрх хязгаарлагдмал болдог. (Møller & Skaaning, 2010). Цаашилбал, эрх баригч нь улс төрийн элитэд албан тушаал, давуу байдлыг олгодог тул гишүүд нь эрх баригчдаа үнэнч байх үүрэг гүйцэтгэж ардчиллыг хөгжүүлэх эрмэлзэл багасдаг.

Товчхондоо, улс орнуудын неопатримониал хэв шинж нэмэгдэх бүрт ардчилал болоод эдийн засгийн өсөлт буурдаг байна. Хөгжиж буй орнууд болон бүтэлгүйтсэн улс орнуудын асуудлын гарц, амжилтад хүрсэн хүчин зүйл нь нэг субъектэд огтолцдог бөгөөд улс төр, эдийн засгийн хөгжлийн суурь бол төр гэдэг нь олон орны жишээн дээр харагдаж байна.

4. Неопатримониал хэв шинж эдийн засгийн өсөлт бууралтад хэрхэн нөлөөлдөг вэ?

Эрх мэдлээ баталгаажуулахын тулд неопатримонийн эрх баригч засгийн газрыг тогтвортой байлгах сонирхолгүй байдаг. Ийм байдлаар болзошгүй аюул заналыг хэт хүчтэй болохоос нь өмнө арилгадаг. Энэхүү кабинетийн тогтворгүй байдал нь үр ашиггүй бодлого боловсруулж, улмаар эдийн засгийн өсөлт сайнгүй байдаг. Эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө нь үйлчлүүлэгч, ивээн тэтгэгч байдлаар тодорхойлогддог практиктай холбоотой юм. Эрх баригч эрх мэдлээ баталгаажуулах арга хэлбэрийн хувьд хүмүүсийг ур чадварых нь оронд (Веберийн меритократад баримталдаг зарчмуудын эсрэг) өөрийг нь дэмжиж байгаа гэсэн үндэслэлээр албан тушаалд томилдог. Энэ нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж хөрөнгө оруулалтын буруу бодлого, тогтворгүй нөхцлийг бүрдүүлдэг (Bratton & van de Walle 1997: 61).

Зураг 2. Неопатримониал хэв шинж ба ардчилал, эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарал



Неопатримониал төрийн үед төрийн чадамж буурснаар сул төр бий болдог. Энэ тухай Ф.Фукуяама улс төрийн тогтолцооны ялзрал номондоо чанартай төр, эдийн засаг нийгмийн амжилт хоёрын хооронд маш хүчтэй шалтгаант холбоо байдаг. Хэлсэндээ хүрч байгаа, хүлээн зөвшөөрөгдсөн данхар төр, авсаархан ч гэсэн цаг ямагт элдэв хүлээсэнд баригдан тээнэгэлзсэн, бодит эрх мэдэлгүй төрөөс илүү амжилттай хэмээн дурдсан байдаг. Сул төртэй улс орон хялбар аргаар ашиг хонжоо олох гэсэн хүмүүсийн гарт орсон байдаг бөгөөд үндэснийхээ ашиг сонирхолд нийцсэн бодлого боловсруулж хөгжлийг явуулахад компаниудын хоорондын уялдаа холбоо, мэргэжлийн меритократ төрийн алба, нэгдмэл үнэнч байдал зэрэг инстүүцүүд нь дутагдалтай байдаг. Сул төртэй улс орнууд эдийн засагаа хөгжүүлэхэд амжилт төдийлөн олдоггүй бол Япон, Тайвань, Солонгос гэх мэт хөгжлийн төртэй гэж тооцогддог улс орнуудад харин эсрэг дүн гарсан. Төрийн алба нь төлөвшсөн байдаг учраас эрх мэдлээ бүрэн хэрэгжүүлэх боломж олдож, хөгжлийг түүчээлэхэд амжилт гаргадаг байна. Үүнийг судлаач Эванс аливаа хөгжлийн үр дүн нь улс төрийн элит хэсэг нь үүрэг ажлаа хэр сайн гүйцэтгэхээс шалтгаална гэж тайлбарлажээ. Гэхдээ хөгжлийн төр нь нийгмээсээ бүрэн тусгаарлагдсан байдаггүй. Улс төрийн элитүүд нь бизнес эрхлэгчидтэй бодлого, стратеги түүний хэрэгжилтээ хэлэлцэж ярилцах нягт сүлжээтэй байдаг. Үүгээрээ клиентлизмын эсвэл ямар нэгэн хувийн харилцаан дээр суурилсан тогтолцооноос ялгаатай.

Дүгнэлт:

Неопатримониализм бол Африк тивийг дүрслэн тайлбарлахад хэрэглэгддэг гэсэн шошготой хошин яриа байдаг. Энэ нь заримдаа неолибераль зах зээлийн шинэчлэл яагаад бүтэлгүйтсэн шалтгааныг тайлбарлаж өгөх арга болдог.¹² Уг хандлага нь уламжлалт төрөөс орчин үеийн төр рүү шилжих шилжилтийн үед төрд тохиолдож болох эрсдэл, нэгэнт системчлэгдээгүй завсрын шинжтэй төрийн сөрөг үр дагавар, буурай хөгжлийн шалтгаанд тайлбар өгөх, таамаглал дэвшүүлэх арга зам юм. Завсрын шинжтэй төрийн нөлөө нь зөвхөн төр, төрийн албадуудад нүүрлэж буй гажуудал биш бөгөөд иргэний нийгмийн хөгжил, аж ахуй нэгжийн бүтээмжид сөрөг нөлөө үзүүлдэг.

¹² Ц.Батболд. Засаглал дахь патримониаль ба неопатримон төрийн ноёрхол. Политологи-V, МУИС, Эрдэм шинжилгээний бичиг, №325

Патрон клиентын харилцаа нь неопатримониал төрийн хэв шинжийг бүрдүүлдэг ба тэгш бус, нарийн нягт уялдаа холбоо, харилцан ашигтай байх зарчимд тулгуурладаг. Төрийн алба дахь албан бус харилцааг институцлэх шаардлага тулгарч байгаа бөгөөд холбогдох судалгааг хийх хэрэгцээ үүсч байна.

Рациональ бюрократын оршин тогтнох гол зарчмуудын нэг нь мерит систем бөгөөд төрийн алба зөвхөн мэргэжлийн өндөр шалгуур, мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж байж үүрэгээ хангалттай гүйцэтгэнэ. Харин патримониализмын гол шалгуур нь эрх баригчдад үнэнч байх явдал бөгөөд тойрон хүрээлэгсдэд тулгуурладаг¹³ байна.

Неопатримониал шинж нь ардчилал, эдийн засгийн өсөлттэй урвуу хамааралтай нь Ван Де Веллийн судалгаанаас харагдаж байгаа бөгөөд иргэдийн саналыг худалдан авах замаар түгээмэл эрх зөрчигдөх, эрх мэдлээ баталгаажуулах зорилгоор засгийн газрын тогтвортой байдал алдагдах зэрэг үзэгдэл нь улс төр, эдийн засгийн хөгжлийг хойш татах хүчин зүйл болдог байна.

Abstract:

The transition between a traditional state and a modern state has crucial impacts on economic and political development. During this transition, the transition state is preserved, which is called a neopatrimonial state. Generally, neopatrimonial state makes irrational decisions based on personal or group interests rather than making policies and decisions for the public interests. Since 1970, neopatrimonial theory was studied in the field of research. The theory's reasoning and how it explains political and social events are mainly discussed.

Keywords: neopatrimonialism, state, clientism, patron, client

Ашигласан материал

- Development leadership program. (2014 оны 11). *The 'State of the Art Paper'*.
file:///C:/Users/Administrator/Downloads/Authoritarianism-democracy-and-development.pdf-ээс Гаграсан
- Erdman, G., & Engel. (2006). *Neo-patrimonialism Revisited - Beyond a Catch - All concept*. GIGA.
- Knudsen, F. V. (2013). *Opening the black box*. Denmark : Aarhus university .
- Mezentseva, L. (2019 оны Jul 16). State capacity: How it is measured and compared. Moscow, RU: NATIONAL RESEARCH UNIVERSITY HIGHER SCHOOL OF ECONOMICS.
- Mkandawire, T. (2015). *Neopatrimonialism and the Political Economy of Economic Performance in Africa: Critical Reflections*. London: The London School of Economics and Political Science.
- Oxford. (2009). *Concise dictionary of politics dictionary*. NewYork: SPI publisher.
- Samuel P Huntington. (1968). *Political order in Changing Societies*. Yale University.
- Schütte, S. A. (2015). *The fish's head: Appointment and removal procedures for anti-corruption agency leadership*. U4 Anti-corruption resource centre:
<https://www.u4.no/publications/the-fish-s-head-appointment-and-removal-procedures-for-anti-corruption-agency-leadership>-ээс Гаграсан
- Statistic news. (2020). *List of countries by GDP (nominal) per capita*. Statistic news:
<https://statisticstimes.com/economy/countries-by-gdp-capita.php>-ээс Гаграсан

¹³ Ц.Батболд, 2018. *Улс төрийн социологи*. Улаанбаатар: МУИС пресс

- Weidman, J. (2019). *Heritage*. Гаргасан 2019 оны 4 16,
<https://www.heritage.org/index/visualize-aac>
- World bank. (2017). *Elite bargaining adaptation, World development report*. NY: World bank.
- World bank. (2020). *Governance effective*. World bank .-ээс Гаргасан
- world meter. (2020). *GDP capita per* . <https://www.worldometers.info/>-ээс Гаргасан
- А.Бат-оргил. (2018). *Хөгжлийн тухай онолууд (Монголын хөрсөнд)*. Улаанбаатар: Номад пабблишинг.
- Б.Мягмарсүрэн. (2013). *Улс төрд нөөц баялгийн үзүүлэх нөлөөлөл ба Монгол улс*. Гаргасан 2021 оны 4 21, https://ulstur.blogspot.com/2013/08/blog-post_1774.html-aac
- Б.Тэрбиш. (2021). Улс төрийн намын санхүүжилт. *Шударга ёс, АТГ*.
- Дэлхийн банк. (2020). Өндөр чадавхтай төрийн албыг бий болгох нь, шинэтгэлийн явц сургамж. *МУ-ын төрийн албаны хүний нөөцийн удирдлага* , 49 50.
- Титмус, Р. (2007). *Авлига ба төр*. NY: МУИС пресс.
- Ф.Фукуяама. (2013). *Улс төрийн тогтолцооны ялзрал* . Нерко.
- Ц.Батболд. (2013). Бюрократ онолын үндэс . *Хөгжиж буй орнууд дахь бюрократ удирдлагын өнөөгийн төлөв, цаашдын хандлага* , хууд. 456.
- Ц.Батболд. (2018). *Улс төрийн социологи*. Улаанбаатар: МУИС пресс.

МОНГОЛ ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫН АСУУДАЛ

Х.БатхүүМУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн докторант**С.Базарпүрэв**МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын зөвлөх профессор**Хураангуй:**

Хууль тогтоох эрх мэдэл, түүний нэг чухал бүрдэл хэсэг нь парламентын хяналтын асуудал байдаг бөгөөд түүнийг хэрэгжүүлж буй байдал нь тухайн улсынхаа засаглалын хэлбэр, эдийн засаг, ардчиллын түвшин зэргээс хамаарч янз бүрийн арга, хэлбэртэй хэрэгжиж байна. Парламент нь гүйцэтгэх эрх мэдлийн институтдээ хяналт тавих нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын харилцан хянах зарчимд үндэслэсэн, түүнд нийцсэн байдаг. Тиймээс тус өгүүлэлд Монгол дахь парламентын хяналтын өнөөгийн байдал, түүнийг хэрэгжүүлж байгаа хэлбэр, арга хэрэгслүүдийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, боломж, улс төрийн нөхцөлийг судлан гаргасан. Парламентын хяналтын үр нөлөөг дээшлүүлж, арга механизмыг боловсронгуй болгох нь парламентын автономи байдал, парламентын ардчилалд чухал нөлөөтэй юм.

Түлхүүр үг: хууль тогтоох эрх мэдэл, парламент, хяналт, сөрөг хүчин

Удиртгал:

Английн философич Жон Стюарт Милль “төлөөллийн ардчилалд парламент нь “ард түмний нүд, чих, дуу хоолой” гээд төрийн энэхүү институтийн гол зорилт нь засгийн газрыг хянах, түүний аливаа үйлдэл, үйл ажиллагааг хэлэлцэж, алдаа дутагдлыг нь буруушааж зэмлэх явдал бөгөөд ард иргэдийн гомдол саналыг авч үзэх, санал бодлоо илэрхийлэх газар байх ёстой гэж үзсэн байна.¹

Хууль тогтоох эрх мэдэл нь Үндсэн хууль хийгээд нийтээр дагаж мөрдөх хуулийг тогтоох, улсын төсөв батлах, түүнчлэн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих эрхийн цогц юм². Ардчилсан нийгэмд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч гол институт нь парламент байдаг. Парламент нь хууль тогтоох, нийт ард түмний эрх ашгийг илэрхийлж, тэднийг төлөөлөх үндсэн хоёр шинжтэй. Энэ хүрээнд ард түмнийг төлөөлөх чиг үүрэгтэй нь холбон парламентын хяналтыг тайлбарласан байна³. Жишээлбэл, “...Ардчилсан нийгэмд төрийн дээд эрхийг иргэдийн төлөөлөгчид гартаа барьж байх ёстой бөгөөд парламентын хяналтаас гадуур төрийн ямар ч салбар байх ёсгүй юм...” гэжээ. Харин доктор Д.Лүндээжанцан парламентын хяналт шалгалтыг түүний хууль тогтоох үйл ажиллагаатай холбон тайлбарлажээ.⁴

¹ Ж.Төртогтох “Үндсэн хуулийн политологийн шинжилгээ” УБ., 2010 он, 62 дахь тал

² Д.Лүндээжанцан “Эрх мэдэл ба ардчилал” УБ., 2015, 18 дахь тал

³ П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015, 115 дахь тал

⁴ П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015, 116 дахь тал

Эрх мэдэл болон мөнгө Засгийн газарт ихээхэн төвлөрч, парламентын лидерүүд гүйцэтгэх засаглалд орж ажиллах болсон, гүйцэтгэх засаглалын оролцооны түвшин нэмэгдэж парламентад нөлөөлөхүйц түвшинд хүрсэн зэрэг нь “парламентын уналт”-ын шалтгаан болох болсон. Ийм нөхцөлд парламентын хяналтыг хэрэгжүүлэх сонирхолгүй байх, хяналт үгүй болох аюултай. Хэдий тийм ч засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох зэрэг нь хууль тогтоох эрх мэдлийн бүрдэл хэсэг болохын зэрэгцээ парламентын үндсэн үүрэг, түүний бүтэц, үйл ажиллагаанд нэвт шингэж, төрийн эрх мэдлийн мөчир хоорондын хяналт, тэнцлийн зарчмыг хэрэгжүүлэх механизм, гүйцэтгэх эрх мэдэлд өгөх улс төрийн үнэлэмж, хууль, бодлогын гажуудлыг арилгах гол хэрэгсэл, арга болдог.

Парламентын хяналт)Parliamentary oversight, Legislative oversight, parliamentary control(гэдэг нь парламентаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих бүхий л талын төлөвшсөн бүхэл бүтэн хяналтын тогтолцоо бөгөөд хууль, тогтоомж, төсвийн бодлого, түүний хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай арга хэмжээ авах, хариуцлага тооцох үндсэн механизм⁵ бөгөөд дараах ач холбогдолтой⁶. Үүнд:

- Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн салаа, мөчир хоорондыг харилцан тэнцвэржүүлэх (check and balance)

- Парламентын автономит байдлыг хангах, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байх боломжийг нэмэгдүүлэх

- Төрийн ил тод, нээлттэй байдлын нэг чухал хөшүүрэг, арга зам болдог
- Гүйцэтгэх засаглалыг залах, чиглүүлэх механизм болно
- Хариуцлага бол ардчилсан засаглалын суурь шинж болдог
- Гүйцэтгэх эрх мэдлийн тодорхой бодлого, үйл ажиллагаа олон нийтээр хэлэлцэгдэх, үнэлэгдэх боломж бий болно

Орчин үеийн төрийн байгуулалд парламентат ёс нь гурван чухал үнэт зүйл бий болгосон⁷.

1. Хууль тогтоох үйл ажиллагааг ард түмний төлөөлөлтэй нэгтгэсэн. Өөрөөр хэлбэл дарангуйлагч дангаар захирах ёсыг халж, ард түмний төлөөллөөр хууль тогтоох болсон
2. Төрийн эрх мэдлийг гурван салаанд хуваарилж хэрэгжүүлэх, хяналт, тэнцэлтэй хүнд ээлтэй тогтолцоог бий болгосон
3. Парламент нь хөгжлийг зогсоогч, саатуулагч бус харин туурвин бүтээгч байхад шилжсэн

Төрийн эрх мэдэл хуваарилах онолын нэгээхэн амин сүнс нь харилцан хяналтын механизм бөгөөд тэр дундаа парламентын хяналтын асуудал чухлаар тавигддаг. Энэхүү сэдэв нь ардчилал, парламентат ёс, засаглал хуваарилах зарчим, парламентын өөрийнх нь судалгааны хөгжилд практик ач холбогдлоороо чухал бөгөөд нийт ард түмний улс төрийн эрх ашиг, төлөөллийн ардчиллын үнэт зүйлстэй салшгүй холбоотой гэж үзэж байна. Монтескьегийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санааг нэг талаас ардчилсан нийгэм, Үндсэн хуулийг бүтээх үзэл баримтлалын цэгцтэй тулгуур онол, нөгөө талаас ардчилсан төрийн байгууллыг зохион байгуулах Үндсэн хуулийн зайлшгүй мөрдлөг болгох суурь шаардлага, норматив болж байдаг

⁵ Улсын Их Хурлын Тамгын газар “Бодлогын судалгаа, шинжилгээ” XII боть, УБ., 2012

⁶ Х.Номингэрэл “Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх механизм, бусад орнуудын жишиг, Монгол Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг боловсронгуй болгох асуудал”, “Байнгын ажиллагаатай Парламент 25 жил” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ., 2015, 23 дахь тал

⁷ Б.Чимид “Парламентын хяналт, шалгалтыг төгөлдөржүүлэх нь” илтгэл УБ., 2010

үндсэн зарчим гэж үздэг. Иймээс түүнийг судлаачид онол төдийгүй зарчим хэмээдэг⁸. Төрийн эрх мэдэл хуваарилах онолын амин сүнс, зарчмыг дараах гурван хүчин зүйлээр тодорхойлж болох юм⁹.

1. Эрх мэдлийг зааглан хуваарилах. Аливаа төр нь нэг л засаглалтай байх бөгөөд түүнийг хуваадаггүй харин эрхлэх ажил буюу чиг үүргийг нь засаглалын гурван салаанд хуваарилж хэрэгжүүлэх нь зохистой. Энэ тухай Ж.Локк засаглалыг хууль тогтоох, гүйцэтгэх (үүндээ шүүхийг хамруулсан), холбооны (гадаадад хэрэгжүүлэх гүйцэтгэх эрх мэдэл) гэж ангилсан¹⁰, бол Монтескье эрх чөлөөг бодитой хэрэгжүүлэхийн тулд төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван төрөлд хэрэгжүүлбэл зохистой гэж үзсэн.
2. Эрх мэдлийг харилцан тэнцвэржүүлэх. Төрийн эрх мэдлийг дээрх засаглалын гурван салаа, мөчирт зааглан хуваарилж, тэдгээрийн хоорондын үйл ажиллагаа, зохион байгуулалтын харилцан шүтэлцээтэй байдлыг хангаж, тэнцвэржүүлэх ёстой. Энэ нь тэдгээрийн гүйцэтгэх эрх үүрэг, мөн чанартай холбоотой юм. Тухайлбал, Ж.Локк хууль тогтоох засаглал “бусдад зориулсан хууль гаргах” чадвар нь “дээгүүр байх шаардлагатай” учраас тэргүүлж байх ёстой гэж үзсэн¹¹. Харин Ш.Л.Монтескье хууль тогтоох байгууллага бүх ард түмэнд харьяалагдаж, ард олон өөрсдийн эс үйлдэж чадах зүйлээ төлөөлөгчдөөрөө дамжуулан гүйцэтгүүлж, тэнд өөр өөр эрх ашгийг илэрхийлж байдаг гэсэн байна.
3. Эрх мэдлийг харилцан хянах. Ж.Локк парламентад онцгой ач холбогдол өгч хэрэв хуулийг үл ойшоох, зөрчих тохиолдолд гүйцэтгэх эрх мэдэлдээ хариуцлага тооцох санаа тусгасан бөгөөд гүйцэтгэх эрх мэдэл нь парламентын хүсэл зоригийн дагуу өөрчлөгдөж, солигдож болно гэсэн. Эндээс парламент гүйцэтгэх эрх мэдлээ хянах, хариуцлага тооцох бүрэн эрхтэй бөгөөд энэ эрхээ ард олноос авсан гэсэн агуулга харагдана. Энэхүү зарчим Монтескьегийн үзэл баримтлалд илүүтэйгээр тусгалаа олсон байдаг. Түүний үзсэнээр засаглалын салаа мөчрүүд хоорондоо нягт уялдаа хамааралтай байж чиг үүргээ харилцан хуваарилсан, эрх мэдэл тус бүртээ харьцангуй автономи буюу бие даасан байж, харилцан тэнцвэртэй, хяналт тавьсан байхыг чухалчлаад засаглалын салаа мөчрүүд харилцан чиг үүргээ хуваарилж, тэнцвэртэй, хяналт тавьж ажиллахыг анхааруулсан байдаг¹².

Дээрхээс хууль тогтоох эрх мэдлийн байгууллага гүйцэтгэх эрх мэдлийн институтдээ хяналт тавих нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын амин сүнс болох харилцан хянах зарчимд үндэслэсэн байдаг бөгөөд хуулийн хэрэгжилтийг хянах, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг томилох, огцруулах, хариуцлага тооцох зэрэг асуудлуудыг хууль тогтоох эрх мэдэл гэдэгт багтаан ойлгох нь зүйтэй юм.

Парламентын хяналтыг хэрэгжүүлж байгаа олон улсын практик

Хариуцлага, ил тод байдалгүй ардчилсан парламентын систем гэж байдаггүй. Парламент нийт ард түмний өмнөөс хяналтын үүргээрээ дамжуулан гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааг хянах, чиглүүлэх, хариуцлага тооцох, нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бодлого боловсруулан баталж мөрдүүлдэг. Өдгөө дэлхий даяар улсуудын парламент маш олон арга замаар хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж байна. Энэ талаар Хиронори Ямамото 88 улсыг харьцуулан судалгаа хийж парламентын хяналтын гол үйл ажиллагааг дараах байдлаар авч үзсэн байна¹³. Үүнд:

⁸ Д.Болд-Эрдэнэ “Улс төрийн философи” УБ., 2015, 343 дахь тал

⁹ Д.Болд-Эрдэнэ “Улс төрийн философи” УБ., 2015, 343 дахь тал

¹⁰ Ж.Төртогтох “Үндсэн хуулийн политологийн шинжилгээ” УБ., 2010, 54 дахь тал

¹¹ Х.Ганбаатар нарын “Өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх” УБ., 2009, 24 дахь тал

¹² Шарль Моньескье “Хуулийн амин сүнс”, 148 дахь тал

¹³ Hironori Yamamoto “Tools of parliamentary oversight” Switzerland., 2007 /IPU/

- Засгийн газрын хууль бус үйл ажиллагаа, эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, дур зоргоороо авирлах зэрэг байдлыг илрүүлэх, сэргийлэх
- Татвар төлөгчдийн мөнгө санхүүг зарцуулж буй байдлыг хянах, хариуцлага тооцох
- Засгийн газрын мэдээлэл болон парламентаар зөвшөөрсөн хууль, тогтоомжийг батлах. Энэ нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр, хуулийн хүрээнд тавьсан зорилтуудын хэрэгжилтэд мониторинг хийх
- Засгийн газрын ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн Засгийн газарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх

Тэрээр судалгаандаа парламентын хороодын хяналт, танхимын хяналт, омбудсмэний хяналт гэсэн гурван ерөнхий хэсэгт парламентын хяналтыг ангилан судалсан. Омбудсмэн нь парламентын хяналтын институтэжсэн хэлбэр байдаг бол хороод болон танхимын хяналт нь функциональ хэлбэр буюу парламентын өөрийнх нь үндсэн чиг үүрэгт шингэсэн байдаг гэж үзжээ.

Парламентын хороодын хяналт: Энэ нь тухайлсан чиглэл асуудлыг хариуцан хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг үндсэн бүтцийн нэгж байдаг. Хороод нь засгийн үйл ажиллагаанд дангаар хяналт тавих, хуулийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, тухайлсан асуудлаар бие даан шийдвэр гаргах эрхтэй байдаг. Тухайлбал, тусгай асуудлаар мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж болдог. Энэ нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын нийтийн эрх ашгийг хохироосон, улс төрийн шинж чанартай хууль бус үйл ажиллагааг шалгах зорилготой байдаг.¹⁴

Парламентын танхимын хяналт: Засгийн газрын мэдээлэл сонсох, асуулга, асуулт тавих, Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх тухай санал хураалт, Засгийн газрыг огцруулах зэрэг хяналтын арга хэрэгслийг хамааруулан ойлгож болно. Тухайлбал, Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх тухай санал хураалт нь парламентын хяналтын нэг арга хэрэгсэл болдог бөгөөд энэхүү конструктив саналын журмыг тусгасан анхны үндсэн хууль нь ХБНГУ-ын 1949 оны үндсэн хууль билээ.¹⁵ Агуулга нь Засгийн газарт итгэл үл хүлээлгэх санал дэвшүүлэхдээ холбооны Канцлерын албан тушаалд нэр дэвшигчийг нэгэн зэрэг дэвшүүлдэг. Ингэснээр Засгийн газарт итгэл хүлээлгэх эсэх асуудлаарх санал хураалт нь нэгэн зэрэг шинэ холбооны канцлерын сонгууль болдог байна.

Омбудсмэн: Парламентын хяналтыг хэрэгжүүлдэг институтэжсэн хэлбэр бол омбудсмэн юм. Өөрөөр хэлбэл гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа, алдаа зөрчилтэй холбогдох иргэдийн гомдлыг хариуцдаг институт юм. Омбудсмэнийг парламент сонгох буюу парламенттай зөвшилцөн төрийн тэргүүн томилдог бөгөөд ажлын тайлангаа парламентад тавьдаг. Өдгөө дэлхийн 50 гаруй улсад энэхүү тогтолцоог хэрэгжүүлж байна.

Рикардо Пелиззо, Рик Штапенхорст нар “Парламентын хяналтын эмпирик судалгаа” бүтээлдээ 88 улсын парламентын хяналтын асуудлыг дараах гурван хувьсагчаар шинжлэн үзэж хоорондын харилцан хамаарлыг тогтоосон байна.¹⁶

1. Улсуудын засаглалын хэлбэр. Парламентын хяналтын хэрэгсэл ба үр нөлөө нь засаглалын хэлбэрээс ихээхэн хамаардаг. Ерөнхийлөгчийн засаглалын хэлбэрт парламентын хороодод, парламентын засаглалын хэлбэрт парламентын цөөнхөд түшиглэсэн нь их байна. Ерөнхийлөгчийн засаглалын хэлбэрт парламентын олонх өөр намаас сонгогдсон бол хяналт ширүүн байж, заримдаа бие биенээ гацаах нөхцөл үүсдэг бол парламентын засаглалд олонх ба хамтарсан засгаас шалтгаалан хяналт сулрах, олонхоороо давамгайлах боломжтой гэж үзжээ.

¹⁴ Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны төв “Бодлогын судалгаа шинжилгээ” УБ., XII боть, 2012

¹⁵ Ч.Энхбаатар, С.Зульфикар “Гадаад орнуудын төрийн байгуулалт” УБ., 2014, 177 дахь тал

¹⁶ Ricardo Pelizzo and Rick Stapenhurst “Tools for Legislative Oversight: An Empirical Investigation” 2007

2. Орлогын түвшин. Улсуудын орлогын түвшин буурах тутам парламентын сонсгол, хяналтыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь багасч, асуулга, асуултын арга хэрэгслийг ашиглах нь орлогын түвшин өгсөх тутам нэмэгддэг гэж үзсэн байна. Харин омбудсмэний хувьд бага орлоготой улсуудын хувьд ашиглах нь 50% хүртэл багасаж байгааг судалгааны дүнгээрээ харуулжээ.

3. Ардчиллын түвшин. Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын хяналтын арга хэрэгслийн тоо, хэлбэр нь тухайн орныхоо ардчиллын түвшингээс хамаарч илүү ардчилсан орнуудад парламентын хяналтын арга, хэрэгслийн тоо, хэлбэр нь нэмэгдэн сайжирч байна гэжээ.

4.

Монгол дахь парламентын хяналт, түүнийг хэрэгжүүлэх боломж

Төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл тэдгээрийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, эрх хэмжээ нийтлэг ба онцлог шинж, хоорондынх нь харилцаанд баримтлах зарчим, үндсэн чиглэл зэргийг Монгол улсын Үндсэн хуулиар тогтоосон.

Монгол улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заасан байдаг. Тодруулж хэлбэл, Улсын Их Хурал нь тус орны дээд жолоодлогын гол зангилаа, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тогтоож, нийгмийн дээд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бөгөөд түүний онц бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг батлах өөрчлөх асуудал хамаарна¹⁷. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд: “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах”, “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” зэргийг Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамааруулсан. Б.Чимид асан “Онцгой бүрэн эрх гэдэг бол ач холбогдолтой онцгой гэдэг ач холбогдолтой үг. Энэ бол бусад байгууллага шийддэггүй асуудлыг хэнтэй ч хуваалцдаггүй нь онцгой гэж байгаа юм гэсэн. Эндээс үзвэл Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг өөр бусад байгууллагад даалган хэрэгжүүлэх боломжгүй юм.¹⁸ Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд: “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” гэж заасан нь Монгол дахь парламентын хяналтын асуудлыг судлах суурь үндэс болж байгаа юм.

Хууль тогтоох эрх мэдэл дан ганц хууль санаачлах хийгээд батлах хүрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд Засгийн газрыг бүрдүүлэх болон бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах, Засгийн газар болон төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагааг хянах (асуулга асуух, буруушаасан тогтоол гаргах, үл итгэхээ илэрхийлэх, сайд нарыг чөлөөлөх, Засгийн газрыг огцруулах зэрэг хэлбэрээр хэрэгжинэ) зэрэг бүрэн эрхүүдийг багтаасан ойлголт юм.¹⁹ Өөрөөр хэлбэл парламентын хяналт нь хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн агуулга, үүрэг болох юм. Үүнийг хураангуйлбал, хууль тогтоох үйл ажиллагаа=хууль гаргах+биелэлтийг хянаж, шалгах хоёрын нийлбэр гэж бүдүүвчилж болно²⁰ гэжээ.

Парламентын засаглалтай улсын парламентыг үндсэндээ хязгааргүй бүрэн эрхтэй төрөлд хамааруулж үздэг бөгөөд үүнд дараах эрх хамаарна:

- Хууль тогтоох эрх гагцхүү парламентад байдаг
- Улсын төсвийг баталж, татвар тогтоодог

¹⁷ Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар “Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй” УБ., 2000, 147 дахь тал

¹⁸ П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015, 114 дэх тал

¹⁹ Д.Лүндээжанцан “Эрх мэдэл ба ардчилал” УБ., 2015, 18 дахь тал

²⁰ Б.Чимид “Парламентын хяналт, шалгалтыг төгөлдөржүүлэх нь” илтгэл УБ., 2010

- Засгийн газар нь парламентад тайлагнаж, ажлаа хариуцдаг
- Шүүгчдийг баталдаг
- Хяналтын чиг үүрэг гүйцэтгэдэг. Энэ бүх шинж манай Улсын Их Хуралд бий²¹.

Манайд Үндсэн хуулиар парламентын хяналт шалгалт хийх бүрэн эрхийг ерөнхий байдлаар тодорхойлсон боловч хуульчлан тодорхойлсноос үзвэл Улсын Их Хурлын хяналт шалгалтын объект нь Засгийн газар болон Улсын Их Хурлаас томилогдсон, түүнд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын үйл ажиллагаа байна²². Харин парламентын хяналтыг хэрэгжүүлэгч субъект нь парламент өөрөө бөгөөд түүнийг дараах байдлаар ангилан үзэж болох юм. Үүнд:

- Улсын Их Хурлын гишүүн: Монтескье “Хуулийн амин сүнс” бүтээлдээ: “...ард олон өөрсдийн эс үйлдэж чадах зүйлээ төлөөлөгчдөөрөө дамжуулан гүйцэтгүүлдэг байх шаардлагатай” гэжээ. Манай Үндсэн хуулийн 23 дугаар зүйлд “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж заасан. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын гишүүн нь нийт иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэгч болохын хувьд парламентын хяналтыг хэрэгжүүлэгч субъект болох юм.
- Байнгын болон дэд, түр хороод: Парламентын бүтэц, зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь байнгын болон дэд хороод байдаг бөгөөд Улсын Их Хурал энэхүү бүтцээрээ дамжуулан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой. Энэ тухай Үндсэн хуулийн 28 дугаар зүйлд “...Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавьбал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэж туссан.
- Гишүүдийн бүлэг буюу ажлын хэсэг: Улсын Их Хурал, байнгын болон дэд, түр хорооноос байгуулагдсан ажлын хэсэг буюу “гишүүдийн бүлэг” хэлбэрээр байж болно. Мөн УИХ дахь намын бүлгийг хамааруулна.
- Улсын Их Хурал: Парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд гол объект нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага байдаг ба энэ нь ихэнхдээ улс төрийн шинжтэй хяналт юм.²³ Өөрөөр хэлбэл Засгийн газар үйл ажиллагааныхаа төлөө нийт ард түмний төлөөллийн байгууллага парламентын өмнө улс төрийн хариуцлага хүлээдэг. Манай Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 6, 8 дахь хэсгүүдэд энэ тухай тусгасан.

Монгол дахь парламентын хяналтын хэлбэр, арга хэрэгсэл: Парламент хяналтын чиг үүрэг, хариуцлага тооцох механизмаа хэрхэн хэрэгжүүлэхээс хууль тогтоох эрх мэдлийн автономит байдал, гүйцэтгэх засаглалын чанар, дэг журам цаашлаад төрийн шударга, ил тод хариуцлагатай байдал, хууль, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх ардчиллын үнэт зүйлс хамаарах нь дамжиггүй. Үүний тулд парламент уг үүргээ хэрэгжүүлэх сонирхол, хүсэл эрмэлзэлтэй байж, түүнийг биелүүлэх сайн тогтолцоо, арга механизмыг бүрдүүлэх нь чухал юм. Улсын Их Хурал дараах хэлбэрээр хяналтаа хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны тайлан мэдээлэл сонсох, хэлэлцэх: Энэ нь хууль, бусад шийдвэрийн хэрэгжилтийн байдал, цаг үеийн мэдээллийг чуулганы хуралдаанаар сонсох, үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг сайн талтай ч зөвхөн мэдээлж, сонсох төдийхнөөр хязгаарлагддаг сул талтай.

²¹ Б.Дэлгэрмаа “Парламентын засаглал, хууль тогтоох бүрэн эрх ба УИХ” “Шинэ толь сэтгүүл” УБ., 1999

²² П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015, 117 дахь тал

²³ Б.Дэлгэрмаа “Парламентын засаглал, хууль тогтоох бүрэн эрх ба УИХ” “Шинэ толь сэтгүүл” УБ., 1999

- Асуулга, асуулт тавих: Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдэд асуулга, асуулт тавих, түүний хариуг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх. Энэ нь нэлээн түгээмэл хяналтын хэлбэр юм. Асуулга, асуулт хоёр нь хоорондоо зарчмын ялгаатай байдаг.
- Байнгын хороодоор дамжуулан хяналт тавих: Энэ нь тодорхой нийгмийн бодлогын салбар хариуцсан байнгын хороод хяналтын чиг үүргийг гүйцэтгэж байгаа хэлбэр бөгөөд түгээмэл арга, хэлбэрт тооцогдоно.
- Тусгайлсан байнгын хяналтын хороодоор хэлэлцүүлэх, дүгнэлт гаргах: Энэ нь байнгын хорооны дэргэд тусгайлсан хяналтын дэд хороодыг байгуулж тодорхой асуудлаар үнэлэлт, дүгнэлт өгөх хэлбэр юм. Тухайлбал, төсвийн байнгын хорооны дэргэд төсвийн зарлагын дэд хороо, хууль зүйн байнгын хорооны дэргэд хүний эрхийн дэд хороо зэргийг ажиллуулж, парламент дахь цөөнхийн гишүүнээр даргалуулах, шууд хяналт хийх эрхийг олгосноороо ихээхэн давуу талтай байна.
- Итгэл үзүүлэх эсэх тухай санал хураах: Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд “Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал...” Улсын Их Хурал шийдвэрлэхээр заасан боловч Засгийн газрын өөрийнх нь бүрэн эрхийн хүрээнд хамааруулсан байдаг. Энэ тухай зарим судлаачид “конструктив механизмыг манай Үндсэн хуульд авч хэрэглээгүй байна... конструктив механизм суулгаагүйн улмаас Ерөнхий сайдыг огцруулах, шинэ Ерөнхий сайдыг сонгох хооронд хугацаа алдаж гүйцэтгэх эрх мэдлийн тасралтгүй байдал алдагдаж байсан гашуун туршлага манайд бий. Тухайлбал, 1998 онд Ц.Элбэгдоржийн засгийн газар огцорч, шинэ ерөнхий сайдаа томилж чадалгүй удсаар зургаан сар болсон тохиолдол бий”²⁴ гэсэн байна.
- Засгийн газрыг огцруулах: Парламентын өмнө Засгийн газар үйл ажиллагааныхаа төлөө улс төрийн хариуцлага хүлээдэг ба энэ талаар манай Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд: “Ерөнхий сайд хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах” гэж туссан.

Улсын Их Хурал парламентын хяналтыг хэрэгжүүлэхдээ мэдээлэл сонсох, хэлэлцэх, асуулга, асуулт тавих, байнгын хороо болон дэд, түр хороод дээр сонсгол хийх, хариуцлага тооцох зэрэг арга хэрэгслийг ашиглаж байна. Ер нь парламентын хяналтын арга хэрэгсэл ба үр нөлөө нь тухайн улсын засаглалын хэлбэр, улс төрийн соёл, улс төрийн намын төлөвшил зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Парламент дахь олонх ба цөөнхийн хүчний харьцаа Улсын Их Хурал, Засгийн газрын харилцааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл цөөнх, сөрөг хүчинд эрх мэдэл илүү олгох замаар хяналтыг хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байдаг.

Монголд шинэ Үндсэн хууль батлагдан, ардчилсан засаглал, парламентат ёс төлөвшиж эхэлснээс хойш даруй 30 жил өнгөрч, найм дахь үеийн парламентын нүүрийг үзэж байна. Энэ хугацаанд парламентын хяналт түүнийг хэрэгжүүлэх хэлбэр, арга хэрэгслүүдийг тодорхой хэмжээнд тодорхойлж, эрх зүйн орчин боломжийн түвшинд бүрдсэн байгаа ч түүнийг хэрэгжүүлэх улс төрийн сонирхол, хүсэл эрмэлзэл хангалтгүй байсаар байна. Судлаачид Улсын Их Хурлын хяналт, шалгалтын байдалд шүүмжлэлтэй хандаж, хяналтын талаарх ойлголт, чадавхи сул байгааг тэмдэглэсээр ирсэн. Тухайлбал, “...мэдээ тайлан сонсох, асуулт тавихаас өөр тогтмол механизм бараг байхгүй байна”²⁵ гэж үздэг. Өөрөөр хэлбэл парламентын хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, арга механизмыг улам боловсронгуй болгох, парламентын автономи байдлыг хангах асуудал чухлаар тавигдсаар байна.

²⁴ О.Машбат “Үндсэн хууль: улс төр-эрх зүй, хяналт-тэнцэл” УБ., 2015, 161 дэх тал

²⁵ “Монгол улсад Ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ” УБ., 2015, 33 дахь тал

Монголд парламентын хяналтыг сайжруулах ямар арга зам байна вэ?

Манайд парламентын хяналтыг хэрэгжүүлэх улс төрийн сонирхол, санаачилга хангалтгүй, хэлбэр төдий байгаа нь парламентад суудалтай улс төрийн хүчнүүдийн бодлого, үйл ажиллагаа, намын лидерүүдийн идэвхи, оролцоо, улс төрийн соёл, иргэд олон нийтийн оролцоо дутмаг гэх зэрэг хүчин зүйлээс хамаарч байна. Тухайлбал, Улсын Их Хуралд аль нэг улс төрийн хүчин олонхи болж дангаар Засгийн газрыг бүрдүүлэн ажиллахдаа УИХ-ын гишүүний болон Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албыг давхар хаших, ингэхдээ ялсан намын дарга Ерөнхий сайд, тухайн намын бусад лидерүүд Засгийн газарт орж ажиллан парламент дахь намын бүлгээрээ уламжлан Улсын Их Хурал, олонхийн гишүүдийг хяналтдаа байлгаж, улмаар парламентын хяналтыг хэлбэр төдий байлгах улс төрийн нөхцөл манайд байсаар байна. Ийм нөхцөлд “Сөрөг хүчин”-ий үйл ажиллагаа, бодлогоос ихээхэн зүйл хамаарна.

Улсын Их Хурлын стратеги, төлөвлөгөөнд туссан үндсэн зорилтод парламентын хянан шалгах, үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлнэ гэж заасан байдаг. Энэ хүрээнд дараах асуудлыг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

- **Парламент, түүний гишүүдийг хариуцлагажуулах:** Парламентын хяналтыг ашиглах улс төрийн нам, улс төрчдийн хүсэл зоригийг төрүүлэх нь хамгаас чухал. Үүний тулд Улсын Их Хурал өөрөө сахилга баттай байж, парламентад ёс, улс төрийн соёлыг төлөвшүүлэх, Улсын Их Хурлын гишүүдэд хяналтын чиг үүргийн ач холбогдлыг тайлбарлан таниулах шаардлага тулгараад байна.
- **“Сөрөг хүчин” буюу цөөнхөд хяналтын давуу эрх олгох:** Цөөнхийн эрхийг хүндэтгэх, тэдний байр суурийг бэхжүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоо төлөвшүүлэх шаардлагатай. Парламентад олонхи болсон улс төрийн хүчин ихэнхидээ гүйцэтгэх засаглалыг толгойлсон намын дарга, лидерүүдээ сахилга баттайгаар захирагддаг бөгөөд ийм тохиолдолд парламентын хяналт сулрах, идэвхигүй, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх сонирхолгүй байх нь ажиглагддаг. Иймд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд сөрөг хүчний оролцоо, боломжийг нэмэгдүүлэх нь ач холбогдол өндөртэй юм. Тухайлбал, ХБНГУ-ын Гамбург мужийн Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн “А” дахь хэсэгт дараах хоёр заалтыг оруулжээ. Үүнд:
 - ✓ Парламентад ёсны салшгүй нэг чухал хэсэг нь сөрөг хүчин мөн
 - ✓ Сөрөг хүчин нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг үндсэн асуудлаар шүүмжлэх, зарим талаар олон нийтийг төлөөлөх байнгын үүрэг, зорилттой байна²⁶ гэжээ.

Мөн “Сүүдрийн Засгийн газар” хэмээх ойлголтыг энд багтаан ойлгох хэрэгтэй. Энэ нь улс төрийн бодлого боловсруулж ард түмэнд хүргэхийн тулд “Сөрөг хүчин”-ий байгуулдаг институт юм. Тухайлбал, Англид сөрөг хүчний хамгийн том намын дарга нь сүүдрийн Ерөнхий сайд болж тус намаас парламентад сонгогдсон гишүүдээс “Сүүдрийн Засгийн газар”-ыг бүрдүүлж, эрх барих хүчний байгуулсан албан ёсны Засгийн газрын бодлоготой санал нийлэхгүй асуудлуудын талаар өөрсдийн байр суурийг илэрхийлж, бодлого боловсруулан ажилладаг байна. Англид ийм институтдээ зориулж төсөв баталж, тусгай өрөө тасалгаагаар хангадаг²⁷ ажээ.

- **Хяналтын үйл ажиллагаанд “Олон нийтийн оролцоо”-г хангах:** Иргэд олон нийтэд парламентын хяналтын ач холбогдлыг сурталчлан таниулах, тэдний дэмжлэгийг авах нь туйлаас чухал. Олон нийтийн санал бодолд тулгуурлан Засгийн газрын бодлого үйл ажиллагааг хэлэлцэн хяналтыг явуулах нь гүйцэтгэх эрх мэдэлд ил тод, нээлттэй байдлыг бий болгоно. Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөнд парламентын

²⁶ Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан “Парламентад ёс” УБ., 2005, 88 дахь тал

²⁷ [mn.wikipedia.org > wiki > : “Сүүдрийн Засгийн газар”](http://mn.wikipedia.org/wiki/Сүүдрийн_Засгийн_газар)

хяналтыг сайжруулах урт хугацааны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “...Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын үйл ажиллагааг илүү ил тод, нээлттэй болгох”²⁸ тодорхой заалтууд туссан байгаа нь сайшаалтай. Мөн энэ хүрээнд “Нээлттэй сонсгол”-ыг парламентын хяналтад түлхүү ашиглах нь чухал ач холбогдолтой. Манайд “Нийтийн нээлттэй сонсголын тухай хууль” батлагдсан байгаа боловч туйлын чамлахаар хэрэгжилттэй байна.

- **Парламентын “Мөрдөн шалгах” эрх:** Парламент өөртөө мэдээлэл олж авах хамгийн хүчтэй хэрэгсэл болдгоороо онцлогтой. Энэ нь тодорхой асуудал дээр илүү гүнзгий дүн шинжилгээ хийхэд зориулагддаг бөгөөд нийгмийн ач холбогдол бүхий маргааныг талууд хамтран сонсож, мэдээлэл аван, шийдвэр гаргахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Макс Вебер “Парламентын гишүүд бол мэдээллийг бүрэн авч байх эрхтэй ард түмний төлөөлөгчид. Гэвч бодит байдал дээр Засгийн газар тэдэнд мэдээллийг бүрэн өгдөггүй. Гэрчийг сонсож, нотлох баримт цуглуулах эрх бүхий парламентын мөрдөн шалгах хороог байгуулах нь гишүүд эрхээ эдлэх чухал механизм юм”²⁹ гэж үзсэн байдаг. Судлаачид мөрдөн шалгах эрх мэдлийг Ерөнхийлөгчийн засаглалтай улсад байнгын хороонд, парламентын засаглалтай үед цөөнхөд эрхийг нь өгвөл илүү үр дүнтэй гэж үздэг байна. Парламентын мөрдөн шалгах эрх мэдэлд хоёр үндсэн загвар байдаг.³⁰
- АНУ-ын загвар. Байнгын хорооддоо голчлон түшиглэдэг
- ХБНГУ-ын загвар. Цөөнхийн эрхэд үндэслэн, парламентын нэгдсэн чуулганаас эрх мэдэл авсан түр хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг.

Дүгнэлт

Хууль тогтоох эрх мэдлийн салшгүй нэг хэсэг нь парламентын хяналтын асуудал бөгөөд төрийн эрх мэдэл хуваарилах онолын харилцан хяналтын зарчимд нийцэж буй юм. Ардчилсан Үндсэн хуульт улс бүрийн парламентад энэхүү хяналтын асуудлыг онцгойлон үздэг. Өөрөөр хэлбэл, парламентын автономи байдал хангагдаж, гүйцэтгэх засаглалаас хараат бус байх нөхцөл бүрдэнэ. Парламент нь нэгдүгээрт нийт ард түмний төлөөлөл, хоёрдугаарт хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг тул нийт ард түмнийг төлөөлөн Засгийн газрын үйл ажиллагаа, бодлого, хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих нь зүй ёсны асуудал бөгөөд парламентын хяналтын үзэл санааны үндэс эндээс харагддаг. Өөрөөр хэлбэл, ард түмний төлөөлүүлсэн эрх мэдлийг парламент л хэрэгжүүлдэг.

Судлаачид парламентын хяналтыг институтэжсэн, мэргэжлийн хэлбэрээр зохион байгуулах нь илүү үр дүнтэйг тэмдэглэсэн байдаг. Энэ ч утгаараа Монголд парламентын институтэжсэн хэлбэр, хороодын хяналтыг сайжруулах, арга механизм, цөөнхийн эрхийг хамгаалах асуудал чухлаар тавигдаж байна. Мөн парламентын хяналтын хэрэгслүүдийн хувьд улс орнуудыг харьцуулж үзэхэд засаглалын хэлбэрээрээ парламентын засаглал бүхий улсуудынх, орлогын түвшингээр нь үзэхэд дундаж улсуудынх илүү, ардчиллын түвшингээр нь авч үзвэл ардчилсан байх тусмаа илүү олон янзын хяналтын арга хэрэгсэлтэй байгаа нь харагдсан. Харин манай улсын хувьд эдгээр үзүүлэлтээр дундаж түвшинд байгаа боловч Улсын Их Хурлын хяналтын арга, хэрэгслийг судлаачид хэлбэр төдий, асуух, сонсохоос хэтрэхгүй, парламент өөрөө хяналтаа хэрэгжүүлэх сонирхолгүй байдаг зэрэгтэй холбон үздэгийг дурдах нь зүйтэй.

Монголд парламентын хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн боловч түүнийг хэрэгжүүлэх сонирхол дутмаг, нарийн зохицуулсан

²⁸ УИХ-ын Тамгын газрын судалгааны төв “Бодлогын судалгаа, шинжилгээ” XII боть УБ., 2012

²⁹ www.niidelch.mn Х.Тэмүүжин “Парламентын мөрдөн шалгах эрх мэдэл” өгүүлэл, 2014

³⁰ Мөн тэнд

арга, механизм байхгүй, хамгийн гол нь сөрөг хүчний энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжсэн хөшүүрэг, зохицуулалт туйлын хангалтгүй байсаар байна. Мөн парламентад олонхын суудал авсан улс төрийн хүчин, намын бодлого, үйл ажиллагаа ихээр нөлөөлж байгаа юм. Сөрөг хүчинд хяналтын чиг үүргийг давуу байдалтай олгох, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг авах улс төрийн болон эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага тулгараад байна. Мөн парламентыг өөрийг нь хариуцлагажуулах, хяналтыг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний дэмжлэгийг авах, “нээлттэй сонсгол”-ыг тогтмолжуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах нь туйлаас чухал. Эцсийн дүндээ Засгийн газрын үйл ажиллагааг хянах, залан чиглүүлэх, хариуцлага тооцох үндсэн арга механизм бол парламентын хяналтыг хэрэгжүүлэх явдал бөгөөд шударга, ил тод, нээлттэй, хариуцлагатай Ардчилсан төрийн үндсийг бүрдүүлэхэд чухал хөшүүрэг болох юм.

Abstract: One of the legislative power or its significant element is a parliamentary oversight issue and the implementation is being implemented in various methods or forms depending on the state governance form, economic, and democracy index. Monitoring an institution for executive power from parliament is based on a mutual monitoring principle for the theory of sovereignty and conformed with them. Therefore, the research paper has determined the current state of parliamentary oversight in Mongolia, the implementation forms, and readjustments as well as studied a legal framework for implementation, potential, and the political state. Improving the parliamentary oversight effects and accomplishing the methods or the mechanism is to be significant results for the parliamentary autonomy and the parliamentary democracy. Key words: legislative power, parliament, oversight, monitoring, and opposition

Ашигласан материал

1. Ж.Төртогтох “Үндсэн хуулийн политологийн шинжилгээ” УБ., 2010
1. Д.Лүндээжанцан “Эрх мэдэл ба Ардчилал” УБ., 2015
2. П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй, Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015
3. Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” УБ., 2010
4. О.Машбат “Үндсэн хууль: улс төр-эрх зүй, хянал-тэнцэл” УБ., 2015
5. Д.Болд-Эрдэнэ “Улс төрийн философи” УБ., 2015
6. Шарль Монтескье “Хуулийн амин сүнс” орчуулга
7. Х.Ганбаатар нарын “Өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх” УБ., 2009
8. Ч.Энхбаатар, С.Зульфикар “Гадаад орнуудын төрийн байгууламж” УБ., 2014
9. “Шинэ толь” сэтгүүл, Б.Дэлгэрмаа “Парламентын засаглал, хууль тогтоох бүрэн эрх ба УИХ” УБ., 50 дахь тал, 1999
10. Д.Лүндээжанцан “Монгол дахь төрийн эрх мэдэл хуваарилал” УБ., 2001
11. Б.Чимид “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь” илтгэл, 2010
12. Улсын Их Хурлын Тамгын газар “Бодлогын судалгаа, шинжилгээ” XII боть, УБ., 2012
13. Х.Номингэрэл “Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх механизм, бусад орнуудын жишиг, Монгол Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг боловсронгуй болгох асуудал” ,“Байнгын ажиллагаатай Парламент 25 жил” ЭШХЭ УБ., 2015
14. Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар “Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй”, 2000
15. www.niitlelch.mn Х.Тэмүүжин “Парламентын мөрдөн шалгах эрх мэдэл” өгүүлэл, 2014
16. Монгол Улсын Үндсэн хууль., 1992

17. Hironori Yamamoto "Tools of parliamentary oversight" Switzerland., 2007 /IPU/
18. Ricardo Pelizzo and Rick Stapenhurst "Tools for Legislative Oversight: An Empirical Investigation" 2000

МОНГОЛ УЛС ДАХЬ СОНГУУЛИЙН ЗАРИМ ТООН ӨГӨГДЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Д.Ундрах

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор

Б.Эрдэнэдалай

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор

Хураангуй:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улсад болж өнгөрсөн ардчилсан сонгуулиудын үр дүн, холбогдох мэдээллүүд сонгогчид, судлаачдад ил тод, нээлттэй байдлаар Сонгуулийн Ерөнхий Хороо, Үндэсний Аудитын Газар, Үндэсний Статистикийн Хороо зэрэг байгууллагуудын албан ёсны сайт дээр байгаа эсэхийг судлан харьцуулалт хийсэн болно.

Түлхүүр үг: Сонгуулийн дүн, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн зардлын тайлан, сонгуулийн өгөгдөл

Оршил:

Монгол Улс 1990 онд ардчилалд шилжсэнээс хойш ардчилсан шинэчлэлээ өрсөлдөх чадвартай, олон нам бүхий улс төрийн тогтолцоог бий болгох, эрх, эрх чөлөөг нэмэгдүүлэх чиглэлд тогтвортой хадгалсан. Монголд улс төрийн тогтворгүй байдал болон авлигын түвшин нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд ардчиллын үндсэн институцэд итгэх итгэл алдарч байгааг, мөн Монголын сонгогчдын улс төрийн намуудад таагүй хандаж байгааг Улс төрийн барометр¹ 2010-2021 оны судалгааны дүнгүүдээс харж болохоор байна.


1992 оноос хойш УИХ-ын, ерөнхийлөгчийн, орон нутгийн тус бүр 8 удаагийн сонгууль явагдсан. Сонгуулиас сонгуульд сонгогчдын ирц, оролцоо буурах, сонгуулийг үл тоох хандлага нэмэгдэх болсон. Ялангуяа орон нутгийн сонгуулийн ирц хүрэхгүй байх явдал давтагддаг, дахин сонгуулийг олон удаа хийж байсан. Мөн сонгууль, сонгуулийн тогтолцоо, сонгогчдын үйл байдлын судалгааг хийхдээ ихэвчлэн УИХ болон ерөнхийлөгчийн сонгуулийг судалдаг, орон нутгийн сонгуулийн талаарх мэдээлэл, судалгаа ховор байдаг зэрэг нь энэхүү судалгааг хийхэд хүргэсэн юм.

Монгол Улсад болж өнгөрсөн ардчилсан сонгуулиудын үр дүн, холбогдох мэдээллүүд сонгогчид, судлаачдад ил тод, нээлттэй байдлаар Сонгуулийн Ерөнхий Хороо, Үндэсний Аудитын Газар, Үндэсний Статистикийн Хороо зэрэг байгууллагуудын албан ёсны сайт дээр байгаа эсэхийг судлан харьцуулалт хийсэн болно. Ингэхдээ сонгуулийн дүн, мэдээллийг олохын тулд Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ), Үндэсний Аудитын газар (ҮАГ), Улс төрийн намуудын сайт зэрэг боломжит мэдээллийн платформууд дээр хайлт хийж эхэлсэн.

¹ Уг судалгаагаар иргэдийн улс төрийн намд итгэхгүй байдал 2010-2016 оны дундаж 58 хувьтай байсан бол 2016-2021 оны дундаж 65.57 хувь болж улам нэмэгдсэн байна. www.santmaral.mn

Сонгуулиудын мэдээллийн нээлтэй байдал

Зураг 1. СЕХ-ны сайт дээр байгаа сонгуулиудын мэдээллүүд



СЕХ-ны сайт дээр УИХ-ын, Ерөнхийлөгчийн, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гэсэн гурван сонгуулийн дүн, мөрийн хөтөлбөр, гишүүд, зардал гэсэн бүтэц бүхий гурван цэс байна. Гэхдээ тухайн цэсүүд дээрх сонгууль бүрийн дүн сонгогчид болон судлаачдад нээлттэй бус, үр дүнг нэгтгэн харьцуулалт хийх, судлах боломжгүй байгааг дараах зургуудаас харж болно.

Зураг 2. УИХ-ын сонгуулийн дүн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ДҮН (6 дугаар тойрог, Дорноговь, Говьсүмбэр аймаг, Сум, нэр дэвшигч түс бүрээр)																					
Үзүүлэлт		СУМД																		ДҮН	Намын харьяалал
		Баянгол	Сүхбэр	Шөвхонь	Сайнцаглан	Ардшар	Баянхураглан	Говь-Уулал	Гуравсайхан	Дэлгэрэнгүй	Дэлгэрсүт	Даран	Луус	Өлзийт	Өндөршил	Сайхан-Овоо	Хулд	Цагаанцайр	Эрдэнэцагай		
Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо		719	7658	2098	10056	1862	818	1031	1421	1479	1100	1382	1269	1619	968	1431	1561	678	3710	40860	
Санал хураалтад оролцсон сонгогчдын тоо		хувиар	507	5697	1593	6999	1122	611	682	824	1002	791	879	836	1037	744	947	953	496	2333	28053
		хувь	70.51	74.39	75.93	69.60	60.26	74.69	66.15	57.99	67.75	71.91	63.60	65.88	64.05	76.86	66.18	61.05	73.16	62.88	68.66
Санал огт тэмдэгтэйгүй саналын хувьд		хувиар	0	10	3	19	3	2	0	2	1	0	1	1	3	1	0	1	5	53	
		хувь	0	0.176	0.188	0.27	0.267	0.327	0	0.243	0.1	0	0.114	0.12	0.289	0.134	0	0.105	0.20	0.21	0.19
1	Сүхбаатарын БАТ-ОД	хувиар	248	2954	924	3731	545	329	294	411	420	394	559	325	366	449	399	406	247	1129	14091
	хувь	48.92	51.85	59.00	53.31	48.57	53.85	43.11	49.88	41.82	49.81	63.59	39.68	34.33	60.35	38.67	42.60	48.90	48.39	50.23	
2	Гомлирдоогийн МОНХЦЭЦЭГ	хувиар	257	2719	862	2138	314	264	196	311	332	219	329	227	169	273	265	290	168	820	10175
	хувь	50.69	47.73	54.11	30.55	27.99	43.21	29.03	37.13	37.33	27.69	37.43	27.15	16.30	36.69	27.98	30.43	37.90	35.15	36.27	
3	Батхуулийн НАРАНХУЙ	хувиар	151	1501	451	2047	413	179	269	181	400	312	232	316	631	240	439	404	205	809	9180
	хувь	29.78	26.35	28.31	29.25	35.81	29.30	39.44	21.97	39.92	39.44	26.39	37.80	60.85	32.26	46.36	42.39	41.33	34.68	32.72	
4	Лувсандоржийн ӨДСЭСР	хувиар	191	2390	545	1091	256	165	195	125	263	194	92	290	274	122	255	205	134	615	7402
	хувь	37.67	41.95	34.21	15.59	22.82	27.00	28.59	15.17	26.25	24.53	10.47	34.69	26.42	16.40	26.93	21.51	27.02	26.36	26.39	
5	Гаадангийн БАТБААТАР	хувиар	2	37	9	38	8	5	6	9	6	10	6	5	10	7	7	4	14	188	
	хувь	0.39	0.649	0.565	0.54	0.713	0.818	0.88	1.092	0.60	1.264	0.683	0.60	0.482	1.344	0.739	0.735	0.81	0.60	0.67	
6	Цэцэгэгийн МОНХБАЯР	хувиар	27	281	86	547	76	33	34	73	61	34	32	46	34	63	259	53	28	88	1855
	хувь	5.33	4.932	5.40	7.82	6.774	5.40	4.985	8.859	6.088	4.30	3.641	5.90	3.279	8.468	27.35	5.561	5.65	3.77	6.61	
7	Дэншэрэнгийн ЭНХБАЯРХАН	хувиар	12	95	19	99	13	8	5	13	4	9	5	3	3	11	6	2	21	334	
	хувь	2.37	1.668	1.193	1.41	1.159	1.309	0.733	0.85	1.30	0.506	0.455	1.077	0.289	0.40	1.162	0.63	0.40	0.60	1.19	
8	Оорын ГАНБАТ	хувиар	53	502	102	1843	362	108	191	197	226	204	258	195	161	145	219	98	686	5802	
	хувь	10.45	8.81	8.40	26.33	32.26	17.68	21.01	23.91	22.55	25.79	27.30	30.86	18.80	21.64	15.31	22.98	19.76	29.92	20.68	
9	Ороолонгийн ЭРДЭНЭТӨГС	хувиар	13	112	27	710	107	23	27	88	80	58	58	62	48	62	23	48	9	212	1765
	хувь	2.56	1.966	1.695	10.14	9.537	3.764	3.959	10.68	7.984	7.332	6.371	6.714	4.629	8.333	2.429	5.037	1.81	9.09	6.29	
10	Баатарын АРВИНБАЯР	хувиар	3	97	5	168	12	1	4	16	21	13	11	9	10	5	9	11	2	29	426
	хувь	0.59	1.703	0.314	2.40	1.07	0.164	0.587	1.942	2.10	1.643	1.251	1.077	0.964	0.672	0.95	1.154	0.404	1.24	1.52	
11	Цэрэнвангийн ЭРДЭНЭБАТ	хувиар	0	6	3	10	1	2	2	1	1	1	4	0	0	0	3	2	0	2	38
	хувь	0	0.105	0.188	0.1	0.089	0.327	0.293	0.121	0.10	0.126	0.455	0	0	0	0.317	0.21	0	0.09	0.14	
12	Эрдэнэцогтын БАТЧИМЭГ	хувиар	1	90	1	21	5	2	3	4	1	2	0	3	3	4	0	2	1	2	64
	хувь	0.20	0.158	0.063	0.30	0.446	0.327	0.44	0.485	0.10	0.253	0	0.359	0.289	0.538	0	0.21	0.20	0.09	0.23	
13	Наранцралтын СОЕМБО	хувиар	48	625	132	1467	117	96	133	207	171	131	189	113	335	90	105	242	68	210	4479
	хувь	8.47	10.97	8.296	20.96	10.43	15.71	19.50	25.12	17.07	16.56	21.50	13.52	32.30	12.10	11.09	25.39	13.71	10.90	15.97	
14	Пүрэжсүрэнгийн ЭНХБАЯР	хувиар	8	46	1	50	9	3	4	14	6	8	2	6	4	9	4	7	4	201	
	хувь	1.58	0.807	0.879	0.71	0.80	0.491	0.44	1.70	0.70	0.759	0.228	0.716	0.482	0.538	0.422	0.944	0.81	0.30	0.72	

СЕХ-ны сайт дээрх Монгол Улсын Их Хурлын сонгууль гэсэн цэс дээр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн 1992-2020” гэсэн файл байгаа боловч судлаачдад нээлттэй, боловсруулан анализ хийх боломжтой өгөгдөл биш .pdf өргөтгөлтэй байлаа. СЕХ болон УАГ-ын сайт дээрх УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын сонгуулийн зардлыг харьцуулан судлах боломжтой өгөгдлүүд .pdf өргөтгөлтэй байна.

Зураг 3. Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ДҮН /Аймаг, нийслэл, сум, дүүрэг, дүүргийн хэсэг тус бүрээр/														
Дугаар	Сумын нэр	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Санал өгсөн сонгогчийн		Нэр дэвшигчдэд өгсөн саналын		Үүнээс						Санал огт тэмдэглээгүй саналын хуудасны	
			тоо	хувь	тоо	хувь	У. Хүрэлсүхийн төлөө өгсөн саналын		С.Эрдэнийн төлөө өгсөн саналын		Д.Энхбатын төлөө өгсөн саналын		тоо	хувь
							тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь		
АРХАНГАЙ														
1	Батцэнгэл	2471	1470	59.49	1442	98.10	1119	76.12	212	14.42	111	7.55	28	1.90
2	Булган	1786	1054	59.01	1008	95.64	797	75.62	105	9.96	106	10.06	46	4.36
3	Жаргалант	2767	1620	58.55	1524	94.07	1181	72.90	227	14.01	116	7.16	96	5.93
4	Ихтамир	3595	1649	45.87	1617	98.06	1284	77.87	196	11.89	137	8.31	32	1.94
5	Өгийнуур	2052	1134	55.26	1099	96.91	795	70.11	207	18.25	97	8.55	35	3.09
6	Өлзийт	2197	1396	63.54	1362	97.56	1024	73.35	229	16.40	109	7.81	34	2.44
7	Өндөр-Улаан	3774	2260	59.88	2207	97.65	1601	70.80	406	17.96	200	8.85	53	2.35
8	Тариат	3252	1953	60.06	1839	94.16	1306	66.87	280	14.34	253	12.95	114	5.84
9	Төвшрүүлэх	1921	1121	58.36	1092	97.41	857	76.45	154	13.74	81	7.23	29	2.59
10	Хайрхан	2491	1635	65.64	1612	98.59	695	42.51	899	54.98	18	1.10	23	1.41
11	Хангай	2090	1363	65.22	1333	97.80	926	67.94	336	24.65	71	5.21	30	2.20
12	Хашаат	2087	981	47.01	963	98.17	767	78.19	109	11.11	87	8.87	18	1.83
13	Хотонт	2988	1444	48.33	1415	97.99	1045	72.37	256	17.73	114	7.89	29	2.01
14	Цахир	1513	1023	67.61	962	94.04	619	60.51	256	25.02	87	8.50	61	5.96
15	Цэнхэр	3771	2011	53.33	1950	96.97	1427	70.96	340	16.91	183	9.10	61	3.03
16	Цэцэрлэг	2460	1360	55.28	1340	98.53	936	68.82	294	21.62	110	8.09	20	1.47
17	Чулуут	2656	1493	56.21	1469	98.39	1068	71.53	319	21.37	82	5.49	24	1.61
18	Эрдэнэмандал	3611	1981	54.86	1944	98.13	1327	66.99	441	22.26	176	8.88	37	1.87
19	Эрдэнэбулган	13795	7227	52.39	6924	95.81	5096	70.51	920	12.73	908	12.56	303	4.19
ДҮН		61277	34175	55.77	33102	96.86	23870	69.85	6186	18.10	3046	8.91	1073	3.14
БАЯН-ӨЛГИЙ														
20	Алтай	2596	1579	60.82	1516	96.01	1352	85.62	103	6.52	61	3.86	63	3.99
21	Алтанцөгц	1767	1009	57.10	960	95.14	832	82.46	86	8.52	42	4.16	49	4.86
22	Баяннуур	2803	1692	60.36	1468	86.76	1260	74.47	185	10.93	23	1.36	224	13.24
23	Бугат	2364	1468	62.10	1381	94.07	1219	83.04	108	7.36	54	3.68	87	5.93

Уг сайт дээрх Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль гэсэн цэс дээр “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021” гэсэн файл байгаа боловч судлаачдад нээлттэй, боловсруулан анализ хийх боломжтой өгөгдөл биш .pdf өргөтгөлтэй байлаа. Мөн ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын сонгуулийн зардлыг харьцуулан судлах, ингэхдээ сонгуулийн кампанит ажлын зардлын анализ хийхэд харьцуулагдах ёстой зардлын тайлангуудаас зөвхөн 2009, 2013, 2017 оны зардлын тайлан .pdf өргөтгөлтэй олдсон (СЕХ-ны сайт дээр зөвхөн 2013 оны зардлын тайлан байв). Бусад оны тайлангууд олдоогүй. Эндээс улс төрийн нам, нэр дэвшигчдийн санхүүгийн тайлан иргэд сонгогчдод нээлттэй, ил тод байх ёстой гэсэн зарчим, хуулийн заалт үйлчлэхгүй байгаа нь энэхүү ажлын хүрээнд ажиглагдлаа. Хэдийгээр 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн гарсан боловч тухайн дүнг мэдээлэхдээ тухайн хэсгийн хороод дээрх санал өгөх ёстой нийт сонгогчийн тоог оруулаагүй нь учир дутагдалтай байна.

Зураг 4. ИТХ-ын сонгуулийн дүн

2020-10-15 23:20:23

Архангай аймгийн ИТХ-ын сонгуульд 19-р тойргоос нэр дэвшигчдэд өгсөн хүчинтэй саналын тоо

Үр дүн ирүүлсэн хэсгийн хороо: 2 тай 2 100.00%
 Нийт уншигдсан хүчинтэй саналын хуудасны тоо: 1,383
 Санал өгсөн сонгогчдын тоо: 1,383
 Хүчингүй саналын хуудасны тоо: 0

Дагвын ӨЛЗИЙСАЙХАН (МАН) 774 55.97%
 Цогтоогийн МӨНХНАСАН (МАН) 677 48.95%
 Хүрэлчулууны ОЮУН-ЭРДЭНЭ (АН) 519 37.53%
 Доржийн БАТСАЙХАН (АН) 503 36.37%
 Санжаахүүгийн МЯГМАРБААТАР (МАХН) 198 14.32%

Нийт хүчинтэй саналын тоо: 2,671
 Санал огт тэмдэглээгүй сонгогчдын тоо: 19

Орон нутгийн сонгуулийн хувьд, сонгуулийн үр дүн .pdf өргөтгөлтэй байлаа. Энэхүү судалгааны ажлын хүрээнд СЕХ-ны өгөгдлийн санд байгаа анхдагч тоон өгөгдлийг албан ёсоор авсан бөгөөд тэрхүү тоон өгөгдөл, түүний хамрах хүрээг харгалзан 2000-2020 оны ИТХ-ын ирц, сонгуулийн оролцоо, хүчинтэй болон хүчингүй санал, ялалт байгуулсан нам зэрэг мэдээллийг ашиглан шинжилгээг хийхийг зорьсон. Шинжилгээнд зөвхөн орон нутгийн сонгуулийн тоон мэдээллийг хамруулсан бөгөөд мэдээллийн олдоцоос хамааран 2012 оны сонгуулийн дүнд шинжилгээ хийхэд харьцангуй хязгаарлагдмал байв. Сонгуульд нэр дэвшигчдийн нас, хүйс СЕХ-оос авсан дээрх өгөгдөлд огт байхгүй, харин ялалт байгуулсан нэр дэвшигчдийн нас, хүйсийн мэдээлэл зөвхөн 2000-2008 оны сонгуулийн хувьд байсан тул холбогдох шинжилгээг тус онуудад хийв. Энэ хүрээнд 2000-2020 оны орон нутгийн сонгуульд оролцсон нийт нэр дэвшигчдийн мэдээлэл байхгүй, харин ялалт байгуулсан нам, эвсэл, бие даагчийн 12,722 тоон мэдээллийг нэгтгэн боловсруулах боломжтой байлаа.

Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэл

УИХ-ын, Ерөнхийлөгчийн, орон нутгийн сонгууль тус бүрт сонгогчдын нэрийн жагсаалт гарч, тухайн нэрийн жагсаалтад бичигдсэн буюу бүртгэгдсэн иргэд тухайн сонгуульд оролцож саналаа өгдөг. Нэрийн жагсаалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газар Сонгуулийн ерөнхий хороо болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагаас ирсэн мэдээллүүдийг нэгтгэн гаргана. Тухайлбал, 2020 онд батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим бүртгэлийн мэдээллийн санд үндэслэн үйлдэх, түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, холбогдох бүртгэлийг хийх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Улсын бүртгэлийн ерөнхий газар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг.

Лийд төгсөгчдийн холбооны 2021 онд гүйцэтгэсэн “Сонгуулийн ирцийн мэдээллийг ил тод болгох нь” судалгаанд “сонгуулийн насны иргэдийн тоо, түүний өөрчлөлт сонгогчийн нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тооны өөрчлөлттэй уялдахгүй, зөрүүтэй байгаа нь сонгогчид сонгох эрхийн суурь болох сонгогчийн нэрийн жагсаалтад бичигдэх эрхээ эдэлж чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна”² гэжээ.

2008 оноос УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үед сонгогчийн нэрийн жагсаалтын мониторингийг³ иргэний нийгмийн байгууллагууд хийж ирсэн боловч орон нутгийн сонгуулийн үеэрх сонгогчдын нэрийн жагсаалтын бүртгэлд мониторинг хийж байгаагүй. Мөн “Сонгуулийн ирцийн мэдээллийг ил тод болгох нь” судалгааны тайланд дурдсанаар⁴, Улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгуулийн насны иргэдийн тоо болон сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгогчдын тоог ил тод болгохгүй, зөвхөн сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн тоог зарладаг. Өөрөөр хэлбэл, сонгуулийн өмнө яг хэдэн сонгогч сонгуулийн эрхтэй байгаа, сонгогчдын нас, хүйс, байршлаар нь тодорхой зарладаггүй нь сонгогчийн бүртгэлийн үнэн бодит байдалд эргэлзэх эргэлзээг төрүүлж байна гэжээ.

² БНОУХ, Азийн сан, Лийд төгсөгчдийн холбоо. Сонгуулийн ирцийн мэдээллийг ил тод болгох нь судалгааны тайлан. 2021. 17 дахь тал

³ Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторингийн талаарх мэдээлэл. <https://www.sanal.mn/category/44?page=1>

⁴ БНОУХ, Азийн сан, Лийд төгсөгчдийн холбоо. Сонгуулийн ирцийн мэдээллийг ил тод болгох нь судалгааны тайлан. 2021. 19 дэх тал

Хүснэгт 1. Сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, саналаа өгсөн сонгогчдын тоо (мянган хүн)⁵

Сонгуулийн жил	Улсын Их Хурлын сонгууль		Орон нутгийн хурлын сонгууль	
	Нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн тоо	Сонгуульд санал өгсөн сонгогчийн тоо	Нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн тоо	Сонгуульд санал өгсөн сонгогчийн тоо
1992 он	1.085.20	1.037.40	Мэдээлэл байхгүй	
1996 он	1.147.30	1.057.20	1.061.80	765.4
2000 он	1.247.00	1.028.00	1.105.40	728.8
2004 он	1.329.80	1.088.30	1.089.30	732.2
2008 он	1.542.60	1.179.50	1.265.50	830.6
2012 он	1.840.80	1.238.50	1.852.20	979.8
2016 он	1.911.00	1.420.80	1.921.10	1.161.10
2020 он	2.004.00	1.475.80	2.014.80	1.129.20

Дээрх хүснэгтээс харахад, сонгуулийн жилийн 6-р сард УИХ-ын сонгуульд саналаа өгөх боломжтой гэж бүртгэгдсэн буюу сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо 10-р сард орон нутгийн сонгуульд саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо 1996, 2000, 2004, 2008 онуудад 8550-27710 хүртэлх сонгогчоор буурч байсан нь харагдаж байна. 2020 онд батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24.1-т зааснаар⁶ орон нутгийн сонгуулийн үеийн сонгогчдын шилжилт хөдөлгөөнийг сонгуулийн санал хураах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоодог тул сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоонд дээрх их тооны зөрүү гарах нь эргэлзээтэй байдлыг үүсгэж байгаа төдийгүй сонгуулийн ирц бага байхад сөргөөр нөлөөлж байна.

Зардлын тайланг хүлээн авах

Сонгуулийн өрсөлдөөн тэгш, шударга, бүх оролцогчдод нээлттэй, сонгуулийн эрхүүдийг хязгаарлаагүй явагдсан эсэхийг харах бас нэг чухал үзүүлэлт бол сонгуулийн зардлын тайланд хяналт, мониторинг хийх явдал байдаг. 1992 оноос хойших УИХ-ын болон ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон улс төрийн нам болон нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажилд зарцуулсан зардлын хэмжээ улам бүр нэмэгдэж байгаа. Сонгууль бүрт нэр дэвшигчдийн тоо тогтмол өсч, өрсөлдөөн түүнийг дагаад нэмэгдсээр байна. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдэл Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд нэмэгдсэн, мөн орон нутгийн төсөв сүүлийн жилүүдэд тогтвортой нэмэгдэж байгаа зэрэг нь улс төрийн намууд болон орон нутгийн иргэд, тухайн орон нутагт байрладаг уул уурхайн болон гадны хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн ашиг сонирхолтой холбоотойгоор орон нутгийн сонгуульд ихээхэн ач холбогдол өгөх болов.

УИХ-ын болон ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторингийг иргэний нийгмийн байгууллагууд хийдэг. Харин орон нутгийн сонгуулийн өрсөлдөөн улам бүр нэмэгдэж байхад орон нутгийн сонгуулийн санхүүжилтийн мониторинг огт хийгдээгүй байна. Санхүүжилтийн асуудалд төрийн

⁵ Сонгогчдын оролцоо. ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2021 он. Энд Ерөнхийлөгчийн сонгуулийн мэдээлэл байгаагүй.

⁶ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль. 2020

байгууллагууд энэ асуудал дээр төдийлөн анхаарал хандуулаагүй орхигдуулжээ. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нам, нэр дэвшигчдийн тоо сонгууль бүрт нэмэгдэж байгаа энэ цаг үед тойрог бүрт улс төрийн нам, нэр дэвшигчдээс зарцуулж болох зардлын дээд хэмжээг баталсан тушаал л гарсан. Энэхүү судалгааны ажлын хүрээнд зөвхөн УИХ, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, намуудын зардлын тайлан олдохоос орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг олж авах боломж байхгүй, олдохгүй байсан нь орон нутгийн сонгуулийн кампанит ажил, санхүүжилт зэрэгт хяналт тавих, анхаарах боломжгүй байгааг илтгэж байна.

Төрийн байгууллага, улс төрийн намын албан ёсны сайтуудад сонгуультай холбоотой мэдээлэл нээлттэй бус байна.

Сонгуулийн тогтолцооны оновчтой хувилбарыг судлах, цаашид олон улсын жишгийн дагуу тогтолцоог өөрчлөх шаардлага тулгарч байна. Хэдийгээр сонгуулийн тогтолцооны оновчтой хувилбарыг яаралтай шийдэх хэрэгтэй боловч сонгуулийг хэрхэн зохион байгуулах, тойрог хуваарилах, сонгогчдын сонгох эрх, нэр дэвшигчдийн сонгогдох эрхийн хэрэгжилт, намуудын оролцоо, мөрийн хөтөлбөр, сонгуулийн кампанит ажлын зохион байгуулалт, сонгогчдод эдгээр мэдээллийг хүртээмжтэй мэдээлэх, сонгуулийн санал хураалтыг зохион байгуулах, сонгуулийн үр дүнг гаргах зэрэг олон асуудлууд сонгуулийн тогтолцоотой холбоотойгоор гарч ирнэ. Тиймээс судалгааны энэ хэсэгт иргэд, сонгогчид зөвхөн орон нутгийн сонгуулийн талаарх мэдээ, мэдээлэл, албан ёсны дүн баримтыг авах боломжтой эсэхийг шалгах зорилгоор Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Улсын дээд шүүх болон Монгол Ардын нам, Ардчилсан намуудын вэб сайтуудыг шүүж ажиглалт хийсэн юм.

Сонгуулийн ерөнхий хороо

Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн талаарх мэдээллүүд тус байгууллагын веб сайтад байршсан бөгөөд тухайн орон нутгийн нэгж бүрийн ИТХ-ын сонгуульд тухайн тойргоос нэр дэвшигчдэд өгсөн хүчинтэй саналын тоо болон сонгуулийн үр дүн ирүүлсэн хэсгийн хороо, нийт уншигдсан хүчинтэй саналын хуудасны тоо, санал өгсөн сонгогчдын тоо, хүчингүй саналын хуудасны тоо зэрэг мэдээллүүд байна. Мөн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг веб сайтдаа оруулжээ. Сонгуулийн хуулийн талаарх мэдээллүүд, сонгуулийг товлон зарлах, сонгогчдын бүртгэлтэй холбоотой мэдээллүүд, сонгогчийн боловсролд чиглэсэн видео контентууд, сонгуулийг зохион байгуулах ажлын талаарх бүхий л мэдээллүүд байршсан байна. Гэхдээ энэхүү сонгуулийн үр дүнг судалгаа, харьцуулалт хийх боломжтой нээлттэй өгөгдөл байдлаар биш, зурган хэлбэрээр оруулсан байгаа нь учир дутагдалтай.

Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн мэдээлэл тус байгууллагын сайт дээр бүрэн байхгүйгээс гадна сонгуульд нэр дэвшиж оролцсон улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан, явцын тайлангуудын талаарх мэдээлэл байхгүй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар

Монгол улсын бүртгэлжүүлэлтийг бүхэлд нь хянаж, гүйцэтгэх үүрэгтэй тус байгууллагын албан ёсны веб сайтыг шүүж үзэхэд 2012 онд нийслэл, орон нутагт хэдэн сонгогч цахим үнэмлэхийн дагуу сонгуульд саналаа өгөх талаар мэдээлэл байв. Мөн орон нутгийн сонгууль болохоос хоёр хоногийн өмнө сонгогчийн сонгох эрхийг хязгаарлахгүйн тулд сонгуулийн санал хураах өдөр цахим үнэмлэх олгохыг үүрэг болгосон талаар мэдээлэл оруулжээ. Түүнчлэн нийслэлд 791,140 иргэн буюу 96.4 хувьтай байгаа бол орон нутагт 1,024,596 иргэн буюу 98.5 хувь нь цахим үнэмлэхээ авсан талаар мэдээ оруулжээ. Тухайн оны 05 сарын 01-ийг хүртэл нийслэлд 24,585 хүн

иргэний үнэмлэхний лавлагааны хуудастай байсныг цахим үнэмлэхтэй болгосон. Харин орон нутагт 12,506 иргэний цахим үнэмлэхийг хүргүүлсэн. 05 сарын 01-ээс 06 сарын 01-ний хооронд нийслэлд 33,789, орон нутагт 10,788 иргэний цахим үнэмлэхийг хэвлэх ажил гүйцэтгэсэн байна. Үүнээс хойш орон нутгийн сонгуулийн талаарх мэдээлэл оруулахгүй явсаар 2020 онд нийтлэгдсэн мэдээлэл дээр Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулиуд зохион байгуулагдана. Иргэний бүртгэлийн асуудал чухал гэсэн агуулга бүхий мэдээлэл оржээ. Иргэний бүртгэлийн талаасаа айл өрхүүдийн албан ёсны хаяг, хаягжилтын асуудал сонгууль зохион байгуулах ажил сонгуулийн жил бүр асуудал дагуулдаг. Тухайлбал, нэг хаяг дээр сонгогчийн бүртгэлийг давхар хийх, тэр дундаа зохион байгуулалттайгаар “царцааны нүүдэл” буюу сонгогчдыг олноор шилжилт хөдөлгөөн хийлгэн санал өгүүлэх нь сонгуулийг будлиантуулах гол шалтгаан болдог тухай санааг оруулжээ. Мөн УИХ-ын 2020 оны сонгуулийн төсөвт 20,6 тэрбум төгрөг, орон нутгийн сонгуульд 16,5 тэрбум төгрөг тус тус батлагдсан. УИХ-ын сонгуулийн тухай хууль батлагдвал саналын хуудасны, техникийн болон гадаад улсад байгаа сонгогчийн санал авах зардал тус тус нэмэгдэнэ гэсэн мэдээлэл оржээ.

Үндэсний аудитын газар

Үндэсний аудитын газрын вэб сайт дээр орон нутгийн сонгуультай холбоотойгоор тухайн тойргуудад зарцуулж болох зардлын дээд хэмжээг тогтоож өгсөн мэдээлэл байна. Нэр дэвшигчээс зарцуулж болох зардлын дээд хэмжээг баталсан тушаалууд дээрх тоо статистикийг судалгаа, харьцуулалт хийхэд нээлттэй өгөгдөл байдлаар ашиглах боломжгүй, зурган хэлбэрээр оруулсан байгаа нь мөн л учир дутагдалтай. Гэхдээ орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нам, нэр дэвшигчдийн тоо сонгууль бүрт нэмэгдэж байгаа ч сонгуулийн зардлын тайланг олж авах боломжгүй байсан нь орон нутгийн сонгуульд хяналт тавих, анхаарах хандуулах явдлыг хязгаарлаж байна. Эндээс орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн зардлын тайланг хүлээн авах, мэдээлэх ажлууд бүрэн хийгдэхгүй байгааг харж болно.

Монгол Ардын нам

Монгол Ардын намын вебсайт болох www.nam.mn дээр орон нутаг болон нийслэл гэсэн хэсэг байгаа боловч сонгуультай ямар ч холбоогүй, мэдээлэл оруулалгүй үлдээсэн байна. Сайт дээрх мэдээ, мэдээлэл цэсний “сонгууль 2021” хэсэгт нэр дэвшигч У.Хүрэлсүхийн Увс аймгийн иргэдтэй уулзсан талаарх болон орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл байна. Мэдээ, мэдээлэл цэсний хэсэгт гарсан 2022 оны 04 сарын 29-ны мэдээлэлд намаас таван баг байгуулж, орон нутагт ажиллах талаар мэдээлэл оруулсан бөгөөд намын 4000 гишүүнтэйгээ уулзаж, санаа бодлыг нь сонсох, МАН-ын 30 дахь их хурлаас гарсан шийдвэрүүдийг танилцуулах талаар мэдээлэл оруулжээ. Орон нутгийн гишүүдтэйгээ уулзах, ажлаа тайлагнах, харилцах талаарх мэдээллүүд болон намын хурлуудын талаарх мэдээллийг оруулсан хэдий ч, орон нутгийн сонгууль, намаас орон нутгийн сонгуульд нэр дэвших, өрсөлдөх зэрэг мэдээллийг оруулаагүй байна.

Ардчилсан нам

Ардчилсан намын вебсайт болох www.Democrats.mn дээрх “сонгууль 2021” хэсэгт Ардчилсан намын даргын сонгуульд нэр дэвшигчдийн танилцуулга, сонгуульд саналаа хэрхэн өгөх зааврыг оруулсан байна. Харин намын дотоод сонгуульд орон нутагт нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг оруулж өгчээ. Орон нутгийн сонгууль, намаас орон нутгийн сонгуульд нэр дэвших, өрсөлдөх зэрэг талаарх мэдээллийг оруулаагүй байна.

Эдгээрээс дүгнэхэд иргэдийн орон нутгийн сонгуулийн талаарх мэдлэг хангалтгүй байдагт албан ёсны сайтууд дээрх мэдээллүүд орон нутгийн сонгуульд чиглэдэггүй, чухалчлан үзэж олон нийтэд энэ талаарх мэдээллийг өгдөггүйтэй

холбоотой байж болох юм. УИХ-ын сонгуулийг чухалчлан авч үздэгийн адилаар ИТХ-ын хурал, түүний төлөөлөгчийн талаар, орон нутгийн сонгуулийн онцлогийг танин мэдүүлэх ажил нэн шаардлагатай байна.

Дүгнэлт, санал

Монгол Улс дахь сонгуулиуд, үр дүнгийн талаарх нэгдсэн өгөгдлийн сан, стандарт байхгүй, сонгууль бүрийн тоон мэдээлэл өөр өөр формат бүхий, нээлттэй өгөгдөл биш зурган файлаар байдаг, судалгааны хүрээнд нэгтгэх, харьцуулах боломжгүй зэрэг нь сонгуулийн дүнг нэгтгэх, харьцуулан анализ хийхэд том хүндрэлийг үүсгэх байдалтай байна. Хэдийгээр орон нутгийн сонгуулийн үр дүнтэй холбоотой тоон өгөгдөл УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнтэй холбоотой тоон өгөгдөлтэй харьцуулахад баялаг, дүн шинжилгээ хийх боломж их боловч өдийг хүртэл нэгдсэн байдлаар бүх мэдээллийг цуглуулаагүй.

Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудитын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, улс төрийн намуудын вэб сайт дээрх сонгуультай холбоотой мэдээллүүд нам, нэр дэвшигчид болон иргэд сонгогчид, судлаачдад төдийлөн хэрэгтэй, бүрэн мэдээлэл байхгүй. Зөвхөн Сонгуулийн ерөнхий хорооны сайт дээр дээрх зарим мэдээллүүдийг нэгтгэх гэж оролдсон боловч иргэд, судлаачид шууд авч ашиглах боломжгүй байдлаар олон нийтэд түгээж байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд сонгуулийн дүн мэдээллийг иргэд, судлаачдад нээлттэй байлгах үүднээс дараах саналуудыг дэвшүүлж байна.

- Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс нэр дэвшигчдийн бүрэн мэдээлэл, сонгуулийн ирц, ялалт байгуулсан нэр дэвшигчийн талаарх зэрэг мэдээллүүдийг нэгдсэн форматаар өгөгдлийг цуглуулж хэвших,
- Сонгуулийн ерөнхий хорооны бүтцэд сонгуулийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийг нэгтгэх, олон нийтэд нээлттэй мэдээлэх тогтолцоог бэлтгэх, ажилтнуудыг чадавхжуулах,
- Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудитын газар, Иргэний бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо зэрэг төрийн байгууллагуудын сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг гаргах, нэгтгэх, олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг ажлын уялдааг нарийн зохицуулах,
- Сонгуульд нэр дэвшиж буй улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хуулийн хүрээнд авах, нэгтгэх, хариуцлага тооцох тогтолцоог сайжруулах,
- УИХ болон ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд сонгогчдын мэдээллийг илүү дэлгэрэнгүй авах зөвлөмж гардаг бол орон нутгийн сонгуулийн хувьд сонгогчдын мэдээлэл дээр нэмээд нэр дэвшигчдийн бүрэн мэдээллийг дэлгэрэнгүй авах шаардлагатай,
- Сонгуулийн үр дүнтэй холбоотой нэгтгэгдсэн бүх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооны сайт болон бусад холбогдох төрийн байгууллагуудын сайтууд дээр нээлттэй өгөгдөл байдлаар тогтмол байлгах, арилгахгүй байх. Өгөгдлийн нэгдсэн сан үүсгэх,
- Сонгууль бүрт нэр дэвшигчдийн овог, нэр (хэрвээ сонгуульд дахин нэр дэвшиж байгаа бол түүнийг тэмдэглэх, овог нэр дээр өөр тэмдэглэгээ хийхгүй байх зэргийг анхаарах), нас, хүйс, нэр дэвшүүлж буй улс төрийн нам эсвэл бие даагч эсэх гэх мэт мэдээллүүд нэгдсэн форматын дагуу байх,
- Сонгуульд саналаа өгсөн сонгогчдын нас, хүйс, санал өгсөн цаг (үдээс өмнө эсвэл хойш)-ийн мэдээллийг байршлаар нь нээлттэй мэдээлэх,
- Санал хураах хэсгийн хороо бүрт нийт бүртгэлтэй сонгогчдын тоо, хүчинтэй саналын тоо, хүчингүй саналын тоо, цагаан хуудас өгсөн сонгогчдын тоо зэргийг мэдээлэх,

- Сонгуулийн үр дүнтэй холбоотой нэгтгэгдсэн бүх мэдээллийг иргэд, судлаачдад нээлттэй өгөгдөл байдлаар мэдээлэх, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах боломжтой байх

Түлхүүр үг: Сонгуулийн дүн, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн зардлын тайлан, сонгуулийн өгөгдөл

Abstract: Within the frame of this article, with the purpose of clarifying transparency and openness of sources for voters and researchers, authors have analyzed data and related information of the last democratic elections held in Mongolia cited on the official websites of organizations such as the General Election Committee, the National Audit Office, and the National Statistics Committee.

Ашигласан материал:

БНОУХ, Азийн сан, Лийд төгсөгчдийн холбоо. 2021. *Сонгуулийн ирцийн мэдээллийг ил тод болгох нь судалгааны тайлан*

Сант марал сан. *Улс төрийн барометр 2010-2021 оны судалгааны тайлан*

www.santmaral.mn

Сонгуулийн ерөнхий хороо. 2020. *УИХ-ын сонгуулийн дүн 1992-2020*

Сонгуулийн ерөнхий хороо. 2021. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021*

Сонгуулийн ерөнхий хороо. 2009-2017. *Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын тайлан*

Үндэсний статистикийн хороо. www.1212.mn

ОНЛАЙН АРДЧИЛЛЫН БЭХЖИЛТ БА МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД

С.Мөнхбат.

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн профессор

Н.Батсүмбэрэл

МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн докторант

Хураангуй:

Улс төрийн нам бол төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх үндсэн институци юм. Нөгөө талаар ард иргэд төрөө эмхлэн байгуулдаг үндсэн хэлбэр болсон бүгд найрамдах төрийн үндсэн хэрэгсэл. Дээрх хоёр утгаар авч үзвэл улс төрийн намыг төр иргэний хооронд “зуучлагч”-ийн үүргийг гүйцэтгэдэг, улс төрийн агрегацийг хэрэгжүүлдэг ардчиллын чухал байгууллага гэж үзнэ. Бид энэхүү өгүүллээр дээрх санааг баталгаажуулж улс төрийн намын орчин үеийн хөгжлийн хэв маяг хийгээд Монголын улс төрийн намын хөгжилд тулгамдаж буй асуудлыг намын гишүүнчлэлийн аспектаар тодруулж, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохыг оролдоно.

Түлхүүр үг: намын гишүүн, гишүүнчлэл, намын дэмжигчид, гишүүнчлэлийн дахин тодорхойлох нь, бодлогын нам, дижитал нам, намын төлөөллийг хангах шинж механизм, ТВ-ийн нам, онлайн ардчилал.

Нэг. Онлайн ардчиллын хөгжилт, намын гишүүнчлэлийн хувьсал.

XXI зуунд хүн төрөлхтөний хөгжлийн ололт амжилт нь нийгмийн бүх салбарт хиймэл оюун ухаан, шинэ мэдлэг, инновацийг ашиглах боломжийг бүрдүүлж, нийгэм-улс төрийн институциудыг өөрчлөн хувиргасаар байна. Үүний нэг илрэл нь улс төрийн намын хөгжилд гарч буй өөрчлөлт, хувирал юм. Эдүгээ намыг тодорхойлж ирсэн уламжлалт ойлголтууд хувиран өөрчлөгдөж, намын мөн чанарыг авч үзэх судалгааны шинэ онол, арга зүйн хандлага бий болжээ. Үүнд ардчилал өндөр хөгжсөн орнуудын төлөөллийн ардчиллын мөн чанар, иргэдийн оролцооны хэлбэрт гарч буй өөрчлөлтүүд нь нөлөөлөгч суурь хүчин зүйл болж байна. Иргэдийн амьдралын чанар, нийгмийн баталгаа нь хүчирхэг эдийн засгийн үндэс болж, ардчиллын бэхжилт, ардчиллын чанар нь улс төрийн тогтвортой байх хөрсийг бүрдүүлж чадсан явдал нь цаашид хөгжих үндсэн нөхцөл болсоор байгаа билээ.

Сонгодог онолчид болох Я.Г. Острогорский, Р. Михельс, М. Дюверже, М. Вебер нарын намын зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх онолын үндэслэлүүд орчин үеийн намуудад илрэх төдий болж байна. (Gerbaudo, 2019) Хуучны олон түмний намууд болох Британий Консерватив болон Лейборист намууд, Германы Христийн Ардчилсан Холбоо болон Социаль демократууд прогрессив буюу дэвшилтэт намын хэв маяг руу хөгжиж, үзэл баримтлал, үйл ажиллагааны хувьд баруун төвийн байр суурь руу шилжих үйл явц явагдаж байна. Намын гишүүнчлэлийн хувьд хатуу гишүүнчлэлээс илүүтэй өргөн хүрээний дэмжигчдийн баазыг бэхжүүлэхэд голлон анхаардаг болжээ.

Ийнхүү орчин үеийн намын хөгжлийн шинэ хандлага, өөрчлөлтүүд нь намын гишүүнчлэлийн асуудлыг зайлшгүй хөндөхөд хүргэж байгаа юм. Өнгөрсөн XX зуун

хатуу гишүүнчлэлтэй олон түмний намын хөгжлийн зуун байв. Баруун Европын ихэнх орнуудад зүүний болон барууны чиг баримжаатай намууд нийгмийн ялгаатай баазад суурилж үнэт зүйл, үйл ажиллагаагаа явуулах зайлшгүй нөхцөлд хатуу гишүүнчлэлийг өргөжүүлэх, тоог өсгөх замаар намын идэвхтэй гишүүдийн оролцоо, дэмжлэгт суурилж амжилт олж байв. Эдүгээ энэ үйл явц өөрчлөн хувирч тогтсон хатуу гишүүнчлэлээс татгалзан өргөн олны дэмжигчдын хүрээг тэлэхэд бодлогоо чиглүүлэх болов.

Өөр нэг шалтгаан нь технологийн дэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үсрэнгүй хөгжил нь намуудыг гишүүдээрээ дамжин иргэд, сонгогчдод хүрдэг тогтолцоог халж, телевиз, радио, цахим хуудас, сошиал орон зайг өргөн ашиглах боломжийг нээсэн явдал юм. Намууд нийгэмд танигдан, хүлээн зөвшөөрөгдсөн лидерүүдийг бэлтгэж, тэдгээр хүмүүсээр бодлого, үйл ажиллагаа сурталчлан таниулах шинэ арга технологийг нэвтрүүлж байна. Үүнийг дагаад цахим нам, дижитал нам, телевизийн нам, бодлогын нам зэрэг намын хөгжлийн шинэ хандлага, хэв маяг бий болжээ. Намын өргөн гишүүнчлэл, партизаны улс төрд олон талт улс төрийн коммуникацийн альтернативууд (Ж.Төртогтох, 2014) нэвтэрч намын үйл ажиллагааны шинэ арга, механизмуудыг ч бий болгож байна.

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд улс төрийн нам иргэд сонгогчдын дунд “урт удаан хугацаанд амьдрах” хэрэгцээ улам өсч байна. Ард түмэнд хүлээн зөвшөөрөгдсөн, шилдэг лидерийг бэлтгэх хэрэгцээ ч нэмэгдсэн. Энэ хоёрын хооронд улс төрийн нам маш сайн бодлого, үйл ажиллагааг явуулж байж сонгуульд амжилт үзүүлэх болсон. Өөрөөр хэлбэл “орчин үеийн намын бүтэц, зохион байгуулалт нь парламент болон засгийн газарт манлайлал үзүүлэхэд чиглэж байна. Лидерүүд нам болдог, нам нь лидерүүдийн үйл ажиллагаанд тулгуурладаг” (Richard S. Katz, 2009) хэв шинжийг намууд олсоор байгаа аж.

Гэвч бодит байдалд зарим ардчилсан орнуудад олон нийт уламжлалт улс төрийн намууд өнөөгийн сорилт, хямралыг даван туулж чадах эсэхэд эргэлзэж, сонгогчдын үл итгэх итгэлийг нэмэгдүүлсэн. Цаашлаад иргэд сонгогчдыг улс төрийн үйл ажиллагааны өөр замыг дэмжихэд түлхэц өгч улмаар үзэл суртлын хэт даврагч нам, хөдөлгөөнүүдийн өсөлтийг өдөөж байна гэж зарим судалгааны тайланд өгүүлжээ. Баруун Европт уламжлалт намын оронд хэт туйлширсан үзэл, түүнийг баримталсан улс төрчид, улс төрийн намууд үе үе засгийн эрхэнд гарах, оролцох болсон нь үүний тод жишээ юм. Ардчилал бэхжсэн улс орнуудын намын тогтолцоонд уламжлалт манлайлал нь нэг талаас бодлогын шийдвэрүүдийг төвлөрүүлэх, нөгөө талаас дургүйцсэн сонгогчдын дунд гацсан дүр төрхтэй байна.

Зарим судлаачид намын хөгжлийн гажуудсан хэв маягийн талаар ч дүгнэлтээ хийж байна. Тухайлбал Чехийн судлаач М.Клима массыг хамарсан хэлбэрээс универсал (catch-all) хэлбэрт шилжих үеийн намуудын хөгжлийн гурван сөрөг чиглэлийг ялгаж болно. Үүнд, 1. Р.Катц, П.Майер нарын тодорхойлсноор Баруун болон хойд Европын нөхцөлд ардчилал нь картелийн хэлбэрт илүү ойртон хөгжиж буй хэлбэр. 2. Төв Европын хувьд коммунист тоталитар дэглэмээс ардчилалд шилжих үед улс төрийн намууд нь клиентелист шинж чанартай бүтцүүд болон хувирч буй хэлбэр. 3. Зүүн Европын орчинд улс төрийн нам өөрөө олигарх бүлэглэлүүд болон хувирч, ардчилал гажуудалд орж буй хэлбэр гэж тус тус дүгнэсэн (Клима, 2017).

Эндээс харахад нийгмийн шилжилтийн ялгаатай нөхцөл, орчин, соёл уламжлал, шашны байдал, хөгжлийн хүрсэн түвшин зэрэг суурь хүчин зүйлүүд тухайн бүс нутаг, улс оронд ардчилал, түүний институциудыг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй гэдгийг харж болно (Натан, 2008). Харин намын хөгжлийн шинэ чиг хандлагыг дагаад намын гишүүнчлэл, гишүүнчлэлийн бодлогод тодорхой өөрчлөлтүүд гарах нь хөгжлийн зүй тогтол. Өргөн хүрээний гишүүнчлэлээс илүү үр дүнтэй, оролцоотой гишүүд,

дэмжигчдийн баазыг бүрдүүлэх үйл явц өрнөж буй нь нөгөө талаар төлөөллийн ардчиллын бэхжилттэй ч шууд холбоотой.

Сүүлийн хэдэн арван жил улс төрийн намууд өргөн хүрээний гишүүнчлэл түүнд суурилсан тогтвортой улс төрийн платформыг хэрэгжүүлж ирсэн. Энэ арга зам нь намуудыг нийгмийн төлөөллийн гол хаалгач, улс төрийн оролцооны үндсэн механизм болгож байв. Том, өргөн хүрээний хатуу гишүүнчлэл нь улс төрийн нам амьдрах чадвартай, эрүүл ардчиллын чухал нөхцөл болж байсан (Дюверже.М, 1951). Харин эдүгээ энэ нөхцөл байдал эрс өөрчлөгдөж байна.

Өнөөдөр бодит байдалд улс төрийн намууд өөрчлөгдөж буй дэлхий дахины өнгө төрхөд нийцэж оршин тогтнохын тулд дор хаяж дараах дөрвөн сорилтыг даван туулах ёстой болж байна. Үүнд, 1. Дэлхий дахины геополитикийн хуваагдал, түүнийг дагасан бодлогын өөрчлөлт, эдийн засгийн хямрал, дүрвэгсэдийн урсгал 2. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бодлогын гадна үлдсэн хэсгийн эсэргүүцлийг даван туулах, шийдвэрлэх 3. Хэт хавтгайрсан популизмд хариу үзүүлэх 4. Намын гишүүд, дэмжигчидтэйгээ харилцах шинэ арга барилд суралцах зэргийг хамруулан үзэж болохоор байна.

Намын үйл ажиллагаа явуулах улс төрийн орчин онлайн хэлбэрт шилжиж байна. Өнөөдөр “цахим сонгогч”, “онлайн ардчилал”, “дижитал нам”, “телевизийн нам”, “кодлогдсон ардчилал”, “хайпер удирдагч” (Gerbaudo, 2019) зэрэг нэр томъёо, ойлголтууд улс төрийн шинжлэх ухааны судалгаанд нэвтрэн орж ирж байна. Ийнхүү улс төрийн орчин бүхэлдээ цахимжих үйл явцад өртөж, намууд улам бүр дижитал болж байна. Барууны орнуудад энэ шилжилт аль хэдийн явагдаж байгаа аж. Дижитал болох нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүний нөөцийг хэмнэх боломжуудыг нээж, дэлгэцээр дамжуулж олон нийтэд хүрэх нөхцлийг намуудад олгож байгаа юм. Намууд нүсэр бүтэц, их зардлаас татгалзаж технологийн дэвшил рүү бодлого, нөөцөө чиглүүлж байна. Зарим тохиолдолд сошиалын нөлөөлөл төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх байдал ч ажиглагдах болсон. Дэлхий дахиныг хамарсан цар тахлын үед энэ үйл явц улам бүр идэвхжиж төр, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулахад дэвшил гарсан. Дижитальчлагдах нь хүнд суртал, авлигаас ангид, ил тод байх боломжийг төрд бүрдүүлж, иргэдийн хяналтыг нэмэгдүүлж чадсан явдал нь төр, иргэний аль алиных нь итгэлийг нэмэгдүүлсэн.

Уламжлалт намуудын үйл ажиллагаа, нэр хүнд унаж байгаа энэ үед иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, татах гол талбар нь сошиал орчин юм. Тиймээс ардчилал бэхжсэн орнуудад намын гишүүнчлэлийн дахин авч үзэх нь гэдэг давалгаа өрнөж гишүүнчлэлийн олон хэлбэрт тогтолцоог бий болгох, шинэ инновацийг нэвтрүүлэх өргөн далайцтай алхамуудыг хийхийг зорьж байна. Жишээлбэл, Их Британы Либераль Ардчилсан нам, Испанийн Ардын нам гишүүнчлэлээ гишүүд ба дэмжигчид гэсэн байдлаар авч үздэг байна. “Гишүүд ба дэмжигчидын хооронд хоёр чухал ялгаа бий аж. Нэгдүгээрт, гишүүн татвар төлнө. Дэмжигчид татвар төлөхгүй, татвар сайн дурынх байна. Төлөх тохиолдолд маш бага татвар төлнө. Хоёрдугаарт, гишүүд намын бүх түвшний шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал өгч оролцох, төлөөллийн байгууллагад (их, бага хурал, удирдах зөвлөл г.м) сонгогдох эрхтэй. Дэмжигчид намын аливаа уулзалт, цуглаанд оролцох боломж нээлттэй ч шийдвэр гаргах түвшинд оролцож санал өгөх, сонгогдох эрх хязгаарлагдмал. Өөр нэг жишээ, Францын Социалист нам, “Тунисын тэмүүлэл” намууд гишүүд болон дэмжигч идэвхтнүндийн эрхийг ижил түвшинд авч үзэн намын дотоод ардчиллаа бэхжүүлдэг байна” (IDEA, 2020, хууд. 13).

Намын олон хэлбэрт гишүүнчлэлийн өөр жишээ бол “Португалийн Либераль санаачлага нам сайн дурын үйл ажиллагаа, намаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд хүмүүсийг татан оролцуулж тэдний санал бодлыг сонсох байдлаар намын

бодлого гаргах үндсэн чигээ олж авдаг байна. Мөн Португалийн Эрх чөлөө нам гишүүдээ хүндэт гишүүн, жирийн болон дэмжигч гишүүн гэж ангилж авч үздэг. Канадын Либераль нам намд элсэхийг хүсдэггүй, улс төрөөс хүнийссэн иргэд рүү хүрч ажиллахыг зорьдог бөгөөд тэдэнд оролцооны маш уян хатан нөхцлүүдийг санал болгодог” (IDEA, 2020).

Сүүлийн жилүүдэд зарим орны улс төрийн намууд гишүүнчлэлийг татвар, хураамжийг авдаггүй байх талаар тодорхой алхамуудыг хийж байна. Тухайлбал, Энэтхэгийн Нийтийн төлөөх нам, Францын Сэргэн мандалын нам, Сенегалийн Бүгд найрамдахчуудын эвсэл, Италийн таван од хөдөлгөөн зэрэг намууд гишүүнчлэлийн татвар, хураамжийг чөлөөтэй буюу авдаггүй байх зохицуулалтыг дүрэм, журамдаа оруулж ирээдүйн гишүүд, дэмжигчдэд ямар нэгэн мөнгөний баррер үүсгэх асуудалд цэг тавихаар зорьж байгаа аж.

Хоёр. Гишүүнчлэлийг дижитальчлах үйл явц

Улс төрийн аль ч намыг нийгмийн бодит тусгал, толь гэж үзэх юм бол намууд дижиталчлагдах үйл явцыг хүлээн авахаас өөр гарц харагдахгүй байгаа юм. Намын гишүүнчлэлийн асуудал ч үүнд хамаарна. Өөрөөр хэлбэл намд гишүүд, дэмжигчдийн оролцоог өргөжүүлэхэд онлайн талбарыг ашиглах хэрэгцээ нэмэгдэнэ гэсэн үг. Ингэж ажиллаж буй намын жишээ цөөнгүй байна. Гишүүд дэмжигчидтэйгээ онлайнаар ажилладаг, тэр ч бүү хэл сонгуулийн кампанит ажлаа онлайнаар явуулж амжилт олж буй намын жишээ бол Францын Сэргэн мандалын нам (2022 оноос өмнө Бүгд найрамдах улс урагшаа гэдэг нэртэй байсан) (IDEA, 2020, хууд. 15) юм. Тус нам гишүүд, дэмжигчдийг намын бодлого, үйл ажиллагаа хийгээд сонгууль, сонгуулийн кампанит ажилд биечлэн оролцохоос илүүтэйгээр онлайн сувгуудийг өргөн ашиглах, тэр орон зайд идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг чухалчлан дэмждэг. Намын дотоод байгууллага, нэгжүүд уялдаж ажиллах гол хэрэгсэл нь утсан харилцаа, онлайн платформууд юм. Түүнчлэн намын шийдвэр гаргах үйл явцад гишүүдийн оролцоог утсаар болон онлайн хэлбэрээр ханган ажилладаг байна. Энэ байдал нь ижил цаг хугацаанд бүх гишүүд, дэмжигчдэд хүрэх, мөн тэдний оролцоог хангаж байдгаараар давуу талтай аж. Мөн түүнчлэн намын дэмжигчдэд зориулсан онлайн платформуудыг үүсгэж гишүүд дэмжигчдийн бодлогод нөлөөлөх, намаас зохион байгуулж буй иргэний оролцоот төрөл бүрийн төсөл, сургалтад хамрагдах, үзэл санаагаа уралдуулах хэлэлцүүлэгүүдэд оролцох өргөн боломжийг олгож байгаа нь тус намын бусад намаас ялгарах давуу тал гэж үздэг байна. Энэ бол дижиталь намын нэг жишээ юм.

Дижитал нам бий болох өөр нэг шалтгаан нь шинэ зуун гарсаар улс төрийн намууд өөрийн гишүүд дэмжигчдийн онлайн оролцооны механизмыг үүсгэж олон нийтээс бодлогын дэмжлэг авах болсон нь онлайн ардчиллыг улам хөгжүүлэх хөрсийг бүрдүүлсэн явдал юм. Намын үйл ажиллагааны энэ хэлбэрийг дижитал нам (Gerbaudo, 2019) гэж нэрлэж байна. Дижитал намын хэлбэрүүд олон оронд хөгжиж байна. Тухайлбал Италийн Таван од Хөдөлгөөн нам, ХБНГУ-ын Ногоон нам нь улс төрийн бодлого гаргах, дэвшүүлэх, хэрэгжүүлэх бүх шатанд иргэд, олон нийтийн саналыг онлайнаар авах, оролцуулах боломжуудыг эрэлхийлж ажилладаг байна. Ингэж ажиллах нь тухайн намын хөтөлбөрийг олон нийт хүлээн зөвшөөрөх, дэмжих хөрсийг бүрдүүлж, хамгийн чухал нь гишүүд, дэмжигчид, иргэдийн намын бодлого болон бусад үйл ажиллагаанд оролцсон сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг явдал нь намаа дэмжих нийгэм, сэтгэл зүйн үндсэн нөхцлийг бүрдүүлдэг гол хүчин зүйл гэдгийг онцгойлон анхаардаг.

Онлайн орон зай хүмүүсийн идэвхтэй амьдралын нэг хэсэг болсон учир намууд урьдынх шиг уламжлалт коммуникацийг ашиглах нь тэдэнд том эрсдлийг дагуулах болсон нь онлайн ардчиллыг бэхжүүлэх, дижитал намуудыг төрүүлэх бас нэг суурь хүчин зүйл болсон байна. Нийгэм дэх ардчиллын диалоги сошиал медиа рүү

илүү чиглэх болсоноор намууд дижитал оролцоо, идэвхийг чухалчилж өөрийн гишүүд, дэмжигчдийн үйл ажиллагааг сошиал талбарт өрнүүлэх бодлогод анхаарах болжээ. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Ардчилсан эвсэл онлайн элчин (online ambassador) хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн гол зорилго нь онлайн талбарт улс төрийн халз мэтгэлцээнийг өрнүүлэх, түүнчлэн онлайн элчин болж буй намын гишүүд, ажилчид, нийгмийн нэр нөлөө бүхий имфлүүсэрүүдэд дамжуулан тэдгээрийг дагагчдыг өөртөө татах, бодлогын мессежүүдээ өгөх зэргээр ажилладаг байна (IDEA, 2020, хууд. 18).

Сүүлийн арван жилд бодлогын намуудыг бий болгох, бодлогод суурилсан сүлжээг бий үүсгэхэд намууд их анхаарч байна. Гол онцлог нь нийгэм, улс орныг хамарсан асуудлыг гол бодлогоо болгон түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар оролцогч бүх талыг оролцоог ханган онлайн хэлэлцүүлэг өрнүүлж гарц, шийдлийг олохыг чухалчилж байна. Ингэж ажиллаж байгаа намууд маш хурдан амжилтанд хүрч байна. Чили Улсын Улс төрийн хувьсал нам ийм арга хэлбэрээр ажиллаж дэмжигчдийн хүрээгээ тэлж чадсан аж. Мөн Шинэ Зеланд Улсын Үндэсний нам сүүлийн жилүүдэд бодлогын нам болон өөрчлөгдөж асуудалд суурилсан нийгмийн сүлжээг бий болгож чадсан нь амжилт олж байна. Дээрх намуудын бодлогодоо дэвшүүлж буй гол асуудлууд хүрээлэн буй орчин, аж үйлдвэржилт, цагаачлал, арлын оршин суугчдын аюулгүй байдал, хүн амын насжилт гэх мэт олон чухал асуудлыг бодлогынхоо төвд тавьж ажилладаг байна.

Намуудын удирдлага, лидерээ сонгох арга барилд ч өөрчлөлт орж байна. Ихэнх намууд удирдлагаа нээлттэй сунгааны зарчмаар сонгодог зарчим, хэм хэмжээ рүү шилжиж байна. Ингэж сонгохдоо хоёр үндсэн арга хэлбэрийг ашиглаж байна. Үүнд, 1. Намын дотоодод тухайн лидерүүдийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, тэдний дэвшүүлж буй бодлогыг нийт гишүүд дэмжигчдээр шүүлгэх, тэднээс санал авч өрсөлдүүлэх. 2. Нийт нийгмийн хүрээнд лидерүүдийн дэвшүүлж буй бодлого, байр суурь, хувь хүнийх нь манлайллыг үнэлүүлэх байдлаар тухайн лидерийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлын итгэлцүүрийг гаргаж эдгээрийг тооцох замаар намууд өөрийн удирдлага, лидерийг сонгодог болсон нь намын төлөөлөх чадварыг дээшлүүлж, легитимийг нэмэгдүүлэх гэж үзэж байгаа аж.

Гурав. Монголын улс төрийн намын гишүүнчлэлийн өнөөгийн байдал ба онлайн ардчилалын хөгжилт

Монгол Улсад 1992 онд Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсанаар хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, улс төрийн олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрсөн тогтолцоо бүрдэх үндсийг тавьсан (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2018, хууд. 5).

Эдүгээ Монгол Улсын Дээд Шүүхэд 36 нам бүртгэлтэй байна. (<https://www.supremecourt.mn>, 2023). Тоон үзүүлэлт талаас нь үзвэл Монгол Улсад олон намын систем, төлөөллийн ардчилал бодитой хэрэгжиж буй мэт боловч агуулга талаасаа арай өөр дүр зураг харагдана. Дээрх намуудаас хамгийн олон гишүүнтэй нь МАН- 1610000, Эх орон нам- 160000, Ардчилсан нам- 150000 гишүүнтэй байна. Улсын хэмжээнд авч үзвэл 632668 иргэн ямар нэгэн намын гишүүн байгаа нь нийт хүн амын 18.6%, сонгуулийн насны 1836548 иргэний 34,4%-ийг эзэлж байна. Эндээс дүгнэж үзвэл иргэд намын гишүүнчлэлийн асуудалд өндөр ач холбогдол өгдөг болох нь харагдаж байна. Сонгуулийн насанд хүрсэн иргэдийн 34.4 хувь нь аль нэг намын харьяалалтай байна. Энэ үзүүлэлтээр дэлхийн дундаж (4.65%) (Ц.Батболд, 2014)-аас 7 дахин их байна.

Италийн судлаач Паретогийн 20:80 онолд нийт сонгуулийн насанд хүрсэн хүн амын 20% нийгмийн идэвхтэй, үлдсэн 80% нь идэвх сул гэж үздэг. Тус онолоор авч

үзвэл Монголд сонгуулийн насанд хүрсэн иргэдийн 20% буюу 408121 иргэн нийгмийн идэвх өндөртэй, үүнээс 20% улс төрийн өндөр идэвхтэй гэж үзэх юм бол 90693 гэсэн тоо гарна. Энэ нь манайд байж болох намын гишүүнчлэлийн тоо буюу сонгуулийн насанд хүрсэн нийт иргэдийн 4.9% гэсэн үг. Дэлхийн жишигт дөхсөн харьцаа. Харин манай улсад энэ харьцаа 34,4% буюу 7 дахин өндөр үзүүлэлттэй байгаа юм.

Улс төрийн намын гишүүдийн тоон мэдээлэл (Улсын дээд шүүхийн цахим хуудас, 2023)

№	Намын нэр	Гишүүдийн тоо
	Монгол Ардын нам	161300
	Ардчилсан нам	150000
	Монголын Ногоон нам	2100
	Иргэний зориг ногоон нам	35000
	Монголын Уламжлалын нэгдсэн нам	1503
	Монголын Либерал ардчилсан нам	863
	Эх Орон нам	160000
	Монголын Либерал нам	1300
	Бүгд найрамдах нам	50000
	Монголын эмэгтэйчүүдийн үндэсний нам	1069
	Монголын Социал демократ нам	3000
	Ард түмний нам	11859
	Монголын үндэсний ардчилсан нам	26000
	Эх чөлөөг хэрэгжүүлэгч нам	1600
	Иргэни хөдөлгөөний нам	315
	Хөгжлийн хөтөлбөрийн нам	933
	Монголын ардчилсан хөдөлгөөний нам	850
	Хамуг Монгол хөдөлмөрийн нам	2000
	ХҮН нам	1024
	Эх орончдын нэгдсэн нам	2150
	Монгол Консерватив нам	959
	Тусгаар тогтнол, эв нэгдлийн нам	3131
	Ард түмнээ хайрлая нам	1388
	Монгол хүний төлөө нам	1135
	Үнэн ба зөв нам	819
	Зон олны нам	2022
	Дэлхийн Монголчууд нам	1022
	Ард түмний олонхийн засаглал нам	1080
	Их эв нам	1056
	Гэр хорооллын хөгжлийн нам	1023
	Миний Монгол нам	979
	Монгол Шинэчлэлт нам	1210
	Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам	913
	Зүй ёс нам	1533
	Ардчилсан шинэчлэлийн нам	893
	Иргэдийн оролцооны нэгдэл нам	939
	НИЙТ	632668

Ингэж дэлхийн дунджаас хэтийдсэн намын гишүүнчлэлийн бодлого, эрх зүйн зохицуулалт нь цөөн хүн амтай манай улсыг нам, намуудад талцан хуваагдаж жалга

довын үзэл, намчирхах үзлээр асуудалд ханддаг улс төрийн соёлыг бий болгоход хүргэж байна. Сөрөг үр дагавар нь намаар бүхнийг шийдэж, намын ивээлд орж хамгаалагдах гэсэн улс төрчдийн эгнээг тэлсээр байна.

Техник, технологийн ололт амжилт, телевиз олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хөгжилт улс төрд байх энэхүү “тажуудсан” ойлголт, хандлагыг өөрчлөх боломжийг сүүлийн хэдхэн жилийн дотор олгож байгаа нь онлайн ардчилал, онлайн оролцооны чухал үр дүн юм. Энэхүү үр дүн нь намын уламжлалт бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд томоохон сорилтыг авч ирэхийн сацуу, өөрчлөлтийг дагуулж байгаа билээ. Энэ өөрчлөлтөд Монголын улс төрийн намууд бэлэн үү? гэдэг асуудал бидний өмнө хариултаа нэхсээр байна. Бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, гишүүнчлэлд посткоммунист тогтолцооны өв хадгалагдсан хэвээр байна. Улс төрийн намыг хөгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдээгүй байна.

ДҮГНЭЛТ.

Эдүгээ улс төрийн намууд хатуу гишүүнчлэлээс татгалзаж олон нийтийн өргөн хүрээний дэмжлэгийг авахад чиглэсэн коммуникацийн олон талт үйл ажиллагааг явуулах болжээ. Дэлхий дахиныг хамарсан технологийн үсрэнгүй хөгжил хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчилж, мэдээлэл авах тал бүрийн боломжийг олгох болжээ. Энэхүү өөрчлөлтийн үйл явц нам, намын гишүүнчлэлийг шинээр эргэн харах, дахин тодорхойлон авч үзэх шаардлага, хэрэгцээг бий болгож байгааг дээр өгүүлсэн билээ.

Дэлхий дахины улс төрийн намууд гишүүнчлэлийн механизмдаа дараах гурван инновацийг нэвтрүүлж амжилт олохыг зорьж байна. Үүнд,

Нэгдүгээрт: намууд гишүүнчлэлийн олон хэлбэрийг бий болгох, намын гишүүн гэж хэн бэ? гэдэгээ дахин тодорхойлж авч үзэх, намын үйл ажиллагаа, оролцоонд эдийн засгийн баррерийг хамгийн бага түвшинд авч үзэх.

Хоёрдугаарт: Нам онлайн технологийн боломжийг ашиглаж дижитал гишүүнчлэлийг механизмыг бий болгох. Эдгээр инновациуд нь дижитал хүрээн дэх улс төрийн идэвхийг нэмэгдүүлэх, оролцооны сүлжээг өргөтгөх зэрэг олон нөхцлийг боломжийг багтааж байдгаараа онцлог юм.

Гуравдугаарт: Нам асуудалд суурилсан оролцоо, идэвхийг нэмэгдүүлэхэд намыг удирдлагыг чиглүүлж, гишүүд, дэмжигчдийн хамтын оролцоо, хамтын дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд бий болгоход анхаарч байна. Зөвхөн цөөн гишүүдийн хүрээнд бус нийгмээрээ асуудлаа хэлэлцдэг, шийдлээ хайдаг, оновчтой гэж үзсэнээ бодлого болгож гаргадаг механизмыг онлайн ардчилалаар дамжуулж улс төрд бий болгох нь орчин үеийн намын улс төрийн агрегацийн гол мөн чанар болон хөгжиж байна.

Key words: party member, membership, redefining membership, digitalizing membership, party supporters, policy party, digital party, representative mechanism of party, cartel party, catch-all party, TV party and online democracy,

Abstract: Political party is the main institution of representative democracy. On the other hand, it is the main tool of the republican state. Considering the above two meanings, the political party is an important organization of representative democracy and political aggregation performs the role of "mediator" between the state and citizens. In this article, we aim to changes in modern party membership and the challenges of Mongolian political party's membership

Эх сурвалж:

1. Gerbaudo, P. (2019). The Digital Party. Political Organization and Online Democracy. Pluto Press.
2. IDEA, I. (2020). New Forms of Political Members: Political Party Innovation Primer. Stockholm: International IDEA.
3. Richard S. Katz, P. M. (2009). The Ascendancy of the Party in Public Office: Party Organizational Change in Twentieth-Century Democracies. In R. G. other, Political Parties: Old Concepts and New Challenges (p. 126). Oxford: Oxford University Press.
4. Дюверже.М. (1951). Политический партий. Москва.
5. Ж.Төртогтох. (2014). Орчин үеийн улс төрийн намын хөгжлийн хандлага: Партизаны улс төрөөс альтернатив коммуникаци тийш. Улс төрийн нам: асуудал, эрэл, шийдэл (р. 8). Улаанбаатар: Бишрэлт тэнгэр притинг.
6. Клима, М. (2017). Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу. Улаанбаатар хот: Слэнэгэ пресс.
7. Натан, Э. (2008). Нийгмийн уламжлалт үнэт зүйлс болон ардчилсан үнэт зүйлс өөр өөр дэглэмийн ардчилсан легитимсэлд хэрхэн нөлөөлдөг вэ?
8. Д.Ганбат, Азийн барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа (р. 101). Улаанбаатар хот.
9. Ц.Батболд. (2014). Улс төрийн намын хатуу гишүүнчлэл, түүний эерэг сөрөг талууд. Улс төрийн нам: асуудал, эрэл, шийдэл (хууд. 101). Улаанбаатар: Бишрэлт тэнгэр пресс.
10. Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2018). Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа. Улаанбаатар: Хууль зүйн үндэсний хүрээлэн.
11. Улсын дээд шүүхийн цахим хуудас. (2023, January 16). Retrieved from <https://www.supremecourt.mn/home?page>

АРДЧИЛЛЫН ХӨГЖИЛД УЛС ТӨРИЙН НАМЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Б.Баярбаатар

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн докторант

Д.Бумдарь

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн профессор, доктор

Хураангуй:

Монгол улс 1990 онд нэг улс төрийн нам бүхий тогтолцооноос, олон намын тогтолцоо бүхий ардчилсан улс төрийн тогтолцоонд харьцангуй тайван замаар шилжсэн билээ. Ардчиллын замд эргэлт буцалтгүй орсон нь дэлхийн жишигт нийцсэн удирдлагын хэлбэртэй болох түүхэн бололцоог олохын чацуу улс төрийн намуудын тогтолцоо хөгжих эхлэлийг тавьсан. Улмаар улс төрийн намууд засаг төрийн үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндэс тавигдсан.

Энэхүү өгүүллийн хүрээнд улс төрийн нам, ардчиллын харилцан нягт уялдаа холбоог эмпирик түвшинд илэрхийллийг зорив. Улмаар улс төрийн намын хэв маяг, үүрэг, тогтолцооны хөгжил нь нь ардчиллын хөгжилтэй шууд хамааралтай болох талаар бичлээ. Учир нь бүх ардчиллын төвд улс төрийн нам оршиж байдаг болно.

Түлхүүр үг: Улс төрийн нам, ардчилал, улс төрийн намын зохион байгуулалтын хэлбэрүүд, улс төрийн намын ардчилалд дах үүрэг, картель нам

I. Ардчилал, улс төрийн намын уялдаа, түүний гүйцэтгэх үүрэг

Улс төрийн нам хэмээх институци бол ардчилсан улс төрд хамгийн чухал оролцогч байдаг. АНУ-ын улс төр судлаач Э.Шатшнайдер 1942 онд “Улс төрийн намууд ардчиллыг бүтээсэн ба орчин цагийн ардчиллыг намуудгүйгээр төсөөлшгүй” хэмээн хэлсэн нь магадгүй энэ тохиолдолд туйлын үнэн юм. Өөрөөр хэлбэл тэд сайн ажиллаж чадвал улс төрийн намууд ардчиллын хүлэг болох буюу ардчиллын хөгжилд эерэг нөлөө үзүүлэх институци юм.

Үүний нотолгоо нь өнөөдрийг хүртэл улс төрийн нам нь хууль тогтоогчид, нэр дэвшигчид, сонгогчдод ардчилалтай холбоотой тулгардаг сорилтуудыг даван туулахад нь тусалдаг институци болон хөгжиж ирсэнд оршино.

Тухайлбал улс төрийн нам нь хууль тогтоох байгууллагад улс төрчдөд бодлого боловсруулах, хоорондоо зөвшилцөл хийхэд улс төрийн намын сонгуулийн мөрийн хөтөлбөр хэмээх удирдамжийг боловсруулж өгч түүний дагуу хууль тогтоох боломжийг өгдөг. Сонирхолтой нэг тал нь улс төрийн нам нь сонгуулийн зардлыг бууруулахад хувь нэмэртэй байж чаддаг. Энэ нь улс төрийн намаас нэр дэвшигч намд суурилсан сурталчилгаа хийдэг тул намын бусад гишүүдэд эерэг нөлөөллийг бий болгодог. Улмаар намын харьяалал нь нэр дэвшигчийг сонгогчдын өмнө нэр хүндтэй болгоход тусалж дэмжигчдийг бүрдүүлж өгч чаддаг нь сонгуулийн зардалд хэмнэлт үүсгэх шууд нөхцөл болдог. Мөн сонгогчдын хувьд намууд хэрэгтэй мэдээллийг дээд

зэргээр боловсруулж хамгийн бага хэмжээний мэдээллээр маш нарийн төвөгтэй шийдвэр гаргахад тусалдаг хэмээн Алдрих (Aldrich) үзсэн байдаг.¹

Улс төрийн нам нь ардчилалд дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь төр, иргэн хоёрыг холбогч болдог. Энэ нь нийгэм болон нийгмийн бүлгүүдтэй харилцах, тэдгээрийн ашиг сонирхлыг илэрхийлэхтэй холбоотой *сонирхол илэрхийлэх (сонирхлын артикуляци), сонирхол нэгтгэх (сонирхлын агрегаци)*, улс төрийн нийгэмшилтийг хангах байдлаар илэрдэг. Улс төрийн нам нь олон нийтийн сонирхлын бүхэлд нь төлөөлөх чадвартай тул сонирхлын бүлгээс маш том ялгаатай. Тиймээс сонирхлын бүлэг эсвэл ТББ-уудаас илүү сонирхлын эрэмбэ тогтоох, бүлгүүдийн сонирхлыг харьцангуй жигд харгалзах бололцоо сонирхлын агрегаци буюу сонирхол нэгтгэх үйл явцаар илэрч байдаг. Энэ нь улс төрийн намууд нь сонгогчид болон намын гишүүдээс санал авах замаар олонхын дэмжлэг авч засаглалыг хэрэгжүүлэхийн төлөө өрсөлддөг ардчиллын нийтлэг жишиг болно.

Нөгөө талаас улс төрийн нам нь боловсруулсан мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хэр сайн гүйцэтгэсэн эсэхийг улс төрчдөөс сонгогчдоор дамжуулж хариуцлага тооцох замаар дамжуулж мэдэж чаддаг цорын ганц институци юм.

Хамгийн чухал нь институцлагдаж чадсан, нийтийн сайн сайханд үйлчилж чаддаг улс төрийн нам байхгүй бол иргэд ардчиллаас хөндийрөх, ардчилалд дургүй болох, ардчилал тухайн төрд байхгүй болох сөрөг байдал илэрнэ. Иймээс чадварлаг улс төрийн намууд нь ардчилал хөгжихөд хамгийн сайн нөлөө үзүүлдэг ардчиллын чухал институци юм. Улс төрийн намын ардчиллын хөгжил, түүний тогтвортой байдалд нөлөө үзүүлэх гурван чухал үзүүлэлт байдаг. Үүнд:

- Улс төрийн намын тоо
- Улс төрийн намын өрсөлдөөн
- Улс төрийн намын тогтолцоог үндэсний болсон байх ёстой гэсэн үзүүлэлтүүд юм.

Улс төрийн намын тоо:

Ардчиллын хөгжилд улс төрийн намын тоо шууд хамааралтай байдаг. Энэ нь парламентад сонгогдох намын тоо нь төлөөллийн болон хариуцлага хоорондын уялдаа холбоог илэрхийлдэг гэж үздэг.

Улс төрийн намын өрсөлдөөн:

Хамгийн чухал үзүүлэлт нь улс төрийн нам хоорондын өрсөлдөөн харьцангуй тогтвортой үед намын тогтолцооны институцлал үүсдэг гэж үздэг. Ийм тогтолцоо дахь улс төрийн намуудын чадавх, институцлагдсан байдлын шошго нь сонгогч, нэр дэвшигчдийн аль алинд нь үнэ цэнтэй болдог.²

Улс төрийн намын тогтолцоог үндэсний болгох:

Энэ хандлагын амин сүнс нь улс төрийн томоохон намуудын хэр хэмжээг илэрхийлж байдаг. Улс төрийн намууд үндэсний эсвэл орон нутгийн түвшин эсвэл үндэсний болон анхан дунд шатны аль сонгуульд оролцож, өрсөлдөж чадаж байгаа эсэх асуудал юм. Улс төрийн намын тогтолцоо сайн төлөвшсөн байдал нь сонголтын төлөөлөх чадвар сайтай, хариуцлага тооцох боломжтой, ихэнх улс төрийн намууд нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг гэх мэт шинжүүд ажиглагддаг. Энэхүү шалгууруудыг хангахгүй байвал ардчиллын хууль ёсны байдал хэврэг байгааг илтгэх юм.

¹ Aldrich, John. 1995. Why Parties?: The Origin and Transformation of Political Parties in America. American Politics and Political Economy Series. University of Chicago Press.

² Mainwaring, Scott, ed. 2018. Party Systems in Latin America: Institutionalization, Decay, and Collapse. Cambridge: Cambridge University Press

Харин улс төрийн нам дараах үндсэн үүргийг биелүүлж чадаж байвал ардчилал оршиж байгааг гэдгийг илтгэж байдаг. Тухайлбал:

Улс төрийн намын нийгмийн үүрэг: Иргэдийн ашиг сонирхлыг нэгтгэн тодорхойлохыг эрмэлздэг бөгөөд тэдний хүсэл зоригоо илэрхийлэх арга замыг “зааж” өгөх хийгээд шаардлагыг тодорхой түвшинд гаргадаг. Тухайлбал, иргэдийн ашиг сонирхлын өмнөөс хурал, жагсаал, цуглаан зохион байгуулахаас эхлээд хувьсгалд уриалан дуудах гэх мэт.

Үзэл сүртлын үүрэг: Нийт нийгмийн гишүүд хийгээд өөрийн гишүүдээ улс төрийн тодорхой үзэл баримтлалыг санал болгож итгэл үнэмшилтэй болгосноор өөрсдийн боловсруулсан нийгмийн өөрчлөлтийн стратегия дэмжүүлдэг. Тухайлбал, либерал, консерватив, социал-демократ, фашист, коммунист гэх мэт үзэл баримтлалыг санал болгодог.

Улс төрийн үүрэг буюу сонгуулийн, удирдлагын үүрэг: Төрийн эрх мэдлийн төлөө сонгуульд оролцож, засаглах эрх мэдэл болон түүнд оролцох эрх авах, төрийн бодлогыг тодорхойлох, төрийн албан тушаалд өөрсдийн хүмүүсийг бэлтгэн байршуулах үүргийг хүлээнэ. Улмаар ард түмний эрх ашигт нийцүүлэн ажиллах хийгээд ард түмнийг төлөөлөх үүргийг хүлээнэ.

Орчин үед институцчлагдсан намууд ардчилалтай нягт холбоотой болохыг нотлох эмпирик баримтууд улам бүр нэмэгдсээр байна. Жишээлбэл, улс төрийн намууд хүчирхэг улс орнуудад популистууд гарч ирэх, амжилтад хүрэх магадлал бага байдаг. Эсрэг тохиолдолд буюу улс төрийн намууд сул, нэгдмэл бус сонгогчид нь популистуудад нээлттэй хаалга болж өгдөг байна.³

Судлаач Бернхардын (Bernhard) үзэж байгаагаар институцчлагдсан намууд ардчиллаас урвах нь боломжийг хаадаг гэсэн. Тухайлбал ардчиллын статус-кво (status quo)⁴ дахь илүү их оролцоо, урт хугацааны үйл ажиллагааны явцад ардчиллын хэм хэмжээ, институцийг зөрчих гэсэн боломжит оролдлогыг эсэргүүцэх магадлал өндөр байдаг. Мөн найдвартай дэмжлэг бааз, зохион байгуулалтын чадавхтай байдаг гэжээ. Учир нь институцчлагдсан намуудын лидерүүд ардчилсан хэлэлцээрээс гажуудсан өрсөлдөгчийнхөө оролдлогын хариуд хамтын үйл ажиллагаагаар даван туулах чадвартай.

Зарим судалгааны өгүүллэгүүд ардчилсан нийгэмд улс төрийн намууд дараах үүргийг гүйцэтгэнэ⁵ хэмээсэн байдаг. Үүнд:

- Гишүүд, дэмжигчдийн тодорхойлсон төрийн бодлогын тэргүүлэх чиглэл, иргэний хэрэгцээ, тулгамдсан асуудлуудыг эрэлхийлж, илэрхийлэх
- Сонгогч, иргэдийг улс төр, сонгуулийн тогтолцооны үйл ажиллагаанд нийгэмшүүлэх, сургах, улс төрийн ерөнхий үнэт зүйлийг бий болгох
- Сөрөг хүчний шаардлагыг тэнцвэржүүлж, ерөнхий бодлого болгон хувиргах
- Иргэдийг улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, дайчлах
- Шийдвэр гаргах, тэдний санал бодлыг бодит бодлогын хувилбар болгон хувиргах
- Олон нийтийн санаа бодлыг төрд дамжуулах

³ Self Darin and Allen Hicken. 2018. Why populism? how parties shape the electoral fortune of populists. V-Dem Working Paper 2018; No. 76.

⁴ Статус кво гэдэг нь өнөөгийн байдал, ялангуяа нийгэм, улс төр, шашин шүтлэг, цэргийн асуудалтай холбоотой латин хэллэг юм.[1] Социологийн утгаараа статус кво гэдэг нь нийгмийн бүтэц эсвэл үнэт зүйлсийн өнөөгийн байдлыг илэрхийлдэг.[2] Бодлогын мэтгэлцээний тухайд энэ нь боломжит өөрчлөлттэй харьцуулахад нөхцөл байдал ямар байна гэдгийг илэрхийлнэ.

⁵ ACE, The Electoral Knowledge Network “Parties and Candidates-Roles and Definition of Political Parties” article, 2012, 2nd edition

- Төрийн албанд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, сургах зэрэг үүргүүд болно. Улс төрийн нам нь ардчилсан нийгэмд олон үүргийг гүйцэтгэдэг ба сонгуульд оролцох, нэр дэвшигчийг тодруулах, танилцуулах нь иргэдэд хамгийн түгээмэл танигдсан үүрэг юм.

Улмаар дээр дурдсан үүрэг, чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн нам, иргэдэд үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажсан, эсхүл заасан эрх, үүрэг шаардлагатай⁶ гэжээ. Энэхүү эрхүүд нь ардчилсан тогтолцоонд нь хэрэгжих боломжтой юм. Үүнд:

- Зохион байгуулалтын эрх чөлөө буюу эвлэлдэн нэгдэх эрх
- Сонгуульд нэр дэвших эрх чөлөө
- Үг хэлэх, цуглаан хийх эрх чөлөө
- Нам, нэр дэвшигчдийн шударга, тайван өрсөлдөөнийг хангах
- Олон ургальч байдлыг хангах механизмууд бүрэлдсэн байх
- Сонгуулийн үйл явцад оролцох, сонгуулийн байгууллагатай харилцах эрх
- Тоглолтын тэгш талбар, гарааны тэгш боломж, ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцөл бүрдсэн байх

- Хэвлэл мэдээллийн хүртээмж, шударга мэдээлэх баталгаа хангагдсан байх
 - Ил тод, хариуцлагатай улс төрийн санхүүжилттэй байх зэргийг дурдаж болно. Энэ бүхнээс харахад улс төрийн нам, ардчилал хоёрын уялдаа холбоо нь харилцан хөгжих хөшүүрэг болдог байна.

Судлаач Л.Даймонд, Р. Гюнтер нар “Улс төрийн намууд ба Ардчилал” бүтээлдээ орчин үеийн ардчилсан улс төрийн системд намууд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж тэмдэглээд улс төрийн намын гүйцэтгэх үүргийг долоо ангилж илүү нарийвчилсан байдаг. Л.Даймонд, Р. Гюнтер нарынхаар улс төрийн намын үүргүүдийг дурдвал:

- Нэр дэвшүүлэх үе буюу элитийг татан оролцуулах, сонгуульд тухайн намыг төлөөлөн өрсөлдөх хүнийг олох, бэлтгэх үүрэгтэй

- Сонгуулийн дайчилгааны үе буюу намууд нэр дэвшигчээ дэмжүүлэхийн тулд сонгогчдынхоо сэдлийг идэвхжүүлж, зарим тохиолдолд тэднийг сонгуулийн үйл явцад идэвхтэй оролцох бололцоогоор хангах үүрэгтэй

- Асуудлыг бүтэцжүүлэх чиг үүрэг буюу нийгмийн бүлгүүд тодорхой асуудлаар богино эсвэл урт хугацааны турш илэрхийлж буй эсэхээс янз бүрийн асуудлаар сонголт, альтернативыг бүтэцжүүлэхэд намууд үүрэгтэй

- Нийгмийн төлөөллийн чиг үүрэг нь нийгмийн янз бүрийн бүлгийг төлөөлөх чиг үүрэгтэй байдаг ба энэ төлөөлөл нь бэлэгдлийн чанартай ч байдаг, тодорхой ашиг сонирхлыг урагшлуулах хэлбэртэй ч байдаг. Энэ үүрэг нь сонгуулийн үед бүлгүүдийн дэмжлэг авахын төлөө өрсөлдөөний явцад илэрнэ. Мөн сонгуулийн дараа хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх үеэр хууль тогтоох явцад илэрдэг

- Ашиг сонирхлыг нэгтгэн нягтруулах нь намуудын үүрэг: бүлгүүдийн сонирхлыг түгээмэл биш юмаа гэхэд илүү өргөн хүрээнд нэгтгэн нягтруулахад чиглэх ёстой. Энэ нь олон нам бүхий парламентын системтэй орнуудад ашиг сонирхлыг нэгтгэх, нягтруулах үйл явц сонгуулийн дараа засаг барих, эсвэл байгуулагдах үед явагддаг.

- Засгийн газрыг ажиллуулах үүрэг нь ажлаа хийж чадаж байгаа эсэхийн чухал хэмжүүр болдог

- Нийгмийн интеграцчлалыг хангах үүрэг нь намууд улс төрийн үйл явцад үр дүнтэй оролцох боломжийг иргэдэд олгодог ба ийнхүү оролцсон иргэд тодорхой амжилтанд хүрэхдээ системийг цааш нь үргэлжүүлэн авч явах сонирхолтой болдог гэж дүгнэсэн байдаг.

⁶ Ibid.

Манай улсын хувьд “Улс төрийн харилцаа, түүнийг өөрчлөх, шинэтгэх үйл явц нь хүний улс төрийн эрх, эрх чөлөөний тэмцлээр, юуны өмнө иргэд улс төрийн хөдөлгөөний тодорхой хэлбэрээр зохион байгуулагдаж нэгдсэн засгийн эрхийн төлөө тэмцэл явдлаар илэрдэг. Тийм чухал хэлбэрийн нэг нь нам мөн”⁷ хэмээн Монгол Улсын Үндсэн хуулийн эрхийг баригч Б.Чимид “Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр” бүтээлдээ тэмдэглэн үлдээсэн байдаг. Өөрөөр хэлбэл улс төрийн нам гэдэг төрийн эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрээр байгуулагддаггүй, иргэдийн сайн дурын эвлэлдэн нэгдэх эрхийн үндэс иргэний байгууллага хийгээд ардчиллын салшгүй нэг хэсэг яах аргагүй мөн гэж үзсэн байна.

Улс төрийн намуудын зохион байгуулалт, иргэд, төр бие биетэйгээ харилцах харилцаа 19-20-р зууны эхэн үед либерал ардчилал үүсэж хөгжсөнөөс хойш хөгжиж ирсэн байдаг. Манай улс хувьд 1921-1990 онд нэг улс төрийн намын тогтолцоогоор, 1990- оноос хойш олон намын тогтолцоо бүхий ардчилсан улс төрийн тогтолцоогоор эрх мэдлийн хуваарилалт хийн харьцангуй тайван замаар ардчилсан улс төрийн соёлыг төлөвшүүлсээр байна. Үүний илрэл нь 1990 оны Улс төрийн намын тухай, 1992 оны ардчилсан Үндсэн хуулиар тус тус “Улс төрийн нам”-ын эрх зүйн зохицуулалтыг баталснаар олон намын тогтолцоог эрх зүйн хувьд баталгаажуулсан явдал билээ. Ингэснээр сөрөг хүчин бусад улс төрийн намууд албан ёсоор бүртгүүлж, үйл ажиллагаа явуулах боломж бүрэлдсэн ба Монголд анхны нам байгуулагдаад 100 жил, намын систем үүсээд 32 жил болж, нийгмийн бүх үйл явцад улс төрийн нам гэх институци том орон зайг эзэлсээр иржээ.

Ардчилал засаглал бүхий улс оронд төрийн эрх мэдэлд хүрэхийн тулд улс төр, эдийн засаг, нийгмийн бодлого хэрэгжүүлэх гол суваг нь улс төрийн намууд болно. Тийм ч учраас Монгол улсын хувьд цаашид ардчилал тогтвортой төлөвших эсэх нь намын системийн тогтвортой байдлаас ихээхэн хамаарна. Өөрөөр хэлбэл намын системийн инстүүчлэл нь эрүүл ардчилал төлөвших нэг нөхцөл болдог байна.⁸

Дээрх байдлаас харахад үүргээ бүрэн биелүүлж чадахуйц чадавхтай, хүчирхэг, институцлагдсан улс төрийн нам ардчиллын хөгжилд чухал байр суурь эзэлдэг болохыг харах боломжтой байна. Нөгөө талаасаа улс төрийн нам нь улс төрчдийн богино хугацааны ашиг сонирхол болон улс орны урт хугацааны ашиг сонирхлыг тэнцвэртэй байлгаж чаддаг.⁹ Гэхдээ зөвхөн урт настай институцлал сайн хийгдсэн нам л чадна.

II. Ардчилалд картель намын үзүүлэх нөлөө

а. Ардчиллын загвар ба улс төрийн намуудын хэв маяг

Улс төрийн намын тоо олон ургалч байдлыг илэрхийлж, үзэл бодлыг дамжуулах институци хэдий ч намуудын тоо өсөх хэрээр бодлогыг хэн хариуцах, гүйцэтгэл муу улс төрчийг албан тушаалаас огцруулах зэрэгт хүндрэл учирдаг сөрөг талтай. Улмаар улс төрийн намын өрсөлдөөн нь түр зуурын шинжтэй, намын үзэл баримтлал нь тодорхойгүй, зохион байгуулалт сул, дэмжлэгийн тогтвортой суурь байхгүй намууд ихтэй бол сул институцилагдсан нам байхгүй байгааг илтгэж байдаг.

Ардчилсан засаглал тогтвортой хөгжихийн хэрээр улс төрийн намын хэв маяг, тогтолцооны өөрчлөлтүүд хийгдсэн. Улс төрийн намын зохион байгуулалт, хэв

⁷ Б.Чимид “Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр” УБ, 2006 он, 37 дахь тал

⁸ Б.Бат-Оргил, Г.Батхишиг “Монголын намын системийн инстүүчлэл”, УБ, 2020 он. Фефакто институт, Конрад Аденауэр Сан.. http://defacto.mn/wp-content/uploads/2020/09/instuchlel_tailanB5_okE01.pdf

⁹ Hicken, Allen, Ken Kollman, and Joel W. Simmons. 2016. “Party System Nationalization and the Provision of Public Health Services.” *Political Science Research and Methods* 4, no. 3: 573–594.

маягаар нь Элит нам, Масс нам, Өргөн хүрээний нам, Хөтөлбөрийн буюу Бодлогын нам гэх мэтээр ангилж ирсэн.

Судлаач П.Норрис намын эрх зүйг зохицуулалтаар нь “монополь, картель, эгалитар” гэж гурав хуваасан байдаг.¹⁰ Тодруулбал:

Монополь:

Эрх баригч намд давуу байдал олгосон сөрөг хүчний намуудыг хязгаарласан, хориглосон, нэг нам засагласан улс оронд буй эрх зүйн зохицуулалт

Картель:

Хүний ерөнхий эрхийг хүндэтгэдэг боловч парламентын эсвэл засгийн газарт буй намуудад ашигтай, өрсөлдөөнийг хязгаарладаг, хуулиар эрх баригч намуудад давуу байдлаа хадгалж үлдэх нөхцөлтэй шударга бус зохицуулалт

Эгалитар:

Хамгийн шударга зохицуулалт нь олон намуудын өрсөлдөөнийг дэмжсэн, төрийн нөөц, дэмжлэгийг том жижиг, шинэ хуучин гэхгүй бүгдэд ижил тэгш хүртээмжтэй тараах, сонгуулийн хуудас дээр нам, нэр дэвшигчдэд шударга нөхцөлийг хангасан эрх зүйн зохицуулалт тус тус ойлгож болно.

Ардчиллын хөгжилд Картель нам сөрөг нөлөөтэй байх гол шинж нь “Улс төрийн нам нь хувь улс төрчдийн нийлсэн орон зай, хувь улс төрчийн дахин сонгогдох хүсэл, стратегийн тусгал” болдог тул эрх зүйн байдлаар өөрийнхөө давуу байдлыг хадгалж чаддаг. Энэ нь улс төрийн намын тоо, өрсөлдөөн, үндэсний хэмжээний нам болон хөгжихөд саад болдог.

Картель намын сөрөг талыг бусад улс төрийн намын хэв маяг, зохион байгуулалттай харьцуулж үзье (Хүснэгт.1-ийг харах).

¹⁰ Э.Гэрэлт-Од, “Монгол Улсын намын эрх зүй ба намуудын байр суурь”, Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл 2020, 33-34 дэх тал.

Хүснэгт. 1. Улс төрийн намуудын загваруудыг ангилсан байдал

Онцлог шинж чанарууд	Элит нам	Массын нам	Өргөн хүрээний нам	Картель нам
Цаг үе	19-р зуун	1880-1960	1945 оноос хойш	1970 оноос хойш
Үүсэл	Парламент дотор	Парламентын гадна	Элит, масс намуудаас хөгжсөн	Төрийн зүгээс намуудын үйл ажиллагааг хүчтэй дэмжсэн газарт үүснэ.
Гол шаардлага	Лидерүүдийн уламжлалт статус	Нийгмийн бүлгүүдийн төлөөлөл	Удирдах ур ухаан	Удирдах ур ухаан, чадвар, манлайлал
Гишүүнчлэл	Цөөн, элит	Батлах бүхий олон тооны гишүүд	Лидерүүд зонхилдог	Батлах бүхий олон тооны гишүүд
Орлогын эх үүсвэр	Хувийн холбоо	Гишүүдийн татвар, хандив	Төрийн санхүүжилт, бусад олон эх үүсвэр	Төрийн санхүүжилт, гишүүдийн хандив, татвар болон бусад эх үүсвэр
Нийгэм улс төрийн оролцооны зэрэг	Хязгаарлагдмал сонгуулийн эрх	Тухайлсан хувь хүн, бүлгийн сонгох эрх ба олон нийтийн сонгуулийн эрх	Бүх нийтийн сонгуулийн эрх	Бүх нийтийн сонгуулийн эрх
Улс төрийн хамааралтай нөөцийн хуваарилалтын түвшин	Маш хязгаарлагдмал	Харьцангуй төвлөрсөн	Төвлөрөл багатай	Харьцангуй тархсан
Улс төрийн гол зорилго	Эрхийн хуваарилалт	Нийгмийн шинэчлэл (эсвэл эсэргүүцэх)	Нийгмийн сайжруулалт	Улс төр бол мэргэжил
Намын өрсөлдөөний үндэс	Нийгмийн гарлаар тодорхойлогдох нийгэмд эзлэх байр суурь	Төлөөлөгчийн чадавх	Бодлогын үр нөлөө	Удирдах ур чадвар, үр нөлөө
Сонгуулийн өрсөлдөөний загвар	Удирдсан	Дайчлах	Өрсөлдөх чадвартай	Хязгаарласан
Намын ажил				

болоод намын сурталчилгааны шинж	Хамааралгүй	Хөдөлмөр шаарддаг	Хөдөлмөр болоод хөрөнгө шаарддаг	Хөрөнгө шаарддаг
Намын нөөцийн гол эх үүсвэр	Хувь хүмүүсийн холбоо харилцаа	Гишүүдийн хураамж ба хандив	Олон төрлийн эх сурвалж бүхий хандив	Төрийн санхүүжилт
Энгийн гишүүн ба намын элитийн хоорондох харилцаа	Элитүүд бол энгийн гишүүд	Доороос дээш, элит нь гишүүдийн өмнө хариуцлага хүлээдэг.	Дээрээс доош, гишүүд нь элитэд зориулсан зохион байгуулалттай.	Эрх мэдлийн давхарга, харилцан бие даасан байдал
Гишүүнчлэлийн шинж чанар	Жижиг, элитист	Том ба нэгэн төрлийн, идэвхитэй элсүүлсэн гишүүнчлэл нь үр дагавар, эрх үүргийг чухалчилдаг.	Гишүүнчлэл нь бүгдэд нээлттэй бөгөөд урамшуулсан, үүрэг бус эрхийг чухалчилдаг, гишүүнчлэл нь хувь хүний шинж чанартай.	Эрх, үүргийн аль нь ч чухал биш (гишүүн болон гишүүн бус хүмүүсийн ялгаа бүдгэрсэн), гишүүдийг зохион байгуулалттай бүлэг гэхээс илүү хувь хүн гэж онцлох, үлгэр домгийг хууль ёсны болгоход оруулсан хувь нэмрийг үнэлнэ.
Намын харилцааны сувгууд	Хувь хүн хоорондын сүлжээ	Нам өөрийн харилцааны сувгийг үүсгэдэг.	Нам нь нам бус харилцааны сувагт нэвтрэхийн төлөө өрсөлддөг.	Нам төрийн зохицуулалттай харилцааны сувгуудад нэвтрэх эрх олж авдаг.
Иргэний нийгэм ба төрийн хоорондох намын байр суурь	Төр болон улс төрийн хамаарал бүхий иргэний нийгмийн хоорондын хил хязгаар тодорхойгүй	Нам нь иргэний нийгэмд харьяалагддаг бөгөөд анхандаа иргэний нийгмийн холбогдох хэсгийн төлөөлөл болно.	Намууд иргэний нийгэм болоод төр хооронд өрсөлддөг зуучлагч (брокерууд) болно.	Нам төрийн нэг хэсэг болно.
Төлөөлөгчийн хэв маяг	Итгэмжлэгч	Төлөөлөгч	Бизнес эрхлэгч	Төрийн төлөөлөгч

Сонгодог жишээ	XIX зууны либерал намууд, Посткоммунист намууд	Социалист намууд	Европын орчин үеийн Христосын болон социал демократ намууд	Итали, Израйлын улс төрийн намууд
----------------	--	------------------	---	-----------------------------------

Эх сурвалж: Катиц болон Майрийн намын загварууд

Манай улсын хувьд социалист тогтолцооны үеийн намын эрх зүйн зохицуулалтыг “Монополь” загвартай байсан гэж үздэг бол ардчилсан тогтолцооны үед намын эрх зүйн зохицуулалтыг “Картель” загвартай гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл картель нам төрийн зүгээс намуудын үйл ажиллагааг хүчтэй дэмжсэн газарт үүсэх бөгөөд намууд хоорондоо хорших, хамтран ажиллах нь их байдаг хандлагатай.

Улмаар улс төрийн намын хөгжил ардчилал хоёр хоорондоо уялдаатай болохыг дараах хүснэгт.2-оос харах боломжтой. Энэ нь ардчилсан тогтолцооны шинжээс хамааран улс төрийн намын аль хэв маяг илүү зонхилдог болохыг үзүүлсэн.

Хүснэгт. 2. Ардчиллын загвар улс төрийн намын хэв маягтай уялдах нь

Улс төрийн нам	Ардчиллын загвар	Үндсэн зарчим
Элитийн Олон түмний Өргөн хүрээний Картель	Хязгаарлагдмал Төлөөллийн Плюраль Зөвшлийн	Элитийг солих Хариуцлага Сөрөг шинж Легитим шинж

Намын хэв маягууд ба ардчиллын загваруудын холбоог дараах байдлаар тайлбарлая. Элитийн намын хувьд ашиг сонирхлыг бүх нийтийн хэмээн төсөөлж засгийн эрхийн төлөө тэмцдэг. Олон түмний намын хувьд төлөөллийн ардчилалтай холбоотой бөгөөд энд засгийн эрхийн төлөө өрсөлдөөний зэрэгцээ бүх нийтийн сонгуулиас үүдэн олон түмний харьцангуй өргөн оролцоог чухалчилдаг. Намууд социал бүлгүүдийн тоймтой ашиг сонирхлыг илэрхийлж, сонгогдсон албан тушаалтууд сонгогчдын өмнө бодлого, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээдэг зарчимтай байна. Catch-all буюу өргөн хүрээний намууд плюраль ардчиллын нөхцөлд үйл ажиллагаагаа сайн явуулж, үзэл суртал болон төлөөллөөр ялгарахыг саармагжуулах бололцоо олгодог байна.

Харин улс төрийн мөрийн хөтөлбөр нь төдийлөн ялгардаггүй “төрийн зүтгэлтнүүд” холбоо нийгэмлэг маягийн “картель намууд” зөвшилцлийн ардчиллыг бий болгодог байна. Орчин үеийн улс төрийн намуудын хөгжилд картель хэв маяг мэдэгдэхүйц тодорч, үүний хажуугаар намууд дотоод ардчиллаа хөгжүүлэх талаар анхаарсаар байна. Картель намын талаар олон нийтийн хөдөлгөөнүүд, хэт баруун, зүүний популист намууд, неокорпоративизмууд өөр өнцгөөр харж, өөрийн хувилбаруудыг дэвшүүлдэг. Үүний учир нь 1970-аад оны үед улстөрийн тавцанд гарч ирсэн олон нийтийн хөдөлгөөнүүд намуудыг шүүмжилж улс төрийн байгууллагууд төржиж, намууд олон түмний язгуур эрх ашгаас тасарч, хэт улстөржиж, элитар, олигархи шинжтэй болж байна хэмээж байсантай холбоотой.

Ардчилсан тогтолцоонд картель нам хэрхэн бий болдог талаар Италийн жишээг үзье. 1996 онд Италийн сонгууль маш хурцадмал болж өнгөрсөн. Сонгуулийн хурцадмал байдал нь “Берлускони¹-ийн улс төрийн ярианы хэт туйлширсан үзэл суртал, Италийн зүүн төвийн эвслийн намуудын Берлусконизмын эсрэг үзэл, хойд лигийн салан тусгаарлах санал” гэсэн гурван хүчин зүйлээс хамаарсан байдаг. 1994 оны сонгуулийн дараа байгуулагдсан Засгийн газар богино хугацаанд хямралд орж их эвсэл эвдэрсэн байдаг. Үүнээс үүдэн зарим улс төрийн намууд Италийн Ерөнхий сайдад итгэл үзүүлэхээ больж зүүний үзэлтэй хүмүүсийг засгийн газарт томилсон ба хууль тогтоох болон улс төрийн бусад институциуд хямралд өртсөн.

¹ Silvio Berlusconi- Сильвио Берлускони нь 1994-1995, 2001-2006, 2008-2011 онуудад Италийн дөрвөн засгийн газарт Ерөнхий сайдаар ажиллаж байсан Италийн хэвлэл мэдээллийн магнат, улс төрч.

Сингапурын менежментийн их сургуулийн судлаач Риккардо Пелиццо 2006 оны “Картелийн намууд ба Картелийн намын тогтолцоо: Италийн жишээ” бүтээлдээ Италийн улс төрд дүн шинжилгээ хийхэд картель намын тогтолцоо бий эсэхийг хоёр аргаар судалжээ. *Нэгдүгээрт*, Италийн парламентын намууд болон олигополийн зах зээл² дэх байгууллагуудын зан төлөвтэй ижил төстэй байдал байгаа эсэхийг үнэлэх. Өөрөөр хэлбэл улс төрд цөөнх ноёрхож байгаа эсэхийг шалгах. *Хоёрдугаарт*, улс төрийн гол намуудын харилцан үйлчлэлийн үр дүнд бий болсон тогтолцоо нь олигополист байгууллагуудын картелийн үйл ажиллагаатай төстэй гэдгийг нотлох баримт байгаа эсэхийг үнэлэхийг зорьсон байна. Судалгааны үр дүнд засгийн газрын үндсэн чиглэл өөрчлөгдсөн, сонгогчдын шаардлагад нийцүүлсэн хууль тогтоомжийн өөрчлөлт гардаггүй, хууль тогтоомжууд гажуудсан гэсэн дүгнэлт гарчээ. Энэ нь бүх намаас дэмжлэг авсан хуулийн төсөл батлагддаг. Харин нам хоорондын санал зөрөлдөөнтэй байгаа хуулийн төсөл бүгдэд ашиггүй тул батлагддаггүй буюу намууд ямар хууль батлах, эс батлахыг тохиролцдог гэх мэт жишээгээр нам картельжих үзэгдэл нь нотлогдсон байна.

Дээрх байдлаас харахад ардчилсан тогтолцоонд улс төрийн намын гажуудсан хэв маяг үүсэх магадлал өндөр байна.

в. Ардчилал ба картель нам

20-р зууны сүүлд улс төрийн намуудын бодлогын үзэл баримтлал буурч, уламжлалт намын бүлгийн шинж чанараа алдаж задарсны улмаар олон түмний намын зохион байгуулалт олон улс оронд буурчээ. Ялангуяа ардчилсан улс орнууд дахь олон түмний намын бууралт нь сонгогчдоос намуудад оруулдаг санхүүгийн болон эд хөрөнгийн дэмжлэгийг буурахад хүргэсэн. Тиймээс улс төрийн намууд ард түмний дэмжлэг буурсныг нөхөхийн тулд намууд илүү том, илүү үнэтэй улс төрийн компани ажлууд хийж төрөөс их хэмжээний татаас болон хандив цуглуулах хэлбэрт шилжиж эхэлсэн.

Картелийн намууд нь 1970-аад оноос хойш үүссэн улс төрийн намуудын нэг төрөл бөгөөд төрийн хүнд санхүүжилт, зохион байгуулах зарчим болох үзэл суртлын үүрэг багассанаар илэрнэ. Картелийн намын тухай анхны судалгааг Ричард Катц, Питер Майр нар боловсруулсан бөгөөд тэд улс төрийн намууд нийгмийн бүлгүүдээс илүүтэйгээр төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг "хагас төрийн агентлагууд" болж хувирсан гэж анхны судалгаандаа бичсэн байдаг.

"Картель нам" гэсэн нэр томьёо нь засгийн газарт нэр хүндтэй намууд, шинэ намууд орж ирэхэд хүндрэл учруулдаг, ингэснээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг намуудын картелийг бүрдүүлдэг гэсэн агуулгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл улс төрийн тогтолцоонд байр сууриа хадгалахын тулд төрийн нөөцийг ашигладаг, картельтэй адил үйл ажиллагаа явуулдаг намыг ойлгож болно.

Тодорхойлолтыг задлан тайлбарлавал картелийн нам нь ардчилсан дэвшилтэт улс төрд үүсэн бий болдог, нам-төр хоёрыг хооронд нь холбож намууд хоорондын тохиролцооны хэв маягаар тодорхойлогддог намуудын нэг төрөл байна. Картелийн нам хөгжихийн хэрээр улс төрийн зорилго нь бие даасан, мэргэжлийн, технократ шинж чанартай болж, нам хоорондын өрсөлдөөн бага хэвээр байвал нэг нам улс төрийг үр ашигтай, үр дүнтэй удирдахад чиглэгддэг. Өргөн хүрээний намуудын нэгэн адил намууд улс төрийн тогтолцоо дахь байр сууриа хадгалахын тулд төрийн нөөцийг ашигладаг тул картель намуудын гишүүдийн үүрэг үндсэндээ ач холбогдолгүй болдог.

² Олигополь зах зээл – шийдвэр гаргалт нь харилцан хамааралтай, харьцангуй цөөн тооны компани зах зээлийн ихэнх хувийг эзэлсэн, орох болох гарах үйл явц бэрхшээлтэй зах зээлийг ойлгоно. Өөрөөр хэлбэл харьцангуй цөөн тооны пүүс тухайн зах зээлд ноёрхол тогтоосон үед олигополь үүснэ.

Картелийн намуудын явуулж буй сонгуулийн кампанит ажил нь хөрөнгө оруулалт их шаарддаг, мэргэшсэн, төвлөрсөн байдаг бөгөөд төрөөс санхүүгийн дэмжлэг авах, бусад хөнгөлөлт, давуу эрх авах үндсэн дээр зохион байгуулагддаг.

Дээрх байдлаас харахад ардчилсан тогтолцоонд улс төрийн нам нь нийгэмд гүйцэтгэх үүргээ гажуудуулсан байдлаар засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэх сул тал байгааг харах боломжтой байна.

Дүгнэлт

Дүгнэж хэлэхэд, ардчиллыг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд улс төрийн намууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэд сонгогчдыг төртэй холбодог гол байгууллага юм. Улс төрийн намууд сайн ажиллаж байгаа тохиолдолд олон талын ашиг сонирхлыг төлөөлөх, ардчилсан хариуцлагыг хөнгөвчилж өгдөг. Харин эсрэг тохиолдолд засгийн газар муудах, сонгогчдын шаардлагад нийцүүлсэн хууль тогтоомжийн өөрчлөлт гарахгүй байх, хууль тогтоомжууд гажуудах, бүх намаас дэмжлэг авсан хуулийн төсөл батлагддаг, нам хоорондын санал зөрөлдөөнтэй байгаа хуулийн төсөл бүгдэд ашиггүй тул батлагдахгүй байх, намууд ямар хууль батлах, эс батлахыг тохиролцдог болох гэх мэт нам картельжих үзэгдлүүд илэрдэг болохыг Итали улсын жишээнээс харж болно. Тиймээс институцлагдсан улс төрийн намууд нь ардчиллын эвдрэл, ухралтаас сэргийлэх үндсэн тулгуурын нэг мөн. Улмаар намын тогтолцоо нь ардчилсан засаглалын даалгаврыг хэр амжилттай гүйцэтгэж байгааг тодорхойлоход тусалдаг. Намын тогтолцоо нь бодлого боловсруулах орчин дахь оролцооны өндөр байдал, итгэл үнэмшлийн түвшинг тогтооход дэмжлэг болдог. Учир нь бараг бүх ардчиллын цөмд улс төрийн намууд оршдог гэж хэлэх нь зүйтэй юм.

Манай улсын хувьд улс төрийн нам бодлогын ялгаатай байдлаараа өрсөлдөж чадахгүй байгаагийн улмаас иргэдийн улс төрийн сонголт мухардаж, клиентелист намын хэв маяг, намын картельжилт уруу шилждэг ба улмаар ардчилсан сонгуулийн зарчим алдагдан, популизм газар авахад хүрдэг.³ Манай улсад ч ийм байдал ажиглагдаж буй билээ. Иргэдийн зүгээс намууд бодлогоор бус популист шинжтэй сонгуулийн амлалтаараа уралдаж, иргэдээс санал авах ил, далд аргуудыг ашигладаг гэж үзэх байдал нийтлэг болохыг янз бүрийн судалгааны үр дүнгээс харж болно. Иймээс улс төрийн намын тогтолцоо нь ардчиллын төлөв байдлыг шууд тодорхойлдог ба харилцан шүтэлцээтэй учир хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах нь чухал байна.

Abstract:

In 1990, Mongolia made a reasonably peaceful transition from a one-party to a multi-party democratic political system. The unavoidable transition to democracy signaled the start of the growth of a political party system that would find a unique opportunity to evolve into a top-tier system of government. The groundwork was thus set for political parties to take part in governmental functions legally. Within the framework of this article, we aim to express the close connection between political parties and democracy at the empirical level. After that, we wrote about how the growth of democracy was closely related to the type, role, and system of political parties. Because a political party remains at the center of every democracy.

³ Я. Төгөлдөр, Д. Бумдарь, “Бодлогын намыг төлөвшүүлэх нь” 2021, (Нээлттэй нийгэм хүрээлэн)

Эх сурвалж:

- Б.Бат-Оргил, Г.Батхишиг “Монголын намын системийн инстүүчлэл”, УБ, 2020 он. Фефакто институт, Конрад Аденауэр Сан.
http://defacto.mn/wp-content/uploads/2020/09/instuchlel_tailanB5_okE01.pdf
- Э.Гэрэлт-Од, “Монгол Улсын намын эрх зүй ба намуудын байр суурь”, Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл 2020 он.
- Б.Чимид “Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр” УБ, 2006 он.
- Я. Төгөлдөр, Д. Бумдарь, “Бодлогын намыг төлөвшүүлэх нь” 2021, (Нээлттэй нийгэм хүрээлэн)
- Я. Төгөлдөр, Д. Бумдарь, “Эвлэлдэн нэгдэх эрх ба улс төрийн намын хатуу гишүүнчлэл” 2021, (Нээлттэй нийгэм хүрээлэн)
- Aldrich, John. 1995. Why Parties?: The Origin and Transformation of Political Parties in America. American Politics and Political Economy Series. University of Chicago Press.
- ACE, The Electoral Knowledge Network “Parties and Candidates-Roles and Definition of Political Parties” article, 2012, 2nd edition
- Hicken, Allen, Ken Kollman, and Joel W. Simmons. 2016. “Party System Nationalization and the Provision of Public Health Services.” Political Science Research and Methods 4, no. 3.
- Katz, Richard S.; Mair, Peter (1995). "Changing Models of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party". Party Politics. 1 (1): 16.
- Mainwaring, Scott, ed. 2018. Party Systems in Latin America: Institutionalization, Decay, and Collapse. Cambridge: Cambridge University Press
- Self Darin and Allen Hicken. 2018. Why populism? how parties shape the electoral fortune of populists. V-Dem Working Paper 2018; No. 76.
- Schumacher, Gijs (2017). "The Transformation of Political Parties". In van Praag, Philip (ed.). Political Science and Changing Politics. Amsterdam: Amsterdam University Press.

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ

С.Номынбаясгалан

МУИС, Шинжлэх ухааны сургуулийн докторант,

МУИС, Хууль зүйн сургуулийн докторант,

Хууль зүйн магистр (LL.M),

Монголын Криминологчдын холбооны судлаач

Товч агуулга:

Энэхүү өгүүллийн сэдвийг “Сонгуулийн эрх зүйн антропологи” гэж томъёолон, агуулгыг хууль зүйн нэр томъёоны асуудлаар хязгаарлав. Антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан юм. Судлагдахуун нь гол төлөв урт хугацааны туршид зорилтот оролцогчдыг ажиглаж, бодит амьдрал дээрх зүйлсийг судлахад оршино. Өөрөөр хэлбэл антропологичид эртний болон өмнө судлагдаагүй зүйлсийг хамруулан аливаа юмс, үзэгдэл зэрэг олон хэлбэрээр орших нийгмийн үзэгдлийг судалдаг. Эрх зүйн антропологи бол антропологийн ухаанд XIX зууны дүнд үеэс бий болсон ууган салбар бөгөөд эрх зүйн антропологи нь олон янзын нийгэм, соёлын онцлог ялгааг нэг талаас нийгэм, соёлын; нөгөө талаас эрх зүйн харилцааны үүднээс судалдаг. Энэ хүрээнд монголд хүний эрхийн талаархи ойлголт хэрхэн төлөвшиж, уламжлалт соёл, ахуй амьдрал, ёс заншил, итгэл үнэмшлийн онцлогтой хэрхэн холбогдож байгааг судлах боломжтой юм.

Түлхүүр үг: Хүн судлал (антропологи), эрх зүйн антропологи (хууль зүйн антропологи), этнографи, хууль зүйн хэл, хууль зүйн нэр томъёо, ius, lex.

I. Оршил

Социализмын гэх тодотголтой өмнөх үеийн эрх зүйн тогтолцоонд *антропологийн*¹ талаар судлах ямар ч бололцоо байсангүй. Энэ нь *хөрөнгөтний гадны*²

¹ Монгол хэлний нэр томъёоны хувьд, Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь хэмээх (1966) бүтээлийн “Хүн” гэсэн үгэнд холбогдох үгүүдэд хүн судлал гэсэн нэр томъёоны талаар бичиж тэмдэглээгүй байна. Харин Шинжлэх ухааны академиас эрхлэн гаргасан Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Таван боть, (Х – Я), Уб., 2008, 2752 дахь талд “хүн судлал” гэсэн нэр томъёог хэрэглэж, утгыг нь хүний гарал үүсэл, түүхэн хөгжил, эрүүл анатоми, галбир төрх, хэл, соёл судалдаг ухаан гэж тайлбарласан байна.

Олон нийтийн цахим сүлжээнд, хүн судлал буюу антропологи (англиар anthropology; оросоор антропология) гэдэг нь хүн, хүн төрөлхтнийг судлах байгалийн болон нийгмийн шинжлэх ухаан юм. 1501 онд Германы гүн ухаанч Магнус Хундт Антропологи (эртний Грек хэлний антропос хэмээх ἀνθρωπος, “хүн”, –логиа хэмээх λογία, “судлал”) гэдэг нэр томъёог анх хэрэглэсэн гэж бичсэн байна. <https://bit.ly/3MSYlbn> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

Монгол хэл дээр хэвлэгдсэн хүн судлалын талаархи бүтээлүүдэд, 1/хүн судлал буюу антропологи (anthropology) нь хүнийг өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн гурван цагийн хэмжээт төдийгүй бөмбөрцгийн бүхий л хэсэгт байгаа жишээ баримтад тулгуурлан судалдаг ухаан юм. Харин хүнийг судалдаг бусад нийгэм, хүмүүнлэгийн ухаанаас арга зүй, судалгааны сэдэв, судлагдахуун болох хүний асуудлыг хүн төрөлхтөн үүссэн эрт цагаас өнөөг хүртэлх цаг хугацааны өргөн хүрээнд судалдгаараа онцлогтой. Антропологи хэмээх нэршил нь үгийн гарлын хувьд Грек хэлний anthropos буюу хүн хүмүүн, logos буюу судлал, тэмдэглэл гэсэн холбоо үгс юм. Мөнх – Эрдэнэ Г., Чулуунбат П., Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., 2017, 3 дахь тал

2/хүн судлал бол хүний тухай шинжлэх ухааны байж болох бүхий л судлагдахууны нарийн түвэгтэй байдлыг тусган харуулсан, бүхнийг хамарсан, хамгийн ерөнхий нэр томъёо юм. Anthropologie гэдэг үг нь герег хэлний anthropologos (anthropos: хүмүүн) хэмээх үг латин хэлнээ зээлдсэн anthropologia гэсэн үг

гэж үзэж байсантай холбоотой болов уу. Ийнхүү антропологиийг зөвлөлтийн нөлөөтэй угсаатны зүй орлож байсан. Энэ нь тийм муу зүйл байсан бус харин онол, арга зүйн чиг баримжаа нь өөр байв. Өдгөө энэ байдал эрс өөрчлөгдөж, өөрийн хөгжлийн шинэ чиг хандлагаа олсон төдийгүй төрөлжин хөгжих нөхцөл боломж нь бүрдсэн байна. Тухайлбал, энэхүү *антропологиин ухааны* үүднээс өөрийн орны үндэсний хууль тогтоомжийг³ судлах нь антропологиин ухааны нэгэн томоохон салбар болох эрх зүйн антропологиийг Монгол Улсад хөгжүүлэх нэн таатай нөхцөл боломж болно гэж үзэж байна. Энэ нь цаашлаад монголын эрх зүйн тогтолцоонд антропологиин эрх зүйн сэтгэлгээ, онолын урсгалыг бий болгож, антропологиин ухаан нь хууль зүйн шинжлэх ухаанд нөлөөгөө улам өргөжүүлэн тэлж, төрөлжин хөгжих боломж байгаа гэдгийг илэрхийлж байна. Энэ нь *“антропологиин ухаан нь хууль зүйн шинжлэх ухаанд ямар хувь нэмэр оруулах боломжтой вэ”* гэсэн асуулт хариултаа хүлээсээр байгааг харуулж байна.⁴ Антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан бөгөөд түүний судлагдахуун нь ихэнхдээ урт хугацааны турш зорилтот оролцогчид дээр ажиглалт хийх замаар бодит амьдрал дээрх зүйлсийг шинжлэн авч үздэг.⁵ Тиймээс *антропологиин талаархи эрх зүйн судалгааг дан ганц эрх зүйн онол, философийн хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс салбар эрх зүйн жишээлбэл, үндсэн хуулийн эрх зүй, нэн ялангуяа сонгуулийн эрх зүйн чиглэлээр төрөлжүүлэн хийж болох*⁶ талаар өгүүллийн оршилд онцлон дурдаж байна. Улмаар эрх зүйн мөн чанар нь хүний мөн чанарт үндэслэгдэх тул орчин үеийн эрх зүй судлаачид нь юуны өмнө сайн хүн судлаач байх шаардлагатай болсон байна.⁷

Энд ийнхүү нуршин өгүүлэхийн учир нь өнөө үед (XX зууны сүүл, XXI зууны эхэн) эрх зүйн ерөнхий онол нь дэлхийн улс орнуудад, ялангуяа эх газрын эрх зүйн

болно. Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), Уб., 2007, 9 дэх тал

² Энэ нь хууль зүйн, тэр дундаа криминологийн зарим бүтээлүүдээс тодорхой харагдаж байна. Энэ талаар Номынбаясгалан С., Түвшинсанаа О., Хүчиндэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын антропологиин асуудал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2022, №2 дугаарт хэвлэгдсэн өгүүллийн **“Чезаре Ломброзогийн үндэслэсэн антропологиин онол”** гэсэн хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

³ Хууль тогтоомж (англи. legislation) – 1.хууль тогтоох байгууллагаас хууль батлан гаргах явдлаар илрэх төрөөс өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх гол үндсэн аргын нэг; ард түмний бүрэн эрхт байдлыг илэрхийлж эрх зүйг бүтээх үйл ажиллагааны нэн чухал хэлбэр; 2.нийгмийн харилцааг бүхэлд нь буюу түүний алив нэг төрлийг зохицуулах эрх зүйн хэм хэмжээний цогц; эрх зүйн зарчим, нийт хүн төрөлхтний үнэт зүйлс, хүний язгуур эрэлт хэрэгцээ ба ашиг сонирхол, нийгмийн дэвшлийн объектив чиг хандлага хууль тогтоомжид тусгалаа олно. Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, (хууль зүйн нэр томьёо ба ухагдахуунтай), Уб., 2021, 530 дахь тал

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 5 дугаар сарын 29–ний өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл (**Хуулийн зорилго**)–д *“1.1.Энэ хуулийн зорилго хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/–ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оришино”* гэж зохицуулсан байна. <https://legalinfo.mn/mn/detail/11119> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

⁴ Номынбаясгалан С., Хууль зүйн нэр томьёоны асуудлууд, Монголын төр, эрх зүй сэтгүүл, Уб., 2022, №1, (100), 80 дахь тал

⁵ Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., Анударь О., Тамир З., ба бусад) Хүний эрх сэтгүүл, Уб., 2022, №1, 101 дэх тал <https://bit.ly/3AnnYwe> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.25)

⁶ Дээр дурдсан хүрээнд бус харин монголын эрх зүйн тогтолцоонд тухайлбал хувийн эрх зүйд хөдөлмөрийн эрх зүйн антропологи, гэр бүлийн эрх зүйн антропологи, үнэт цаасны эрх зүйн антропологи, арилжааны эрх зүйн антропологи гэх мэт; нийтийн эрх зүйн хүрээнд татварын эрх зүй, сонгуулийн эрх зүй, хүрээлэн буй орчны эрх зүй гэх мэт антропологиин чиглэлээр төрөлжүүлж, гүнзгийрүүлэн судалж болно гэж үзэж байна.

⁷ Сэлэнгэ Х., Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №2 – 3, 97 дахь тал

тогтолцоотой улс оронд хууль зүйн цоо шинэ шинэ шинжлэх ухааны (эрх зүйн антропологи болон бусад) шинэ мэдлэг, арга зүйн болон үзэл суртлын олон урьгалч хандлагад тулгуурлан хөгжиж байна.⁸ Энэ утгаар Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд эрх зүйн антропологийн судалгаа хийхийн⁹ (Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухаанд судалгааны объектуудыг антропологичлох) зэрэгцээ эрх зүйн антропологийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна. Хэдий тийм боловч монголын хуульч эрдэмтэн судлаачид эрх зүйн антропологийн чиглэлээр төдийлөн судлаагүй байна.¹⁰ Иймд энэ чиглэлийн судалгаа хийж эхлэхээс өмнө нэн тэргүүнд нэр томъёог цэгцлэх жишээлбэл “хуулийн хүн судлал”¹¹ эсвэл “хуулийн антропологи судлал”¹² мөн түүнчлэн “хууль зүйн антропологи”¹³ буюу “эрх зүйн антропологи”¹⁴ хэмээх нэр томъёоны үзэл санаа, утга агуулгыг антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үүднээс хэрхэн зөв оноож хэвшүүлэн хэрэглэх вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна. Энэ байдлыг харгалзан энэхүү өгүүллээр нэр томъёоны нэршил, оноолтын талаар авч үзэхийг гол зорилгоо болгов. Энэ үндсэн дээр эрх зүйн антропологи гэж юу болохыг тодорхойлох оролдлого хийв.

II. Эрх зүйн антропологи: Нэр томъёоны асуудал

Эрх зүйн антропологийн тухай лавшруулан судлахаас өмнө нэн тэргүүнээ тодруулваас зохих хэдэн зүйл байгааг энэхүү хэсэгт тайлбарлах нь зүйтэй. Үүнд: эрх зүйн антропологи гэж юу болох, эрх зүй судлал гэсэн бүхэл бүтэн нийгмийн шинжлэх ухааны асар том ухаан байхад антропологийн ухаан ямар хэрэгтэй болох, түүнээс юугаараа ялгаатай болох, эрх зүйн антропологи нийгмийн яг ямар ухагдахууныг судалдаг болох, эрх зүйн антропологи эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар мөн эсэх, гадаад хэлэн дэх “*legal anthropology*”, “*anthropology of law*”, “*law’s anthropology*”¹⁵ хэмээх нэр томъёо, түүний агуулга, хэрэглээ монгол хэлэн дэх “хуулийн хүн судлал” эсвэл “хуулийн антропологи”, мөн түүнчлэн “хууль зүйн антропологи” буюу “эрх зүйн антропологи” хэмээх ухагдахуунтай хэрхэн зохицон нийцэх тухай асуудлуудад

⁸ Нямсүрэн Ч., Эрх зүйн ерөнхий онол, (Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал), Хоёр дахь хэвлэл, УБ., 2017, 44 дэх тал

⁹ Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт “. . . хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно . . .” гэсэн нь антропологийн талаар судалгаа хийх хууль зүйн үндэслэл нь болж байна. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

¹⁰ Сарантуяа Ц., Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2000, №1, 20 – 21 дэх тал, Сэлэнгэ Х., Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, УБ., 2000, №2 – 3, 97 – 99 дэх тал, Номынбаясгалан С., Улс төрийн намын тухай хуульд хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах зарчмыг тодорхойлсон нь, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ., 2021, №3, 56 дахь тал, Номынбаясгалан С., Түвшинсанаа О., Хүчиндэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын антропологийн асуудал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ., 2022, №2

¹¹ Орчуулгын бүтээлд хуулийн хүн судлал (*Anthropologie juridique*), практик хуулийн хүн судлал (*Anthropologie juridique pratique*) гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), УБ., 2007, 71 болон 135 дахь тал

¹² Эксперт бүлгийн хурлын тэмдэглэлд “хууль зүйн салбарт *хуулийн антропологи судлал* гэж бий” гэж бичсэн байна. Булаг Э., Монгол дахь ясны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, (Орчуулсан: Туулайхүү Э., Туяа Ш.), УБ., 2020, 130 дахь тал

¹³ Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтрэхий толь бичиг, Анхны хэвлэл, УБ., 2021, 524 дэх тал

¹⁴ Фернанда Пириес., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., Анударь О., Тамир З., ба бусад) Хүний эрх сэтгүүл, УБ., 2022, №1, 101 дэх тал

¹⁵ Burke Paul., Law’s Anthropology, (From ethnography to expert testimony in native title), Printed by Griffin Press, 2011 https://books.google.mn/books?id=IR-I8jTxwMYC&printsec=frontcover&dq=legal+ethnography&hl=mn&sa=X&redir_esc=y#v=onepage&q=legal%20ethnography&f=false (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

хариулт өгөхийг оролдлоо. Эдгээр асуултуудын хариулт нь нэгэн зангилаа бөгөөд нэгнийх нь хариулт нөгөөгөө тодруулсаар төгсгөлд нь илэрхий тодорхой болно гэж үзэж байна. Хариултаа сүүлээс нь буюу нэр томьёоны гадаад болон монгол хэлний үгийн утга, түүний хэрэглээний талаар авч үзье.

А.Нэр томьёоны тухай цөөн үгээр

Монголчууд төрөөс тогтоосон хэм хэмжээний актыг “цааз” гэж нэрлэж байжээ.¹⁶ Үүнээс гадна <<цааз хууль>>, <<хууль цааз>> гэсэн хоршоо үг өргөн хэрэглэгдэж байсан. Монголчууд “хууль” гэдэг үгнээс “цааз” гэдэг үгийг илүүтэй хэрэглэж байснаа яваандаа “хууль цааз” гэж хоршуулан хэрэглэж байсан нь түүхийн сурвалж бичгүүдээс харагддаг.¹⁷ Цаазын бичиг (хуулийн эмхэтгэл), цааз зарлах (хууль гаргах), шүүх цаазын бичиг (эрүүгийн хууль), цаазлах (шийтгэх) гэх мэт нэр томьёо үүсчээ.¹⁸ Харин эрх зүй гэдэг энэхүү монгол нэршил 1978 оноос албан ёсны нэр томьёо болж хэрэглэгдсээр өнөөг хүрсэн байна.¹⁹ Эрх зүй гэсэн үгийн “зүй” гэсэн үг нь ч монголчуудын сэтгэлгээнд хожуу бий болсон бололтой.²⁰ Өмнө нь эрх гэсэн нэр томьёог хэрэглэн захиргааны эрх, эрүүгийн эрх гэж нэрлэж байсан байна.

Жан Копаны Угсаатан судлал, хүн судлалын удиртгал хэмээх орчуулгын бүтээлд “... Хууль цаазын болон аман уламжлалын өргөн талбар бол хуулийн хүн судлалын салбарыг үүсгэдэг. Хүн судлалын олон сэтгэгчид хуульчид байсан учраас хуулийн үүднээс бодож сэтгэж байв...” гэж бичсэн байна.²¹ Ийнхүү эрх зүйн антропологийн үүднээс авч үзвэл, монголын эртний уламжлалт хууль цаазын дурсгалт бичгүүдэд тусгагдсан нэр томьёог гүнзгий судалж, өнөөгийн практикт тусгаж хэрэглэх нь ихээхэн ач холбогдолтой байж болох юм. Тэр тусмаа “тодорхой” нэр томьёо тухайн үедээ ямар утга санаа илэрхийлж байсныг сайтар судалж, түүнийг утгыг нь тайлбал нэр томьёо судлалд их нэмэртэй.²² Энэ талаар эрх зүй судлаачдын дунд цөөн хэдэн үзэл санаа бий. Жишээ болгон дурдвал, доктор, профессор Т.Сэнгэдорж уламжлалаар цааз, хууль цааз, хууль зүй гэсэн ойлголтууд өргөн хэрэглэгдэж байсныг сэргээн судалж эрх зүй гэсний оронд хууль зүй гэсэн нь илүү оновчтой байна гэж үзэв.²³ Тэгвэл академич С.Нарангэрэл монгол хэлний өдөр тутмын ярианд монголын хууль тогтоомж гэхээсээ монголын эрх зүй гэж хэлэгдэх нь илүүтэй болжээ гэж бичиж байв.²⁴

Харин доктор, профессор Х.Сэлэнгийн “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл” хэмээх (2014) бүтээлд “эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёонуудын үндэс, агуулгыг хэл шинжлэл, эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн онолын үүднээс авч үзэхийн зэрэгцээ эрх зүй гэсэн нэр томьёоны оронд хууль зүй гэсэн нэр томьёог хэрэглэх нь үндэслэлтэй хийгээд зохистой юу? Эрх зүй гэсэн нэр томьёог хууль зүйн шинжлэх ухааны нэр томьёоноос хасах нь зөв үү? Энэ нь монголын хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд сайн нөлөөтэй юу гэсэн асуултуудад үндэслэл бүхий хариултуудыг өгсөн байна. Тодруулбал: Нэгд, хууль зүйн шинжлэх ухааны тулгуур нэр

¹⁶ Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, Уб., 2008, 550 дахь тал

¹⁷ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 146 дахь тал

¹⁸ Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Анхны хэвлэл, Уб., 2021, 555 дахь тал

¹⁹ Улсын нэр томьёоны комиссын мэдээ, Хууль зүйн нэр томьёо, №107–108 (Тэргүүн дэвтэр) Уб., 1978

²⁰ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 146 дахь тал

²¹ Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), Уб., 2007, 71 дэх тал

²² Баярсайхан Д., Хууль зүйн шинжлэх ухааны нэр томьёог цэгцлэн төгөлдөржүүлэх асуудалд, Эрх зүй сэтгүүл, Уб., 2001, №4 – 5, 49 дэх тал

²³ Сэнгэдорж Т., Эрх зүй хэмээх нэр томьёоны эргэн тойронд, Эрх зүй сэтгүүл, Уб., 2012, №1 – 2 (21), 8 дахь тал

²⁴ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), Уб., 2001, 5 – 6 дахь тал

томьёо болох “эрх зүй” нь хожуу бий болсон нь монголчуудын эрхийг бус үүргийг дээдэлж ирсэн эрх зүйн сэтгэлгээний хөгжил, түүний онцлогтой холбоотой гэж үзсэн байна. Учир нь энэхүү нэр томьёог хэрэглэснээр эрх зүйн мөн чанар, агуулга, үнэт зүйлийг ойлгон танин мэдэж, хуулийг агуулгаар хэрэгжүүлэх үндэс, боломж тавигдсан гэж үзэв.²⁵ Хоёрт, хэл шинжлэлийн үгийн үндэс, язгуур, гарал зүйн үүднээс “эрх зүй”, “хууль”, “хууль зүй” гэсэн нэр томьёонууд нь ялгаатай байх тул эрх зүй гэсэн нэр томьёоны оронд хууль, хууль зүй гэсэн нэр томьёог хэрэглэх нь зохистой биш гэсэн дүгнэлтийг хийв.²⁶ Гуравт, эрх зүйн онолын түүхэн үүднээс авч үзвэл хууль зүйн шинжлэх ухааны тулгуур нэр томьёо болох эрх зүй, хууль гэсэн нэр томьёо нь өрнийн улс орнуудад анх эртний Ромд үүссэн. Ромын хуульчид “эрх зүй”, “хууль”-ийг нэр томьёоны хувьд ялгаж, эрх зүйг “*iūs*”, хуулийг “*lex*” гэж нэрлэж байв.²⁷ Дөрөвт, хүн төрөлхтний эрх зүйн сэтгэлгээний түүхийн үүднээс авч үзвэл Ромын хуульчид эрх зүй, хууль гэсэн ойлголтуудыг нэр томьёоны хувьд ялгахад гадна агуулгын хувьд ялган зааглаж байсан юм. Эдгээр нэр томьёо нь ялгаатай байх тул эрх зүйг хууль гэж үзэж, хуулиас өөр нэр томьёо байхгүй гэж үзэж болохгүй нь байна гэж тэмдэглэв.²⁸ Тавд, хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн үр дүнд “эрх зүй судлал”, “хууль зүй судлал” хөгжиж байна. Эрх зүй судлал, хууль зүй судлал нь судалгааны онол, арга зүйн хувьд ялгаатай. *Хууль зүй судлал* нь позитив эрх зүйд төвлөрч, хуулийн тухай сургаал онолуудаас гадна позитив эрхийг судлах арга зүй, позитив эрхийн тухай тайлбар, ангилал, системчлэл гэсэн эмперик фактуудыг эрх зүйн тогтолцооны хүрээнд судална. Харин *эрх зүй судлал* нь эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдагаараа хууль зүй судлалаас ялгаатай. *Эрх зүй судлал* нь танин мэдэхүйн хүрээнд эрх зүйн мөн чанар агуулгыг буюу эрх, эрх чөлөөний боломж, хязгаарын мөн чанар, агуулгыг тодорхойлж, эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлздэг бол үнэт зүйлийн хүрээнд эрх зүйн объектив мөн чанар, үнэт зүйлийг илрүүлж, түүний зорилго, ач холбогдлыг тодорхойлдог. Түүнчлэн онтологийн хүрээнд *эрх зүй судлал* нь эрх зүйн оршин буйг нотолж, эрх зүйн объектив шинж, үүрэг зорилгыг илрүүлж, эрх зүйн илрэн гарах хэлбэр хууль болохыг тодорхойлдог байна. Ийнхүү *эрх зүй судлал* нь эрх зүйн зүй тогтол, онолыг судалдаг гэсэн байна. Эцэст нь доктор, профессор Х.Сэлэнгэ “*эрх зүй гэсэн нэр томьёог хууль зүйн шинжлэх ухаанаас хасч, эрх зүй судлалыг үгүйсгэж, зөвхөн хууль зүй гэсэн нэр томьёог хэрэглэх нь хууль зүйн шинжлэх ухааны тулгуур ойлголтын мөн чанар, агуулгыг алдагдуулж, цаашилаад хууль зүйн шинжлэх ухааны зорилгоос ухарч, судалгааг хязгаарлаж байгаа явдал болно*”²⁹ гэсэн маш үндэслэл бүхий нухацтай дүгнэлтийг хийсэн байна. Энэхүү дүгнэлт, тэдгээр үндэслэлүүдтэй бүрэн санал нэгдэж, дэмжиж байгаа онцлон тэмдэглэж байна.

Б.Нэр томьёоны нэршлийн тухайд

Хүн судлал буюу антропологи хэмээх нэр томьёо нь хууль зүйн шинжлэх ухаанд танил бус “*шинэ нэр томьёо*” болох нь монголын хууль зүйн зарим толь бичгүүдээс тодорхой (энэхүү эрх зүйн хүн судлал буюу эрх зүйн антропологи гэсэн нэр томьёоны

²⁵ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 145 дахь тал

²⁶ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 147 дахь тал

²⁷ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 147 дахь тал

²⁸ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 148 – 149 дэх тал

²⁹ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 151 – 152 дахь тал

талаар дурдаж, тэмдэглээгүй) харагдаж байна.³⁰ Харин академич С.Нарангэрэлийн Эрх зүйн эх толь бичиг хэмээх бүтээлд “эрх зүйн антропологи” буюу “хууль зүйн антропологи” гэсэн нэр томъёог хэрэглэж, нэр томъёо, хэллэг, ухагдахууныг авч үзэхдээ агуулгын хувьд адилтган бичсэн байна(С.Нарангэрэл, 2008: 529, 610, 2011: 563, 610). Энэ нь дээрхи нэр томъёог хууль зүйн шинжлэх ухаанд зохих түвшинд ердийн эсвэл мэргэжлийн байна уу гэдгээс үл хамааран нийтээр ойлгон хэрэглэж дадсан болохыг нотлон харуулах нэгэн жишээ болж байна. Хэдий тийм боловч нэр томъёоны хувьд тааралдах хүндрэлүүдийн нэг нь гадаад нэр томъёог оноох, дүйцүүлэх явдал тулгарах нь гарцаагүй. Тухайлбал “anthropology of law”, “legal anthropology”, “law’s anthropology” гэсэн нэр томъёонууд нь англи хэлнээс монгол хэлэнд агуулгын хувьд адил төстэй, эсвэл зөрүүтэй орчуулагдах боломжтой байна. Иймд дээрхи нэр томъёоны үзэл санаа, утга агуулгыг нэгдсэн агуулгаар тодорхойлох буюу дүйцүүлэх боломжтой эсэх, мөн түүнчлэн гадаад хэлнээс монгол хэлэнд хэрхэн хөрвүүлэн буулгах вэ, нэр томъёоны оноолтоос үүдэлтэй агуулгын зөрүүтэй байдал гарах боломжтой юу, эсвэл нэр томъёоны давхардал бий болсон уу гэх мэт асуултууд нээлттэй төдийгүй шинжлэх ухааны үүднээс хариултаа хүлээсээр байна.

В.Нэр томъёо оноолтын талаар эргэцүүлэх нь

Аливаа нэр томъёогоор илэрч буй ухагдахууны хүрээг харгалзах нь хувилбар нэр томъёо, давхцал, буруу оноолт зэрэг асуудлаас сэргийлэх ач холбогдолтой. Түүнээс гадна нэр томъёо нь шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийг тээгч болох тул зөвхөн хэлний тухай асуудал бус харин нийгмийн бүх салбарын нэгэн судлагдахуун байдаг онцлогтой болно.³¹ Нэр томъёо, нэн ялангуяа гадаад үг хэллэгийг анхнаас нь зөв орчуулж хэрэглэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Анхнаасаа буруу орчуулагдан хэрэглэгдээд заншчихвал дараа нь янз бүрийн хүндрэл гарах эрсдэлтэй. Тиймээс хууль зүйн нэр томъёо онооход таарч тохирох тодорхой нэр томъёог олж орлуулахаас эхлэн олон асуудлууд тулгарна. Өөр бусад эрх зүйн тогтолцоотой харьцуулан судлахаас гадна эрх зүйн нэр томъёонуудын адил хамаарлыг олж тогтоох нь хоёрдмол утгагүй, төөрөгдүүлэхгүй, буруу ойлголтод хүргэхгүй байх³² чухал холбогдолтой болохыг санах учиртай.

Тэгээд ч хууль зүйн нэр томъёоны³³ үр нөлөө нь хэм хэмжээ тогтоогчид хууль зүйн нэр томъёонд тавигдах 1/ нэгдмэл; 2/ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн; 3/ тогтвортой байдал гэсэн шаардлагуудыг хангасан эсэхээс шууд шалтгаална³⁴ гэж үздэг. Энд онцлон тэмдэглэхэд эрх зүйн нэр томъёог хуулийн нэр томъёоноос ялган ойлгох, нэр томъёог оноох, сонгон хэрэглэхэд хэлбэр талаас нь бус харин агуулга талаас нь авч үзэхийг антропологийн ухааны онол, арга зүй талаасаа шаардаж байна. Энэ нь эрх зүйн антропологийн дараахь бүтээлүүдийн агуулгаас тодорхой харагдаж байна.³⁵ Хууль

³⁰ Амарсанаа Ж., ба бусад, Хууль зүйн тайлбар толь, УБ., 2003, Баярсайхан Б., Хууль зүйн тайлбар толь, (Монгол Улсын төр, эрх зүйн түүх), УБ., 2003, . . . гэх мэт.

³¹ Мөнхцэцэг Н., Нэр томъёоны орчуулга судлал, УБ., 2020, 25 дахь тал

³² Чимгээ Н., Хууль зүйн орчуулгын онцлог, “Орчуулга, нэр томъёо, толь зүй, заах арга зүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2010, 65 дахь тал

³³ Хууль зүйн нэр томъёо (англи. Legal terminology) – Хууль зүйн техникийн нэг хэсэг; Төр – эрх зүйн ухагдахууныг заан тэмдэглэж, түүний тусламжтайгаар хэм хэмжээний актын эх бичвэрт үгээр илэрхийлэгдсэн хэлбэр. Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Анхны хэвлэл, УБ., 2021, 524 – 525 дахь тал

³⁴ Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Анхны хэвлэл, УБ., 2021, 525 дахь тал

³⁵ Fernanda Pirie, The Anthropology of Law, Clarendon Law Series, Oxford university press, 2013

https://books.google.mn/books?id=SbbDAQAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false James M. Donovan, Legal Anthropology: An introduction, printed in the United States of America, AltaMira, 2008
https://books.google.mn/books?id=vRAfAAAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false

зүйн шинжлэх ухаанд нэр томьёо судлал чухал байр суурь эзэлдэг³⁶ бөгөөд хууль зүйн хэлний онцлог нь нэр томьёотой шууд холбоотой.³⁷ Энэ нь үг, өгүүлбэрээр дамжин илэрдэг. Нэр томьёо товч, оновчтой, утга санаа бүрэн төгс байх нэг гол үндэс нь үгийг зөв сонгож хэрэглэх явдал юм.³⁸ Тиймээс хууль зүйн нэр томьёог гадаад хэлнээс гадаад нэр томьёонд нутагшуулан оноон хэрэглэх эсэх сонголтыг шинээр нэр томьёо бүтээхэд баримтлах зарчмын дагуу хийх ёстой. Гэхдээ нэгэнт тогтсон хууль зүйн нэр томьёог өөрчлөх гэхээсээ илүүтэй утга агуулга, үзэл санааг нь нэг мөр ойлгох нь чухал байна.³⁹ Чухамдаа нэр томьёог нэр томьёогоор орчуулах⁴⁰ зарчмыг харгалзан үзэх шаардлагатай юм.

Нийтээр хэвшсэн нэр томьёог аль болох хэвээр нь хэрэглэхийн хамт үг хэмнэх зарчмыг баримтлахын⁴¹ зэрэгцээ антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс хүлээн зөвшөөрөгдөхүйц байх нь зохимжтой гэж үзэж байна. Энэ утгаар антропологи хэмээх нэр томьёог хууль зүйн салбарт, нэн ялангуяа хуулийн антропологи гэсэн томьёог хэрэглэснээр “эрх зүйн антропологийн агуулгыг хэт явцууруулан тодорхойлуулах” төдийгүй “эрх зүйн илрэн гарах хэлбэрийн тухай ойлголтыг эрх зүйн мөн чанарын тухай ойлголттой хольж, хутган ойлгох” нөхцлийг бүрдүүлж байна. Тухайлбал, сонгуулийн хуулийн антропологи гэх зэргээр нэрлэх нь сонгуулийн эрх зүйн антропологиос агуулга, мөн чанарын хувьд эрс ялгаатай гэж үзэж байна. Түүнчлэн эрх зүйн онолын хувьд эрх зүй хуулиас ялгаатай төдийгүй илүү өргөн агуулгаар тодорхойлогддог⁴² болохыг мартах учиргүй юм. Өөрөөр хэлбэл, эрх зүй судлал (эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг) нь хууль зүй судлал (эрх зүйн тогтолцооны хүрээнд)–аас судалгааны онол, арга зүйн хувьд ялгаатай болно. Эрх зүй, түүний илрэн гарах хэлбэр болох хууль, тэдгээрийн ялгаа, харилцан хамаарлын тухай үзэл санаа нь эрх зүйн тухай үзэл санаатай зэрэгцэн нэн эртнээс үүссэн бөгөөд одоо ч гэсэн эрх зүйн танин мэдэхүйн анхаарлын төвд байсаар байна.⁴³ Энэ дээр үндэслэн эрх зүй, хуулийг агуулгын ялгаагүй гэж үзэж болохгүй, ялангуяа хууль нь агуулгаасаа гажсан тохиолдол бүр ч болохгүй юм. Харин хууль нь

[0#v=onepage&q&f=false](#) Norbert Rouland, Legal Anthropology, (Translated by Philippe G. Planel), The Athlone Press, London, 1994

[https://books.google.mn/books?id=5gLNDs-](https://books.google.mn/books?id=5gLNDs-G_u8C&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false)

[G_u8C&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false](#) . . . etc. (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

³⁶ Баярсайхан Б., Монгол Улсын Үндсэн хуульт ёсны уламжлал, (БНМАУ–ын 1949 оны Үндсэн хуулийн эрх зүйн шинжилгээ), Уб., 2017, 32 дахь тал

³⁷ Амархүү О., Эрх зүйн онолын арван таван сэдэв, Уб., 2008, 52 дахь тал

³⁸ Амарсанаа Ж., Эрх зүй – нийгмийн харилцааг тохируулагч, Уб., 1988, 67 дахь тал

³⁹ “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” (Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл) Уб., 2016, 73 болон 77 дахь тал

⁴⁰ Сергей Влахов, Сидер Флорин., Непереводимое в переводе, Москва, 1980, Стр. 285,

⁴¹ Улсын нэр томьёоны комиссын мэдээ, Хууль зүйн нэр томьёо, №107–108, (Тэргүүн дэвтэр), Уб., 1978, 5 дахь тал

⁴² Хууль нь эрх зүйн илрэх гадаад хэлбэр. Баярсайхан Д., Эрх зүйн онол, Тав дахь хэвлэл, Уб., 2018, 34 дэх тал

Эрх зүйн ба хууль тогтоомжийн тогтолцооны харьцаа: эрх зүйн тогтолцоо ба хууль тогтоомжийн тогтолцоо бие даасан бөгөөд харилцан уялдаатай юм. Эдгээр нь өөр хоорондоо хэлбэр ба агуулгын харьцаатай байна. Эрх зүйн тогтолцоо бол агуулгыг илэрхийлэх бөгөөд нийгмийн харилцааг зохицуулах шинжид нийцсэн эрх зүйн дотоод бүтэц юм. Хууль тогтоомжийн тогтолцоо нь эрх зүйн эх сурвалжийн байгууламжийг илэрхийлдэг эрх зүйн гадаад хэлбэр өөрөөр хэлбэл хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын тогтолцоо. Эрх зүй нь хууль тогтоомжгүйгээр оршихгүй болохын хамт харин хууль тогтоомж нь өргөн хүрээтэй ойлгоцоор эрх зүй болно. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), Уб., 2001, 87 дахь тал

⁴³ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 150 дахь тал

агуулгаасаа гажаагүй, эрх зүйд нийцсэн буюу эрх зүйт хуулийг эрх зүй гэж үзэж болох боловч өнөөг хүртэл хууль тогтоох явцад хууль нь агуулгаасаа гажиж байдаг тул эрх зүй, хууль хоёрыг ялгах хэрэгцээ шаардлага байгаа юм.⁴⁴ Тиймээс нэр томъёог хэрхэн оноож өгснөөс шалтгаалан хоёрдмол утгаар ойлгогдох үр дагавартай байна. Өөрөөр хэлбэл эрх зүйн онол, философийн үүднээс эрх зүйн хэлбэрийг агуулгатай адилтган авч үзэх эрсдэлтэй болж байна. Тийм учраас хууль эрх зүйт шинжийг бүрэн олоогүй байгаа тохиолдолд “эрх зүй”, “хуулийн” ялгааг сайтар ухаарах, судлах, хууль тогтоомж бүрийг эрх зүйн шалгуураар шалгах шаардлага зайлшгүй бий. Энэ бол эрх зүйт төр, хуультай болох нэн чухал угтвар нөхцөл⁴⁵ болохыг онолын хувьд бас санах учиртай. Хэдий тийм ч Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг хэмээх (2021) бүтээлд *хууль зүйн антропологи* гэсэн нэр томъёог хэрэглэж, англи хэлэнд *legal anthropology* гэж орчуулсан нь ихээхэн ач холбогдолтой байна. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн гаргадаг Хүний эрх сэтгүүлийн 2022 оны №1 дугаарт хэвлэгдсэн Фернанда Пириегийн *Anthropology of law*⁴⁶ хэмээх (2013) бүтээлийн орчуулгын цувралд эрх зүйн антропологи гэсэн нэр томъёог хэрэглэж, монгол хэлэнд буулгасан байна.⁴⁷

Иймд антропологи гэсэн нэршлээр хууль зүйн салбарт нэгэнт нийтээр хүлээн зөвшөөрч нэрлэж, цаашлаад хэрэглэж дадсан “дадна” гэж үзвэл салбар эрх зүй бүрт адил утгаар ойлгон хэрэглэгддэг нийтлэг нэр томъёо болгон хэвшүүлэх боломжтой гэж үзэж байна. Жишээлбэл, үндсэн хуулийн эрх зүйн антропологи, эрүүгийн эрх зүйн антропологи, захиргааны эрх зүйн антропологи, иргэний эрх зүйн антропологи гэх мэт. Ийнхүү өгүүллээр авч үзэж буй нэр томъёоны нэршил, оноолтын тухайд антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс **хуулийн антропологи* гэж нэрлэхийн оронд ***эрх зүйн антропологи* гэсэн нэр томъёонд хэвшүүлэн нэрлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна. Учир нь эрх зүй судлал нь эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг байхад хууль зүй судлал эрх зүйн тогтолцооны хүрээнд авч үздэг онцлогтой байна. Эндээс авч үзвэл хууль зүйн хэрэглээнд ***эрх зүйн антропологи* (хууль зүйн антропологи) гэж нэрлэн хэрэглэх нь хууль зүйн нэр томъёонд зайлшгүй тавигддаг *нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, тогтвортой, хоёрдмол утга санаагүй (нэгдмэл) байх* гэсэн шаардлагуудыг ханган илүү тохиромжтой байна.

Мөн түүнчлэн Монгол хэлний тухай хуульд “... эрдэм шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томъёог монгол хэлнээ орчуулан хэрэглэхийг эрхэмлэнэ...”⁴⁸ гэж заасныг харгалзан эрх зүйн антропологи гэсэн гадаад нэр томъёогоор нэрлэн хэрэглэхээс илүүтэй цаашид монгол хэлэнд “эрх зүйн хүн судлал” гэж буулгаж, нэрлэж хэвших нь зүйтэй юу гэдгийг авч үзэх хэрэгтэй байна. Учир нь эрх зүйн гүн ухаан гэхийн оронд дэлхий нийтээр хэл зүйн хувьд ижил хэрэглэдэг философи гэдэг нэр томъёогоор нь “эрх зүйн философи” гэж нэрлэдгийн адил антропологи гэсэн нэр томъёог монгол хэлэнд хөрвүүлэхгүй “эрх зүйн антропологи” гэх нь зохистой байна уу эсвэл заавал орчуулж “эрх зүйн хүн судлал” гэх нь оновчтой юу гэсэн асуултууд зүй ёсоор тавигдаж, хариултаа хүлээсээр байна.

⁴⁴ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 151 дэх тал

⁴⁵ Лүндэндорж Н., Jurisprudence // Эрх зүй судлал: Философи, онол, УБ., 2011, 26 дахь тал

⁴⁶ <https://bit.ly/3AlBmRN>

⁴⁷ Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., Анударь О., Тамир З., ба бусад) Хүний эрх сэтгүүл, УБ., 2022, №1, 101 – 125 дахь тал

⁴⁸ Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр баталсан Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйл (**Монгол хэлийг хэрэглэх**)-ийн 6.5 дахь хэсэгт “*Бүх шатны сургалт, эрдэм шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томъёог монгол хэлнээ орчуулан хэрэглэхийг эрхэмлэнэ*” гэж хуульчилсан байна.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=10932> (Сүүлд үзсэн: 2022.11.01)

III. Эрх зүйн антропологи: Ерөнхий ойлголт, судлах зүйл

Эрх зүйн антропологийн талаар нэр томъёоны тайлбарыг хийж байгаа бол мэдээж, түүний ойлголт, агуулга, судлах зүйлийг авч үзэх нь нэр томъёог илүү зөв, тодорхой болгоно гэж үзэж байна.

А.Шарль Монтескьогийн хуулийн амин сүнсийн ойлголтын үүднээс авч үзэх нь

Хуулийн амин сүнсийн тухай хамгийн даацтай, хүлээн зөвшөөрөгдсөн онолын судалгаа шинжилгээг Шарль Монтескьог [Charles de Montesquieu] (1689 – 1755) хийсэн хэмээн үздэг. Ш.Монтескьогийн 1748 онд хэвлүүлсэн “Хуулийн амин сүнс” хэмээх зохиол нь хуулийн амин сүнсийг судалсан хамгийн алдартай бүтээл хэмээгдэн дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн байна.⁴⁹ Орчин цагийн бүхий л улс гүрнүүдийн хууль, түүний дотор “үндсэн хууль” Ш.Монтескьогийн боловсруулсан онолыг эш үндэс болгож ирсэн байна.⁵⁰ Тодруулбал, АНУ-ын Үндсэн хуулиас эхлээд 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал Ш.Монтескьогийн дэвшүүлсэн үзэл санаанд тулгуурлагдсан байна.⁵¹ Энэхүү бүтээлд “хууль нь тухайн орныхоо газарзүйн шинж чанарт, хүйтэн, халуун эсвэл сэрүүн цаг агаарт нь, газрын хөрсний чанарт, уг орны байршилд, нутаг дэвсгэрийнх нь хэмжээ дамжаанд, цаашилбал, тариачид, анчид, малчид болох ард түмнийх нь амьдралын хэв маягт, улсынх нь байгууллаар тодорхойлогддог эрх чөлөөнийх нь хэр хэмжээнд, оршин суугчдынх нь шашин шүтлэг, авъяас чадварт, мөнөөх ард түмний баялаг, тоо хэмжээнд, худалдаанд нь, зан төлөв, ёс заншилд нь нийцэж байх учиртай” хэмээсэн маш нухацтай үндэслэгээг дэвшүүлэн тавьсан байна.⁵²

Энд ийнхүү онцлон өгүүлэхийн учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэг антропологийн судалгаа хийх хууль зүйн үндэслэл нь болох төдийгүй эрх зүйн антропологийн судалгааг дан ганц эрх зүйн онол, философийн хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс төрөлжүүлэн хийснээр “Угтаа бол үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөө бол хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсэд зүй ёсоор тооцогдох учиртай. Харин хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийг монгол орны өвөрмөц онцлог, үндэсний хэв маяг, уламжлал, монгол хүний сэтгэлгээ, хандлагад нийцүүлэн “монгол хөрсөнд” буулгаж чадсан уу”, “монголчуудын төрт ёс, түүх соёлын үнэт зүйлс нь үндэсний хууль тогтоомжтой хэрхэн уялдаж эсвэл ондоошиж (эсрэгцэж) байна вэ”, “даяаришлын нөлөөгөөр монголд хурдан дэлгэрч байгаа орчин үеийн үзэл санаа, түүнийг илэрхийлсэн үнэт зүйлс болон нөгөө талд монголчуудын түүх, соёлын өвөрмөц онцлогийг илэрхийлсэн үнэт зүйлс хэрхэн зэрэгцэн оришиж байна вэ”, “монголд хүний эрх, эрх чөлөөний талаарх ойлголт хэрхэн төлөвшиж, үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг бодит амьдрал дээр, нийгмийн харилцаанд хэрхэн хэрэгжиж, монголын түүх, уламжлалт соёл, ахуй амьдрал, ёс заншил, итгэл үнэмшлийн онцлогтой хэрхэн холбогдож байна вэ” гэсэн асуултуудад хариулах боломж олгож байгаагаараа онолын болон практик ач холбогдолтой байна. Учир нь эрх зүйн соёлыг бүрэлдэхэд түүх – нийгэм, улс төр, эрх зүй, соёл, заншил зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг⁵³ болохыг санах ёстой.

Иймээс л дэлхийн улс орон бүр “өөрийн” гэсэн үндэсний эрх зүйн тогтолцоотой ба тэдгээр нь хүн амын амьдралын хэв маяг, зан заншил, эрх зүйн уламжлал, сэтгэлгээний хувьд өөр хоорондоо ихээхэн ялгаатай учраас энэхүү онцлог байдлыг

⁴⁹ Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, Уб., 2018, 7 дахь тал

⁵⁰ Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, Уб., 2018, 8 дахь тал

⁵¹ Нарангэрэл С., Хуулийн амин сүнсийн эрэлхийлэл, (Чингис хааны гэрээс), Уб., 2016, 10 дахь тал

⁵² Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, Уб., 2018, 8 дахь тал

⁵³ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), Уб., 2001, 181 дэх тал

харгалзан зохицуулах асуудал үндэсний эрх зүйн шинжлэх ухаан бүрийн өмнө зүй ёсоор тавигдаж ирсэн байна. Энэ байдлыг эрх зүйн антропологийн ухааны онол, арга зүйн үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлага монголын эрх зүйн тогтолцоонд үгүйлэгдэж байна. Нүүдлийн мал аж ахуйн өвөрмөц соёл иргэншилтэй, өдөр тутмын амьдрал ахуйдаа эдэлж хэрэглэдэг зарим зүйлс нь Европынхоос өөр учраас монгол орны хувьд зарим хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд өвөг дээдсээс уламжилж ирсэн заншлын хэм хэмжээг баримтлах шаардлага үүсэх нь гарцаагүй.⁵⁴

Б. Эрх зүйн антропологийн ойлголт, агуулгын талаарх эргэцүүлэл

Эрх зүйн мөн чанарын тухай асуудал нь эрх зүй гэсэн үзэгдлийн дотоод талд хамаарагдах асуудал тул түүний уг сурвалжийг авч үзэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг тодорхойлох боломжгүй юм. Эрх зүйн уг сурвалж бол хүн. Иймд хүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг ойлгож, түүний тухай ярих боломжгүй байна. Ер нь аливаа нийгмийн шинжлэх ухаан нь хүн судлалгүйгээр хөгжих боломжгүй⁵⁵ гэдгийг анхаарах учиртай. Өдгөө дэлхийн улс орнууд хөгжлийн асуудлыг дан ганц эдийн засгийн талаас нь бус харин түүх соёл, улс төр, нийгмийн болон улс төрийн философи, улс төрийн эдийн засаг, *антропологийн* талаас нь бүрэн гүйцэд судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн замналыг тодорхойлохыг оролдож байна. Монголчууд бид ч гэсэн хөгжлийн шинэ замналаа хайж байна.⁵⁶ Үүний нэг тод илрэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалаас харж болно. Тодруулбал, (1992 оны) Үндсэн хууль нь социалист чиг баримжаа, тоталитар дэглэмд хамаарах өмнөх 3 үндсэн хуулиас мөн чанарын ялгаатай өөр буюу “ардчилсан” маягийнх гэж үздэг. Энэ нь түүний гол гол үзэл баримтлалаар тодорхойлогдох⁵⁷ бөгөөд эрх зүйн антропологийн агуулга ч гэсэн дээрхи байдлаас хөндийрөх учиргүй гэж үзэж байна. Үүнээс гадна хүн судлалаар дэмжигдэн буй хүний эрхийн хандлага (*the human rights approach supported by anthropology/ethnology*)⁵⁸ гэж байна. Орчин үеийн эрх зүйн үнэт зүйлд суурилсан хандлага нь эрх зүйн хүн судлал – хууль зүйн практик үйл ажиллагааны зүй зохистой харилцан хамааралтай салшгүй холбоотой юм. Иймд эрх зүйн хүн судлал, түүний агуулгад юу хамаарах, хэрхэн тодорхойлох вэ гэдгийг антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үндэслэлтэй авч үзэх хэрэгцээ шаардлага үүсч байна.

Жишээлбэл үндсэн эрхийн талаар эргэцүүлж үзвэл, антропологийн аспектаар эрх зүйн үндэс суурь нь хүн өөрөө бөгөөд төрсөн цагаасаа эхлэн нийгмийн харилцаа, дэмжлэг дунд оршин байдаг. Ертөнцөд хүн мэндлэхэд түүнд тодорхой халамж шаардагддаг бөгөөд энэ нь түүнийг насан туршид нь дагалддаг. Хүрээлэн буй орчноос түүнийг хамгаалах дэмжүүлэх шаардлага байнга тулгардаг. Ийнхүү социаль шинж чанартай суурь харилцаануудыг тойрон үндсэн эрхүүд бий болдог. Төрийн үндэс болсон хүн, түүний хэрэгцээг зөв үнэлж, зохистой гүйцэлдүүлэх байдлаар төр өөрөө тодорхойлогдох боломжтой. Хүний үндсэн эрэлт, хэрэгцээг төр болон эрх зүйн аль нь ч хүлээн зөвшөөрөх ёстой байдаг. Тодорхой зарим (шүтэж бишрэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх гэх мэт) үндсэн эрх нь түүхийн болон антропологийн аспектаас улбаалан үзэхэд социаль хүрээнд хэрэгжихдээ нилээд эмзэг

⁵⁴ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), Уб., 2001, 121 дэх тал

⁵⁵ Сэлэнгэ Х., Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №2 – 3, 97 дахь тал

⁵⁶ <https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group14/01.pdf> (Сүүлд үзсэн огноо: 2022.08.01)

⁵⁷ Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт, (1924–1992), Эмхэтгэл, Уб., 1998, 122 дахь тал

⁵⁸ Булаг Э., Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, (Орчуулсан: Туулайхүү Э., Туяа Ш.), Уб., 2020, 101 – 102

байдаг. Тэдгээрийг зөрчихөд хялбар боловч бүхэлдээ буюу өргөн утгаараа тэд хүний оршин байх зорилго, утга агуулгыг тодорхойлж байдаг⁵⁹ онцлогтой байна.

Өмнө дурдсанчлан антропологийн ухааны олон сэтгэгчид хуульчид (Х.Мейне, Л.Х.Морган зэрэг) байсан учраас энэ салбар ухааны хамгийн эртний мэргэжил мэргэшлийн нэг болсон байна.⁶⁰ Тэд бүгд л ямар нэгэн байдлаар тухайн судалж буй нийгмийнхээ хууль, ёс заншил, дэг журмын тухай бүтээлдээ тусгаж байв. Жишээлбэл, эрх зүйн антропологийн Малиновскигийн “Бүдүүлэг нийгэм дэх гэмт хэрэг ба ёс заншил” хэмээх (2018 [1925]) бүтээл⁶¹ зэргийг дурдаж болох юм. Эрх зүйн антропологи нь XIX зууны дунд үеэс хөгжсөн бөгөөд түүнийг нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсарын ижилсэл, ондоошлыг; нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь судалдаг антропологийн ухааны болон хууль зүйн шинжлэх ухааны салбар дундын бие даасан хавсарга ухаан⁶² гэж тодорхойлж болох юм. Энэ утгаараа антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан бөгөөд эрх зүйн антропологийн онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, уламжлал, зан заншил, үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан бичмэл болон бичмэл бус хэм хэмжээ, ахуй зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуунаа болгон судалдаг гэж үзэж болох юм. Тэгэхлээр эрх зүйн антропологи нь эрх зүйн мөн чанарыг нийгмийн үзэгдэл талаас нь судалдаг байна.

Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг болон Эрх зүйн эх толь бичиг хэмээх бүтээлүүдэд ““Эрх зүйн антропологи” ~ “Хууль зүйн антропологи” гээд аман (үлгэр, домог, туульс, зүйр цэцэн үгс, ардын аман зохиол, ардын уран бүтээл зэрэг) буюу түүхэн дурсгалт бичиг, нийгмийн практикийг задлан шинжлэх замаар нийгэм хэв маяг бүрт хэвшмэл буй хүн төрөлхтний ахуйг хуульчлах үйл явцыг судалж, тухайн тодорхой эрин үе болон нийгмийн тухайн хэв маягийг хүний эрх зүйн ахуйн үндэс болсон зүй тогтол ба логикийг тодорхойлоход чиглэгдсэн шинжлэх ухаан ба хичээлийн судлагдахуун” гэж тэмдэглэсэн байна (С.Нарангэрэл, 2008: 529, 610, 2011: 563, 610, 2021: 524). Харин Фернанда Пириегийн Эрх зүйн антропологи хэмээх бүтээлд “. . . эрх зүйн антропологи нь хуулийг нийгмийн хэлбэр болохын хувьд утга учир олгодог таамаг, санаануудынх нь хамтаар шинжлэх ёстой. Хууль гэж нэрлэдэг нийгмийн үзэгдлийн бүхий л хүрээг төрөл зүйл, нийцэжгүй байдал бүхэнд нь нухацтай авч үзэж, хэв маяг, нийтлэг байдал, холбоог тэдгээрийн дундаас эрэлхийлнэ гэсэн үг. Зорилго нь тодорхойлохоосоо илүүтэй зааварчилж, нийтлэг шинж, ойлголтыг эрэлхийлэх юм . . .” гэж бичсэн байна.⁶³ Мөн түүнчлэн зарим бүтээлд “эрх зүйн антропологи бол хүнийг нийгмийн оршихуй болох эрх зүйн илрэл, хэмжээсийн тухай шинжлэх ухаан юм. Эрт үеэс өнөөдрийг хүртэл хүмүүсийн нийгмийн амьдралын эрх зүйн хэлбэрүүд түүний мөн чанар”⁶⁴ гэж тодорхойлж авч үзсэн байна.

В. Эрх зүйн антропологи эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар болох нь

Доктор, профессор Х.Сэлэнгийн “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл” хэмээх (2014) бүтээлд “эрх зүй судлал нь эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг учраас эрх зүй судлал нь танин мэдэхүйн

⁵⁹ Сарантуяа Ц., Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №1, 20 – 21 дэх тал

⁶⁰ Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), Уб., 2007, 71 дэх тал

⁶¹ Malinowski B., 2018 [1925]. *Crime and Custom in Savage Society*, London: Routledge.

⁶² Номынбаясгалан С., Мөнх – Эрдэнэ Г., Баатарцогт Б., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), Уб., 2021, 5 дахь тал

⁶³ Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., Анударь О., Тамир З., ба бусад) Хүний эрх сэтгүүл, Уб., 2022, №1, 123 дахь тал

⁶⁴ Нерсесянц В. С. Юридическая антропология как наука и учебная дисциплина // Рулан Н. Юридическая антропология. Пер. с франц. М., 1999. с 1

хүрээнд эрх зүйн мөн чанар агуулгыг буюу эрх, эрх чөлөөний боломж, хязгаарын мөн чанар, агуулгыг тодорхойлж, эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлздэг бол үнэт зүйлийн хүрээнд эрх зүйн объектив мөн чанар, үнэт зүйлийг илрүүлж, түүний зорилго, ач холбогдлыг тодорхойлдог. Түүнчлэн онтологийн хүрээнд *эрх зүй судлал* нь эрх зүйн оршин буйг нотолж, эрх зүйн объектив шинж, үүрэг зорилгыг илрүүлж, эрх зүйн илрэн гарах хэлбэр хууль болохыг тодорхойлдог байна. Ийнхүү *эрх зүй судлал* нь эрх зүйн зүй тогтол, онолыг судалдаг гээд эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар нь эрх зүйн философи, эрх зүйн онол болно” гэж тэмдэглэсэн байна.⁶⁵ Үүн дээр нэмээд эрх зүйн хүн судлал буюу “эрх зүйн антропологи” ч гэсэн эрх зүйн судлалын шинжлэх ухааны салбарын нэг болох нь гарцаагүй юм.

Г.Эрх зүйн антропологиог төрөлжүүлэн хөгжүүлэх боломж

Академич С.Нарангэрэлийн Эрх зүйн эх толь бичиг хэмээх бүтээлд сонгуулийн эрх зүй гэдгийг *“төрийн сонгуульт байгууллагыг бүрдүүлэх журам буюу өөрөөр хэлбэл, сонгуулийн эрх зүйн нэг институт болох сонгуулийн тогтолцоог зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц”* гэж бичсэн байна.⁶⁶ Хэдий тийм ч сонгуулийн эрх зүйн амин сүнс нь иргэний улс төрийн суурь эрх болох сонгох, сонгогдох эрх болох учир сонгуулийг сонгогчгүйгээр, сонгуулийн эрх зүйг сонгогчийн эрхгүйгээр сэтгэж, зохицуулж, зохион явуулж болдоггүйн учир үүнд л оршиж байна.⁶⁷ Тиймээс сонгуулийн эрх зүйн асуудлыг антропологи, нэн ялангуяа сонгуулийн эрх зүйн антропологи үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлага монголын эрх зүйн тогтолцоонд үгүйлэгдэж ирсэн байна. Гэвч монголын хуульч эрдэмтэн судлаачид эрх зүйн антропологи чиглэлийн судалгааг төдийлөн хийж байгаагүй хэдий ч эрх зүйн антропологи нь салбар эрх зүй бүрээр төрөлжин хөгжих боломжтой байсаар байна.⁶⁸ Энэ байдлаас улбаалан антропологи ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үүднээс хариултаа хүлээсэн асуултууд, жишээ болгон дурдвал сонгуулийн тогтолцоог хэрхэн тодорхойлох вэ, сонгуулийн тогтолцоо, түүнийг хэлбэрүүдтэй нь хольж хутгасан уу гэсэн асуултууд хариултаа хүлээсээр багагүй хугацааг өнгөрүүлсэн байна. Иймд сонгуулийн эрх зүйн хөгжлийн асуудлыг сонгуулийн тогтолцоо, түүнд хамаарах эрх зүйн зохицуулалтын жишээн дээр авч үзвэл *“сонгуулийн эрх зүйн антропологи”*–ийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болсныг хууль зүйн практик харуулж байна.⁶⁹ Энэ нь цаашлаад иргэний сонгох, сонгогдох эрх зөрчигдөхөд хүргэж байна

IV. Дүгнэлт, санал

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол Улсын хууль зүйн салбарт өнөөг хүртэл үндэсний хууль тогтоомжийг төдийгүй хууль зүйн тодорхой (тохиолдлыг) асуудлуудыг антропологи үүднээс судалсан судалгаа хэвлэгдээгүй байна. Энэ нь *“антропологи ухаан нь хууль зүйн шинжлэх ухаанд ямар хувь нэмэр оруулах боломжтой вэ”* гэсэн онолын асуулт хариултаа хүлээсээр байгаа гэдгийг харуулж байна. Энэ нь бас антропологи судалгаа хийх *“эрх зүйн зохицуулалтын хөшүүрэг”* байхгүйтэй холбоотой байж болох юм. Ийнхүү антропологи ухааны онол, арга зүйн үүднээс үндэсний эрх зүйн зохицуулалтуудыг судлах нь *“эрх зүйн антропологи ухааныг*

⁶⁵ Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 151 дэх тал

⁶⁶ Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, УБ., 2008, 383 дахь тал

⁶⁷ Чимид Б., Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), УБ., 2008, 45 дахь тал

⁶⁸ Номынбаясгалан С., Хууль зүйн нэр томъёоны асуудлууд, Монголын төр, эрх зүй сэтгүүл, УБ., 2022, №1, (100), 79 дэх тал

⁶⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 05 дугаар сарын 02–ны өдрийн 03 дугаар тогтоол МУҮХЦ, Тогтоол №03/2012.05.02., Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 22–ны өдрийн 05 дугаар дүгнэлт МУҮХЦ, Дүгнэлт №05/2016.04.22., Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 06 дугаар сарын 27–ны өдрийн 01 дүгээр тогтоол МУҮХЦ, Тогтоол №01/2022.06.27.

Монгол Улсад хөгжүүлэх нэн таатай нөхцлийг бүрдүүлэхээс гадна антропологиин судалгааг дан ганц эрх зүйн онол, философийн хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс сонгуулийн эрх зүйн чиглэлээр төрөлжүүлэн хийх боломжтой байна” гэсэн ерөнхий дүгнэлтэд хүрэв. Энэ үндсэн дээр дараахь цөөн хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1/ *Anthropology of law, legal anthropology, law's anthropology* гэсэн нэр томъёонууд нь энгийн утгаар эрх зүйн эсвэл хуулийн хүн судлал гэсэн утга агуулгыг илэрхийлдэг хэдий ч монгол хэлэнд хэрхэн оновчтой буулгах вэ гэсэн асуулт шинжлэх ухааны үүднээс хариултаа хүлээсээр өнөөг хүрсэн байна. Харин антропологиин ухааны болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс авч үзвэл **хуулийн антропологи* гэж оноон нэрлэхийн оронд ***эрх зүйн антропологи* гэсэн нэр томъёонд хэвшүүлэн нэрлэж, хэрэглэх нь зүйтэй болов уу гэж үзэж байна. Учир нь хуулийн антропологи гэсэн томъёог хэрэглэснээр “*эрх зүйн антропологиин агуулгыг явцууруулан тодорхойлуулах төдийгүй эрх зүйн илрэн гарах хэлбэрийн тухай ойлголтыг эрх зүйн мөн чанарын тухай ойлголттой хольж, хутган ойлгох*” нөхцлийг бүрдүүлж байна. Жишээлбэл, сонгуулийн хуулийн антропологи гэх зэргээр нэрлэх нь сонгуулийн эрх зүйн антропологиос агуулга, мөн чанарын хувьд эрс ялгаатай байх болно.

2/ Хууль зүйн нэр томъёоны асуудлуудын зангилаа нь “*хуулийн антропологи буюу хуулийн хүн судлал эсвэл эрх зүйн антропологи хэмээх нэр томъёогоор дамжин илэрхийлэгдэх үзэл санаа, утга агуулгыг яаж ялган ойлгох вэ, тэдгээрт уялдаа холбоо, хамаарал байгаа юу, үзэл санаа, агуулгыг нь хэрхэн тодорхойлох вэ, хэрэглэх хүрээ нь ямар байх вэ*” гэсэн асуултуудад байна гэж үзээд, тэдгээрт ач холбогдол өгч эргэцүүлж болохоор байна. Энэ үндсэн дээр эрх зүйн зохицуулалтаас цааш (*дан ганц эрх зүйн онол, философийн хүрээнд бус хууль зүйн хэрэглээний хүрээнд бол*) өргөн утгаар нь хэрэглэх үед *anthropology of law* гэсэн агуулгаар нь ойлгох нь зүйтэй болов уу, харин эрх зүйн зохицуулалтын хүрээнд явцуу утгаар хэрэглэх тохиолдолд *legal anthropology* гэсэн агуулгаар ялган зааглаж, агуулгын болон хэрэглэж байгаа хүрээнээс нь хамааран ийнхүү авч үзэж болох юм.

3/ Эрх зүйн антропологи нь нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсарын ижилсэл, ондоошлыг; нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь авч үздэг бөгөөд эрх зүйн антропологиин онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, уламжлал, зан заншил, үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан хэв хууль, ахуй зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуунаа болгон судалдаг гэж үзэж болно. Энэ утгаар бол сонгуулийн эрх зүйн антропологи гэдгийг сонгуулийн эрх зүйн болон эрх зүйн тогтолцооны талаархи антропологи анализ гэж энгийнээр тодорхойлж болох юм.

4/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, түүнд хамаарах эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн зарим шийдвэрийн үндэслэл зэргээс аваад үзвэл, сонгуулийн эрх зүйн хүн судлалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Key words: *Anthropology, anthropology of law (legal anthropology), ethnography of law, legal language, legal terminology, ius, lex.*

Abstract: *The article is named as the “Anthropology of Electoral law” and its content is conducted within legal issues on the translation of legal terminology. Anthropology is an empirically-grounded discipline. Its material is observed in the real world, typically through long-term, focused participant observation. The anthropologist studies social forms as they exist in all their variety, including ideas as well as physical activities, and what may be regarded as archaic or marginal. “Anthropology of law” is the first branch of anthropology*

to emerge from mid–nineteenth century. The field studies different social and cultural differences in terms of social, cultural and legal relations. In this context, it is possible to study how the concept of human rights is developed in Mongolia and how it is related to traditional culture, way of life, customs and beliefs.

Ашигласан материал

А.Эрх зүйн эх сурвалж:

1/ Монгол хэлний тухай хууль (2015.02.12)

Б.Үндсэн хуулийн маргаан:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 05 дугаар сарын 02–ны өдрийн 03 дугаар тогтоол МУҮХЦ, Тогтоол №03/2012.05.02.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 22–ны өдрийн 05 дугаар дүгнэлт МУҮХЦ, Дүгнэлт №05/2016.04.22.

3/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 06 дугаар сарын 27–ны өдрийн 01 дүгээр тогтоол МУҮХЦ, Тогтоол №01/2022.06.27.

В.Монгол хэл дээрхи эх сурвалж:

1/ Бум – Очир Д., Мөнх – Эрдэнэ Г., Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд, Уб., 2012

2/ Мөнх – Эрдэнэ Г., Чулуунбат П., Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., 2017

3/ Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, (II хэвлэл), Уб., 2008

4/ Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, (III хэвлэл), Уб., 2011

5/ Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, Уб., 2018

6/ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), Уб., 2001

7/ Нарангэрэл С., Хуулийн амин сүнсийн эрэлхийлэл, (Чингис хааны гэрээс), Уб., 2016

8/ Нарангэрэл С., Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Анхны хэвлэл, Уб., 2021

9/ Номынбаясгалан С., Хууль зүйн нэр томъёоны асуудлууд, Монголын төр, эрх зүй сэтгүүл, Уб., 2022, №1, (100)

10/ Номынбаясгалан С., Түвшинсанаа О., Хүчиндэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын антропологийн асуудал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2022, №2

11/ Нямсүрэн Ч., Эрх зүйн ерөнхий онол, (Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал), Хоёр дахь хэвлэл, Уб., 2017

12/ Сарантуяа Ц., Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №1

13/ Сэлэнгэ Х., Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, Уб., 2000, №2 – 3

14/ Сэнгэдорж Т., Эрх зүй хэмээх нэр томъёоны эргэн тойронд, Эрх зүй сэтгүүл, Уб., 2012, №1 – 2 (21)

15/ Фернанда Пирие., Эрх зүйн антропологи, (Орчуулсан: Номынбаясгалан С., ба бусад) Хүний эрх сэтгүүл, Уб., 2022, №1

16/ Жан Копан., Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, (Орчуулсан: Дулам С.), Уб., 2007

Г.Гадаад хэл дээрхи эх сурвалж:

1/ Fernanda Pirie., The Anthropology of Law, Oxford university press, 2013

Д.Бусад эх сурвалж:

1/ Хамтын бүтээл., Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Таван боть, (X – Я), Уб., 2008

ЗОХИОГЧИД

Зохиогчийн нэр	Ажил, албан тушаал	E-mail
Ж.Төртогтох	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор	turo@num.edu.mn
С.Мөнхбат	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн профессор	munkbat.s@num.edu.mn
Б.Эрдэнэдалай	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	erdenedalai@num.edu.mn
Г.Туяагэрэл	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш	tuyagerel.g@num.edu.mn
Д.Ганбат	Улс төрийн Боловсролын Академийн УЗ-ийн дарга	ganbat@academy.org.mn
Павел Маскаринеч	БНЧУ, Евангелистийн Их Сургууль, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	maskarinec@centrum.cz
Д.Мягмарсүрэн	ШУТИС, Хүний нөөцийн захирал, дэд профессор	myagmarsurend@must.edu.mn
Я.Төгөлдөр	ШУТИС, БУХС, Нийгмийн ухааны салбарын эрхлэгч, дэд профессор	tugul@must.edu.mn
Б.Одгэрэл	Отгонтэнгэр их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал	odgerel@otgontenger.edu.mn
О.Мөнхжаргал	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн багш	munkhjargal.o@num.edu.mn
Хьюн Чин Лим	БНСУ-ын ШУА-ийн гишүүн, Сөүлийн Үндэсний Их Сургуулийн хүндэт профессор	hclim@snu.ac.kr
Сүк Ки Кон	БНСУ, Сөүлийн Үндэсний Их Сургуулийн Ази Төвийн профессор	skong@snu.ac.kr ; sukki.kong@gmail.com
Николас Назке	Англи хэлний багш, Фулбрайт	Natzken@umich.edu
Г.Золзаяа	Отгонтэнгэр Их Сургуулийн Сэтгүүл зүй олон улсын харилцааны тэнхимын эрхлэгч	Zolzaya@otgontenger.edu.mn
Г.Жаргалмаа	Отгонтэнгэр Их Сургуулийн Сэтгүүл зүй олон улсын харилцааны тэнхимын багш	Jargalmaa@otgontenger.edu.mn
О.Хатанболд	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, ЭШТА	khatanboldo@gmail.com
Д.Уртнасан	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны	urtnasan_d@num.edu.mn

	салбар, Улс төр судлалын тэнхимийн дадлагажигч багш	
Саша Ханниг Нүнец	ЧБНУ, Ардчилалын институтын судлаач БНЯУ, Хицобашу Их Сургууль, Дэлхийн засаглалын судалгааны институтийн туслах судлаач	Sascha.hannig@hotmail.com
Д.Хулан	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант	hulkadeleg@gmail.com
Д.Түмэнжаргал	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш	tumeed@num.edu.mn
Г.Мөнхтуяа	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант	ganbolddmunkhtuyaa@gmail.com
Х.Батхүү	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант	batkhuukhurelbaatar@gmail.com
С.Базарпүрэв	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор	bazarpurev@num.edu.mn
Д.Ундрах	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	poli_und@num.edu.mn
Н.Батсүмбэрэл	МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн докторант	batsummerel@gmail.com
Д.Бумдарь	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн профессор	bumdari@num.edu.mn
Б.Баярбаатар	МУИС,ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант	B_bayar8888@yahoo.com
С.Номынбаясгалан	Монголын Криминологчдын холбооны судлаач	snomtoibayar@gmail.com

CONTRIBUTORS

Author	Affiliation	E-mail
Turtogtokh Janar	Professor, Chairman of Department of Political science, National University of Mongolia	turo@num.edu.mn
Munkhbat Sonomdarjaa	Professor, Department of Political science, National University of Mongolia	munkbat.s@num.edu.mn
Erdenedalai Bat-Ulzii	Associate professor, Department of Political science, National University of Mongolia	erdenedalai@num.edu.mn
Tuyagerel Ganbat	Senior lecturer, Department of Political science, National University of Mongolia	tuyagerel.g@num.edu.mn
Ganbat Damba	Chairman of the Board Academy of Political Education	ganbat@academy.org.mn
Pavel Maškarinec	Associate professor at the Department of Political Science, Faculty of Arts, Jan Evangelista Purkyně University in Ústí nad Labem, Czech Republic	maskarinec@centrum.cz
Myagmarsuren Dashzevge	Associate professor, Director of Human Resources, Mongolian University of Science and Technology	myagmarsurend@must.edu.mn
Tuguldur Yanjiv	Associate professor, Head of Division of Social Sciences, Mongolian University of Science and Technology	tugul@must.edu.mn
Odgerel Batsaikhan	Associate Professor, Vice Rector for Academic and Scientific Affairs, Otgontenger University	odgerel@otgontenger.edu.mn
Munkhjargal Otgonbayar	Lecturer, Department of Political Science, National University of Mongolia	munkhjargal.o@num.edu.mn
Hyun-Chin Lim	Member, The National Academy of Sciences, Republic of Korea Professor Emeritus of Sociology, Seoul National University Founding Director of Seoul National University Asia Center	hclim@snu.ac.kr
Suk-Ki Kong	Research Professor, Seoul National University Asia Center	skong@snu.ac.kr; sukki.kong@gmail.com
Nicholas Natzke	English Teaching Assistant, Fulbright	Natzken@umich.edu
Zolzaya Gankhuyag	Head of International Relations	Zolzaya@otgontenger.edu.mn

	Department, Otgontenger University	
Jargalmaa Ganbaatar	Lecturer of International Relations Department, Otgontenger University	Jargalmaa@otgontenger.edu.mn
Khatanbold Oidov	Leading Academic Researcher, Head of Department of Political Science & Legal Studies, Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences	khatanboldo@gmail.com
Urtnasan Dagiidamba	Lecturer, Department of Political Science, National University of Mongolia	Urtnasan_d@num.edu.mn
Sascha Hannig Núñez	Associated Researcher, Instituto Desafíos de la Democracia (IDD) Chile. Assistant, Institute for Global Governance Research, Hitotsubashi University	Sascha.hannig@hotmail.com
Khulan Deleg	Master student, Department of Political science, National University of Mongolia	hulkadeleg@gmail.com
Tumenjargal Davaadorj	Senior lecturer, Department of Political science, National University of Mongolia	tumeed@num.edu.mn
Munkhtuya Ganbold	Graduate student, department of Political science, National University of Mongolia	ganbolddmunkhtuyaa@gmail.com
Batkhuu Khurelbaatar	Doctor student, Department of Political science, National University of Mongolia	batkhuukhurelbaatar@gmail.com
Bazarpurev Sambuu	Advisory professor, Department of Political science, National University of Mongolia	bazarpurev@num.edu.mn
Undrakh Davaadorj	Associate professor, Department of Political science, National University of Mongolia	poli_und@num.edu.mn
Batsumberel Natsagdorj	Doctoral student, Department of Social science, Mongolian State University of Education	batsumberel@gmail.com
Bumdari Dagva-Ochir	Professor, Department of Political science, National University of Mongolia	bumdari@num.edu.mn
Bayarbaatar Bayarmagnai	Doctor student, Department of Political science, National University of Mongolia	B_bayar8888@yahoo.com
Nomynbayasgalan Suld	Senior Researcher, Mongolian Criminological Society	snomtoibayar@gmail.com

ⁱ Мөн тэнд. 124 дэх тал.

ⁱⁱ Даль А.Роберт. Ардчиллын тухай. орч. Ганхуяг Д. УБ., 2004. 82 дахь тал.